

МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ БОДИС
ХЭРЭГЛЭСЭН ЭТГЭЭДИЙГ ТАНИХ ЗАРИМ АРГУУД

А.Лхамсүрэн

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Мөрдөн арга зүйн тэнхимийн
дэд профессор, цагдаагийн хошууч*

Товч агуулга: Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны практикт мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн этгээдийн таних, илрүүлэх шаардлагат олонтаа тулгардаг. Ийм этгээдийг илрүүлэх, үйлдлийг баримтжуулахад цагдаагийн байгууллагад түргэвчилсэн тестийг ашиглах эсхүл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл журамын дагуу шинжээч томилох замаар хийгддэг.

Америк, Европын цагдаагийн байгууллагад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн этгээдийг таних, илрүүлэх, баримтжуулахад олон төрлийн арга хэрэглэдэг бөгөөд нэг төрлийн аргын талаар энэхүү нийтлэлд дурдсан болно.

Түлхүүр үг: Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис, биед гарах өөрчлөлт, сэтгэцэд гарах өөрчлөлт, шууд болон шууд бус шинж тэмдэг, Ромбергийн сорил

Үндсэн хэсэг. Монгол Улс дахь нийгмийн сөрөг үзэгдлүүдийн дунд мансуурах бодис сэтгэцэд нөлөөт эм бэлдмэлтэй холбоотой гэмт хэргийн нөхцөл байдал жилээс жилд хүндэрч, мансууруулах эм бэлдмэл, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах гэмт хэргүүдийн нэлээд хэсэг нь нуугдмал байгаа нь тухайн төрлийн гэмт хэргийн нийгмийн аюул өсөх хандлагатай, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдэд дүн шинжилгээ хийж, эрчимжүүлэх шаардлага гарч байгааг харуулж байна¹. Мансууруулах сэтгэцэд нөлөөлөх бодис хүний биеийн болон сэтгэцийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх, өвчлөх, ХДХВ, бусад халдварт өвчнөөр өвдөх эрсдэлийг нэмэгдүүлэхээс зэргээс гадна тухай хүний нийгмийн амьдралыг сүйтгэдэг, нийгмийн анхан шатны нэгж болох гэр бүлийн тогтворгүй байдалд хүргэх зэрэг олон сөрөг үр дагавартай нийгмийн үзэгдэл юм.

Мансууруулах бодис буюу “Narkotic” нь грек хэлнээс уйтгар гуниг, согтуу, солиотой гэх үгнээс, сэтгэцэд нөлөөт эм бэлдмэл буюу “Psychotropos” нь грек хэлнээс “Psyche” буюу сэтгэл, “tropos” нөлөөлөх, үйлчлэх³ буюу сэтгэцэд нөлөөлөх, үйлчлэх гэсэн утгатай үг болох талаар ОХУ-ын эрдэмтэд Бойко Е.С, Дьяченко В.А нар тодорхойлсон байдаг. Судлаачдын үзэж байгаагаар, хүн төрөлхтөн мансууруулах бодисыг эртнээс таньж, хамгийн анх намуу цэцгийг Месопатамчууд⁴ манай тооллын өмнөх 340 жилийн тэртээ хэрэглэж байсан нь эртний булш, бунхнаас олдсон эд өлгийн зүйл, хадны сүг зураг зэргээс ажиглагддаг тухай тэмдэглэсэн байна.

Сүүлийн жилүүдэд БНХАУ, ОХУ болон Зүүн өмнөд Азийн орноос амфетамин, метамфетамин, төрлийн болон мансууруулах ургамлын гаралтай бодисыг Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн, нэвтрүүлэхийг завдсан, зарж борлуулсан гэмт хэрэг, зөрчлийн тоо ихсэх болсон бөгөөд цагдаа, хил, гаалийн байгууллагаас гаргасан мэдээллээр БНХАУ-аас ихэвчлэн амфетамин, метамфетамин, төрлийн мөс (ICE) болон ургамлын гаралтай шавар (Hashish), ОХУ-аас сэтгэцэд нөлөөт “Анданте” зэрэг эм хууль бусаар нийлүүлэх болжээ. Мансууруулах эм сэтгэцэд нөлөөлөх бодисын гэмт

¹ Б.Болдбаатар Хар тамхи, мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэж буй хууль тогтоомжийн хэрэгжилт тулгамдсан асуудал Хар тамхины гэмт явдал шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам ЭШХ-ын эмхэтгэл 4-р тал Улаанбаатар 2018 он

явдалын дийлэнхи хэсэг нь Монгол улсын нутаг дэвсгэрт ургадаг мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбогддог.

Манай орны зарим нутаг дэвсгэрт ургадаг мансууруулах болон донтуулах үйлчилгээтэй бодис бүхий ургамал болох намуу, зэрлэг олс, зээргэнэ, лантанз зэрэг 9 овог, 11 төрөлд хамаарах 18 зүйл ургамал нь манай улсын 14 аймгийн 49 гаруй сумын нутаг дэвсгэрт 15,000 орчим га талбайд ургадаг гэсэн судалгаа байдаг бөгөөд түүнийг механик аргаар устгах хөрөнгө мөнгө байхгүйгээс дээрх төрлийн ургамлыг устгах ажил хангалтгүй хийгдэж ирсэн байна. Өдгөө Монгол Улсын нутаг дэвсгэрт 15000 орчим га газар буюу 14 аймагт мансууруулах, донтуулах үйлчилгээтэй ургамал ургадаг ажээ².

Мансууруулах зүйл хэрэглэснээс үүсэх ерөнхий шинжүүд:

- Оюун ухаанд гарах өөрчлөлт: Оюун ухаанд гарах шинжийг хөнгөн ба гүн илрэх шинж гэж хоёр ангилж болно. Оюун ухаанд бага хэмжээний өөрчлөлт гарах тохиолдолд мансуурагч нь дуугаа хурааж, шалтгаангүй инээх, гараараа илүү дутуу дохио зангаа хийх, ганцаараа ярих, эргэн тойрны хүмүүст анхаарлаа хандуулахгүй байх зэрэг үйлдэл гаргадаг. Оюун ухааны гүнзгий өөрчлөлт гарсан тохиолдолд мансуурагч нь хөдөлгөөн багатай хөл гар султай болдог.

- Сэтгэл санааны тогтворгүй байдал эсрэг тэсрэг түвшинд: Мансуурсны дараа хөгжилтэй цовоо, хэл ам, хөдөлгөөн хурц болж сэтгэл санааны байдал огцом сайжирна. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын дутагдал буюу өлсгөлөнд орсон үедээ үйлдэл нь тодорхойгүй, уур уцаартай болж уй гашууд автан сэтгэл санааны уналтанд огцом орно.

- Бие махбодид гарах өөрчлөлт: Нүд гал цоггүй, үхмэл өнгөтэй болох, Хүүхэн хараа нарийсах, эсхүл өргөсөх, Арьс хуурайших, Шүлс ихээр ялгарах, Нүүр ихээр хөлрөх зэрэг шинж илэрнэ.

Мансууруулах бодист гүнзгий хордох: Хордолтын эхэнд сэтгэл хөдлөлийн төсөөлөл байдаггүй, байсан ч маш түргэн хугацаанд болж өнгөрөөд 15-20 минутын дараа зогсох, бөөлжих шинжүүд илэрнэ.

Дараагийн 10-20 минутанд өвчтөн алхаж явах чадвараа хараахан алдаагүй ч ухаан санаагаа алдах, хөдөлгөөний болон сэтгэл санааны сааталд орох, бие сулрах, нойр хүрэх бөгөөд эцэст нь бие дааж явж чадахаа больж бэгтрэх, комд орох үйл ажиллагаа явагдана. Мансууруулах бодис хэрэглэж хордох үйл явц нь харилцан адилгүй хугацаанд явагдана. Комын өмнөх үе шат нь 1.5-аас 18 цаг хүртэл хугацаанд үргэлжилнэ. Комын үеийн үе шат нь 7-10 цагаас 3-5 хоног хүртэл хугацаагаар, комын дараах үе шат нь 12 цагаас 3 хоног хүртэл хугацаанд тус тус үргэлжилнэ³.

Байнгын хэрэглэгчид: Дээр дурдсан 3 бүлгийн хүмүүсээс бүрдэнэ. Сэтгэхүйн хувьд мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисоос хамааралтай агаад зуршил тогтсон учир байнгын хэрэглэгч болдог.

Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодист донтогчид: Энэ бүлэгт хамаарах хүмүүс нь бие болоод сэтгэцийн хувьд хамааралтай болсон хүмүүс байдаг. Ийм төрлийн хүмүүст мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхээс нааш бие махбодь, сэтгэл санааны аль алин нь тайвширдаггүй хүмүүс орно. Өнгөц харахад мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэгч хүн бүрийг өвчтөн гэж нэрийдэх боломжийг олгодог. Тав дахь бүлэгт хамаарах этгээдийг эмчлэхээс өөр ял шийтгэл байдаггүй. Зан үйлийн гэж нэрлэгдэх дээр дурдсан дөрвөн бүлэгт хамаарах этгээдэд хүмүүжлийн арга хэмжээ авдаг бол тав дахь бүлгийн хүмүүст эмнэлгийн туслалцаа төдийгүй нийгмийн туслалцаа хэрэгтэй байдаг.

² ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газрын мэдээлэл 2019 он Улаанбаатар

³ Основы общей и судебной наркологии Бакин.А.А, Острецов.О.В 16-р тал Санкт-Петербург 2012 он

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг бэлтгэх, үйлдвэрлэх аргаар дараах байдлаар ангилна.

1. Ургамлын /байгалийн/ гаралтай буюу байгалийн гаралтай түүхий эдээр бэлтгэсэн бодис
2. Хагас нийлэгжүүлсэн аргаар бэлтгэсэн
3. Химийн аргаар бэлтгэсэн ⁴

Зарим төрлийн ургамлын гаралтай морфин, кодеин, кокаин зэрэг мансууруулах бодисыг химийн аргаар гарган авч болдог тул дээр дурдсан ангилал хөрвөх чадвар өндөртэй харьцангуй ойлголт юм.

Ургамлын гаралтай мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодист зэрлэг болон таримал олсны ургамал буюу конопля, каннабис, намуу цэцэг, зэрлэг болон таримал кока, эфедра агуулсан ургамалууд /зээргэнэ/, зарим төрлийн мөөгнүүд хамаарна. Гэмт этгээдүүд зарим тохиолдолд өөрийн улс ороны байгаль, цаг уурын нөхцөлд нийцүүлэн шинэ төрлийн сорт ургамал гарган авсан байх нь тохиолдолддог. Жишээлбэл: Бразилд 6 сарын дотор 2-3 метр өндөр ургадаг ургамал гарган авсан тухай тохиолдол бүртгэгдсэн байна. Мнай улсын хувьд байгаль, цаг агаарын онцлогоос шалтгаалан олсны ургамал, намуу цэцэг тариалах боломжтой тул энэ төрлийн ургамлуудыг суулгасан, тариалсан тохиолдлууд бүртгэгдсэн байна.

Ургамлын гаралтай мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисыг түүхий эдээр дараах байдлаар ангилж болно.

- Олсны ургамал буюу каннабисээс гарган авсан
- Намуу цэцгийн түүхий эдээс гарган авсан
- Кокагийн ургамлаас гарган авсан кокаин
- Псилобин, псилоцины агуулга бүхий мөөгнүүд

Олсны төрлийн ургамлуудад сэтгэц идэвхит бодис болох тетрагидраканнабинол /THC/ агуулагддаг. Түүний дундаас Дельта 9 тетрагидраканнабинол хамгийн хүчтэй сэтгэц идэвхит бодист тооцогддог.

Марихуан- Олсны ургамалам буюу каннабисийн хуурай болон нойтон навчыг ургамлын үндэс, мөчирийн үлдэгдэлтэй хамт боловсруулсан мансууруулах сэтгэцэд нөлөөлөх бодис юм. Марихуаныг бэлтгэдэг ургамлын гол мөчирыг ашигладаггүй.

Гашиш- каннабисийн давирхай эсхүл тоосонцорыг бутлах, үйрүүлэх, бяцлах аргаар гаргаж авсан бодисыг хэлнэ. Гадаад хэлбэр таблетка, шахмал нунтаг, нухаш, шавар хэлбэртэй байх бөгөөд каннабисын дэлбээг ашиглан боловсруулсан байдаг.

Гашишын тос- Каннабисын ургамлыг тос болон уусгагч бодис агуулсан химийн бодисоор ялган авсан өтгөн гарцыг хэлнэ. Тетрагидроканнабинол нь тосонд амархан уусах чанартай тул биологийн гаралтай тос, бензин, керосин, будаг шингэлэгч-растворитель зэргээр ялгаж гашишын тос гаргаж авах нь түгээмэл байдаг. Энэ төрлийн мансууруулах бодисыг ихэвчлэн амьсгалын замаар хэрэглэдэг. Тамхины ургамалтай хольж татах, тамхинд шингээх, утааг сорох зэргээр хэрэглэдэг боловч сүүнд чанаж уух, ургамлын тостой шарах зэрэг аргаар хэрэглэдэг бөгөөд амьтны гаралтай үйлдвэрийн аргаар боловсруулаагүй сүү нь тослог өндөртэй 3-18 хувийн тослогийн агууламжтай байдаг. Зарим амьтаны сүү 50 хүртэл хувийн тослогтой байх нь тохиолддог⁵.

Дараагийн түгээмэл тохиолддог ургамлын гаралтай мансууруулах бодис нь намуу цэцэгээс гарган авдаг бодисууд юм. Намуу цэцэгийн навч, опиум, намуу цэцэгийн навчны ханд, омнопон, морфин, кодеин, тебаин зэргийг олон зуун жилийн өмнөөс анагаах ухаанд ашиглаж эхэлсэн. Морфиныг өвчин намдаах, кодеиныг ханиалга дарах зэрэг зориулалтаар 18-19-р зуунд өргөн ашиглаж байсан.

⁴ Справочная книга криминалиста Селиванов.Н.А Москва 2012 он 73-р тал

⁵ Учебное пособие для сотрудников УФСИН Баринов.В.П 8-р тал Рязань 2018 он

Дээрх төрлийн бодисууд нь хүчтэй донтуулах үйлчилгээтэй бөгөөд 2-3 удаагийн тарилга хүний биеийн онцлогоос шалтгаалан донтуулах, хамаарал үүсгэх тохиолдол гардаг.

Кокаины төрлийн мансууруулах бодисыг кока ургамлын навчнаас гаргаж авах бөгөөд Өмнөд америкаас гаралтай ургамал юм. Далайн түвшинээс дээш 2000-4000 метр өндөрт өргөгдсөн ширэнгэд ургахад хамгийн тохиромжтой байдаг. Өмнөд америкийн уугуул иргэд олон мянган жилийн туршид энэ ургамлыг сэргээш байдлаар хэрэглэж ирсэн бөгөөд хүний бие, сэтгэцийг сэргээх хамаарал, донтолт үүсгэдэг бодис юм. Боловсруулсан кокаиныг хамрын нүхээр сорж хэрэглэх бөгөөд шууд тархинд хүрдэг үйлчилгээ хурдан байдаг.

Сүүлийн үед хууль бус зах зээл дээр шинэ төрлийн аргаар бэлтгэсэн “крек” /crack/ гэх нэршилтэй мансууруулах бодис түгээмэл тохиолдох болсон. Дээрх төрлийн мансууруулах бодисыг цэвэр кокаиныг 3:1 харьцаатай устай найруулж халаахад ууршилт явагдаж өтгөн хэсэг үлддэг. Хэсэг хугацааны дараа өтгөн уусмал хатаж хатуу хэлбэрт орох бөгөөд хагарахдаа өвөрмөц дуу гардаг тул crack гэх нэршил үүсчээ. Бүрэн хатсан крек нь жижиг хэмжээтэй саарал, ягаан, эсхлэ цагаан өнгийн эдийн савантай төстэй биет байдаг⁶.

Энэ нь ургамлын гаралтай түүхий эдийг тодорхой химийн бодис ашиглан уусгах, агууламжийг өндөр болгох, молекул бүтэцийг загварчлах аргаар гарган авсан мансууруулах бодисыг хэлнэ. Энэ бүлгийн мансууруулах бодисоос ОХУ, БНХАУ, АНУ-д хамгийн түгээмэл тохиолддог төрөл нь героин, морфины гидроклорид буюу шингэн хэлбэрийн морфин юм. Героин /диацетилморфин/-ийг морфиныг уусгагчаар уусгах замаар гаргаж авдаг. Дээрх аргаар гарган авахдаа уксусны ангидрид, хлорлог ацетил түгээмэл ашигладаг. Героиныг дангаар хэрэглэх нь ховор бөгөөд үнэтэй, хэтрүүлэн хэрэглэх эрсдэл ихтэй тул глюкоз, элсэн чихэр, гурил, төмсний цардуул зэрэг бусад дүүргэгч бодис, мансууруулах үйлчилгээг хүчитгэх зорилгоор барбитурат, кофеин, анальгин, сульфат бария, цахиурын хэт исэл зэрэгтэй хольж хэрэглэдэг. Героин орц найрлага тарьсан газар орон зэргээс шалтгаалан хар саарал, цайвар саарал, шаравтар, цагаан, өнгөтэй байж болно. Героин нь мансууруулах нөлөөлөлөөрөө морфиноос 5-7 дахин их бөгөөд 3-4 дэх хэрэглээнээс хамаарал, донтолт үүсгэж эхэлдэг.

Мансууруулах бодис хэрэглэсэн эсхүл тогтмол хэрэглэдэг хүнийг дараах аргуудаар илрүүлж болно.

1. Шинжээчийн дүгнэлтээр
2. Экспресс тестээр
3. Мансууруулах бодис хэрэглэгчийн шууд бус шинжүүдээр
4. 7 шатлалт сорилоор

Мөрдөгч нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн эсэх талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.7 –р зүйлд заасан үндэслэл журмын дагуу хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс өмнө шатанд шинжээч томилж шинжилгээ хийлгэх боломжтой. Мансууруулах эм сэтгэцэнд нөлөөлөх бодисын шинжилгээг Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасан үндэслэл журмын дагуу Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Тусгай шинжилгээний газарт мөрдөгчийн тогтоолын дагуу хийнэ.

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис нь хүний биеэс шүүрэл, ялгадасаар дамжин гадагшилдаг. Экспресс тест нь манай улсын практикт urinal test буюу мансууруулах бодис хэрэглэсэн байж болзошгүй этгээдийн шээсийн урвалжууд бүхий тусгай саванд хийж шалгадаг тестийг хэрэглэж байна. Тухайн тестийн саванд мансууруулах бодис хэрэглэсэн байж болзошгүй этгээдийн шээсийг хийснээс хойш 1-5 минутын дотор хариу нь гардаг. Сүүлийн жилүүдэд экспресс тестүүд нь харьцангуй боловсронгуй болж халуун хэмжигчтэй өөрөөр хэлбэл хүний биеийн халуунтай ойролцоо шингэнийг

⁶ Методика расследования незаконного сбыта синтетических наркотических средств, совершенного с использованием интернет-магазинов Земцова.С.И нар 52-р тал Красноярск 2019 он

хэмжих мэдрэгчтэй, манай улсад түгээмэл тохиолддог 4-6 төрлийн бодис хэрэглэсэн эсэхийг шалгах боломжтой, тестийн мэдрэг чанарыг нэмэгдүүлэн ашиглаж байна.

Хүний биеийн онцлог, тухайн төрлийн мансууруулах бодисыг хэрэглэсэн давтамж, хугацаа зэргээс шалтгаалан хүний биед хадгалагдах, шээсээр биеэс гадагшлах хугацаа харилцан адилгүй байдаг.

Согтууруулах ундаа 7-12 цаг, амфетамин 48 цаг, кокаин 6-8 цаг, героин 36-72 цаг, кодеин 48 цаг, каннабис 3-28 хоног, метадон 72 цаг, барбитуратын төрлийн бодисууд 1-20 хоног, морфин 48-72 цаг, фенциклидин 6-8 хоног, ЛСД 24-48 цаг, МДМА 24-48 цаг, метамфетамин /мөс/ 1-5 хоног тус тус хадгалагдаж шээсээр гадагшилдаг⁷.

Дээр дурдсан 2 арга нь цаашид ямар нэг эрх зүйн үр дагавар үүсгэх боломжтой байдаг өөрөөр хэлбэл шинжээчийн дүгнэлт шууд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэгт нотлох баримт, экспресс тест нь гэрчийн мэдүүлэг, үзлэг, зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тодорхой ажиллагаагаар нотлох баримт болох боломжтой байдаг.

Харин сүүлд дурдсан 2 арга нь шууд нотлох баримт болох боломжгүй боловч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хүний бие, эд зүйл, хувцасанд үзлэг хийх, мэдүүлэг авах зэрэг тодорхой ажиллагаагаар цаашид нотлох баримт болгон ашиглах эсхүл мэдээллийн эсхүл хөтлөх чанартай тактикийн мэдээлэл болгон ашиглах боломжтой.

Согтууруулах, мансууруулах бодис хэрэглэсэн эсэх, ямар төрлийн мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах 7 шатлалт сорил: Энэ арга D.A.R 7 буюу Drug Abuse Recognition нэрээр олон жилийн турш АНУ-ын хууль сахиулах байгууллагад хэрэглэгдэж байгаа бөгөөд согтууруулах, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэгсэн байж болзшгүй этгээдийг сэтгэц, физиологийн нөлөөг эмнэлгийн энгийн тоног төхөөрөмж ашиглан илрүүлэх, ямар төрөл бүлгийн мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэсэн эсэхийг өндөр магадлалтай тогтоодог арга юм⁸.

Энэ аргыг дараах 7 шатлалт сорилыг ашигладаг.

1. Зүрхний цохилт
2. Хөндлөн нистагм
3. Босоо нистагм
4. Конвергенц
5. Хүүхэн харааны харьцуулалт
6. Хүүхэн харааны хувирал
7. Ромбергийн сорил

Дүгнэлт. Энэ аргыг хэрэглэхэд эмнэлгийн зориулалттай нүдний хүүхэн харааны өөрчлөлтийг шалгах гар чийдэн шаардагдана. Гар чийдэн 4 люменээс ихгүй гэрлийн урсгалын хүчтэй байх ёстой. Түүнээс их хүчтэй гар чийдэн ашигласан тохиолдолд нүд анивчих, нарийсах урвал үзүүлэх магадлалтай болж сорилын дүн худал гарах нөхцөл үүснэ.

Мөн эмнэлгийн болон ахуйн зориулалттай пульс-оксиметр хэрэглэж хүний судасны лугшилтыг тогтоовол зохино. Гарын дор пульс-оксиметр байхгүй тохиолдолд цаг харж гараар судасны лугшилтыг тоолж болно. Энэ тохиолдолд зааваал хамгаалалтын, эсхүл эмнэлгийн зориулалттай бээлий ашиглах хэрэгтэй. Мансууруулах бодис хэрэглэгч этгээдүүд арьсны олон төрлийн өвчин, бусад халдваруудын тээгч, тараагч байх боломжтой тул өөрийн аюулгүй байдлыг хангах шаардлагатай.

⁷ Профилактика зависимостей от психоактивных веществ. Коробицина.Т.В 32-р тал Красноярск 2012 он

⁸ DAR course US Embassy сургалтын материал 2019 он Улаанбаатар

Ашигласан материалын жагсаалт

1. Хар тамхины гэмт явдал шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл Улаанбаатар 2018 он
2. ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газрын мэдээлэл Улаанбаатар 2019 он
3. Основы общей и судебной наркологии Бакин.А.А, Острцов.О.В Санкт-Петербург 2012 он
4. Справочная книга криминалиста Селиванов.Н.А Москва 2012 он
5. Учебное пособие для сотрудников УФСИН Баринов.В.П Рязань 2018 он
6. Методика расследования незаконного сбыта синтетических наркотических средств, совершенного с использованием интернет-магазинов Земцова.С.И, Суров. О.А, Галушин.В.П Красноярск 2019 он
7. Профилактика зависимостей от психоактивных веществ. Коробицина.Т.В Красноярск 2012 он
8. DAR course US Embassy сургалтын материал 2019 он Улаанбаатар

ПОЛИЦИЯ ПРОТИВ КОРРУПЦИИ

(сравнительный анализ практики России и Монголии)

Г.Болор-Эрдэнэ
*Эрүүгийн эрх зүй, Криминологийн тэнхимийн
багш, доктор (Ph.D) цагдаагийн хошууч*

Коррупция - одно из самых злободневных явлений, с которыми сталкивается современное общество. Оно разрушает государство, систему управления обществом, порождает утрату доверия к власти и правоохрательным органам, приводит к массовым конфликтам, беспорядкам и снижению уровня социального благополучия и спокойствия населения. Поэтому борьба с коррупцией рассматривается как важнейшее направление деятельности полиции большинства стран. Не являются исключением Монголия и Россия.

Предпринимая попытку сравнить полицейскую практику в сфере борьбы с коррупцией в названных странах, нельзя не отметить несколько обстоятельств. Во-первых, определение коррупции и ее видов регламентируется как международным, так и национальным законодательством.

Полиция преимущественно строит свою работу, ориентируясь на законы своего государства. Антикоррупционное законодательство Монголии отличается от российского, но в каждой из стран имеются отдельные законы, направленные не только на борьбу с коррупцией, но и в целом на правовое обеспечение противодействия.

Определения коррупции схожи, но масштабы различны. Во-вторых, задачи и полномочия полиции в России и Монголии различны. Так, основную нагрузку по борьбе с коррупцией в Монголии несет Независимый орган по борьбе с коррупцией, в России в системе МВД имеется особое подразделение - Главное управление экономической безопасности и противодействия коррупции. В-третьих, средства борьбы с коррупцией в каждой из стран различны, что влияет на методы работы полицейских и результаты антикоррупционной деятельности.

Говоря о результатах борьбы с коррупцией в Монголии, можно указать на следующие факты: число сообщений о фактах коррупции растет из года в год и с 2018 г. превысило 300 ед., по каждому третьему факту возбуждалось уголовное дело; половина из привлекающихся к уголовной ответственности за коррупцию являются сотрудниками государственных органов, более 30 человек (ежегодно) - сотрудниками государственной власти; наиболее частая мера воздействия, которая применялась до 2018 г. к чиновникам за совершение коррупционных правонарушений, - это уведомление о совершенном правонарушении. Сейчас все чаще применяется понижение в должности. Подробные сведения о борьбе с коррупцией в Монголии размещены на официальном сайте Независимого органа по борьбе с коррупцией⁹

В России сходные данные публикуются на официальных сайтах МВД России и Генпрокуратуры России. Проводя сравнительный анализ практики борьбы полицейских Монголии и России с коррупцией, важно отметить, что в каждой из стран соответствующая деятельность осуществляется по нескольким направлениям:

а) предупреждение (установление причин и условий коррупционных правонарушений и их устранение). Работа в данном направлении осуществляется полицейскими в рамках полномочий, которыми они обладают. В России таковыми обладают сотрудники соответствующих подразделений, и для них установлены соответствующие критерии эффективности деятельности, хотя Федеральный закон

⁹ Официальный сайт Независимого органа по борьбе с коррупцией. URL: <https://www.iaac.mn/news/653?menu=147> 63

«О полиции» обязывает каждого полицейского предпринимать меры по предупреждению правонарушений. Сходная ситуация и в Монголии: лишь незначительная часть полицейских сориентированы и предотвращают коррупционные правонарушения. Чаще всего можно говорить об ином, когда полиция задерживает коррупционеров, которые сумели довести преступление до конца и получить желаемую имущественную выгоду, в ряде случаев даже успеть растратить либо передать третьим лицам незаконно приобретенные блага. Вернуть или изъять их удастся далеко не всегда. Эффективность работы полиции в данном направлении пока низка в каждой из стран. При этом данные о снижении числа коррупционных преступлений не всегда могут трактоваться как результат успешной профилактики;

б) выявление (документирование коррупционного взаимодействия на различных стадиях совершения правонарушений). Задачи по выявлению коррупции преимущественно решают субъекты, которые вправе осуществлять оперативно-розыскную деятельность. Часть полицейских подразделений и Монголии, и России обладают соответствующими полномочиями. Оценить эффективность работы полиции по известным причинам затруднительно, но по оценкам экспертов масштабы латентной коррупции огромны, что позволяет предположить наличие существенных недостатков работы полиции в данном направлении;

в) пресечение (приостановление коррупционных действий на стадиях приготовления или покушения). Тот факт, что доля пресеченных на ранних стадиях совершения коррупционных преступлений в каждой из стран составляет менее 0,01 % от общего числа регистрируемых посягательств, пусть косвенно, но говорит о наличии проблем и в выявлении, и в пресечении коррупции. Большинство коррупционных скандалов как в Монголии, так и в России связано с очевидными фактами необоснованного 64 обогащения чиновников и фактами вымогательства в отношении граждан;

г) раскрытие (установление фактов совершения коррупционного правонарушения и лиц, которые виновные в этом). Большая часть коррупционных правонарушений относится к числу раскрытых, хотя в России существует проблема, которая не столь актуальна для Монголии: неустановление всех лиц, которые причастны к совершению коррупционных преступлений, в том числе в качестве организаторов коррупционных схем и покровителей коррупционеров;

д) расследование (процессуальное оформление выявленных обстоятельств совершения коррупционного правонарушения и подготовка проекта решения о мерах воздействия на виновных). Учитывая, что большая часть коррупционных посягательств фиксируется при наличии подозреваемых, проблемы расследований связаны лишь с многоэпизодностью отдельных преступлений, множеством участников преступной деятельности, что удлинит сроки проведения расследования. Кроме того, если речь идет об участии в коррупции высокопоставленных чиновников, то последние успевают скрыться за границей. Разыскать и привлечь их к ответственности даже с помощью Интерпола удастся далеко не всегда;

е) взаимодействие с другими субъектами, осуществляющими функции по противодействию коррупции, включая СМИ и другие институты гражданского общества. Учитывая множественность субъектов борьбы с коррупцией, вопросы их взаимодействия остры как никогда и требуют самостоятельного глубокого исследования. Здесь практика Монголии и России различна: полицейские каждой из стран выработали национально адаптированные формы межведомственного взаимодействия и координации работы, учитывающие полномочия каждого из субъектов, определенные законом. Таким образом, полицейские практики в сфере противодействия коррупции в Монголии и России не идентичны, что в значительной мере обусловлено статусным положением данных органов в системе субъектов борьбы с коррупцией, а также формами и масштабами коррупционных проявлений.

Отдельного рассмотрения 65 требуют вопросы внутрисистемной коррупции, т. е. среди полицейских. Они являются частью более серьезной проблемы - коррупции в системе государственной правоохранительной службы каждой из стран.

ЦАГДААГИЙН ХЭСГИЙН БАЙЦААГЧИЙН АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ХЭЛБЭР, АРГА ЗҮЙГ САЙЖРУУЛАХ ЗАРИМ АРГА ЗАМ

ДХИС-ийн ЦС-ийн
ЦЭЗТ-ийн дэд профессор,
доктор (Ph.D), цагдаагийн
дэд хурандаа Б.Баянмөнх
*Дотоод хэргийн их сургууль,
Монгол Улс Цахим шуудан:*
bayanmunkh@uia.gov.mn

Товчлол. Энэхүү өгүүлэлд “Цагдаагийн хэсгийн байцаагч” албан тушаалын үүсэл, хөгжил, тухайн албан тушаалтай адилтгах алба хаагчийн үүслийг тодорхойлох шинж болон хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын уламжлалыг дотоодын хууль тогтоомжийн хүрээнд товч дурдсан болно.

Түлхүүр үг: хэсгийн байцаагч, ажлын зохион байгуулалт, хэлбэр, арга зүй, томъёо, ажлын ачаалал

Үндсэн хэсэг. Энэхүү өгүүллээр цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх боломжийн талаар авч үзсэн болно. Үүнд:

1. Цагдаагийн хэсгийн байцаагчийн хариуцах нутаг дэвсгэрийг тогтоодог журмыг шинэчлэх.
2. Хороонд багаар ажиллах зохион байгуулалтын хэлбэрийг нэвтрүүлэх.
3. Иргэний бүртгэлийг цагдаагийн байгууллагад хариуцуулж, хороонд багаар ажиллах хэлбэрийг нэвтрүүлэх.

Нэг. “Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив”-ыг боловсронгуй болгон дагаж мөрдөх.

Хорооны нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоонд тулгуурлан хэсгийн байцаагчийн тоог тогтоох асуудал олон жил яригдсаар Монгол Улсын Засгийн газрын 2011 оны “Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” 153 дугаар тогтоолоор “Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив”-ийг батлан “4000 хүн ам тутамд нэг хэсгийн байцаагч ажиллуулна”¹⁰ гэж жишиг нормативыг тогтоосон. ЦЕГ-ын даргын 2012 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 700 дугаар тушаалаар 2013 оноос эхлэн хүн ам, аж ахуйн нэгж, байгууллагын нягтаршил ихтэй хороодод гурав, бусад хороодод хоёр, бүгд 392 хэсгийн байцаагч, үүнээс Улаанбаатар хотод 271, аймгуудад 121 хэсгийн байцаагч ажиллуулж эхэлжээ.

Гэвч энэ норматив удаан үргэлжлээгүй бөгөөд ЦЕГ-ын даргын 2015 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн “Улаанбаатар хотын цагдаагийн газар, харьяа нэгж, дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн бүтцийн зураглал, орон тоо батлах тухай” Б/284 дүгээр тушаалаар нэг хороонд 1 хэсгийн байцаагч ажиллуулах болсон бөгөөд нийслэлийн 152 хороонд 154, орон нутагт 122, нийт улсын хэмжээнд 276 хэсгийн байцаагчийн орон тоо баталж, 116 хэсгийн байцаагчийн орон тоо хасаж, 138 хороо хариуцсан цагдаагийн орон тоо нэмсэн.

¹⁰<https://www.legalinfo.mn>. ЗГ-ын 2011 оны “Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” 153 дугаар тогтоол.

Хороонд хоёр байцаагч ажиллах болсноор гарсан гол үр дүн бол хэсгийн байцаагч нарын ачаалал, илүү цагаар ажиллах нь багассан, дуудлага, хэргийн газар очих хугацаа багасч шуурхай байдал дээшилсэн байна. Хоёр байцаагч ажилласан 2013, 2014 онд хэсгийн байцаагч нарын илрүүлсэн хэрэг, шалган шийдвэрлэсэн зөрчил, эрэн сурвалжлах ажил зэрэг тодорхой тоогоор илэрхийлж болох ажлын хэмжээ нийслэлд мэдрэгдэхээр нэмэгдээгүй. Товч хэлбэл, олигтой үр дүн гараагүй гэж үзэж хуучин журамдаа буцаж орсон. Олигтой үр дүн гараагүй гол шалтгаан нь байцаагч бүрт хариуцах ажлыг нь оноон тогтоож өгөөгүй, хороо хариуцах ажлыг элбэж хийхээр дунд нь орхисонд байсан гэж бид үзэж байна.

2019 оны 1-р сарын 1-ны байдлаар нийслэлийн 9 дүүргийн 152 хороонд 387453 өрхийн 1444.7 мянган хүн оршин сууж байгаа нь Монгол Улсын нийт хүн амын 45.3 хувийг эзэлж байна.¹¹ Нийслэлийн хүн амын 786825 иргэн буюу 54.5 хувь, 212008 өрх буюу 54.7 хувь нь гэр хороололд, 657844 иргэн буюу 45.5 хувь, 175445 өрх буюу 45.3 хувь нь нийтийн орон сууцанд амьдарч байна.

2019 оны нийслэлийн хороодын хүн амын тоог 2014 онтой харьцуулан үзвэл:

Хүснэгт №1

№	Хүн амын тоо	Хорооны тоо	
		2014	2019
1.	641-2103 хүн амтай	3	4
2.	2104-3353 хүн амтай	2	3
3.	3354-4328 хүн амтай	4	10
4.	4329-5029 хүн амтай	9	9
5.	5030-6025 хүн амтай	15	22
6.	6026-7033 хүн амтай	18	22
7.	7034-8064 хүн амтай	20	16
8.	8065-9010 хүн амтай	20	19
9.	9011-10009 хүн амтай	11	14
10.	10010-11024 хүн амтай	8	13
11.	11025-12209 хүн амтай	13	10
12.	12210-13381 хүн амтай	8	9
13.	13382-14042 хүн амтай	4	6
14.	14043-15646 хүн амтай	4	4
15.	15647-16668 хүн амтай	6	2
16.	16669-17125 хүн амтай	1	1
17.	17126-18833 хүн амтай	4	2
18.	18834-20179 хүн амтай	1	1
19.	20180-21299 хүн амтай	-	1
20.	21300-22449 хүн амтай	-	2
21.	22450-аас дээш хүн амтай	-	1

Дээрх хүснэгтээс үзвэл хороодын хүн амын тоо жил ирэх тусам өсч, хэсгийн байцаагчийн ажлын ачаалал нэмэгдэх нэг хүчин зүйл болж байна. 2019 оны 1-р сарын 1-ны байдлаар нийслэлийн хэмжээнд нэг хэсгийн байцаагч хэдэн өрх, хүн ам хариуцан ажиллаж байсныг дүүрэг бүрээр гаргаж, дунджаар авч үзвэл:

Хүснэгт №2

¹¹ <http://ubstat.mn>. Нийслэлийн статистикийн газрын 2019 оны тоо мэдээ.

№	Дүүрэг	Хороо	Өрхийн тоо	Хүн амын Тоо	1 хэсгийн байцаагч /дунджаар/	
					Өрх	Хүн амын тоо
1	2	3	4	5	6	7
1.	Хан-Уул дүүрэг	16	48940	178919	3058	11182
2.	Багануур дүүрэг	5	8569	29512	1713	5902
1	2	3	4	5	6	7
3.	Баянзүрх дүүрэг	28	95714	343619	3418	12272
4.	Налайх дүүрэг	7	10606	37608	1515	5372
5.	Сүхбаатар дүүрэг	20	38563	145335	1928	7267
6.	Баянгол дүүрэг	23	59536	226869	2588	9864
7.	Багахангай дүүрэг	2	1272	4399	636	2199
8.	Чингэлтэй дүүрэг	19	40017	157258	2106	8276
9.	Сонгинохайрхан дүүрэг	32	84236	321150	2632	10035
Нийт		152	387453	1444669	2549	9504

Дээрх тоо мэдээнээс үзвэл нийслэлийн нэг хэсгийн байцаагч дунджаар 2549 өрхийн 9504 хүн амтай хороо хариуцан ажиллаж байна. Хамгийн цөөн өрх, хүн ам хариуцан ажиллаж байгаа нь Багахангай дүүргийн нэг хэсгийн байцаагч дунджаар 636 өрхийн 2199 иргэн, харин хамгийн олон нь Баянзүрх дүүргийн нэг хэсгийн байцаагч дунджаар 3418 өрхийн 12272 иргэнтэй хороо хариуцаж байна. БЗД-ийн 5-р хорооны хэсгийн байцаагч 6458 өрхийн 23536 хүн амтай хороо хариуцаж байна.

Нийслэлийн цагдаагийн газрын төвийн дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдийн нэг хэсгийн байцаагчийн хариуцсан нутаг дэвсгэрийн хүн амын тоог дунджаар нь авч үзвэл:

Хүснэгт №3

№	Хэлтэс	Нэг хэсгийн байцаагч /дунджаар/
1	Баянгол дүүргийн цагдаагийн 1-р хэлтэс	7335
2	Баянгол дүүргийн цагдаагийн 2-р хэлтэс	9707
3	Баянзүрх дүүргийн цагдаагийн 1-р хэлтэс	11138
4	Баянзүрх дүүргийн цагдаагийн 2-р хэлтэс	9833
5	Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн 1-р хэлтэс	8736
6	Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн 2-р хэлтэс	7756
7	Чингэлтэй дүүргийн цагдаагийн 1-р хэлтэс	7760
8	Чингэлтэй дүүргийн цагдаагийн 2-р хэлтэс	8409
9	Хан-Уул дүүргийн цагдаагийн 1-р хэлтэс	10206
10	Хан-Уул дүүргийн цагдаагийн 2-р хэлтэс	6950
11	Сүхбаатар дүүргийн цагдаагийн 1-р хэлтэс	6168
12	Сүхбаатар дүүргийн цагдаагийн 2-р хэлтэс	6964
Дунджаар		8413

2019 оны нийслэлийн хороодын хүн амын тоог Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны жишиг норматив”-оор авч үзвэл өнөөдөр хоёр байцаагч ажиллах 54 хороо, гурван байцаагч ажиллах 18 хороо, дөрвөн байцаагч ажиллах дөрвөн хороо, нийт 129 байцаагчийн орон тоо дутагдалтай гэсэн судалгааны дүн гарч байна.

Хүснэгт №4

№	Дүүрэг	Хорооны тоо	Шинээр нэмэгдэх хэсгийн байцаагчийн тоо				Шаардлагатай орон тоо
			1	2	3	4	
1.	Хан - Уул	13	9	4	-	-	17
2.	Багануур	1	1	-	-	-	1
3.	Баянзүрх	23	7	8	4	3	47
4.	Сүхбаатар	8	7	1	-	-	9
5.	Баянгол	13	6	2	3	1	23
6.	Чингэлтэй	8	5	3	-	-	11
7.	Сонгинохайрхан	19	19		-	-	19
Нийт		85	54	18	7	4	129

Нийслэлийн нэг хороог нэг хэсгийн байцаагч хариуцан ажиллаж байгаа зохион байгуулалтын хэлбэр амьдралд нийлэмжгүй байгааг өмнө хэлсэн. Гэхдээ “4000 хүн ам тутамд 1 хэсгийн байцаагч ажиллуулна” гэсэн норматив бас сайн тохирохгүй байна. Учир нь хүн амын нягтаршил, нутаг дэвсгэрийн хэмжээ, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал, аж ахуйн нэгж, байгууллагын онцлог зэргийг харгалзахгүй байгаагаас ачаалал хэт ялгаатай хэвээр байх нь тодорхой байна.

Иймээс дүүргийн цагдаагийн газрын саналыг үндэслэн хэсгийн байцаагчид хариуцуулах нутаг дэвсгэрийн хил хязгаарыг тогтоох эрхийг Нийслэлийн цагдаагийн удирдах газарт өгөх нь зүйтэй гэсэн саналтай байна. Тэгвэл хэсгийн байцаагчдын ажлын ачаалал нэлээд жигдрэх боломжтой болно. Улмаар ажлын үр дүн дээшилнэ.

Хороонд хоёр байцаагч ажиллах болсныг больж хуучнаар нэг хороог нэг байцаагч хариуцах журамд буцаж орохдоо 2015 онд нийслэлийн хороо бүрт нэг цагдаагийн орон тоо нэмсэн. Гэвч хорооны цагдаа хороондоо тогтвортой ажиллахгүй, албадан саатуулах байр, хэлтсийн жижүүр, явган болон машинт эргүүлийн алба хаагч амарсан, чөлөөтэй, өвчтэй зэрэг шалтгаанаар эзгүй байхад нөхөх байдлаар үүрэг гүйцэтгэх нь их байна.

Энэ хувилбарыг бас жаахан өөрчилж, хорооны цагдааг туслах байцаагч болгон ажиллуулах саналыг бид дэвшүүлж байна. Үүний давуу тал нь ажиллах хүний цалин, цол зэрэгт ямар нэг өөрчлөлт, нэмэлт зардал гарахгүй, туслах байцаагч цагдаагаас илүү үр дүнтэй ажиллах магадлалтай, хэсгийн байцаагчийн нөөцийг бэлтгэхэд ач холбогдолтой гэж тооцож байна. Мөн хэсгийн байцаагч амарсан зэрэг шалтгаанаар эзгүй байх үед туслах байцаагч нутаг дэвсгэрээ хариуцаж байх болно.

Аймгуудын хэсгийн байцаагч нарын хариуцах нутаг дэвсгэр, хүн ам нийслэлийнхээс арай бага байгаа дундаж үзүүлэлт гардаг. Жишээлбэл, Дархан-Уул аймгийн Дархан сум 18 багтай, 3193-6788, Орхон аймгийн Баян-Өндөр сум 21 багтай, 3070-6254, Дорнод аймгийн Хэрлэн сум 10 багтай, 3694-6984 хүн амтай. Зарим онцлог сум бий. Увс аймгийн Улаангом сум 12 баг, 29840 хүн амтай 4 байцаагч ажилладаг, Өвөрхангай аймгийн Арвайхээр сум 11 баг, 31918 хүн амтай, 4 ажилладаг. Харин Дундговь аймгийн Сайнцагаан сум 9 баг 14602 хүн амтай, нэг байцаагч ажилладаг.¹²

Хэсгийн байцаагч нар баг, хороо биш, тодорхой нутаг дэвсгэр хариуцах санал нийслэл болон аймгуудад нэгэн адил хамаарна. Гэхдээ орон нутагт багийн хүн ам хэт их байгаа тохиолдол цөөн, мөн багт ганц хэсгийн байцаагч ажилладаг учир нутгийн засаг байгууллагаа түшиж ажиллах хэрэгцээ,

¹² ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны 2019 оны мэдээнээс хэсэгчилэн авав.

шаардлага илүү их гарах магадлалтай тул баг хариуцах, нутаг дэвсгэр хариуцах хувилбарыг сонгох боломж олгох нь зүйтэй.

Хэсгийн байцаагчийн хариуцах нутаг дэвсгэрийг тогтооход юуны өмнө хэсгийн байцаагчийн ачааллыг тооцож гаргах шаардлагатай. Цагдаагийн ерөнхий газар болон “Ажиглалт” төрийн бус байгууллагын хамтарсан баг 2019 оны эхээр цагдаагийн байгууллагын зарим ажлын байрны ачааллыг тооцон хүний нөөцийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох аргачлал боловсруулсан байна. Тэгэхдээ:

- ажлын ачааллыг тооцох түүвэрт орсон нэгжийн ажил үүрэг;
- гүйцэтгэх ажил үүргийг тоо /давтамж/;
- гүйцэтгэх цагийн дундаж /үндсэн ба тараах/ цаг;
- жилийн ажлын цаг гэсэн дөрвөн суурь тоо баримтад тулгуурласан гэжээ.

Ажилтны жилийн ажлын цагийг дараах байдлаар тооцжээ. Жилийн ажлын хэрэгцээг – 213 хоног буюу 102240 минут (365-52-52-8-24-5-11)

- нийт хоног–365;
- бямба гараг–52;
- ням гараг – 52;
- нийтээр амрах баярын өдөр -8 хоног (хуульд заасан);
- ээлжийн амралт – 24 хоног (хөдөлмөрийн хуульд ажилласан жилээс хамаарч 15-33 хоног байдаг ба түүний дунджаар);

- сургалтын чөлөө – 5 хоног (жилд 1 удаа);
- бусад чөлөө - 11 хоног (сард 1 өдөр).

C- дундаж цаг (минут)

A-үндсэн цаг (минут)

A 6%-тараах цаг

f- Жилийн ажлын цагийн хэрэгцээ

d- Жилд гүйцэтгэх ажил үүргийн тоо

k- Хүний нөөцийн хэрэгцээ

j- Нэг ажилтны жилийн ажлын цаг (минут)

C= a- /a6%//

F = c*d

K = j / f

Алба хаагчийн үндсэн цагийг тараах хувиар үржүүлэн үндсэн цагаас хасч, дундаж цагийг жилд гүйцэтгэх ажлаар үржүүлэн жилийн ажлын цагийн хэрэгцээг гаргаж, нэг ажилтны жилийн ажлын цаг минутад хувааж, ажлын байрны хэрэгцээг гаргажээ.

Хэсгийн байцаагчийн төлөөлөл болгон гурван алба хаагчийн ажлын ачааллыг тооцжээ.

Хүснэгт №5

№	Алба хаагчдын нэр	Ажлын ачаалал
1.	Баянгол дүүрэг дэх Цагдаагийн 2-р хэлтсийн хэсгийн байцаагч М.Одбаяр	0.5295512
2.	Орхон аймаг дахь Цагдаагийн газрын хэсгийн байцаагч Э.Цогтсайхан	0.5811944
3.	Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын хэсгийн байцаагч Г. Хатанбаатар	0.5745228
Нийт		1.7

Нийт гурван хэсгийн байцаагч тутамд (3/1.7) хоёр орон тоо хэрэгтэй байхаар тооцоо гарчээ. Ажлын ачааллыг тооцсон цагдаагийн алба хаагчдаас хэсгийн байцаагч нар хамгийн өндөр ачаалалтай гарсан байна. Жишээлбэл, 5 хэрэг бүртгэгч тутам хоёр, 4 хэсгийн төлөөлөгч тутамд 2 орон тоо нэмэх шаардлагатай гэж гарсан бол 3 хэсгийн байцаагч тутам 2 орон тоо нэмэх шаардлагатай гэж гарчээ.

Цагдаагийн ажилтан С.Динагийн боловсруулсан ба нэг аргачлалаар бодвол 2020 оны 9 дүгээр сарын байдлаар нийслэлийн Баянгол дүүргийн таван хэсгийн байцаагчийн ачаалал нь 8.3 байцаагчийн, Орхон аймгийн таван хэсгийн байцаагчийн ачаалал (11 дүгээр сарын байдлаар) 6.2 байцаагчийн хэвийн ачаалалтай тэнцэж байна гэж гарчээ.

2020 оны 9 дүгээр сарын 29-ний мягмар гарагт авсан судалгаанд хамрагдсан нийслэлийн хэсгийн 38 байцаагч, орон нутгийн 27 байцаагчийн 11 дүгээр сарын 4-ны өдрийн ажлын цагийг ямар ажилд голчлон зарцуулсанд зураг авалт хийх байдлаар ажиглалтын аргыг хэрэглэн явуулсан судалгааны үр дүнг дараах байдлаар нэгтгэж үзье.

Y - хамаарах хувьсагчууд буюу хэсгийн байцаагчийн ажлын цагийн бодит ачаалал;

X - үл хамаарах хувьсагч-хүчин зүйлийн шинж тэмдгүүд буюу хэсгийн байцаагчийн тодорхой ажилд зарцуулж буй бодит цаг;

Y* - хамаарах хувьсагчууд буюу хэсгийн байцаагчийн ажлын цагийн боломжит ачаалал;

X* - үл хамаарах хувьсагч-хүчин зүйлийн шинж тэмдгүүд буюу хэсгийн байцаагчийн тодорхой ажилд зарцуулах боломжит цаг.

Хүснэгт №6

№	Шинж тэмдэг	Цагийн бодит ачаалал	Цагийн боломжит ачаалал
1	2	3	4
1	Үүрэг чиглэл авах	X_1	X_1^*
2	Өргөдөл, гомдол, зөрчил гаргагчийг хүлээн авах	X_2	X_2^*
3	Хорооны Засаг даргатай уулзах, хамтарсан багийн хуралд оролцох	X_3	X_3^*
1	2	3	4
4	Аж ахуйн нэгж, байгууллагад мэдэгдэл, шаардлага өгөх	X_4	X_4^*
5	Бүртгэл судалгаа	X_5	X_5^*
6	Рапортанд суух	X_6	X_6^*
7	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	X_7	X_7^*
8	Зөрчил, дуудлага шалган шийдвэрлэх	X_8	X_8^*
9	Эргүүл, шалгалт явуулах	X_9	X_9^*
10	Эрэн сурвалжлах	X_{10}	X_{10}^*
11	Санд материал шивэх	X_{11}	X_{11}^*
12	Илтгэх хуудас, танилцуулга бичих	X_{12}	X_{12}^*
Дундаж үзүүлэлт		$\bar{X}$	$\bar{X}^*$

Хэсгийн байцаагчийн ажлын ачааллыг бууруулах коэффициент:

$$K = \frac{Y}{Y^*} \text{ томъёо (1)}$$

Бидний нийслэлийн 38 хэсгийн байцаагчаас авсан судалгаагаар:

$$Y = X_1 + X_2 + X_3 + X_4 + X_5 + X_6 + X_7 + X_8 + X_9 + X_{10} + X_{11} + X_{12} = 677.8 \text{ минут}$$

Үндсэн цаг 40 + боломжит цаг 10 = 50 цаг гэж тооцоолж үзвэл Хөдөлмөрийн тухай хуульд заасан нэг өдрийн 8 цаг дээр нэмж 2 цаг нэмж ажиллах боломжтой гэж үзээд 7 хоногийн боломжит цаг 10, нийтдээ 50 цаг ажиллах боломжтой гэж үзлээ. Тиймээс хэсгийн байцаагчдын нэг өдрийн ажлын бодит цаг 13.48 цагийг боломжит цаг 10 –т хувааж, гарсан тоог тодорхой ажиллагааны цагт хувааснаар ажлын ачааллыг бууруулах коэффициентийг гаргаж авсан болно.

$$K = \frac{677.8}{600} = 1.13$$

$$Y^* = X_1^* + X_2^* + X_3^* + X_4^* + X_5^* + X_6^* + X_7^* + X_8^* + X_9^* + X_{10}^* + X_{11}^* + X_{12}^* \\ = 600 \text{ минут буюу } 1 \text{ өдөрт } 10 \text{ цаг ажиллахаар тооцоолсон.}$$

Нийслэлийн 38 хэсгийн байцаагч нарын ажлын ачааллын судалгаа
/2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн байдлаар/

Хүснэгт №7

№	Хэсгийн байцаагчийн дугаарлалт	Харьяалах цагдаагийн хэлтэс	Үүрэг чиглэл авах	Өргөдөл, гомдол, зөрчил гаргагчийг хүлээн авах	Хорооны Засаг даргатай уулзах, хамтарсан багийн хурал	А.А.Н.Б-д мэдэгдэл, шаардлага өгөх	Бүртгэл судалгаа	Рапорганд суух	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Зөрчил, дуудлага шалган шийдвэрлэх	Эргүүл, шалгалт явуулах	Эрэн сурвалжлах	Санд материал шивэх	Илтгэх хуудас, таницуулга бичих	Бүгд
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
1	Хэсгийн байцаагч-1	БГД I	90	30		60		75		460		40		10	765
2	Хэсгийн байцаагч-2	БГД I	90	30		60		75		410	40		40	10	755
3	Хэсгийн байцаагч-3	БГД I	90	40		60		75		380			40	10	695
4	Хэсгийн байцаагч-4	БГД II	80		65		45		30	120	210		25	15	590
5	Хэсгийн байцаагч-5	БГД II	60	120			30			360					570
6	Хэсгийн байцаагч-6	БНД	30					90		210	420	65			815
7	Хэсгийн байцаагч-7	БНД	30	35	10			90		320	60	35		10	590
8	Хэсгийн байцаагч-8	БНД	30	90	120		30	60	60	180		60	30		660
9	Хэсгийн байцаагч-9	БЗД I	90	30		180				390				60	750
10	Хэсгийн байцаагч-10	БЗД I	45	15	30	90				135	90		30	30	465
11	Хэсгийн байцаагч-11	БЗД I	45	15	30				320	450		60	30		950
12	Хэсгийн байцаагч-12	БЗД III	90	30				60		450		240			870
13	Хэсгийн байцаагч-13	БХД	10	65	60	130		40	20	165				30	520
14	Хэсгийн	СХД I	20	30		140	50			320	30		30	40	660

	байцаагч-14														
15	Хэсгийн байцаагч-15	СХД I	20	30	20		120		140	240	70		30	50	720
16	Хэсгийн байцаагч-16	СХД I	30	30					120	300			40	150	670
17	Хэсгийн байцаагч-17	СХД II	30	70				60	30	450	60	15			715
18	Хэсгийн байцаагч-18	СХД II	105	70				60		430	60				725
19	Хэсгийн байцаагч-19	СХД II	40	90						510	120		20		780
20	Хэсгийн байцаагч-20	СХД III	30	30	60					420	20		30		590
21	Хэсгийн байцаагч-21	СХД III	30	10		90		60		300	120	45			655
22	Хэсгийн байцаагч-22	ЧД I	30	30				30		540				30	660
23	Хэсгийн байцаагч-23	ЧД I	60	120					60	420				30	690
24	Хэсгийн байцаагч-24	ЧД I	30	60	25	45			50	460			20		690
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
25	Хэсгийн байцаагч-25	ЧД II	35	30	40	40	60		60	335	40		60	40	740
26	Хэсгийн байцаагч-26	СБД I	40	30		190			130	340	10			15	755
27	Хэсгийн байцаагч-27	СБД I	80	20		120				415				20	655
28	Хэсгийн байцаагч-28	СБД II	30						310	370		30		20	760
29	Хэсгийн байцаагч-29	СБД II	60	40		180	30		60	450				20	840
30	Хэсгийн байцаагч-30	СБД II	60	90		130	70			430				10	790
31	Хэсгийн байцаагч-31	Налайх ЦХ	30		10			90	180	390	120		80		900
32	Хэсгийн байцаагч-32	Налайх ЦХ	30					60	250	320	100		50		810
33	Хэсгийн байцаагч-33	ХУД I	30		20			40		370	150		180	-	790
34	Хэсгийн байцаагч-34	ХУД I	60	30	120	120				120	180		30	90	750
35	Хэсгийн байцаагч-35	ХУД I	60						120	390	60			20	650
36	Хэсгийн байцаагч-36	ХУД II	20	130						600	120			10	880
37	Хэсгийн байцаагч-37	ХУД II	25	20	15		60		60	365	90			10	645
38	Хэсгийн байцаагч-38	ХУД II	20	130						480	120			10	760
Хэсгийн байцаагчдын нийт ажилласан цаг			1605	1530	625	1515	495	815	2000	12925	2250	550	725	720	25755
Нэг хэсгийн байцаагчийн ажилласан дундаж цаг			42.2	40.3	16.4	39.9	13.0	21.4	52.6	340.1	59.2	14.5	19.1	18.9	677.8

Тодорхой ажилд зарцуулсан цагийн нийт цагт эзлэх хувь	6.2	5.9	2.4	5.9	1.9	3.2	7.8	50.2	8.7	2.1	2.8	2.8	100.0
Нэг хэсгийн байцаагчийн ажиллах боломжит цагийг 10 гэж тооцвол Ү*													600
Хэсгийн байцаагчийн тодорхой ажилд зарцуулах боломжит цагийн тооцоолол Х*	37.4	35.6	14.6	35.3	11.5	19.0	46.6	301.1	52.4	12.8	16.9	16.8	600.0
Хэсгийн байцаагчийн тодорхой ажилд зарцуулах боломжит цагаас илүү зарцуулсан хэмжээ Ү-Ү*	4.8	4.6	1.9	4.6	1.5	2.5	6.0	39.0	6.8	1.7	2.2	2.2	77.8

Орон нутгийн 28 хэсгийн байцаагч нарын ажлын ачааллын судалгаа

/2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн байдлаар/

Хүснэгт №8

№	Хэсгийн байцаагчийн дугаарлалт	Харьяалах цагдаагийн хэлтэс	Үүрэг чиглэл авах	Өргөдөл, гомдол, зөрчил гаргагчийг хүлээн авах	Хорооны Засаг даргатай уулзах, хамтарсан багийн хурал	А.А.Н.Б-д мэдэгдэл, шаардлага өгөх	Бүртгэл судалгаа	Рапортанд суух	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Зөрчил, дуудлага шалган шийдвэрлэх	Эргүүл, шалгалт явуулах	Эрэн сурвалжлах	Санд материал шивэх	Илтгэх хуудас, танилцуулга бичих	Бүгд
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
1	Хэсгийн байцаагч-1	Архангай ЦГ	20	140	165			120		240		60		60	805
2	Хэсгийн байцаагч-2	Дархан-Уул ЦГ	30	60	60	120	60	60	60	120			30	30	630
3	Хэсгийн байцаагч-3	Дархан-Уул ЦГ	30	60	60	120	60	60	60	120			30	30	630
4	Хэсгийн байцаагч-4	Дархан-Уул ЦГ	30	30	130	50	60	90	120	100					610
5	Хэсгийн байцаагч-5	Дархан-Уул ЦГ	10	35	65	60	105	60	60	120		30	40		585
6	Хэсгийн байцаагч-6	Дархан-Уул ЦГ	30	60	60	120	60	60	60	120			30	30	630
7	Хэсгийн байцаагч-7	Дархан-Уул ЦГ	30	60	60	120	60	60	60	120	60		30	30	690
8	Хэсгийн байцаагч-8	Дархан-Уул ЦГ	30	60	60	120	60	60	60	120			30	30	630
9	Хэсгийн байцаагч-9	Дархан-Уул ЦГ	40	220	50	120	60	50	60	120			30	30	780

10	Хэсгийн байцаагч- 10	Дархан- Уул ЦГ	30	60	60	120	60	60	60	120				60	630
11	Хэсгийн байцаагч- 11	Дархан- Уул ЦГ	15	10	30	40	180	40		35		30	30	60	470
12	Хэсгийн байцаагч- 12	Дархан- Уул ЦГ	25	60	55	110	50	55	55	110			30	30	580
13	Хэсгийн байцаагч- 13	Дархан- Уул ЦГ	30	10	20	40	120	45	105	65				70	505
14	Хэсгийн байцаагч- 14	Дархан- Уул ЦГ	25	25	70	120	70	50	90	180		40	30	30	730
15	Хэсгийн байцаагч- 15	Дархан- Уул ЦГ	15	10	70	10	275	40		75	30				525
16	Хэсгийн байцаагч- 16	Орхон ЦГ	80	20	85	40	20	150	420	480	300	40	80	10	1725
17	Хэсгийн байцаагч- 17	Орхон ЦГ	30	25	100	60	60	150	180	180					785
18	Хэсгийн байцаагч- 18	Орхон ЦГ	30	20	60	60	60	60	180	180					650
19	Хэсгийн байцаагч- 19	Орхон ЦГ	30	20	85	40	20	90	420	480	300	40	30	10	1565
20	Хэсгийн байцаагч- 20	Орхон ЦГ	30	10	65	55	180	30	60	30		10	20		490
21	Хэсгийн байцаагч- 21	Орхон ЦГ	10	10	50	130	110	60	60	120			30		580
22	Хэсгийн байцаагч- 22	Орхон ЦГ	30	10	50	25	120	40	120	120		60	30	30	635
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
23	Хэсгийн байцаагч- 23	Орхон ЦГ	20	20	70	120	120	60	180	60		150	30	10	840
24	Хэсгийн байцаагч- 24	Орхон ЦГ	30	10	50	30	30	40	60	60	180	20	30	90	630
25	Хэсгийн байцаагч- 25	Орхон ЦГ	10	10	35	110	180	60	150	30	180	120	30	30	945
26	Хэсгийн байцаагч- 26	Орхон ЦГ	20	30	30	90	130	40	200	50	180	120	60	50	1000
27	Хэсгийн байцаагч- 27	Хэнтий ЦГ	60		30		60	60		480			15	10	715
28	Хэсгийн	Хэнтий	30	60	30		60	50	60	470	180		30	30	1000

	байцаагч-28	ЦГ													
Хэсгийн байцаагчдын нийт ажилласан цаг			750	945	1530	1910	2370	1620	2880	4145	1410	660	665	670	19555
Нэг хэсгийн байцаагчийн ажилласан дундаж цаг			19.7	24.9	40.3	50.3	62.4	42.6	75.8	109.1	37.1	17.4	17.5	17.6	514.6
Тодорхой ажилд зарцуулсан цагийн нийт цагт эзлэх хувь			2.9	3.7	5.9	7.4	9.2	6.3	11.2	16.1	5.5	2.6	2.6	2.6	75.9
Нэг хэсгийн байцаагчийн ажиллах боломжит цагийг 10 гэж тооцвол Y*															600
Хэсгийн байцаагчийн тодорхой ажилд зарцуулах боломжит цагийн тооцоолол X*			17.5	22.0	35.6	44.5	55.2	37.7	67.1	96.6	32.8	15.4	15.5	15.6	600.0
Хэсгийн байцаагчийн тодорхой ажилд зарцуулах боломжит цагаас илүү зарцуулсан хэмжээ Y-Y*			2.3	2.9	4.6	5.8	7.2	4.9	8.7	12.5	4.3	2.0	2.0	2.0	77.8

Хоёр. Багаар ажиллах зохион байгуулалтын хэлбэр.

Нийслэлийн дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдэд хороо хариуцсан мөрдөгч, эрүүгийн мөрдөгч ажилладаг боловч бүгд хэлтсийнхээ төв байранд ажилладаг нь хороо хариуцсан алба хаагчдын ажлын уялдаа холбоо хангалтгүй байх нэг хүчин зүйл болжээ. Тиймээс хороо хариуцсан эрүүгийн мөрдөгч, мөрдөгч, зөрчлийн хэрэг бүртгэгч нарыг цагдаагийн хэсгийн байранд хэсгийн байцаагч, цагдаа, олон нийтийн цагдаагийн ажилтан нартай хамтад нь байрлуулах замаар хамтран нэг баг болж ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлмээр байна.

Цагдаагийн хэсэгт хамтран ажиллах багт дараах алба хаагчид орж байна. Үүнд:

- хэсгийн ахлах байцаагч;
- хэсгийн байцаагч;
- хэсгийн туслах байцаагч;
- эрүүгийн мөрдөгч;
- мөрдөгч;
- зөрчлийн хэрэг бүртгэгч;
- олон нийтийн цагдаа зэргээс бүрдэх юм.

Одоо ажиллаж байгаа хэсгийн цагдаагийн оронд хэсгийн байцаагчийн туслах гэсэн албан тушаалыг шинээр оруулж байгаа бөгөөд бусад алба хаагчид нь өнөөдөр дүүрэгтээ сууж, өөр өөрсдийн үүргээ гүйцэтгэж байна. Хэсгийн ахлах байцаагч нь хэсгийн нийт алба хаагч нарыг удирдан гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах ажил, арга хэмжээг зохион байгуулах, нутгийн захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран зохион байгуулах ажил, арга хэмжээг зохицуулах үүрэгтэй ажиллана.

Хамтарсан багаар ажиллах хэлбэрийг хороо дундын цагдаагийн хэсэг байгуулах замаар шийдвэрлэх нь илүү оновчтой болохыг цагдаагийн хэсэг, дэд хэсэг ажиллаж байгаа одоогийн практик харуулж байна.

Зохион байгуулалтын дээрх хоёр хувилбар юуны өмнө нийслэл болон Дархан-Уул, Орхон аймгийн төвийн хороодод хамаарах бөгөөд тэгэхдээ хоёр хувилбарын аль нэгийг сонгох замаар хэрэгжүүлэх нь зүйтэй, өөрөөр хэлбэл энэ хувилбар зэрэгцэн оршино гэж тооцож байна. Мөн эрүүгийн

болон хэв журмын нөхцөл хүнд, төвөөс алслагдсан зарим нутаг дэвсгэрийг сонгож дээрх хувилбарыг туршиж үзэх ажлыг хойш тавилгүй хийх цаг болсон гэж үзэж байна.

Цагдаагийн хэсгийн тоо цаашид нэмэгдэх нь зайлшгүй болж байна. Тиймээс хэсгийн байрны талаар саналаа бид төлөвлөсөн юм.

Цагдаагийн хэсгийн шинэ байрны бүдүүвч зургийг олон талаас нь бодож төсөл маягаар гаргалаа. Энэхүү хэсгийн байр нь ойролцоогоор 119.92 м² талбай буюу нэг алба хаагч дунджаар 19.98 м² талбай ногдохоор бодсон. Цагдаагийн хэсгийн шинэ байрны бүдүүвч зураглалын зарим онцлог, давуу талуудыг авч үзвэл:

- иргэдийг хүлээн авч уулзах, урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ зохион байгуулах, хууль зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх зориулалт бүхий хурлын бичил танхимтай;
- алба хаагч нартай уулзахаар хүлээж буй иргэдийн тав тухтай орчныг бүрдүүлэх зорилгоор төв хэсгийг тохижуулсан байх;
- эрүүгийн мөрдөгчийн ажлын онцлогоос хамаарч өрөөндөө дотор ба гадна талаас орж гарах хаалгатай байх;
- алба хаагчид цайны цагаараа амрах, хоол унд хийх боломжтой амралтын өрөөтэй;
- түр саатуулах байр гаргаж, хэсгийн туслах байцаагчийн хажуу өрөөнд хяналт тавих боломжтой шилэн цонх бүхий өрөөтэй;
- зоорины давхарт автомашин байрлах гарааш, хураан авсан эд зүйл хадгалах өрөө, архивын өрөөтэй байвал зүгээр гэж тооцсон.

Хэсгийн байрны аюулгүй байдлыг хангах зорилгоор цонх нь хамгаалалттай, байр нь дохиоллын хамгаалалттай, галын аюулгүй байдлын дохиоллын систем болон унтраах хэрэгслийг өрөө бүрт байршуулж, камераар тоноглогдсон байна.

Хэсгийн байр нь цахилгаан, дулаан, агааржуулалтын систем, усан хангамж, сантехникийн шугам сүлжээнд холбогдсон байхаар тооцсон болно.

Цагдаагийн хэсэг бүр мэдээллийн самбартай байна. Мэдээллийн самбар нь цагдаагийн хэсэг үйл ажиллагаагаа сурталчлах, иргэдтэй холбоо тогтоох, нөгөө талаараа ажлын ачааллыг бага боловч бууруулах, шаардлагатай мэдээллийг иргэдэд хүргэхэд нөлөө үзүүлнэ гэж үзэж байна. Цагдаагийн хэсгийн мэдээллийн самбарт дараах агуулга бүхий мэдээллүүдийг багтаасан байна. Үүнд:

- цагдаагийн хэсгийн байранд ажиллаж байгаа алба хаагчдын нэр, цол, албан тушаал, утасны дугаар;
- хэсгийн байцаагчийн ажлын цагийн хуваарь;
- иргэдийг хүлээн авч уулзах өдөр ба цаг;
- иргэдээс өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах журмын мэдээлэл;
- нутаг дэвсгэрийн зураг /нутаг дэвсгэрийн хил хязгаарыг тэмдэглэсэн карт схем ба зураглал/;
- эрэн сурвалжлагдаж буй этгээд болон эд зүйлийн талаарх мэдээлэл.

Мэдээллийн самбар доторх мэдээллийн агуулгыг долоо хоног бүр шинэчилж байх шаардлагатай бөгөөд самбарын ашиглалтад хэсгийн ахлах байцаагч хяналт тавьж ажиллана.

Өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”¹³-т шаардлагатай эд зүйлийн жагсаалт тусгаагүй байдаг.

Монгол Улсын Засгийн газрын 1992 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн “Цагдаагийн байгууллагын хэсгийн төлөөлөгч, байцаагч нарын ажлын нөхцөлийн тухай” 43 дугаар тогтоолд “Цагдаагийн байгууллагын сум, хороо хариуцсан хэсгийн төлөөлөгч, байцаагч нарыг албан ажлаа явуулахад нь шаардагдах ажлын байр, тээврийн хэрэгслээр хангах, цахилгаан, дулааны зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх, хойшлуулшгүй ажилд хэрэглэх шатахууны лимит тогтоож олгох,

¹³ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. УБ., 2008. 425-430 дахь тал

хариуцсан дэвсгэрт нь байр, сууцаар хангах арга хэмжээ авах”¹⁴; Засгийн газрын 2000 оны 6 дугаар сарын 21-ны өдрийн “Цагдаагийн байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” 94 дүгээр тогтоолд “Сум, хороонд ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчийн эхнэр (нөхөр)-ийг ажлын шаардлагаар цагдаагийн туслах ажилтнаар хуульд нийцүүлэн томилон ажиллуулбал уг алба хаагчийн сарын үндсэн цалингийн 50 хүртэл хувьтай тэнцэх хэмжээгээр сар тутам цалинжуулж байх, цагдаагийн алба хаагчдын цалин урамшууллыг нэмэгдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах нөхцөл бололцоог сайжруулах, уналга, холбоо, техник хэрэгслээр хангах арга хэмжээг жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлж байх”¹⁵-ыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгажээ. Гэвч Засгийн газрын тогтоолын дээрх заалт хэрэгжиж чадаагүй байна.

Нийслэл, аймагт Засаг даргын дэргэдэх цагдаагийн газар, хэлтэс гэж байсныг 2013 оны Цагдаагийн албаны тухай хуулиар төвлөрсөн удирдлагатай болгон нийслэл, аймаг дахь цагдаагийн газар, хэлтэс болгосноор цагдаагийн газар, хэлтсийн төсөв аймаг, нийслэлийн төсвөөс ЦЕГ-ын төсөвт шилжиж Засгийн газрын дээрх заалтууд биелэхэд нэг саад болсон. Өөрөөр хэлбэл төсөвтэй харьцдаггүй байгууллагад аймаг төсвөөсөө зарцуулах боломж хязгаарлагдмал байна.

Хэсгийн байцаагчид байвал зохих байр, тээврийн хэрэгсэл, техник тоног төхөөрөмж, тавилга, эд зүйлийн жагсаалт болон ашиглалтын жишиг нормативыг Засгийн газраар батлуулбал шаардагдах төсөв хөрөнгийг төсөвт тусгах боломж нэмэгдэнэ. Хэсгийн байранд ажиллах нийт алба хаагчдад байвал зохих техник хэрэгсэл нь нэг улсад үйлдвэрлэсэн, ижил үзүүлэлт бүхий хүчин чадалтай байх, эд зүйл нэг ижил загварын байх, мөн ашиглалтын хугацааг болон стандарт тогтоож өгөх замаар шаардлага хангахгүй техник хэрэгсэл, эд зүйлсээр хангахыг таслан зогсоох боломжтой.

2019 оны байдлаар нийслэлийн нийт хэсгийн байцаагч нарын 31 буюу 20.9 хувь нь албаны компьютер байхгүй, 66 буюу 44 хувь нь принтер /хувилагч/ байхгүй, ашиглагдаж байгаа компьютер, принтерийн 90 хувь нь 5-аас дээш жил ашиглагдаж, ашиглалтын хугацаа дууссан байна.

Цагдаагийн хэсгийн байранд байвал зохих эд зүйл, техник хэрэгслийн жагсаалтыг гаргаж, ашиглалтын хугацааг заан өгч баталгаажуулах нь ажлын таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх, улмаар ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ гэж үзсэн болно.

Гурав. Иргэний бүртгэлийг цагдаагийн байгууллагад хариуцуулах.

1940 оны 12-р сарын 13-ны өдөр Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 67 дугаар тогтоолоор баталсан дүрэм, заавар ёсоор Цагдан сэргийлэх байгууллагын паспортын албаны ажилтан нь иргэний паспорт олгох, солих, бүртгэх, хасах болон дүрэм зааврын биелэлтэд хяналт тавих, паспортын журам зөрчигсдөд хариуцлага хүлээлгэх, тусгай дэглэм тогтоосон бүс нутгаас зайлуулах хүмүүсийн материал бүрдүүлж зайлуулах, иргэний паспорт гээгдүүлэх, үрэгдүүлэх явдлыг бүртгэж шийдвэрлэх, хүчингүй паспортыг устгах, хаяг лавлагааны ажлыг эрхлэх, эрэн сурвалжлаг явуулах зэрэг хэм хэмжээг тогтоож хэрэгжүүлжээ.¹⁶

“Иргэний бүртгэл, мэдээллийн ажлыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1990 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 304 дүгээр тогтоолоор Төлөвлөгөө, эдийн засгийн улсын хорооны хүн амын регистрийн товчоо, Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын харьяа Паспортын хэлтэс, Иргэний баримт бичгийн төв архивыг нэгтгэн “Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв” байгуулж, Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрын харьяанд ажиллуулахаар тогтоожээ.

1992 онд ажлын ачаалал, шаардлагыг харгалзан тус төвд гадаадын иргэдийг бүртгэх хэлтэс, мөн Улаанбаатар хотын дүүргүүдийн хэлтсийн гадаад паспортын хэсгүүдийг нэгтгэж, Улаанбаатар хотын цагдаагийн газарт хотын паспорт, бүртгэлийн хэлтсийг шинээр байгуулж ажиллуулжээ.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 1993 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 108 дугаар тушаалаар Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвд гэмт хэрэг үйлдэгчид, олон нийтийн хэв журмын

¹⁴ <https://www.legalinfo.mn/law/details/5518?lawid=5518>

¹⁵ <https://www.legalinfo.mn/law/details/5529?lawid=5529>

¹⁶ Думбурай.А. Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжил. /I дэвтр/. Уб.,1999. 168 дахь тал

зөрчлийн тоо бүртгэл, мэдээллийг хариуцсан тавдугаар хэлтэс байгуулан, төвийн орлогч дарга нь энэ хэлтсийн дарга байхаар тогтоожээ.¹⁷

Монгол Улсын Засгийн газрын 1996 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн “Тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 279 дүгээр тогтоолоор Иргэний бүртгэл мэдээллийн албыг ЦЕГ-ын бүтцээс гарган Хууль зүйн яамны харьяа болгосон байна.¹⁸ Иргэний бүртгэлийг цагдаагийн хэсэг хариуцдаг байх нь илүү ашигтай, оновчтой хувилбар гэж үзэж байна. Энэхүү ажлыг цагдаагийн хэсэг хариуцан иргэний үнэмлэх, төрсөн, нас барсан, гэрлэсэн, гэр бүл цуцалсан зэрэг иргэний бүртгэлийг хөтлөхийн зэрэгцээ хүн амын шилжилт хөдөлгөөнийг хянаж, дараах бүртгэлийг хийж ажиллах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

- хот, аймаг болон аймаг хоорондын шилжилт хөдөлгөөн;
- дүүрэг хоорондын шилжилт хөдөлгөөн;
- сум хоорондын шилжилт хөдөлгөөн;
- дүүрэг дотор хороо хоорондын шилжилт хөдөлгөөн;
- түр оршин суугчдын бүртгэл;
- оршин суух хаяг байхгүй байгаа хүмүүсийн бүртгэл.

Дүгнэлт. Хүн амын бүртгэлийг нарийвчлан үнэн зөв хийх нь эдийн засаг, нийгмийн олон талын ашигтай нь эргэлзээгүй. Паспорт, иргэний бүх төрлийн бүртгэл, манай улсын иргэд хувийн хэргээр гадаадад зорчих ажлыг анх буй болсон цагаас нь эхлээд цагдаагийн байгууллага олон ажил хариуцаж ирсэн туршлага бий бөгөөд үүнийг хийхэд хүндрэл гарахгүй.

БНХАУ, ОХУ зэрэг дэлхийн олон улсад иргэний бүртгэл, хөдөлгөөнийг цагдаагийн байгууллага эрхэлдэг туршлага бий.

Хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхийн тулд зохион байгуулалтын зарим шинэ хэлбэрийг нэвтрүүлэх боломжийг судлах шаардлагатай байна.

¹⁷ Пүрэв.Б. Монгол Улсын Засгийн газрын дэргэдэх цагдаагийн байгууллага. Уб., 2016. 41-42 дахь тал

¹⁸ Думбурай.А. Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжил. /II дэвтэр/. Уб.,1999. 320 дахь тал

ЗӨРЧЛИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

А.Амарсайхан
Цагдаагийн сургуулийн
Цагдаагийн эрх зүйн тэнхимийн
эрхлэгч, цагдаагийн хурандаа

Товч агуулга. Энэхүү судалгаагаар хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж дахь холбогдох зохицуулалтын хэрэгжилтийн байдлыг дүгнэхийн зэрэгцээ цаашид хуулийг боловсронгуй болгоход анхаарах саналаа гаргалаа. өгөхийг зорив.

Түлхүүр үгс. Зөрчлийн тухай хууль, зөрчил, асуудал.

Үндсэн хэсэг. Зөрчлийн тухай хуулийн ерөнхий ангийн зүйл хэсэг, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхдээ дараах байдлыг судлан үзэж дүгнэлт саналаа гаргалаа. Үүнд:

- Зөрчлийн тухай хуулийн ойлголт, өнөөгийн байдал,
- Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж дахь холбогдох зохицуулалтын хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийж тулгамдаж байгаа асуудлыг хөндөн гаргах,
- Дээр дурдсан асуудлыг нэгтгэн дүгнэж, цаашид боловсронгуй болгоход санал гаргасан байна.

Хүн бүр өдөр тутам нийгмийн харилцаанд оролцдог бөгөөд хүмүүсийн хоорондын харилцаа, нийгмийн дэг журмыг Монгол Улсын Их хурлаас батлан гаргасан хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмаар зохицуулдаг. Энэ нь иргэн, хуулийн этгээдийг хуулийн мэдлэгтэй байхыг шаарддаг. Иргэн, хуулийн этгээд болон түүний удирдлага өөрийн ажиллаж, үйл ажиллагаа явуулж байгаа салбарын хууль тогтоомж, хэм хэмжээ тогтоосон акт, эрх зүйн баримт бичгийн талаар мэдлэгтэй байх нь тодорхой хэмжээгээр өөрийгөө болон бизнесээ эрсдэлээс хамгаалах боломжийг бидэнд олгож байдаг.

Хууль, тогтоомж зөрчигчдөд хариуцлага хүлээлгэдэг тогтолцоог урьд авч үзэхдээ эрүүгийн хариуцлага, захиргааны хариуцлага гэж ерөнхийд нь ангилж гэмт хэрэгт ял оногдуулж, захиргааны зөрчилд захиргааны шийтгэл хүлээлгэж байжээ.

Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хууль 1992 оны 12 дугаар сарын 15-наас эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр захиргааны албадлагын арга хэмжээ, түүний дотор шийтгэлийн төрөл хэмжээг нарийвчлан тогтоож захиргааны зөрчил гаргасан этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулах болсон юм.

Гэмт хэрэг, зөрчлийг ялгаж заагласан үйлдэлд хүлээлгэх хариуцлага нь хоорондоо уялдаагүйгээс нэг бол эрүүгийн хариуцлага хэмээн ял шийтгэх нэг бол захиргааны хариуцлага хэмээн батлагдсан хууль болгонд торгох шийтгэл тусгаж ирснийг хууль зүйн нэгдсэн бодлогоор цэгцэлж Зөрчлийн тухай хуулийг хууль тогтоогчоос батлан гаргажээ. Түүнчлэн урьд нь үйлчилж байсан 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан зарим гэмт хэрэг, Захиргааны хариуцлагын тухай хууль, бусад хуульд заасан захиргааны зарим зөрчил нь ижил, төстэй байсан бөгөөд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга болон Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар дээрх бэрхшээлийг шийдвэрлэсэн.

Өөрөөр хэлбэл, бусдын өмч хөрөнгөнд халдсан нийгмийн хор аюул багатай үйлдэл, нийгмийн хэв журам зөрчсөн, олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулсан үйлдэл, түүнчлэн дүрэм, журам, норм, стандарт зөрчсөн, эсхүл тодорхой нэрлэн заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэж үзэхээр зохицуулалтыг оруулж ирсэн. Үүнийгээ товчхондоо хүснэгтээр харуулвал:

Ялгаа	Гэмт хэрэг	Зөрчил
Өмнө нь	Эрүүгийн хуулиар зохицуулдаг байсан	Захиргааны хариуцлагын тухай хуулиас гадна 230 гаруй хуулиар зохицуулдаг байсан.
Одоо	Эрүүгийн хуулиар зохицуулна.	Зөрчлийн тухай хуулиар зохицуулна.
Өмнө нь	Захиргааны зөрчлийг хуульчилсан хуулийн заалт нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй давхардсан байсан.	
Одоо	Давхардлыг арилгасан	
Өмнө нь	Иргэд ямар үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэг болохыг Эрүүгийн хуулиас мэдэж болдог	Иргэд, хуулийн ямар үйлдэл, эс үйлдэхүй зөрчил болохыг 230 гаруй хуулиас хайж олж чадвал мэдэж болдог.
Одоо	Иргэд ямар үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэг болохыг Эрүүгийн хуулиас мэдэж болдог	Иргэд ямар үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчил болохыг Зөрчлийн хуулиас мэдэж болдог

Зөрчлийн тухай хуулийн зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино бөгөөд өнөөдрийн байдлаар дараах бүтэцтэй. Үүнд:

1.	Бүлгийн дугаар	Хуулийн бүтэц (бүлгийн дугаар, гарчиг)	Зүйлийн тоо
2.		ЕРӨНХИЙ АНГИ	
3.	Нэгдүгээр бүлэг	Нийтлэг үндэслэл	5
4.	Хоёрдугаар бүлэг	Зөрчил	5
5.	Гуравдугаар бүлэг	Шийтгэл	8
6.	Дөрөвдүгээр бүлэг	Албадлагын арга хэмжээ	5
7.		ТУСГАЙ АНГИ	
8.	Тавдугаар бүлэг	Нийтийн хэв журам, аюулгүй байдлын эсрэг зөрчил	19
9.	Зургаадугаар бүлэг	Нийтийн ёс суртахуун, хүн амын эрүүл мэнд, эрүүл ахуйн журмын эсрэг зөрчил	26 /-1
10.	Долоодугаар бүлэг	Байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчил	17
11.	Наймдугаар бүлэг	Нийтийн өмч, өмчлөх эрхийн эсрэг зөрчил	9
12.	Есдүгээр бүлэг	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны журмын эсрэг зөрчил	12
13.	Аравдугаар бүлэг	Аж ахуйн үйл ажиллагааны журмын эсрэг зөрчил	28
14.	Арваннэгдүгээр бүлэг	Үнэт цаас, банк, санхүү, гааль, татвар, мэргэжлийн хяналт, даатгалын журмын эсрэг зөрчил	32
15.	Арванхоёрдугаар бүлэг	Барилга, үйлдвэрлэл, эрчим хүчний журмын эсрэг зөрчил	12
16.	Арвангуравдугаар бүлэг	Хөдөө аж ахуй, газар тариалангийн талаар тогтоосон журмын эсрэг зөрчил	9
17.	Арвандөрөвдүгээр бүлэг	Мэдээлэл, харилцаа холбоо, тээвэр, тээврийн хэрэгслийн ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг зөрчил	12
18.	Арвантавдугаар бүлэг	Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааны эсрэг зөрчил	32
19.	Арванзургадугаар бүлэг	Монгол Улсын хилийн аюулгүй байдлын болон гадаадын иргэн, харъяалалгүй хүн Монгол Улсад зорчих журмын эсрэг зөрчил	4
20.	Арвандолдугаар бүлэг	Улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг зөрчил	1
21.	Арваннаймдугаар бүлэг	Бусад зүйл	1
22.	18	-	236

Зөрчлийн тухай хуулийн ерөнхий ангийн зүйл хэсэгт хийсэн дүн шинжилгээ:

-Нэгдүгээр бүлэг буюу нийтлэг үндэслэл хэсэгт хуулийн зорилго, зарчим, хууль үйлчлэх нутаг дэвсгэр, хугацаа, хөөн хэлэлцэх хугацааны талаар тусгагдсан.

Хууль ёсны зарчмын хүрээнд зөрчил, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээг зөрчлийн тухай хуулиар тогтоох, хуулийг төсөөтэй хэрэглэхгүй байх зохицуулалт тусгагдсан байна.

Хөөн хэлэлцэх хугацааны талаарх зохицуулалтад хүн 10-500, 500-10000, 10000-20000 торгох шийтгэлийг оногдуулахаар заасан зөрчил үйлдсэнээс хойш зургаан сар, нэг жил, хоёр жил гэсэн хугацаа өнгөрсөн, баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэнээс хойш зургаан сар өнгөрсөн бол шийтгэл оногдуулахгүй байх зохицуулалтыг тусгасан байна.

Мөн зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүй эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй ба зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулах үндэслэлтэй бол хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тухай шийдвэр гарсан өдрөөс эхлэн тоолохоор заажээ.

Хоёрдугаар бүлэгт зөрчил, зөрчил хамтран үйлдэх, шийтгэлээс чөлөөлөх үндэслэл, зөрчил үйлдсэн хугацаа, газрын талаарх зохицуулалтыг тусгасан байна. Энэ бүлэг хүчин төгөлдөр үйлчилж байгаа зөрчил үйлдсэн зохицуулалт байна.

Гуравдугаар бүлэгт шийтгэл оногдуулах үндэслэл, шийтгэл хүлээх хүн, хуулийн этгээд, шийтгэлийн төрөл, зөрчлийн үр дагаврыг арилгах, тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигчид шийтгэл оногдуулах зохицуулалтыг тусгасан.

Дөрөвдүгээр бүлэг буюу албадлагын арга хэмжээ хэсэгт хөрөнгө, орлогыг хураах, шилжүүлэх, зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураах, хохирол, нөхөн төлбөр гаргуулах, албадан эмчлэх, албадан сургалтын талаар тусгагдсан байна.

2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн “Зөрчлийн тухай хууль нь өнөөдрийг хүртэл хугацаанд мөрдөгдөхдөө өөрөө зөрчилтэй байна” хэмээн иргэд төдийгүй хуулийг баталсан УИХ-ын гишүүд ч хэлж байгаа юм. Хатуу чанга гэгдэх Зөрчлийн хуулиас болж иргэд, олон нийтийн дунд хүндрэлүүд гарч ирсээр байсан. Тухайлбал,

-Гэр бүлийн салалт нэмэгдсэн,

-Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй зөрчлүүд нэмэгдсэн,

-Өмнө нь Захиргааны хариуцлагын тухай хуулиар иргэнийг 100-50,000 төгрөгөөр, байгууллага аж ахуйн нэгжийг 50,000-250,000 төгрөгөөр торгох заалттай байсан бол Зөрчлийн хуулиар торгуулийн хэмжээ иргэнийг 10-20000 торгуулийн нэгж буюу 10,000-20,000,000 төгрөгөөр торгох, хуулийн этгээдийг 100-200,000 торгуулийн нэгж буюу 100,000-200,000,000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар хуульчилсан иргэдэд хүндээр нөлөөлж байгааг дурдаж болно.

Мөн Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан Захиргааны хариуцлагын болон бусад 11 хуулиар тогтоосон 231 зөрчлийг шалган, шийдвэрлэж байсан бол Зөрчлийн тухай хуулийг 2017 оны 07 дугаар сарын 01-нээс эхлэн дагаж мөрдсөнөөр хагас жилийн хугацаанд нийт 264 төрлийн зөрчлийг шалган, шийдвэрлэж эхэлсэн нь тэдний ажлын ачааллыг улам бүр нэмэгдүүлсэн байна.

Тэгвэл, хуулийн хэрэгжилт ямар байна вэ?, иргэд болон төрд ямар бэрхшээл тулгарч байна вэ? гэдгийг олон талаас нь судалж шаардлагатай арга хэмжээг тухай бүрд нь авч ажиллах нь зүйтэй.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу хуулийн хэрэгжилтийг дүгнэсэн байдаг.


Зөрчлийн тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд буюу 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас 5.391.342 зөрчилд шийтгэл оногдуулсны 96.9 хувийг хүнд, 3.1 хувийг хуулийн этгээдэд оногдуулсан байна. Дээрх хугацаанд нийт 5.309.421 зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган, торгуулийн шийтгэл оногдуулсан байна.

2020 оны байдлаар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зааснаар 31 байгууллагын 216 орчим нэгжид хамаарах 10011 орчим субъект зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж байна.

Зөрчлийн тухай хууль хэрэгжих хугацаанд тухайн жилд бүртгэгдсэн нийт зөрчлийн 90 дээш хувийг цагдаагийн байгууллага харьяалан шалган шийдвэрлэж ирсэн. Нийт зөрчлөөс:

- 92.4 хувь нь замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих
- 3.3 хувь нь олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах,
- 0.3 хувь нь худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааны журам зөрчих,
- 0.4 хувь нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих,
- 3.6 хувь нь бусад төрлийн зөрчил эзэлж байна.

Цагдаагийн байгууллагын шалган шийдвэрлэсэн зөрчлийг 2018-2020 оны 8 дугаар сарын байдлаар харуулбал:



Нийт 2018 онд-1.698.178, 2019 онд-2.175.825, 2020 оны 8 дугаар сарын байдлаар-1.523.116 зөрчлийг шалган шийдвэрлэжээ.

Зөрчлийн тухай хуулийн дагуу “2017 онд 4337, 2018 онд 10981, 2019 онд 15296 хүнийг баривчилсан байна. Тухайлбал, 2020 оны 11 дүгээр сарын байдлаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчил гаргасан 7571 хүнийг баривчлах шийтгэл ногдуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 2034 буюу 36.9 хувиар тус тус өссөн байна.”¹⁹

2019 онд харьяаллын дагуу шийдвэрлэсэн хэрэгт нийт шийтгэл оногдуулсан 17829 хүнээс 1596 хүн буюу 8.9 хувьд торгох, 16235 хүн буюу 91 хувьд баривчлах шийтгэл тус тус оногдуулжээ. Шүүхээс оногдуулсан 10 шийтгэл тутмын 9 нь баривчлах шийтгэл байна.

Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас ирүүлсэн мэдээллээр хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулсан гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт 3 жилийн дунджаар 81 хувь байгаа боловч, мөнгөн дүнгийн биелэлт 45 хувь байна²⁰.

Хууль хэрэгжих явцад уялдаа холбоог сайжруулах, зарим зүйлсийг өөрчлөх, нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг хууль эрх зүйн хувьд тулгарч болох асуудлууд тулгараад явж байна. Үүнийг шат шатны хууль хяналтын байгууллагууд дүгнээд явж байгаа бөгөөд Зөрчлийн тухай хууль нь 2017 оноос хойш өнөөдрийг хүртэл хугацаанд нийт 28 удаа нэмэлт өөрчлөлт орсон байна.

Дүгнэлт: “... Хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар

¹⁹ ЦЕГ мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба

²⁰ Шүүхийн ерөнхий зөвлөл 2019 оны Шүүхийн үйл ажиллагааны тайлан

шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх зорилго бүхий Зөрчлийн тухай хууль нь 2017 оны 07 дугаар сарын 01-нээс эхлэн мөрдөгдөж эхэлсэн, өнөөдрийн байдлаар 18 бүлэг, 236 зүйлтэй ерөнхий болон тусгай гэсэн 2 ангид хуваагдан мөрдөгдөж байна.

Аливаа хуулийн хэрэгжилтийг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу дүгнэх боломжтой.

Зөрчлийн тухай хуулийн дагуу 2017 онд 4337, 2018 онд 10981, 2019 онд 15296 хүнийг баривчилсан, 2019 онд харьяаллын дагуу шийдвэрлэсэн хэрэгт нийт шийтгэл оногдуулсан 17829 хүнээс 1596 хүн буюу 8.9 хувьд торгох, 16235 хүн буюу 91 хувьд баривчлах шийтгэл тус тус оногдуулсан байна.

Хууль хэрэгжих явцад уялдаа холбоог сайжруулах, зарим зүйлсийг өөрчлөх, нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг хууль эрх зүйн хувьд тулгарч болох асуудлууд тулгараад байна. Үүнийг шат шатны хууль хяналтын байгууллагууд дүгнэж байгаа бөгөөд Зөрчлийн тухай хууль нь 2017 оноос хойш өнөөдрийг хүртэл хугацаанд нийт 28 удаа нэмэлт өөрчлөлт орсон байна.

Санал: Дээрх тоон үзүүлэлтээс торгуулийн шийтгэлийн үр нөлөөг эргэн харах, шийтгэлийн шинэ арга механизм, оновчтой хувилбарыг бий болгох зайлшгүй шаардлагатай. Тухайлбал, торгуулийг цаг хугацаанд нь төлж байгаа тохиолдолд төлбөрийн хэмжээг бууруулах нь хэрэгцээ шаардлага байна.

Ашигласан материал

Монгол хэлээр:

1. Б.Цэдэндамбаа, Ц.Болор-Эрдэнэ., “Зөрчлийн эрх зүй”, УБ., 2019 он.

II . Интернет сайтууд:

1. Монгол улсын Үндсэн хууль. (1992). Хуулийн нэгдсэн портал сайт <https://www.legalinfo.mn/law/details/367?lawid=367>, (2021 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн хандалтаар).
2. Монгол улсын Зөрчлийн тухай хууль, (2017). Хуулийн нэгдсэн портал сайт <https://www.legalinfo.mn/law/details/12695?lawid=12695> (2021 оны 5 дугаар сарын 01-05-ны өдрийн хандалтаар).
3. <http://eagle.mn/r/42099> eagle.mn сайт (2021 оны 5 дугаар сарын 01-05-ны өдрийн хандалтаар).
4. <http://www.judoinstitute.mn/statistic/> Шүүхийн ерөнхий зөвлөлийн сайт (2021 оны 5 дугаар сарын 01-05-ны өдрийн хандалтаар).
5. <https://information.police.gov.mn/a/5067> Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны сайт (2021 оны 5 дугаар сарын 01-05-ны өдрийн хандалтаар).

ОХУ, БНХАУ-ЫН ГАДААД БОДЛОГО МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ

Цагдаагийн хурандаа А.Баасанцэрэн

Дотоод хэргийн их сургууль

Монгол улс цахим шуудан:

baadnaa_22@yahoo.com

Товчлол. ОХУ, БНХАУ-ын гадаад бодлого Монгол улсад сүүлийн 20 гаруй жил хэрхэн нөлөөлж байгаа, Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын өнөөгийн байдал зэргийг тусгасан.

Түлхүүр үг: Монгол улсын гадаад бодлого, Үндэсний аюулгүй байдал, ОХУ, БНХАУ-ын гадаад бодлого Монгол улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх нь.

1. Монгол улсын гадаад бодлого.

Монгол улс ардчилал шинчлэл зам шилжин орж 1994 оны 6-р сарын 30-нд батлагдаж байсан бол, МУ-ын Их хурлын 2011 онд шинэчлэн батлагдаж эдүүгээ 20 гаруй жилийг үзэж байна “Монгол Улс гадаад улс төрийн бодлогоо хэрэгжүүлэхдээ баримтлах чиглэлийн **нэгдүгээрт** “ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны эн тэргүүний зорилт мөн.” гээд “Монгол Улсын гадаад бодлогын **хоёр дахь** чиглэл бол өрнө, дорнын өндөр хөгжилтэй, хүчирхэг гүрнүүдтэй найрсаг харилцаа хөгжүүлэх явдал мөн. Энэ зорилтын хүрээнд АНУ-тай улс төрийн утгаар чухал түншийн хэмжээнд харилцана. Японтой Ази дахь гол түнш байхаар харилцана, Европт Европын холбоо бүхэлдээ, түүний дотор ХБНГУ-тай харилцахад түлхүү анхаарна, Монгол Улс бие даасан гадаад бодлого явуулах үзэл баримтлалын үндэс нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд дурдсанчлан “Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын үзэл бодлын үндэс нь эх оронч үндэсний үзэл байна” гэж тодорхойлсон заалт юм²¹. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд Эвсэлд үл нэгдэх, Хоёр хөрштэй эн тэнцүү харилцах, Гуравдахь хөршийн харилцаа чухал зарчимуудыг тусгасан байна.

1.Эвсэлд үл нэгдэх зарчим

Эвсэлд үл нэгдэх гэдэг ойлголтыг бид одоо бол нэлээн бүдгэрсэн гэж хэлж болохоор “эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн”-тэй заримдаа хутгаж ухаарах нь бий. Гэтэл уг ойлголт маань тэр хөдөлгөөнөөс арай өөр. Тодорхойхон хэлбэл “цэрэг улс төрийн эвсэлд нэгдэхгүй” гэсэн санаа юм. Сүүлийн үед Шанхай хамтын ажиллагааны байгууллагад элсэх тухай нэлээлд яригдаж байгаа өнөө үед элсэх нь ашигтай ашиггүй гэх мэтээр нэлээд яригдаж байна.

2. Хоёр хөрштөйгөө эн тэнцүү харилцах зарчим

Хоёр хөрштэйгээ эн тэнцүү, эрх тэгш харилцана гэсэн ойлголт одоо бидэнд байгаа. Энэ бол өмнөх үе буюу 1960-аад оноос хойш, 80-аад оны шувтарга хүртэлх үеийн үйл явдал, сургамжтай холбоотой. Бид тэр үед өмнөд хөрштэйгээ лав л 25 жил муудалцаж, толхилцож, үзэл суртлаар бие биеэ муулж, үгийн муухайгаар занаж зүхэж явсан. Нөгөө талд нь хойд ах нарынхаа өвөрт улам бүр л шигдээд байсан, Хоёр хөрштөйгөө харилцаагаа жигнээд, цэгнээд үзэхэд чухамдаа эн тэнцүү байна уу гэхээр бас л янз бүрийн юм яримаар. Улс төрийн хувьд яахав юм шиг. Нөгөө эдийн засгийн харилцаа гэдгээ, тэх тусмаа хөрөнгө оруулалт талаас нь ярих юм бол эн тэнцэх битгий хэл огт өөр, ерөөсөө хоёр шал ондоо тоо, үзүүлэлт харагдахаар шахуу тийм байдалтай байна. Одоогоор хоёр хөршийн худалдаа экспортын тэнцэл БНХАУ-тай 90 хувь, ОХУ-тай 10 хүрэхгүй хувьтай байна.

²¹ Академич П.Очирбат /Монгол Улсын анхны Ерөнхийлөгч, Монгол Германы Чуулганы тэргүүн/ Монгол улсад гадаад бодлогын үзэл баримтлалын 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хуралд хэлсэн үгнээс.

Монгол улс нь ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ. Чингэхдээ энэ хоёр улстай харилцаж ирсэн түүхэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзах,²² гэж заасан байна.

3. “Гуравдахь хөрш”-ийн зарчим

Онцолж ярих ёстой нэг зүйл бол гуравдахь хөршийн асуудал. Ер нь 1990-ээд оны эхнээс 2000 он гартал шилжилтийн гэгдэх 10-12 жилийн хоорондох үнэнхүү хүнд нөхцөл байдлыг даван туулах үед “гуравдахь хөрш” гэж бөөнд нь нэрлэсэн тэр улсууд, тэр улсуудын идэвхитэй оролцож байдаг олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагууд бидний хувьд гачаал зовлонгоос аврах хүчин зүйл болсон. Тэр үүднээсээ 3 юмыг байтугай, 2 юмыг ч зэрэг, давхарлуулаад биччихэж болдоггүйн адил нэгдүгээрт хоёр хөрш, дараачийн дугаарт гуравдахь хөрш гэж бичихээс өөр аргагүй байсан. Гуравдахь хөршийн бодлого маань шилжилтийн үеийг туулах гадаад бодлогын хувьд хоёр хөрштэйгээ харилцах харилцаатай дүйх хэмжээний чиг баримтлал байсан юм²³. 1990 оноос хойш манай улстай нагт хамтран ажиллаж байгаа оронуудаас Япон хамгийн их зээл тусламж үзүүлсэн байх жишээтэй үүний дараа БНСУ, АНУ, ХБНГУ, Турк, Энэтхэг, гэх мэт оронуудтай нягт хамтын ажиллагаа хөгжүүлж ирсэн байна.

2. Монгол улсын үндэсний аюулгүй байдал.

Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд МУ-ын Их хурлын 2010 оны 07 сарын 15 өдрийн 48-р тогтоолоор шинэчлэн батлагдаж Үндэсний аюулгүй байдлыг 5 бүлэг 29 зүйлд хуваан ангилсан байдаг байна. Гадаадын аюулын хүчин зүйл Монгол улсын оршин тогтнохын аюулгүй байдлаар хязгаарлахгүй, эдийн засаг, нийгэм-төрийн байгуулал, иргэдийн эрх, эрх чөлөө, экологи, мэдээллийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдалд ч нөлөөлж байдаг. Учир нь дээр өгүүлсэн чиглэлийн аюулгүй байдлыг хангахад мөн л гадаадын хүчин зүйл, хамтын ажиллагаа чухал юм. Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах нь гадаад бодлогын тэргүүлэх зорилт мөн²⁴.

Тиймээс Гадаад бодлогын үзэл баримтлалд тусгагдаагүй зарим санааг ҮАБҮБ-д тусгасан байна. Тухайлбал, далайд гарцгүй орны тухай, хоёрдмол харъяаллын тухай заалт ГБҮБ-д тусгагдаагүй боловч ҮАБҮБ-д тусгагдсан байдаг. Хоёр хөрштэй харилцах бодлогын хувьд гэвэл ГБҮБ-д тэрхүү харилцааг гадаад бодлогын эн тэргүүний зорилт, тэр хоёр оронтой тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хамтын ажиллагаа хөгжүүлнэ гэж заасан боловч “тэнцвэртэй харилцах” гэж чухам юуг хэлэхийг тодруулаагүй байдаг. Тэгвэл ҮАБҮБ-д тэнцвэртэй харилцана гэж адил зай барих, бүх асуудлаар адил байр суурьтай байхыг бус, харин хоёулантай нь “итгэлцлийг бэхжүүлэх, сайн хөршийн найрсаг харилцааг хөгжүүлэхийг хэлнэ. Эдгээр орнуудтай харилцахдаа хөрш орнуудаас Монгол Улсын үндэсний ашиг сонирхол, нэн ялангуяа үндэсний язгуур ашиг сонирхолын талаар баримталж буй бодлогыг зохих ёсоор харгалзаж байна. Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолыг хөндөөгүй хөрш хоёр орны маргаанд эс оролцож, төвийг сахих бодлого баримтална” гэж тодорхой заасан байдаг²⁵.

Гуравдагч хөршийн бодлогыг амьдруулахын тулд гуравдагч орнуудтай эдийн засгаар харилцах, тэдний хөрөнгө оруулалтыг бий болгох нь нэн чухал. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нэг орноос оруулах гадаадын хөрөнгө оруулалт нийт гадаадын хөрөнгө оруулалтын гучин хувиас хэтрэхгүй байх бодлого баримтална гэж заасан байдаг. Энэ заалтыг амьдрал дээр хэрэгжүүлэх амар биш. Гэвч үүнийг хэрэгжүүлэх улс төрийн хүчин чармайлт, хүсэл эрмэлзэлтэй байх, тооцоо судалгаатай ажиллах

²² Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалын 14.1-д.

²³ Ц.Гомбосүрэн /ГЯЯ-ны сайд асан, Соёлын гавьяат зүтгэлтэн, Монгол улсад гадаад бодлогын үзэл баримтлалын 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хуралд хэлсэн үгнээс.

²⁴ Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал 2011 оны Монгол улсын их хурлын 10-р тогтоол

²⁵ Ж.Энхсайхан /Тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайд/

чухал байна. Өнгөн дээрээ эдийн засгийн аюулгүй байдалтай холбоотой мэт боловч гуравдагч хөршийн бодлогыг баталгаажуулах нэг чухал заалт гэж боддог.

ЗХУ, БНХАУ-ын хооронд олон жил үргэлжилсэн газар нутгийн маргааныг нэг тийш шийдвэрлэх тохиролцоо 1980-аад оны эцсээр эхэлсэн билээ. Асуудлыг шийдэж амжаагүй байтал ЗХУ задран маргаантай улс орнууд хүрээгээ тэллээ. Үүнд юун түрүүн Киргизстан, Казахстан, Тажикстаныг нэрлэх хэрэгтэй. Чухам ийм үндсэн дээр хамтарч асуудлаа шийдэхийн тулд 1996 онд “Шанхайн тав” хэмээх байгууллага буй болсон юм. Тэр үед уг байгууллагын гол зорилгыг цэргийн салбар дахь харилцан итгэлцэл, хил орчим дахь цэрэг зэвсгийн тоо хэмжээг харилцан бууруулах гэж томъёолж байв. 2001 онд Шанхайн тавыг зургаан орны гишүүнчлэлтэйгээр Шанхайн хамтын нийгэмлэг (ШХН) болгон өргөжүүлсэн юм. 2004 оноос уг байгууллагыг өөрийн төсөв, ажиллагааны механизмтай болгон албажуулжээ. Уг байгууллагын зорилго нь : хамтын итгэлцэл, найрамдал, сайн хөршийн холбоо, энх тайван аюулгүй байдал, бүс нутгийн тогтвортой байдлын төлөөх хамтын ажиллагаа, терроризм, салан тусгаарлал, хэт давралын эсрэг хамтран тэмцэх, улс төр худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа гэх мэтээр тодорхойлжээ. ШХН 2004 оноос ажиглагчийн статус буй болгосонд хамгийн түрүүн Монгол улс нэгдэв. Гишүүнээр элсүүлэх урилгыг юун түрүүн Монгол, Туркменистан хоёр оронд тавьсан боловч түркменчүүд татгалзсан ба одоо болтол ямар ч холбоо тогтоогоогүй явсаар. Харин Монгол улс хоёр хөршийн байнгын урилга заллага, хатуу нэхлийн үр дүнд ажиглагчаар орсон юм. Дараа нь энэ нийгэмлэгт Энэтхэг, Афганистан, Пакистан, Иран улсууд ажиглагчийн статустай болсон ба Түрэг, Шри Ланка, Беларусь улсууд ажиглагчаар нэгдэх хүсэлтээ гаргачихаад байна.

ШХН-ийн анхаарлын төвд байдаг нэг хэрэг бол бүс нутгийн тогтвортой байдалд саад болж болохуйц газар нутгийн маргаантай асуудал юм. Эдгээр гишүүн орнуудын нийтлэг хилийн шугамын алинд нь ч талууд бүрнээ хүлээн зөвшөөрсөн димаркаци байхгүй. Үүнээс болж өнөөдөртөө маргаан шүүмжлэл өрнөөгүй боловч хэдийд ч хэрүүл шуугиан үүсэх магадлалтай. Иймд ШХАБ нь цэрэг улс төрийн байгууллага болохын хувьд Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал эвсэлд үл нэгдэх гэсэн зарчимаар энэ байгууллагад нэгдэн орох шаардлагагүй байна Монгол Улс хоёр хөрштэйгээ газар нутгын хувьд ямар нэгэн маргаан байхгүй байгаа нь одоохондоо Терроризм, Салан тусгаарлал, Хэт давралтын байхгүй боловч Үндэстний цөөнх гэгдэх Монгол улсын Баян-Өлгий аймгийн Казах иргэд Монгол хэл сурахыг хүсэхгүй, Бүх хэвлэл мэдээлэлийн хэрэгсэл нь ихэнхи нь Казахстан улсын телевизийн сувагууд нэвтэрсэн байгаа нь салан тугаарлах, Казахстан улстай нэгдэх бодлого явуулж болзошгүй юм. Одоогийн байдлаар Монгол улсын төрийн бодлого нэгдмэл залгамж чанарыг хадгалж байхгүй бол Төрийн эрх барьж байгаа нам солигдох бүрд бодлого өөрчилөгдөж байгаа нөхцөлд ОХУ нь 2014 онд Крымыг өөртэй нэгтгэсэн шиг Баян-Өлгий аймгийн Казах иргэдийн дунд Казахстан улсын нөлөөгөөр санал асуулга явуулах хэлбэрээр нэгтгэж авах санаархал байна гэсэн үг, Монгол улсын үндсэн хуулийн 2019 оны 11-р сарын 14-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр *Хорин дөрөвдүгээр зүйл.16-д /ард нийтийн санал асуулга явуулах.*

3. ОХУ, БНХАУ-ын гадаад бодлого Монгол улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх нь

ОХУ-ын гадаад бодлого нь “ОХУ-ыг дэлхийн тэргүүлэгч гүрний нэг гэдэг статусыг бэхжүүлэх, мөн тэргүүлэгч гүрнүүд олон туйлт дэлхийн дэх стратегийн тогтвортой байдал болон харилцан бие биедээ ашигтай байдлаар түншлэх асуудлыг баталгаажуулахад үндсэн үйл ажиллагаагаа чиглүүлэхээр байна.

Тогтворгүй байгаа газруудад нөлөөгөө тогтоох Ойрх-дорнод, Алс дорнод, Африк, Өмнөд ази, Латин Америк, Солонгосын хойг багтаж байгаа ба шинээр иймэрхүү газруудад нөлөөлөө тогтоох явдал юм.

Монгол улсын хувьд ОХУ-ын гадаад бодлогод сүүлийн жилүүдэд нэлээд ахиц гарч байгаа нь эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалт, цэргийн зэвсэг техникийн тусламж үзүүлэхэд чиглэж байна. Монгол улсын Ерөнхий сайдын ОХУ-д хийсэн айлчлалаар БНХАУ-руу тавих байгалийн хийн хоолой “Сибирийн хүч-2 төсөлд Байгалийн хийн хоолойг Монголоор дайруулан тавих асуудлууд нэлээд түлхүү яригдсаны үр дүнд ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин Газпром компани удирдлагад үүрэг чиглэл судалгаа хийлгэсэн нь Монгол улсын нутаг дэвсгэр дээгүүр байгалийн хийн хоолой дамжин өнгөрүүлж тавих боломжтой гэсэн дүгнэлтэнд хүрсэн нь сүүлийн 30 гаруй жил яригдсан хийн хоолой тавигдах асуудал шийдвэрлэгдэх боломжтой болж байна.

ОХУ-ын гадаад бодлогод Монгол улсын үндэсний аюулгүй байдалд харшлах зүйл одоохондоо алга байна гэж үзэж байна, Яагаад гэвэл ОХУ өргөн уудам нутаг дэвсгэртэй нийт хүн ам тоо 145 сая хүнтэй нийт хүн амын 30 хувь нь Уралын нуруунаас Алс дорнодын бүсэд амьдарч байна, 70 хувь нь европын хэсэг буюу Уралын нуруунаас баруун тийш амьдарч байна. Ийм учираас газар нутагаа тэлэх бодлоггүй харин хүн ам цөөрч байгаа Сибирийг хөгжүүлэх нь ОХУ-ын нэг чухал асуудал юм. Гэвч Монгол улс байнга болгоомжтой байхад илүүдэхгүй 2014 онд ОХУ Крымыг өөртэй нэгтгэсэн явдал нь хэзээ ч ийм зүйл болохгүй гэсэн баталгаа алга үүнд Монгол улс төрийн хар хайрцагны бодлого чангатгаж хэзээч хаанаас ч аюул ирж болох үүднээс төрийн тогтвортой байдал, залгамж чанарыг хадгалж байх нь зүйтэй байна.

БНХАУ-ын гадаад бодлогын нэг том арга хэмжээ бол сүүлийн үед “Бүс ба Зам” “Евроазийн эдийн засгийн коридор” төслүүдийг санаачлан хэрэгжүүлж байгаа нь эдийн засгийн хувьд Хятад ашигтай нэг үгээр хэлвэл Хятадын бараа бүтээгдэхүүнийг евроазийн газар нутгаар дамжуулж борлуулах том сүлжээг үүсгэх сонирхолтой байна.

Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалд Дэлхий, бүс нутагт нөлөө бүхий улсуудтай харилцаа, хамтын ажиллагааг түлхүү хөгжүүлэхийг зорихын хамт аль нэг улсаас хэт хамааралтай буюу хараат байдалд орохоос сэрэмжилнэ гэж заасан байдаг нь зүгээр ч нэг бичээгүйг анхаарах ёстой байна.

Өнөөдөр Монгол улс БНХАУ-аас эдийн засгийн хувьд хараат байдалд орсон байна, худалдааны эргэлтийн 90 хувь, Монгол Улсад БНХАУ-аас 4.4 тэрбум орчим ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн. Монгол Улсад бүртгэлтэй БНХАУ-ын нийт 10.000 гаруй аж ахуйн нэгж байна. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал Хоёр хөрштөйгөө эн тэнцүү харилцах зарчим Хоёр хөрштөйгөө харилцаагаа жигнээд, цэгнээд үзэхэд чухамдаа эн тэнцүү байна уу гэдэг асуудал гарч ирнэ, Энэ нь эдийн засгийн хувьд хараат байдалд орж цаашлаад улс төрийн хувьд хараат байдалд орж болзошгүй байна. Жишээ нь Тажикстан улс БНХАУ-д их хэмжээний өртөй мөн бусад оронуудад өртэй байсан 2014 онд БНХАУ Тажикстан улсын өрийг барагдуулаад газар нутгаас нь авч улмаар онцгой бүс болгож Хятадын цэрэг оруулсан байна, Манай ийм явдал болохгүй гэх баталгаа алга, нэг улсаас эдийн засгийн хувьд хараат байх явдал нь үндэсний аюулгүй байдал алдагдахад хүрч мэднэ.

Хятадын үе уламжилсан төрийн бодлогод Монгол улсын өөртэй нэгтгэх бодлого юм, энийгээ хэрэгжүүлэхийн тулд хэдэн арав зуун жилээрч тэвчээртэй таатай нөхцлийг хүлээж байдаг байна.

Шанхайн хамтын ажиллагааны байгууллага нь 2004 оноос уг байгууллагыг өөрийн төсөв, ажиллагааны механизмтай болгон албажуулжээ. Байгууллагын зорилгыг: хамтын итгэлцэл, найрамдал, сайн хөршийн холбоо, энх тайван аюулгүй байдал, бүс нутгийн тогтвортой байдлын төлөөх хамтын ажиллагаа, терроризм, салан тусгаарлал, хэт давралын эсрэг хамтран тэмцэх, улс төр худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа гэх мэтээр тодорхойлсон байна.

ШХАБ нь цэрэг улс төрийн байгууллагын тул сүүлийн үед Монгол улсыг гишүүнээр элсэх тухай нэлээд яригдсан энэ нь Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалтай зөрчилдөж байгаа нь “Эвсэлд үл нэгдэх” гэдэг ойлголтыг тодорхойхон хэлбэл “цэрэг улс төрийн эвсэлд нэгдэхгүй” гэсэн санаа юм. Хэрэвээ Монгол улс ШХАБ-д гишүүнээр элсэн тохиолдолд МУ-ын гадаад бодлогын үзэл баримтлалтай зөрчилдөж болзошгүй байна. Иймд Монгол улс ажиглагчын статустайгаар оролцож байх нь зүйтэй байна.

БНХАУ, Монгол улс ОХУ-ын төрийн тэргүүн нарын гурван талт уулзалт Монгол улсад одоогийн нөхцөл байдалд ашиг багатай хоёр талт харилцаа нь илүү чухал байсан байх, Монгол улстай холбоотой асуудал шийдвэрлэх болгонд ОХУ, БНХАУ заавал нэг нэгнээс нь асуух шаардлага урган гарна, харин хоёр талт хамтын ажиллагаан хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэх боломжтой нь давуу талтай байна.

Монгол улс тусгаар тогтнолын баталгаа болсон Оюуны тусгаар тогтнол, Цусны тусгаар тогтнол, Орон зайн тусгаар тогтнол, Засаглалын тусгаар тогтнол, Ахуйн тусгаар тогтнол, дөрвөн баталгааг БНХАУ-д алдах байдалд хүрээд байгаа ба одоогийн байдлаар Орон зайн тусгаар тогтнол буюу хил хязгаарын бүрэн бүтэн байдал хэвээр хадгалагдаж байгаа боловч, Монгол улсын үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн маргаан дагуулаад байгаа 6-р зүйлийн 6.2 заалтыг /Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн/²⁶дахин авч үзэх зайлшгүй шаардлага гарч байна.

БНХАУ өнөөгийн байдлаар 1 миллиард 360 гаруй сая хүн амтай Хятадын бодлого бол аль болох хүн амаа цөөлөх бодлого барьж байгаа ийм ч учираас хүн амын өргөн хэрэглэгддэг хүнсээр нь дамжуулж насжилтыг богиносгох, генийн өөрчлөлттэй хүнсний бүтээгдэхүүн маш хямд үнэтэй хүнсний ногоо ихээр тариалаж хүнсний хэрэгцээг хангаж байна. Монгол улс импортын хүнсний түүхий эд. бүтээгдэхүүний хувьд 2017 оны эхний 8 сарын байдлаар 20 бүлгийн 178 төрлийн нийт 331.5 сая ам. долларын хүнсний түүхий эд. бүтээгдэхүүнийг импортолсон байн²⁷ эдгээрийн нэлээд хувийг жимс жимсгэнэ, хүнсний ногоо эзэллэж байгаа юм, Иймд аль болох гаднаас авахгүй дотооддоо үйлдвэрлэж хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах шаардлагатай байна.

4. Дүгнэлт Санал

Монгол Хятадын өнөөгийн харилцаа бол Монгол улсад зээл тусламж их хэмжээгээр агч байгаа нь яваандаа эдийн засгийн хувьд нэг ороноос /БНХАУ/-аас хараат байх явдал үүсэх, улмаар улс төрийн хувьд хараат байдал үүсч болзошгүй тул хэт нэг БНХАУ-аас авч байгаа зээл тусламжаа тодорхой түвшинд барьж хязгаарлах, гуравдагч оронтой худалдаа, эдийн засаг хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

БНХАУ-ын хэрэгжүүлж байгаа “Бүс ба Зам” нь Хятадын бараа бүтээгдэхүүний дундад азиар дамжуулж Европын оронуудад хүргэх худалдааны төсөлд юм, үүнд Монгол улс оролцох нь эдийн засгийн хувьд ашигтай юу ашиггүй юу гэсэн хувилбарууд яригдаж байгаа энэ үед Монгол улс энэ төсөлд нэгдсэнээр эдийн засгийн хувьд ямар үр өгөөжтэй тодорхойлох хэрэгтэй, энэ төсөл оролцсоноор Монголын экспортын бараа бүтээгдэхүүнийг гуравдагч зах зээлд борлуулах боломжтой эсэх судлах шаардлагатай байна.

Монгол, Хятадын харилцаанд нөлөөлдөг тодорхой ба тодорхой бус хүчин зүйлсийг авч үзлээ. Тодорхой хүчин зүйлс нь Монгол, Хятад хоёр улсын цар хэмжээний зөрүү, хөгжлийн ялгаа, ашиг сонирхлын давхцал, эдгээрээс үүссэн хүндрэл байв. Тодорхой бус хүчин зүйлс нь гадаад талд их гүрнүүдийн өрсөлдөөн, хүчний шилжилт гэсэн мегатрендийн хүчин зүйл байв.

Монгол, Хятадын харилцаанд туламдаж буй болон ойрын ирээдүйд тулгарч болох эрсдэл гол төлөв тодорхой хүчин зүйлстэй холбогдож байгаа учраас эрсдлийг саармагжуулах боломжтой, тодруулбал дотоодын бодлого болон хоёр талын хамтын ажиллагаагаар дамжуулан зохицуулалт хийх, шийдвэрлэх боломжтой нөхцлүүд харагдаж байна. Харин алс хэтдээ тодорхой бус хүчин зүйлсээс ирэх аливаа эрсдэл, өөрөөр хэлбэл цаашид Хятад, АНУ, Орос гурав нэгнээ хазаарлах оролдлого худалдааны дайнаас халин аюулгүй байдлын нөлөөний бүсээ хуваах чиглэлд шилжвэл Монгол Улсын гадаад бодлого, аюулгүй байдалд томоохон сорилт учруулна болох юм.

²⁶ Монгол улсын үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт 2019 он.

²⁷ Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны албан ёсны сайтаас статистик мэдээлэл.

ОХУ-ын нэг онцлог нь өргөн уудам нутаг дэвсгэр хүн ам сийрэг нийт хүн амын 70 хувь нь Европын хэсэг буюу Уралын нуруунаас цааш, 30 хувь нь Сибирь, Алс дорнодод амьдарч байна, ОХУ-ын хувьд одоохондоо Украин, Крымын асуудлаас болж Европын холбооны хориглоос болж эдийн засгийн хувьд сайнгүй боловч байгалийн баялагын асар их нөөцтэй ороны хувьд сүүлийн жилүүдэд Алс дорнодыг хөгжүүлэх, сибир гэж жил ирэх тусам хүн амын сийрэгжиж байгаа тул энэ бүс нутгийн эдийн засгийн хөгжүүлэх Монгол улс дагаж хөгжихөд таатай боломж байна гэж болно, Бүс нутгийн аялал жуулчлал, хил орчимын худалдаа, эдийн засгийн чөлөөт бүсийг хөгжүүлэх боломжтой байна.

Монгол улс ОХУ-ын харилцаа сүүлийн жилүүдэд улс төр эдийн засгийн хувьд нэлээд сайжрах хандлагатай байна, Монгол Оросын худалдааны эргэлт маш тэнцвэргүй байгаа Монгол улсын нийт экспортоос 10 хүрэхгүй хувь байгаа харин ОХУ-аас импортоор авч байгаа бараа бүтээгдэхүүний ихэнхи хувийг нефть, нефтийн бүтээгдхүүн эзлэж байна, мөн Баруун аймгуудын цахилгаан эрчим хүчийг ОХУ-аас импортоор авч байна, Харин Монгол улс Экспортоор мах махан бүтээгдэхүүн, арьс шир, ноос ноолууран бүтээгдэхүүнийг ОХУ-д гаргахад татвар өндөр байгаа нь хүндрэлтэй байна.

Шанхай хамтын ажиллагааны байгууллагад Монгол улс гишүүнээр элсэх талаар сүүлийн жилүүдэд нэлээд яригдсан Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалтай зөрчилдөж байгаа нь “Эвсэлд үл нэгдэх” гэдэг ойлголтыг тодорхойхон хэлбэл “цэрэг улс төрийн эвсэлд нэгдэхгүй” гэсэн санаа юм. Хэрэвээ Монгол улс ШХАБ-д гишүүнээр элсэн тохиолдолд МУ-ын гадаад бодлогын үзэл баримтлалтай зөрчилдөж болзошгүй байна. Иймд Монгол улс ажиглагчын статустайгаар оролцож байх нь зүйтэй байна.

Эцэс нь хэлэхэд Монгол улс гуравдагч хөршийн бодлогодоо ахиц гаргах шаардлагатай, Орос Хятад хоёр хөршийн төрийн хар хайрцагны бодлого бол Монгол улсыг хөгжүүлэх дургуй энэ хэмжээнд нь байлгаж байх сонирхолтой хоёр хөршөөс хараат байх бодлого бол аль ч үед байсан одоо ч байгаа гэж хэлж болно.

Монгол улсад амьдарч байгаа Казах иргэд гадны шашны байгууллагуудын санхүүжилтээр лалын шашинтай улс оронд суралцах болсон байна энэ хүмүүс юу сурч ирээд байна бас нэг анхаарч үзэх хэрэгтэй, Иймд Казах иргэдийн асуудалд анхаарах ёстой Дэлхийн улс оронуудад үндэстэн, шашин хоорондын мөргөлдөөн их гарах болсон тул Монгол улсын төр анхааралдаа авах нь зүйтэй болов уу.

Санал:

1. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал хоёр хөрштэйгээ эн тэнцүү харилцах гэсэн зарчимаа хадгалах, нэг талыг хит барихгүй байх тэнцвэртэй харилцааг хөгжүүлэх.
2. Монгол улс эдийн засгийн хувьд гуравдагч хөршийн бодлого ахиц гаргах харилцан ашигтай худалдаа, хөрөнгө оруулалтыг түлхүү оруулах
3. Аливаа үндэсний аюулгүй байдал нөлөөлсөн эвсэлд нэгдэхгүй байх зарчимаа хадгалж Монгол Улс ШХАБ-д гишүүнээр элсэн орох шаардлагагүй байна.
4. Монгол, ОХУ, БНХАУ-ын дээд хэмжээний 3 талт уулзалтаар Монголын талд одоогоор үр ашиг багатай тул 2 талд хамтын ажиллагаа нь Монголд хоёр хөрштэйгээ тус тус нь асуудлаа шийдээд явах нь үр дүнтэй гэж харагдаж байна.
5. Монгол улсад амьдарч байгаа Казах иргэд тэр тусмаа Баян-Өлгий аймагт Төрийн албан хэргийг монгол хэл бичгээр явуулах, бусад талаар тодорхой бодлого боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.
6. Монгол улсын үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн маргаан дагуулаад байгаа 6-р зүйлийн 6.2 заалтыг /Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн/дахин авч үзэх зайлшгүй шаардлагатай байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол улсын үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт 2019 он.
2. Монгол улсын Гадаад бодлогын үзэл баримтлал 1994, 2011 он.
3. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 2011 он.
4. Монгол улсад Гадаад бодлогын үзэл баримтлал батлагдсаны 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын материалууд.
5. Московские новости сонин 2012 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн нийтлэлээс.
6. ОХУ үндэсний аюулгүй байдлын стратеги шинэчилэл 2015 он.
7. ОХУ-ын Уфа хотноо "Аюулгүй байдлын асуудал эрхэлсэн өндөр, дээд албан тушаалтнуудын 10 дахь удаагийн уулзалт" 2019 оны уулзалтын материалаас.
8. “Монгол Хятадын Харилцаа Ба Нөлөөлөгч Хүчин Зүйлс” Аюулгүй байдал судлалын хүрээлэнгээс гаргасан нийтлэл 2019 он.
9. Б.Батцэцэг: “Монгол, Хятадын харилцаа түүхэн дэх хамгийн таатай үедээ байна” нийтлэлээс 2019 он.
10. Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны албан ёсны сайтаас статистик мэдээлэл.

ЁС ЗҮЙ, ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ ОНОЛ, АРГА ЗҮЙН АСУУДАЛ

ДХИС-ийн докторант,
цагдаагийн хурандаа Л.Нямдаваа

Товчлол. Нийгмийн хөгжлийг тодорхойлогч нэг чухал хүчин зүйл бол нийгмийн ёс суртахууны төлөвшил, хандлага байдаг. Ёс суртахууны төлөвшил ямар байна вэ гэдгээс хамаар ч тухай улс үндэстний соёл, хөгжлийн түвшин тодорхойлогддог. Энэхүү өгүүлэлд ёс зүйг шинжлэх ухаан, философи, шашин гэсэн түвшинд авч үзсэний зэрэгцээ ёс зүйн хандлага болон ёс зүй, хандлагын талаар эрдэмтэн судлаачдын үзэл санаа, философийн үзэл баримтлалын талаар товч дурдсан болно.

Түлхүүр. Ёс зүй, хандлага, ёс суртахуун, ухамсар, харилцаа, шашин

Үндсэн хэсэг. Нийгэм боловсронгуй болж, хөгжил дэвшил нэмэгдэх хэрээр ёс зүйн үүрэг, хариуцлага улам бүр нэмэгдэж байна. Эртний Грекийн нэрт сэтгэгч Аристотелийг ёс зүйн шинжлэх ухааны эцэг гэж үздэг. Тэрээр энэ чиглэлийн судалгааны салбарыг “Ethice” гэж томъёолж, “*Хүний зөв амьдрал бол аз жаргалтай амьдрал юм*”, “*Хүмүүс аз жаргалтай байхуйцаар биеэ авч явах ёстой*” хэмээн хариулснаас хойш ёс суртахуун, ёс зүйн талаар олон янзын чиг хандлагууд бий болж, улмаар ёс зүйн онол бий болжээ. Энэхүү өгүүлэлд ёс зүйг дараах 3 түвшинд авч үзэн бичлээ. Үүнд:

1. Шинжлэх ухаан;
2. Философи;
3. Шашин.

Ёс зүй нь “Ethos” буюу оршин суух газар, хэв маяг гэсэн грек үгнээс гаралтай бөгөөд түүхэн хөгжлийн явцад “хүмүүсийн үндсэн чанар хамт олны дотор танигддаг” гэдгийг ажилласантай холбоотойгоор “ёс заншил, зан суртахуун гэсэн утгатай” болжээ. “Ethos” нь латины “mos” буюу хүний ёс суртахуун, зан суртахуун, ёс заншил, дэг журам гэсэн утгыг илэрхийлдэг. Эртний Ромын философичид “mos” гэдэг үгээс “moralis”, хожим “moralitas” гэсэн үг гарган авсан бөгөөд “moralitas” нь грекийн “ethice” гэдэг утгын хувьд адил юм²⁸.

Эртний Ромын домогт “Veritas” буюу “Шударга үнэний сахиусан тэнгэр”-ийн тухай өгүүлдэг. Англи хэлэнд түүнийг “Goddess of truth” буюу шударга үнэний охин тэнгэр гэдэг. Тэрээр эртний Ромын ургацын бурхан болох “Vir-tue”-ийн ээж хэмээгдэн гоо үзэсгэлэнт охин тэнгэрийн дүрээр алдаршжээ. Дэлхийн хамгийн алдартай сургууль гэгдэх “Харвард”-ын их сургуулийн бэлгэдэл дээр “VE-RI-TAS” гэж байх бөгөөд шударга ёсыг илэрхийлэгч долоон үсгийг гурван хос болгож өөрсдийн сүлд тэмдэг болох бамбайн дээрээ бичсэн байдаг²⁹. Дэлхийн олон орны хууль эрхзүйн тогтолцоонд чин шударгын бэлгэдэл болдог энэхүү охин тэнгэрийн хөшөө Канад улсын дээд шүүхийн ордны өмнө сүндэрлэн байдаг³⁰.

Эртний грекчүүд шударга ёс гэдгийг *нэгдүгээрт* ёс суртахуунтай, *хоёрдугаарт*, хууль ёстой холбон үзэж байсан нь харагддаг. Сократ шударга ёс гэдэг бол шударга, ухаалаг хуулийг ягштал баримтлахыг хэлнэ. Хууль ухаалаг биш, шударга биш байвал шударга ёс өөрөө утга учиргүй болно гэсэн байдаг. Гүн ухаантнууд шударга ёс гэдгийг нийгмийн аливаа системийн оршихуйн үндэс гэж үзэх болжээ.

Ёс зүй гэдэг нь хүн төрөлхтний амьдралын онцлог чанаруудыг нэг билээ. Үүнд түүх, философи, ёс заншил, боловсрол, шашин шүтлэг зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг байна. Ёс зүй нь ёс суртахуун болон

²⁸ А.А.Гусейнов. “Введение в этику”. М., 1985. С.3

²⁹ <https://news.harvard.edu/> (хандалт: 2020.01.10)

³⁰ <https://www.scc-csc.ca/home-accueil/index-eng.aspx> (хандалт: 2020.01.10)

ёс суртахууны зан чанарыг үүсгэдэггүй. Харин уламжилж ирсэн ёс заншил, нийгмийн чиг хандлагаараа хувь хүнийг төлөвшүүлж, нийгмийн харилцааг зохицуулж, ард иргэдэд ёс зүй, ёс суртахууны талаарх мэдлэгийг олгож ирсэн цаг үе өөрчлөгдөж системтэй, үр дүнд суурилсан хувь хүний хөгжилд анхаарсан сургалтаар ёс зүй гэх өргөн ойлголтыг бий болгодог.

Ёс зүй шинжлэх ухааны бие даасан салбар болох нь:

Ёс зүй нь хөгжлийн явцад “ёс заншил, сэтгэлгээний хэв маяг, хүн чанар” гэсэн агуулгатай болж, тэдгээрийн шинж чанарыг илэрхийлэх болсон. Аристотель хүний зан төлөвийн өвөрмөц шинжийг илэрхийлэхийн тулд “Этос” гэх ойлголтыг анх хэрэглэсэн. Үүгээрээ сайн үйл болох эр зориг, шударга байдал зэрэг хүний сайн чанарыг тэмдэглэж, түүнийгээ дианозтик болон оюун ухааны сайн үйлээс ялгаатай авч үзжээ. Энэхүү үзэл дээр үндэслэн тэрээр ёс зүйг тайлбарлахдаа “Ёс зүй гэдэг нь хүний сайн сайхан үйлийг хэлнэ” гэжээ.

Этика буюу ёс зүй хэмээх ойлголтын түүх нь эртний Римээс үндэслэлтэй гэж бас үздэг. Римчүүд “Этос” гэсэн үгнээс Мораль гэх ойлголтыг гаргаж авсан. Өөрөөр хэлбэл 2 өөр үг боловч нэг ижил утга санааг илэрхийлдэг байж. Харин яваандаа Этика нь Ёс зүй, Мораль нь Ёс суртахуун гэх ойлголтуудыг тус тусдаа илэрхийлэх болсон. Ийнхүү харахад Этика буюу ёс зүй нь тусдаа бие даасан салбар шинжлэх ухаан болон хөгжиж, харин Мораль буюу ёс суртахуун нь түүний нэгэн судлагдахуун болсон байна.

ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурлын 33-р чуулганаар “Био ёс зүй болон хүний эрхийн түгээмэл тунхаглал”³¹-ыг 2005 оны 10 дугаар сарын 19-ний өдөр баталсан байна. ЮНЕСКО-гийн 191 гишүүн орнуудын хүлээн зөвшөөрч баталсан энэхүү тунхаглал нь био ёс зүйн цогц дүрэм журмыг багтаасан бөгөөд үүнийг дэлхийн үндэстэн бүрийн төлөөлөл болсон хувь хүн болон засаг төрийн мэргэжилтнүүд нэг санаан дор хамтран ажиллаж боловсруулжээ.

Судлаач Б.Оюунчимэг “Ёс зүй гэдэг бол зайлшгүй дагаж мөрдөх зүй тогтолтой, зөв зүйтэй горим, журмуудын тухай онол, сургаалын нийлбэр цогц”³² хэмээн тодорхойлжээ. Эндээс ёс зүй бол ёс суртахууны тухай шинжлэх ухаан юм гэж үзэж болохоор байна. Ёс зүй нь хувь хүний ёс суртахуунлаг шинж чанарын буюу сайн чанаруудын нийлбэр цогцыг, нөгөө талаас хүмүүсийн хоорондын харилцааны хэм хэмжээний нийлбэр цогцыг хамран судалдаг шинжлэх ухаан юм.

Нийгмийн хөгжлийг тодорхойлогч нэг чухал хүчин зүйл бол нийгмийн ёс суртахууны төлөвшил байдаг. Ёс суртахуун бол ёс зүйн шинжлэх ухааны судлагдахуун юм. Ёс суртахууны төлөвшил ямар байна вэ гэдгээс хамаарч тухай улсын дотоод соёл, хөгжлийн түвшин тодорхойлогддог. Нийгэм боловсронгуй болж, хөгжил дэвшил нэмэгдэх хэрээр ёс зүйн үүрэг, хариуцлага улам нэмэгдэж байна. Өөрөөр хэлбэл, ёс суртахуун бол хувь хүний, гэр бүлийн, улс орны орны оршин тогтнох үндэс нь болдог.

“Morality”³³ () нь зохистой гэж ялгаж, зохисгүй гэж үзсэн хүмүүсийн зорилго, шийдвэр, үйлдлийг ялгах явдал юм³⁴. Монгол хэлэнд “ёс суртахуун” хэмээн үздэг байна.

“Мораль” хэмээх үг тухайн хэлэндээ утга дүйх үгстэй бөгөөд энэ нь орос хэлэнд “нравственность” гэдэг үгтэй, герман хэлэнд “sittlichkeit” гэдэг үгтэй адил утгатай. Орос хэлний “нрав” гэсэн үгний үндэс нь оюун ухаанаас ялгаа бүхий сэтгэлийн мөн чанарыг илэрхийлсэн шунал тачаал, эр зориг г.м ёс суртахууны ойлголтуудыг илэрхийлдэг. Эдгээр “нрав, нравно” гэдэг үгс нь 1704 онд хэвлэгдсэн Ф.Поликарповагийн “Лексико”, И.И.Срезневскийн “Эртний орос хэлний толь бичиг” зэрэгт тэмдэглэгдсэн байдаг. “Нравственность” гэдэг үг анх 1793 онд хэвлэгдсэн оросын академийн толь бичигт бичигджээ. Орос, герман хэлний эдгээр үгс нь бүхэлдээ латины “moralitas” хэмээх үгийн түүхийг бүхэлд нь давтаж, улам баяжигдсаар бодит үйл явцын хөгжлийн зүй тогтлыг зааж байжээ.

³¹ https://www.un.org/ru/documents/decl_conv/declarations/bioethics_and_hr.shtml (хандалт: 2021.01.10)

³² Б.Оюунчимэг Ёс зүй ёс суртахууны тухай ном. Уб., 2019. 5 дахь тал.

³³ Латинаас: moralitas, lit. 'Зан байдал, зан чанар, зохистой зан байдал'

³⁴ Long, A. A.; Sedley, D. N. (1987). The Hellenistic Philosophers: Translations of the Principal Sources with Philosophical Commentary. 1. Cambridge: Cambridge University Press. p. 366–67.

Эдгээр үгс нь тухайн үедээ шинжлэх ухааны шинж чанартай байгаагүй ч философичдын зохиомол ойлголт биш, харин амьдралын зүй ёсны хөгжлөөс зайлшгүй гарч ирсэн ойлголтууд юм. Ийнхүү нийгмийн хөгжлийн явцад “этика”, “мораль” гэдэг нэр томьёо нь янз бүрийн утга агуулгаар баяжигдан, “этика” /буюу ёс зүй/ нь мэдлэгийн бие даасан салбар болсон байна. Эндээс ёс зүй бол ёс суртахууны тухай шинжлэх ухаан юм гэсэн анхны ерөнхий дүгнэлтийг гаргаж болно. Ёс зүйн судлах зүйлийг улам гүнзгийрүүлэн ойлгохын тулд нэг талаас, гадаад ертөнцийн үзэгдэл үйл явцад ёс суртахууны эзлэх байр суурийг тодорхойлох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, ёс зүйн шинжлэх ухааны статус, ёс суртахууны ахуйн статусыг тодорхойлох явдал зайлшгүй чухал юм.

Ёс зүйн түүхэнд ёс суртахуун, зан суртахуун хоёрыг ижил хэрэглэж, ёс суртахуун буюу зан суртахууныг ёс зүйн судлах зүйл гэж үзэж иржээ. Иймээс ёс зүйг зан суртахууны философи ч гэж нэрлэдэг байна. Тэрээр хүний тодорхой үйлдлийн субъектив талыг ёс суртахуун гээд объектив талыг нь зан суртахуун гэж үзжээ. Ёс суртахуун нь хоёр үндсэн хэлбэртэй болох нь туршлагаар батлагдсан. Үүнд: нэгдүгээрт, хувь хүний мөн чанарыг илэрхийлдэг ёс суртахууны чанарууд /эр зориг, шударга ёс, өгөөмөр сэтгэл, даруу зан г.м/. Хоёрдугаарт, нийгмийн зан суртахууны хэм хэмжээ /хулгай бүү хий, амьтан бүү ал г.м/ ба ойлголтуудын үнэлэмж /сайн, муу, үнэнч шударга чанар г.м/. Хувь хүний ёс суртахууны шинж нь хувь хүнээс нийгэмтэйгээ хэрхэн харьцаж буйгаар тодорхойлогддог.

Хэрвээ хувь хүний тухай ярихдаа түүний энгийн даруу, хүнлэг, өрөвч, тусархаг зэрэг мөн чанарынх нь тухай ярьж байвал энэ нь түүний бусад хүмүүстэй харилцах харилцаагаар илэрхийлэгдэнэ гэсэн үг. Өөрөөр хэлбэл, хувь хүний ёс суртахууны чанаруудаар илэрдэг бөгөөд зан суртахууны хэм хэмжээ нь хувь хүмүүсийн хоорондын харилцаа холбооны агуулга нь болдог. Энэ харилцаа холбоо нь нэг тохиолдолд субъектив хэлбэрээр илэрч байхад нөгөө тохиолдолд объектив харилцаагаар илэрдэг байна. Иймээс ёс суртахуун нь хувь хүмүүсийн үйл ажиллагааны олон талыг болон тухайн нийгмийн зан байдлын хэв шинжийг тодорхойлж өгдөг.

Ёс суртахуун нийгмийн бүхий л харилцаанд илэрч байдаг. Тухайлбал, улс төрийн харилцаа нь хүмүүнлэг ба хүмүүнлэг бус, эдийн засгийн харилцаа нь шударга ба шударга бус, оюун санааны харилцаа нь үнэнч ба үнэнч бус г.м ёс суртахууны мөн чанараар тодорхойлогддог. Улс төр, эдийн засаг, оюун санааны бүх үйл явцад ёс суртахууны мөн чанар илэрдэг төдийгүй хувь хүмүүсийн хоорондын харилцаанд ч мөн илэрдэг. Үүнээс үзвэл, нийгэм хувь хүний бүхий л үйл ажиллагаа өөрийн зан гэсэн зан суртахууны хэмжүүртэй байдаг ба ёс суртахууны тодорхой үнэлэмжийг бий болгодог.

Гегелийн философийн ёс зүйн сургаалынх нь баялаг өвөөс суралцах, эзэмших нь нийгмийн сэтгэлгээний нэн чухал асуудал юм. Тэрээр “ахуйн болон танин мэдэхүйн асуудлыг шийдвэрлэх үндсэн дээр хүмүүсийг хамтаараа эрхэм зарчим үзэл санаанд захирагдан ухаалаг аж төрөхөд сургах практик зорилго, чиглэл бүхий философийг төлөвшүүлэх баримжааг төгс хийхэд чиглэгдсэн байдаг³⁵.”

Нийгмийн хэм хэмжээт, зохицуулагч шинжтэй үзэгдлүүдийн тухай философийн мэдлэгийг интеграцлах (нэгтгэх) санаа Платон³⁶, Аристотель³⁷ зэрэг сэтгэгчдийн бүтээлд байдаг бөгөөд ихэвчлэн ёс зүй болон эрх зүйн онолыг нэгдмэл “практиктч” философид нэгтгэх тухай санаа гардаг. Германий алдарт сэтгэгч И.Кант ч бас тэдний сэтгэлгээний уламжлалыг хүлээн зөвшөөрч байжээ³⁸. Тэрээр олон жилийн турш философийн онолын мэдлэгийн цом хэсэг болох бодит байдлын уг чанарын тухай сургаал, ахуй ба түүний төрлүүд, тэдгээрийн мөн чанар, харилцаа, шалтгаал, орон, цаг зэргийн тухай философи онолыг судалсан байдаг. Өөрөө хэлбэл, ёс суртахууны мөн чанарын тухай метафизик схем ёс зүйд ч, эрх зүйд ч нэгэн адил хамааралтай гэж үзсэн байдаг.

Ёс суртахууны харилцаа нь ёс суртахууны ухамсрын илрэл, тусгал, түүнийг хэрэгжүүлэх арга нь болдог. Гэхдээ үүнийг ахуйн идэвхгүй тусгал гэж ойлгож болохгүй. Ёс суртахууны ухамсар бол харьцангуй биеэ даасан шинжтэй. Ёс суртахууны ухамсрын харьцангуй биеэ даасан шинж нь дараах гурван байдлаар илэрдэг. Үүнд:

³⁵ Коллинз Р. Социология философий: глобальная теория интеллектуального изменения. (Пер. с англ. Н. С. Розова и Ю. Б. Вертгейм). — Новосибирск: Сибирский хронограф, 2002. Ст. 85.

³⁶ Гусейнов А.А., Иррлитц Г. Краткая история этики. М., 1987. Прил. С. 538.

³⁷ Диоген Лаэртский. О жизни, учениях и изречениях знаменитых философов. С. 307.

³⁸ Кант И. Метафизика нравов в двух частях // Кант И. Соч.: в 6 т. Т. 4 (2). М., 1965. С. 311.

1. Ёс суртахуун нь нийгмийн ахуйгаасаа шалтгаалдаг боловч эргээд нийгмийнхээ ахуйдаа эерэг, сөрөг байдлаар нөлөөлдөг;

2. Ёс суртахууны ухамсар нь нийгмийн ахуйгаасаа түрүүлэх буюу хоцрох байдлаар илэрдэг;

3. Ёс суртахуун нь өвлөн уламжлагдах шинжтэй байдаг.

Судлаач Б.Сандаг “Ёс суртахуун гэдэг бол хүмүүсийн хоорондох харилцааны бичигдээгүй хууль бөгөөд хүний аливаа юманд хандах ухамсартай үйл ажиллагаа юм. Ёс суртахууны хэв шинж, төлөвшил нь хувь хүний боловсрол соёлоос үлэмж хамааралтай” хэмээсэн байна. Мөн тэрээр суртахууныг бүтцээр нь 3 хэсэгт авч үзсэн байна. Үүнд:

1. *Ёс суртахууны ухамсар.* Энэ нь хүмүүсээс бие биетэйгээ, байгаль ертөнцтэй нийгэмтэйгээ харилцах хэм, хэмжээ үнэлэлт, дүгнэлт, ойлголт, үнэлэмжийг тусгасан нэлээд гүнзгий төсөөлөл юм. Ёс суртахууны ухамсрыг түвшингөөр нь ердийн ба онолын ухамсар гэж ангилдаг.

2. *Ёс суртахууны харилцаа:* Энэ нь нийгмийн олон талт харилцааны өвөрмөц нэг хэлбэр бөгөөд үйл ажиллагааны явцад төлөвшдөг. Нийгмийн харилцааны бүхий л харилцаанд ёс суртахуун өдөр дутам илэрч байдаг. Монголчууд харилцааны хэвшил болсон зан үйл, дадал заншил, уламжлалт ёс жаягаа бидний зан суртахуун гэдэг. Нэг ёсондоо зан суртахуун, ёс суртахуун нь ижил утгаар ярьж, бичигддэг.

3. *Ёс суртахууны үйл ажиллагаа:* Энэ нь хүмүүсийн нэгдмэл амьдрал, үйл ажиллагааны онцгой төрөл юм. Ёс суртахуун нь нийгэм хамт олны болон хүний амьдрал, үйл ажиллагааны байнгын чухал нөлөө үзүүлэх олон үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал:

- Ёс суртахууны үнэлэмжийн үүрэг;
- Ёс суртахууны танин мэдэхүйн үүрэг;
- Ёс суртахууны ертөнцийг үзэх үүрэг;
- Ёс суртахууны зохицуулах үүрэг³⁹ гэсэн түвшинд хуваан авч үзжээ.

Ёс суртахуун нь нийгмийн харилцааны нэг хэлбэр болохынхоо хувьд зан суртахууны мэдрэмж болон ёс суртахууны ухамсарт тусгалаа олдог. Бие хүний сайн үйл, хэм хэмжээ, хууль дүрэм гэх мэтийн шаардлагууд нь ёс суртахууны харилцааны өвөрмөц хэлбэрүүдийг өөртөө агуулж байдгаараа үнэн хэрэгтээ бодит байдлын шууд илэрхийлэл нь болж байдаг. Ёс суртахууны ухамсрын хэлбэрүүдийн цаана хувь хүн, нийгмийн бодит харилцааны хэв маяг оршиж байдаг. Өөрөөр хэлбэл, ёс суртахууны ухамсрын гол хэмжүүр болох сайн муугийн тухай ойлголт нь хүн бүрийн амьдрал үйл ажиллагаа болон нийгмийн харилцааг бүхэлд нь илэрхийлдэг.

Академич С.Нарангэрэл өөрийн бүтээлдээ “Ёс суртахуун бол хүний хөдөлмөрийн үйл ажиллагаа ба хүмүүс хоорондоо харьцахад үндэслэгддэг, нийгмийн эрэл хэрэгцээ ба ашиг сонирхлоор нөхцөлддөг нийгмийн хөгжлийн бүтээгдэхүүн юм. Ёс суртахууны нийгэм-түүхийн төлөвшлийн уг сурвалж нь нийгмийн инстинкт ба хүний бүтээлчээр хөдөлмөрлөх эрэлт шаардлага билээ. Нийгмийн инстинкт нь хүнийг бусад хүнтэй адилхан бие хүнтэй харилцаа тогтоолгож, нигүүлсэхүй болгон хүмүүжүүлнэ. Өөр бусад хүмүүстэй хамтран орших нь ёс суртахууны төлөвшлийн хөгжлийн хамгийн гол урьдчилсан нөхцөл юм”⁴⁰ гэж үзсэн байна. Өөрөө хэлбэл, мөр зэрэгцэн аж төрж байгаа хэн нэгнийг хайрлах ба шаналж зовсноо илэрхийлэх нөхцөл болно.

Ёс суртахууны харилцаа нь ёс суртахууны ухамсрын илрэл, тусгал, түүнийг хэрэгжүүлэх арга нь болдог. Гэхдээ үүнийг ахуйн идэвхгүй тусгал гэж ойлгож болохгүй. Ёс суртахууны ухамсар бол харьцангуй биеэ даасан шинжтэй. Ёс суртахууны ухамсрын харьцангуй биеэ даасан шинж нь дараах гурван байдлаар илэрдэг. Үүнд:

1. Ёс суртахуун нь нийгмийн ахуйгаасаа шалтгаалдаг боловч эргээд нийгмийнхээ ахуйдаа эерэг, сөрөг байдлаар нөлөөлдөг;

2. Ёс суртахууны ухамсар нь нийгмийн ахуйгаасаа түрүүлэх буюу хоцрох байдлаар илэрдэг;

3. Ёс суртахуун нь өвлөн уламжлагдах шинжтэй байдаг.

Ёс суртахууны төсөөлөл, ухагдахуун, дэвшил болон дээд эрмэлзэл нь нийгмийн ахуй, нийгмийн харилцаа, хүний практик үйл ажиллагааны дагуу түүхэн ёсоор өөрчлөгдөн хөгжиж ирсэн түүхтэй юм. Хүмүүс амьдралынхаа явцад тодорхой харилцаанд орж бие биесээ таньж үнэлэхийн хамт амьдралын

³⁹ Б.Сандаг. Төрийн албан хаагчийн ёс зүй. Уб., 2018. 22 дахь тал.

⁴⁰ С.Нарангэрэл Монголчуудын зан суртахууны гарваль. Уб., 2010. 15 дахь тал.

нөхцөлийнхөө дагуу өөрийн хамаарагдах үзэл суртал, ертөнцийг үзэх үзлийг боловсруулан эзэмшиж улмаар зан үйлийн харилцааны ухагдахуун хэм хэмжээг төлөвшүүлж иржээ. Ёс суртахуун бол аливаа хүний уураг тархинд оршдог олдмол бус төрлөх өгөгдөл. Чухамхүү хүмүүнд ёс суртахууны өгөгдөл байдаг учраас адгуус араатан, бусад амьтнаас ялгарна.

Ёс суртахуун нь бие хүний үйлийн субьектив хэмжүүр ба үзүүлэлт. Ёс суртахууныг эдүгээ харилцан уялдаа бүхий хоёр талтай авч үзэж байна. Үүнд:

1. Бие хүний хувьд шударга, үнэнч, нигүүлсэхүй, нинжин сэтгэл хэмээн тусгайлан авч үзэж болох хүний ёс суртахууны эрхэм чанарын тухай тодорхойлолт.

2. Бие хүн хоорондын хувьд нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, шаардлага ба журмын цогцоор зохицуулагдах хүмүүс хоорондын харилцааны хэв шинж⁴¹. гэж авч үздэг байна.

Ёс суртахуун нь нэг талаас хүн өөрийгөө муу муухай зүйлээс хязгаарлан барьдаг, өөрийн төрлөх буюу адгуусан шинж бүхий ааш араншинд хориг тогтоож чаддаг, нөгөө талаас өөр бусад хүмүүсийн сайн сайхны төлөө өөрийгөө золиослох чадвартай болгох явдлаар илэрдэг байна.

Тэгвэл бид ёс зүйг шинжлэх ухаан хэмээн судалсан авч амьдрал дээр ёс зүйтэй хүн хэмээн ярих нь нэр томъёоны хувьд буруу хэрэглээ болон хүмүүсийн харилцаанд тогтсон хэвээр байна. Ёс зүйтэй хүн биш ёс суртахуунтай хүн хэмээх ойлголтыг ярьж хэвших нь чухал билээ.

Зан суртахуун:

Зан суртахуун гэдгийг монгол хэлэнд “нийгмийн шаардлагад тохирох хүний зан авир, хүмүүжил⁴²” гэж тайлбарлажээ.

Зан суртахуун нь нийгэм ба гэр бүлдээ ёс суртахууны хэм хэмжээг хүн өөрийн үйлээр бодитой хэрэгжүүлэх явдал юм. Зан суртахууны үнэт зүйлс нь бүх хүмүүсийн хувьд нийтлэг бөгөөд хүний оюунлаг дээд чанараар илэрнэ. Хүний зан суртахуун хэчнээн төгөлдөржинө, нийгмийн хөгжил төдий чинээ түргэсэж байдаг.

Ёс суртахууны чиг үүрэг нь хүмүүсийн харилцан ойлголцол, харилцааг баталгаажуулдаг. Бодит байдлыг оюун санааны талаар эзэмдэхэд чиглэгдэнэ. Өөрөөр хэлбэл, нийгмийн харилцаа ба үнэт зүйлсийн хүрээнд ёс суртахуун нь хүнээс чиг баримжаагаа зөв олох хэрэглүүр болж, нийгмийн харилцааны бүх тогтолцоонд хүн зан үйлийг зохицуулж хэрэгжүүлэхэд тусалж байдаг. Ёс суртахуун нь боловсролын хэмжээ төдийгүй нийгмийн харилцаа, орчин ахуй бусад зүйлээс зэрэг хамаардаг. Иймээс нийгмийн харилцааг өөрчлөхгүйгээр зөвхөн боловсрол гэгээрийг дэлгэрүүлэх замаар хүний ёс суртахууныг өөрчилж болохгүй. Үүрэг, хариуцлага, ичих, сэтгэл зовох, нэр төр гэсэн ухамсрын ёс суртахууны хэлбэрүүд нь адгуусанд ч байдаггүй зөвхөн хүний өвөрмөц бүтээл юм.

Академич С.Нарангэрэл өөрийн бүтээлдээ зан суртахууны зориулалтыг доорх байдлаар авч үзсэн байна⁴³. Үүнд:

1. *Зохицуулах чиг үүрэг.* Энэ нь ёс суртахууны үнэт зүйлс ба шаардлагад нийцсэн, ёс суртахууны талаар хөгжсөн бие хүнийг төлөвшүүлж, нийгмийн харилцааг зохицуулсан ёс суртахууны хэм хэмжээг хэрэгжүүлэхэд оршино. Ёс суртахууны үнэт зүйлс ба шаардлага нь хүн өөрийн төгөлдөршилтийн эрэл хэрэгцээ ба зайлшгүй шаардлагыг ухамсарлах арга болно. Ёс суртахуун, зан суртахуун нь зохицуулалтын чиг үүрэг хэрэг зэрэг амжилттай хэрэгжүүлэх эсэх нь хүн өөрийн хувийн зан үйлийн сэдлэг болон нийгмийн шаардлагыг хүлээн авах чадвараас ихээхэн шалтгаална. Энэ зорилт нь хэрэв нийгмийн зүгээс хүний ашиг сонирхол ба эрэлт хэрэгцээг харьцангуй тэнцвэртэй тогтоож, хүлээн зөвшөөрч баталгаажуулбал хялбар дөхөм хэрэгжинэ. Энэ бүхэнд зан суртахууны журамт үүргээ хэрэгжүүлэхэд аливаа хүнд туслах түүний оюун санааны өндөр түвшин нэн чухал үүрэг гүйцэтгэнэ.

2. *Үнэлэлт-хоригийн чиг үүрэг* нь бодит байдлыг журамт үүргийн үүднээс тусган авснаар илэрлээ олно. Зан суртахуун нь ёс суртахууны үнэт зүйлсийн зарчимд нийцүүлэн хүн зан үйлийг тогтоох ба үнэлэх бөгөөд аливаа үйлийн зан суртахууны мөн чанарыг тодорхойлно.

3. *Хүмүүжил-хүмүүнлэгийн чиг үүрэг* нь нинжин, нигүүлсэхүй, уужуу талбиун, тэсвэр тэвчээртэй чадвараар илэрдэг ёс суртахууны мэдрэмжийг хүний хөгжилд буй болгох, ёс суртахууны

⁴¹ С.Нарангэрэл Монголчуудын зан суртахууны гарваль. Уб., 2010. 10 дахь тал.

⁴² Монгол хэлний их тайлбар толь. Уб., 2012.

⁴³ С.Нарангэрэл Монголчуудын зан суртахууны гарваль. Уб., 2010. 10 дахь тал.

үнэт зүйлс, оюун санааны эрхэм дээд үзэл баримтлалын тогтолцоонд хүнийг хэвшүүлэхэд оршино. Эдгээр мэдрэмжээр хүнийг хүн ёсоор нь байлгах асуудлын гол гогцоо тодорхойлогдоно.

4. Танин мэдэхүйн чиг үүрэг нь хүнийг хүн ёсоор нь байлгах зарчим ба зан суртахууны хувьд болох, болохгүйн үүднээс ёс суртахуунаар бодит байдлыг тусгах чадвартай болгоход оршино. Танин мэдэхүйн хүрээ болох ёс суртахуун нь хүний цаашдын чиг баримжаа болж, түүнд заавал байх ёстой шаардлага болон тавигдаж, бас нийгмийн бодит нөхцөл байдалд үйлдэх ёсгүй заагийг тодорхойлж өгдөг⁴⁴. гэж үзжээ.

Иймээс ёс суртахууны төлөвшилтэй хүн бол хаана ч, хэн бүхэнтэй ч зохицон амьдарч чаддаг. Өнөөдрийн монголын нийгэмд техник технологийн боловсронгуй хөгжил дэвшил хурдацтай өрнөж, байшин барилга хоромхон хугацаанд сүндэрлэн босох болжээ. Гэвч монгол хүний үнэт зүйлсийн нэг бол ёс суртахуун ямархуу байна вэ? гэдэг нь төдийлөн хангалттай бус байна.

Орчин цагт ёс зүйн шинжлэх ухаанд хандах 3 суурь хандлага байдаг⁴⁵. Ёс зүй судлаач J.Svara тэдгээр хандлагыг:

- Virtue (зан байдлын үнэлэмж)
- Consequences (үр дүн)
 - Principle (зарчим) гэж авч үзсэн байна. Үүнээс үүдэж ёс зүйн гурван суурь хандлагыг доорх утгаар тайлбарласан байна.

1.Ёс зүйн зан байдал, сайн чанарын хандлага:

Плато, Аристотель болон Күнз нарын сургаалаас эхтэй. Хүний ямар зан байдал, зан чанарыг дээдэлж үзэх ёстойг тодорхойлох, түүнийгээ хэрэгжүүлэх, эзэмших нь чухал гэж үздэг. Зан байдалд суурилсан онолууд нь үйлдэл биш харин хүн нь ёс суртахууны үнэлгээний объект гэж үздэг байна. Өөрөөр хэлбэл, хүний ямар үйлдэл хийх чухал биш харин ямар хүн бэ гэдэгт анхаарах ба хувь хүмүүсийн сайн үйлс хийдэг шалтгаан нь тэд сайн хүмүүс байгаад оршино гэж үздэг⁴⁶.

Энэхүү хандлага нь ёс зүй бол зан чанаруудын нэгдэл бөгөөд зан чанар нь дадал зуршил учраас үүнд суралцаж болно гэж үздэг.

2. Ёс зүйн үр дүнгийн хандлага: Сонгодог төлөөлөгчид болох Jeremy Bentham⁴⁷, John Stuart Mill нар “**utilitarianism**” (teleological ethics) онолыг үндэслэсэн. Энэхүү үзэл нь дараах элементүүдийг өөртөө агуулдаг бөгөөд эдгээр элементүүдийн нийлбэр л энэ үзлийн үндсэн суурь болохоос биш аль нэг эсвэл зарим нэг хагас нь түүнийг илэрхийлэх боломжгүй. Үүнд: аз жаргал, ашиг тус, ёс суртахууны сонголт, сэтгэл ханамж, тэгш байдал, шударга ёс, чөлөөт байдал г.м⁴⁸.

Хамгийн олон хүнд хамгийн их аз жаргал авчрах үйлдлийг ёс зүйтэй үйлдэл хэмээх үзэл юм⁴⁹. Өөрөөр хэлбэл, үр дүн чухал бөгөөд ямар арга замаар хүрэх нь төдийлөн ач холбогдолтой биш гэж үздэг. Жишээ нь Дарьгангын шилийн сайн эр Тоорой Банди буюу Данзаны Нанзад нь ядуу ардын зовлон зүдгүүрийг үл ойшоогч ноёд баяд, харийн худалдаачдын эсрэг эр бяр, зориг хүчээрээ тэмцэж тэдний адуу малаас авч ядарсан ард түмэнд тараасан түүх байдаг⁵⁰. Энэхүү үйлдлийг нь энэ онолоор бол зөвтгөгдөж болох. Үр дүн чухал бөгөөд ямар арга замаар хүрэх нь ач холбогдолтой биш байна. Хүн үргэлж өөрийн үйлдлийн үр дүнг баттай таамаглаж мэдэж чадахгүй нь энэхүү онолын гол сул тал гэж үздэг.

4. Ёс зүйн зарчмын буюу үүргийн хандлага:

Германы философич Immanuel Kant үйлдлийн үр дагавраас үл хамааран хүний гүйцэтгэх ёстой үүрэг, баримтлах зарчим байдаг ба энэ нь ёс зүйтэй үйлдлийн суурь болно (“deontology” буюу үүрэгт

⁴⁴ Мөн тэнд

⁴⁵ J.Svara “The Ethics primer for Public administrators in government and nonprofit organizations” Jones and Bartlett Learning LLC. 2015. P.12.

⁴⁶ Alon Lawton. Julie Rayner. Karen Lasthuizen 2013, “Ethics and management in the public sector”, Routledge, P.21.

⁴⁷ <https://plato.stanford.edu/entries/bentham/>

⁴⁸ Julia Driver. Stanford Encyclopedia of Philosophy. 2014. P.22.

⁴⁹ Dean Geuras, Charles Garofalo “Practical ethics in Public administration” 2011. P.61.

⁵⁰ Тоорой бандийн домог. <https://mn.wikipedia.org/wiki/>

суурилсан ёс зүй) Үйлдлийн үр дагавар, үр дүнг үл харгалзан тухайн үйлдэл ёс зүйтэй эсэхэд ач холбогдол өгдөг хэмээх онолыг гаргаж ирсэн байна⁵¹. Энэхүү хандлагын үүднээс үйлдлийн үр дагавар, үр дүнг үл харгалзан тухайн үйлдэл ёс зүйтэй эсэхэд ач холбогдол өгдөг.

Хүн үйлдэл хийхдээ хэрэв өөрийнх нь үйлдлийг хүн бүр хийвэл хэрхэх талаар тунгаан бодох мөн хүнийг ямар нэгэн үр дүнд хүрэх арга хэрэгсэл болгон ашиглаж болохгүй.

Энэхүү 3 хандлага нь тус бүртээ давуу ба сул талуудтай бөгөөд нөхцөл байдлаас хамааран дангаар болон хосолмол байдлаар хэрэглэдэг. Түүнчлэн нөхцөл байдлаас гадна аль нэг аргыг илүүд үзэх хүмүүсийн хандлага бас нөлөөлдөг. Ийнхүү J. Svara өөрийн бүтээлдээ дээрх 3 хандлагыг нэгтгэн “**ёс зүйн гурвалжин**” хэмээх ойлголтыг гаргаж ирсэн⁵². (зураг...) Өөрөөр хэлбэл, ёс зүйн 3 хандлагыг хамтад нь ашиглах нь аль нэг хандлагын сул талыг нөхдөг тул гэж үздэг.



Тэгвэл ёс зүй хэмээх энэ өргөн ойлголтын тухай ярихын өмнө ёс суртахууныг хөндөх нь чухал билээ.

Ёс зүйн шинжлэх ухаан нь хүн төрөлхтний оршин тогтнох нэг үндсэн хүчин зүйл нь ёс суртахууны судлагдахуун гэж үздэг. Тиймээс аливаа нэг улс, үндэстэн урт хугацаанд оршин тогтнохдоо төрийн ухаалаг бодлого явуулж, өөрийн газар нутаг, хэл, соёлоо авч үлдэнэ. Энэхүү бодлогыг явуулахад ёс суртахуун машид чухал нөлөө үзүүлдэг. Өөрөөр хэлбэл, иргэдээ хөгжүүлэх, төлөвшүүлэх, сайн, сайхан амьдруулах үүргээ биелүүлэхэд нь ёс зүйн шинжлэх ухаан туслах юм.

Философийн ёс зүйн үзэл баримтлал:

Ёс зүй нь анх философийн шинжлэх ухаанд бойжсон бий болсон гэж үзэж болно. Философичид ёс зүйг хүний сайн, сайхан амьдрал, эрх, хариуцлагын тогтолцоо, зөв буруу үйлдэл ба эс үйлдэхүй, сайн ба муу ёс зүйн шийдвэрийн талаар хариулт өгөх зорилготой гэж үздэг байна.

Ёс зүй гэдэг үгийг түүхээс нь эхэлж судалбал илүү ойлгомжтой болно. “Ёс зүй” хэмээх ойлголт нь эртний грекийн “ethos” гэдэг үгнээс гаралтай бөгөөд хамтран амьдрах орон байр, оршин амьдрах газар гэсэн утгыг илэрхийлж байжээ. Хожим энэ ойлголт нь хүмүүсийн амьдралын ямар нэг үзэгдэл, ёс заншил, зан төлөв, зан араншин, сэтгэлгээний хэв маяг гэх мэт шинэ утга агуулгатай болж тэдгээрийн дотоод мөн чанарыг илэрхийлэх болсон. Эртний философичид энэ ойлголтоор аливаа нийгмийн болон

⁵¹ David Misselbrook. Duty, Kant, and Deontology. British Journal of General Practice ·2013

⁵² Ryan C. Urbano. Public Administration Ethics: James Svara's Model. Journal of Human Values. 2014. P.27.

физик үзэгдлийн тогтвортой шинжийг илэрхийлсэн шинжлэх ухааны утга бүхий нэр томьёо болгон хэрэглэсэн.

“Этос” гэдэг үгийн түүх нь хамтын амьдралын явцад хүмүүсийн зан заншил, зан араншин бүрэлдэн тогтдогийг илэрхийлсэн утгатай байсан бөгөөд энэ нь орчин үеийн нийгэм судлаачдын хэлээр атракцийн орон зайн (хүмүүсийн бие биедээ харилцан татагдах) ойртох явцтай холбоотой ойлголт юм.

Ёс зүйн онолын ойлголтууд философи, шашин, соёл, зан заншлаас үүдэлтэй хөгжсөөр ирсэн бөгөөд философичид ёс зүйг дараах гурван үндсэн салбарт хуваан үздэг.⁵³

1. Мета ёс зүй /*ёс зүйн зарчим, үнэт зүйлсийн эх үндэс, утга учир*/
2. Норматив ёс зүй /*зөв буруугийн шалгуур, ёс зүйн үнэлгээний агуулга*/
3. Хэрэглээний ёс зүй /*амьтны эрх, дайн, цаазаар авах ял гэх мэт*/

Мета-ёс зүй.

Английн философич Жорж Э.Мур 1903 онд "Principia Ethica" хэмээх бүтээлдээ анх “Meta-ethics” мета-ёс зүйн онолыг гаргаж ирсэн байдаг. Түүнээс хойш Garner Richard, Bernard Rosen гэх мэт эрдэмтэд энэ онолыг гүнзгийрүүлэн судалсан байна.

Мета-ёс зүй нь юуг зөв, юуг буруу болохыг онолын түвшинд судалдаг ёс зүйн философийн салбар юм. Тухайлбал, “албан үүргээ гүйцэтгэсний төлөө би бэлэг авах нь зөв үү?” гэсэн асуулт нь мета-ёс зүйд бус, харин хэрэглээний ёс зүйд хамаарна. Тэгвэл мета-ёс зүйн асуудлууд нь хийсвэр, онолын шинжтэй бөгөөд “бид юуг зөв, эсхүл буруу болох талаар нэгдсэн ойлголттой болж чадах эсэх нь үүнд хамаардаг.

Норматив ёс зүй

“Normative ethics” Норматив ёс зүй нь ёс зүйт үйлдлийг судалж, хэн нэгэн тодорхой нөхцөл байдалд ямар үйлдэл хийвэл зохистой болохыг тайлбарладаг ёс зүйн философийн салбар юм. Норматив ёс зүйд ёс суртахууны стандартуудыг бий болгох, үнэлэх үйл ажиллагаа орно. Тиймээс хүмүүс ёс суртахууны ямар ч стандартыг ашиглаж байгаа нөхцөлд юу хийх, ёс суртахууны одоогийн ёс зүйг зөв зохистой ашиглахыг тодорхойлох оролдлого юм. Уламжлал ёсоор бол ёс суртахууны философийн талбар нь норматив ёс суртахууныг хамарч, хүмүүсийг юу хийх ёстойг яагаад тайлбарлаж байгаагаа, тайлбарлахыг оролдсон цөөн хэдэн гүн ухаантнууд байдаг.

Ёс зүйн хүнийг үйлдэл, дүрэм журам, захиран зарцуулалт гэж яг юу өгдөг талаар санал зөрөлдөөн байдаг. Ёс суртахууны асуудлуудад хэрхэн хариулах, тус бүрийн зарим элементүүдийг хослуулсан эрлийз байр суурийн хамт өрсөлдөх гурван үзэл бодол байдаг.

- **Virtue ethics;** - зан байдлын үнэлэмжийн ёс зүй;
- **Deontological ethics;** and -деонтологийн ёс зүй; бусад
- **Consequentialism;**-үр дагавар.

Эхнийх нь жүжиглэж байгаа хүмүүсийн зан чанарт анхаарлаа төвлөрүүлдэг. Үүний эсрэгээр деонтологийн ёс зүй ба үр дагаврын аль аль нь үйл хөдлөл, дүрэм журам, хандлагын төлөв байдалд төвлөрч, янз бүрийн хэлбэртэй байдаг.

Норматив ёс зүй нь ямар нэгэн үйлдлийг сайн, муу болгож байгаа зүйлийг судалдгаараа мета-ёс зүйгээс ялгаатай. Гэвч ёс зүйн асуудлууд нь зөвхөн сайн, муу гэж тайлбарлагдахгүй байх тохиолдол их гардаг тул ХХ зууны дунд үеэс энэхүү салбарын судалгааны ач холбогдол нь буурсан.

Virtue ethics- Аристотелийн ёс зүйн онолыг Гэгээн Томас Аквинский дэмжиж зан байдлын үнэлэмжийн ёс зүй нь тодорхой үйлдлүүд гэхээсээ илүү тухайн хүний төрөлх шинж чанарт төвлөрдөг гэж үзжээ. Сүүлийн хагас зууны туршид Г.Э.М.Анскомб, Филиппа Фут, Аласдэйр Макинтир, Мортимер Ж.Адлер, Жак Маритейн, Ив Симон, Розалинд Херстхаус зэрэг философичдын бүтээлээр дамжуулан зан байдлын үнэлэмжийн ёс зүй нэлээд сэргэсэн⁵⁴.

⁵³ Төрийн албан хаагчийн ёс зүй. /Авлигатай тэмцэх газар/ УБ., 2019. 7 дахь тал.

⁵⁴ https://wikipedia.org/wiki/Normative_ethics (хандалт: 2020.01.10)

Ёс суртахууны үнэлгээний объект болох үйл ажиллагаанд анхаарлаа төвлөрүүлдэг ёс суртахууны үүргийн онолуудаас гадна үйл ажиллагаа биш харин агент төв шатанд ордог өөр нэг зүйл байдаг. Энэ хандлагын хувьд тухайн үйлдэл, үр дагаврыг биш харин тухайн хүнийг үнэлэмж юм. Хүмүүсийн хийдэг зүйлийг дүгнэхийн оронд хүмүүс хэн бэ гэдгийг хардаг. Энэхүү онолын объект нь бол тухайн хүний шинж чанарууд юм.

Deontological ethics -Деон нь грекээс гаралтай бөгөөд үүрэг хариуцлага гэсэн утга. Зөв зүйтэй гэх зүйл нь сайн сайхан гэсэн ойлголтоос илүүд тавигдаж, зөв болон сайн гэсэн ойлголт нь хоорондоо хамааралгүй гэж үздэг. Ямарваа үйлдлийн үр дагавар нь сайн муу байхаас үл хамааран түүний анхны тодорхойлолтоор зөв ба бурууг тодорхойлдог. Зөв буюу ёс зүйд нийцтэй үйлдэл нь хүмүүний эрх ба үүргээс уламжлагдан тодорхойлогдож болох ба энэ нь хэзээ ч үйлдсэн үйлдлийн үр дүнтэй харьцуулагдах ёсгүй гэж үздэг. Энэ урсгалд үүрэг давамгайлсан, эрх давамгайлсан гэх хоёр хандлага хоёул багтдаг. Зарим тохиолдолд плюрализм (pluralism), контрактианизм (contractarianism) гэж ч үздэг⁵⁵.

Consequentialism -Консекционализм нь аливаа үйлдлийн ёс суртахуун нь тухайн үйл ажиллагааны үр дүнд хамааралтай гэж үздэг. Утилитаризм нь тухайн үйлдлийг хамгийн олон хүнд хамгийн их аз жаргал авчирвал зөв гэж үздэг. 1958 онд GEM Anscombe-ийн "resultentialism" хэмээх нэр томъёог боловсруулж, дараа нь уран зохиолд энэ нэр томъёог нэвтрүүлсэн. Эгоизм, ёс суртахуунтай хүн бол хувийн ашиг сонирхлыг эрхэмлэдэг гэсэн итгэл үнэмшил нь тухайн үйлдлийг өөртөө ашигтай байдлыг хамгийн дээд хэмжээнд байлгах юм бол зөв гэж үздэг⁵⁶.

Оюунлаг үзэл нь мэдлэгийг хамгийн сайн дэмжиж, сурталчлах хамгийн сайн үйл ажиллагаа гэдгийг заадаг. Хамгийн сайн үйлдэл нь хамгийн нийтлэг сэтгэл ханамжид хүргэдэг үйлдэл гэж үздэг утилитаризмыг эрхэмлэдэг.

Хэрэглээний ёс зүй

Applied ethics -Хэрэглээний ёс зүй нь амьдралд тохиолддог аливаа нөхцөл байдалд ёс зүйн онолыг хэрэглэхэд чиглэсэн ёс зүйн философийн салбар юм. Энэхүү салбар нь инженерийн ёс зүй, биотехнологийн ёс зүй, бизнесийн ёс зүй, төрийн албаны ёс зүй, эмчийн ёс зүй, хуульчийн ёс зүй, хэвлэлийн ёс зүй гэх мэт чиглэлүүдэд хуваагддаг⁵⁷.

Хэрэглээний ёс зүй нь бодлогын шинжтэй асуудлаас гадна хувь хүнд тулгарсан ёс зүйн асуултад тодорхой хариу өгч байдаг. Тухайлбал, “Хүний эрх гэж юу вэ? Түүнийг хэрхэн тодорхойлох вэ?”, “Амьтанд эрх гэж байдаг уу?”, “Үр хөндөлт хийлгэх нь ёс зүйтэй үйлдэл мөн үү?”, “Эмчилгээ хийснийхээ төлөө бэлэг авч болох уу?” гэх мэт асуултуудад хариулт өгөхийг зорьдог.

Хүний сэтгэхүй нь аливаа зүйлийг сайн, муу гэж эсрэг тэсрэгийн туйлаар авч үзэх сэтгэлгээнд илүү дассан байдаг. Гэвч ёс зүйн асуудал нь олон талт, төрөл бүрийн “өнгө”-өөс бүрддэг. Иймд ёс зүйн аливаа асуудалд “сайн ба муу”, “зөв ба буруу” гэх тодорхойлолт таардаггүй. Тухайн нөхцөл байдлыг дээрдүүлэхийн тулд олон төрлийн шийдвэр гаргах бөгөөд тухайн шийдвэрүүд нь аль нэг талд тус дэм болох эсэх нь эргэлзээтэй байдаг.

Хэрэглээний ёс зүй нь хувь хүний ёс суртахууны төлөвшилийг сайжруулах, мэргэжлийн ёс зүйг дээшлүүлэх, нийгмийн харилцааг боловсронгуй болгох, нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүн төрөлхтний түүхийн бүхий л цаг үед улс орнууд, эрдэмтэн мэргэд хэрэглээний ёс зүйн асуудалд онцгой анхаарсаар ирсэн билээ. Мэдлэгийн тогтолцоонд хэрэглээний ёс зүй томоохон байр суурь эзэлдэг. Орчин үед дэлхий дахинд хэрэглээний ёс зүйн асуудлаар сургалт, судалгааны ажил улам өргөн цар хүрээтэй болж байна.

⁵⁵ Muel Kaptein, Johan Wempe. Three General Theories of Ethics and the Integrative Role of Integrity Theory. SSRN Electronic Journal · July 2002. P. 18-19.

⁵⁶ Christopher T. Wonnell Published online by Cambridge University Press: 25 November 2011 P. 301 - 317.

⁵⁷ "Applied Ethics" Oxford Bibliographies. Retrieved June 25, 2017.

Эрх зүй ба ёс суртахууны харилцан холбооны тухай асуудал нь философийн үндсэн асуудлын нэг юм. Эрх зүй, ёс суртахууны асуудлаар Сократ, Аристотель, Платон, Гегель, Кант зэрэг сэтгэгчид хүн төрөлхтөнд сургаал, номлолоо үлдээсэн байна.

Францын нэрт сэтгэгч Шарль де Монтескьё 1748 онд гаргасан “Хуулийн амин сүнс” бүтээлдээ “Хүн чөлөөтэй бодох, чөлөөтэй үйлдэх чанарыг эзэмшдэг тул тэрээр ямар шийдвэр гаргах, өөрийгөө хэн болгож төлөвшүүлэх нь зөвхөн өөрөөс нь л их хэмжээгээр хамаарна. Хүний ухамсарт ёс суртахуунтай байх төрлөхийн өгөгдөл оршиж, хүн сайн байх ёстой нь түүний уураг тархин доторх нэг ёсны бодит байдал юм. Хүн сайн мууг ялгаж, бодож, сэтгэж, сонголт хийх чадвараараа бусад амьд амьтнаас ялгагдана”⁵⁸ хэмээн бичсэн байх юм.

Германы гүн ухаанч Перхт “Хүний ёс суртахууны чадвар төрлөхийн гэхдээ хэр их вэ гэдгийг хэлэхэд хүндрэлтэй. Бидний приматаас гаралтай тархи бусдын сэтгэлийг ойлгох боломж өгсөн ба мөн “сайн үйл” хийснийхээ төлөө нейро химийн урамшуулал авахаа ч мэддэг. Иймд ёс зүйтэй зан төрх бол маш нарийн төвөгтэй алтруизм бөгөөд сэтгэл бол он цагийн эргэцүүлэн бодохоос бүтнэ...ёс суртахуунаа ямар түвшинд хэрэглэх нь хүн өөрийгөө хүндлэх хүндлэл болон хүмүүжлээс хамаардаг ” гэж тайлбарлажээ.

АНУ-ын алдарт сэтгэлзүйч Дейл Карнеги өөрийн амьдралын туршлага дээр үндэслэн “хүний харилцаа 30 зарчим”-ыг томъёолон гаргасан байна⁵⁹. Эдгээр аргуудыг эзэмшсэнээр харилцах урлагийг суралцах боловч хамгийн сүүлийн аргыг тэрээр “Чин сэтгэл” хэмээн нэрийдсэн байна. Өөрөөр хэлбэл, хүн дээрх аргуудыг эзэмшиж өөрийн бодол санааг бусдад төвөггүй ойлгуулж, илэрхийлж, бусдыг ойлгож сурах боловч чин сэтгэл байхгүй бол тэр бүх зүйл нь хөндий, хий хоосон зүйл болох гэсэн санааг илэрхийлжээ. Иймдээ ч 100 гаран жилийн өмнө бичигдсэн хүний сэтгэлзүйн тухай ном аль ч нийгэмд, аль ч цаг үед амьдарч байгаа хүмүүсийн сонирхлыг татаж байгаад түүний хүч нь орших мэт.

И.Кант “Ёс зүй бол итгүүлж үнэмшүүлэх гүн ухаан” гэж үзсэн байдаг. Тэрээр ёс зүйтэй байна гэдэг бол “хүн гадны нөлөөгөөр болон өөрийн дотоод итгэл үнэмшил дээр суурилан итгэх явдал” гэж үзжээ. Ёс зүйг үндэслэгч гэгддэг Аристотель “Ёс зүй гэдэг нь хүн юу хийх, юунаас татгалзах ёстойг судалдаг ухааны нэр” хэмээн үзсэн байдаг.

Ёс зүйн судлагдахуун болсон ёс суртахууныг хүний зан байдалтай холбон тайлбарладаг ба түүний дээд хэлбэрийг шударга зан, үнэнч байдал зэрэг эерэг хандлагаар хүмүүсийн амьдралд илэрч байдаг. ёс суртахууны ерөнхий ойлголтуудыг:

- Сайн ба муу;
- Шударга ёс;
- нинжин сэтгэл;
- нэр төр;
- үүрэг хариуцлага хэмээн авч үздэг.

Сайн ба муу: энэ нь ёс зүйн ухааны суурь ойлголт ба хүмүүсийн үйл ажиллагаа, амьдралын зохистой, зохисгүй шинж чанар, үйлдэл, харилцаа, зан байдлын шинж чанар, эерэг хандлагын тухай ойлголт юм. “Би”-гийн онолоор нэгдүгээрт бодит бие (маери) махан бие, хоёрдугаарт дээд бие (ёс суртахууны сайхан чанарууд, үнэт зүйлс, хайр хүндлэл) оюун санаа гуравдугаарт доод бие (муу зан, залхуурал, хуурч мэхлэх худал ярих г.м) буюу муу сэтгэл, шунал, мунхаг сэтгэл юм. Дээд биеэр доод биеийг удирдвал тэр хүн ёс суртахууны өндөртэй явна. Харин доод биеэр матери биеэ удирдвал тэр хүн уруудан доройтно гэж тайлбарлажээ⁶⁰.

Шударга ёс:

Орчин үеийн философи сэтгэлгээнд шударга ёсны дараах нийтлэг шинжүүдийг хүлээн зөвшөөрч байна. Үүнд:

1. Шударга ёс нь нэг л агуулгатай зүйл биш. Шударга ёс нь нийгмийн янз бүрийн харилцаатай тухайлбал, эдийн засаг, нийгэм, улс төр, зан суртахуун, эрх зүйн харилцаануудтай холбоотой. Шударга

⁵⁸ III. Монтескье. О духе законов. Г.Г. Аркадий (франц-перевод). М., 2019. С.201.

⁵⁹ Dale Carnegie. The Quick and Easy Way to Effective Speaking. "The Library of Congress Record". Archived from the original on 2012. Retrieved September 16, 2011.

⁶⁰ М.Азжаргал. Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, түүнийг төлөвшүүлэх зарим асуудал. УБ., 2014. 6 дахь тал.

ёс нь агуулгаа түүхийн хөгжлийн үе шат бүрд өөрчлөхөөс гадна зөвхөн түүхэн нэг тодорхой үе шатны дотор ч өөрчилж болно.

Шударга ёсны хамгийн чухал шинж нь тэгш байдал, пропорциональ байдал, шуналгүй байх, бүгдэд сайн сайхныг хүсэгч байх, объектив бодитой байх, өөртөө шүүмжлэлтэй хандах явдал юм.

2. Шударга ёс нь нийгмийн харилцааны дараах хэлбэрүүдээр илэрнэ. Тухайлбал:

- Бодгаль этгээд ба социал бүлгийн хоорондын, тэдгээрийн социал байдлын нийгэмд гүйцэтгэх үүрэг, бодит байдлын хоорондын;
- Тэдгээр субъектүүдийн эрх, үүргийн хоорондын;
- Үйлдэл ба үр дагаврын хоорондын;
- Хөдөлмөр ба шагнал урамшууллын хоорондын;
- Гэмт хэрэг ба ял шийтгэлийн хоорондын гэх мэт болно.

3. Шударга ёс бол социал субъектийн үйлдлээр орших бодит байдал мөн. Шударга ёс нь зөвхөн субъект-субъект, субъект-нийгмийн институт гэсэн харилцаанд л илэрнэ. Шударга ёсны агуулга болсон бодит байдал нь:

- Хариулгын хэмжээ;
- Шаардлагын хэмжээд;
- Эрх зүйд нийцсэн эсэх тухай үнэлгээний орчин гэсэн гурван хүрээнд оршино⁶¹.

Өөрөөр хэлбэл, шударга ёс нь хувь хүний үйл ажиллагаа нь нийгмийн сайн сайханд тохирч байхыг хэлдэг. Шударга хүн нийгмийн ашиг сонирхлыг харгалзан үзэх үүрэгтэй боловч нийгэм нь бие хүний өмнө хариуцлага хүлээдэг, бие хүн түүнийг үнэлэх эрхтэй байдаг.

Нинжин сэтгэл:

Энэ нь бие хүний өөрийн бодол санаа, мэдрэмж, үйлдлийг зан суртахууны үнэт зүйлсээр дамжуулан өөрийгөө үнэлэх үнэлэмж юм. Нинжин сэтгэл нь хүний зан суртахуунд амьдралыг идэвхжүүлэгч сайн үйл, шударга ёс тогтоох чухал механизм бөгөөд бусдыг хайрлах хайр, энэрэх сэтгэл, сайхан сэтгэлийн илэрхийлэл юм. Хайрлах гэдэг нь ямар нэгэн юмыг өгөхдөө хариу нэхэх бодол төрөхгүй байхыг хэлнэ. Харамгүй хайр нь үнэндээ бусдын сул талыг мартаж, уучлан, хүн болгоны зөвхөн давтагдашгүй гоё сайхныг олж харах чадвартай байдлыг хэлдэг⁶². Өрөвдөх сэтгэл нь нөхцөл байдал, нөхцөл байдлын талаар сэтгэл хөдлөлийг илэрхийлэх сэтгэл хөдлөлийн хамгийн чухал хэсгүүдийн нэг юм. Өршөөл гэж юу вэ? Энэ нь хувь хүнд бусад хүний сэтгэл хөдлөлийг ойлгож, хүн хэвээрээ үлдэх боломжийг олгодог. Ийм төр нь дараах зарчмууд дээр суурилж болно:

- хайр дурлал;
- ойлголт;
- хүндэтгэл.

Ихэнхдээ иймэрхүү сэтгэл хөдлөл нь өөр хүний хувьд сэтгэл хөдлөлийг илэрхийлдэг. Тэдгээрийг янз бүрийн аргаар илэрхийлж болно. Үүнд:

- шаардлагатай буюу зөөлөн үг;
- үйл ажиллагааг урамшуулах;
- материаллаг болон материаллаг тусламж.

Хүмүүсийн сайн зан чанар нь өрөвч сэтгэлийн чадвар юм. Үүнийг цаг хугацаагаар хийх, инээмсэглэлд оруулахгүй байх нь заримдаа халуурах нөхцөлүүд нь хэт их байх бөгөөд өрөвдөх нь сэтгэл зүйн хохирол учруулж болзошгүй магадлал өндөр байдаг.

Нэр төр:

Хувь хүний эрхэм чанар, өөрийн нийгэмд эзлэх байр сууриа ухамсарлаж байгаа байдал, нөгөө талаас тэрхүү үнэ цэнийг нь нийгмийн зүгээс үнэлж байгаа илэрхийлэл байдаг. Нэр төрийг ихээхэн цаг зарцуулж, эерэг хандлага, ёс зүй, үлгэр дуурайлал, хичээнгүй хөдөлмөрөөр олж авдаг ба алдахад амархан зүйл байдаг. Нэр төр нь бусдаар хүндлүүлэх үнэлэмж болдог ч тэр чинээгээрээ бусдын өмнө хариуцлага, итгэл хүлээдэг. Өөрөөр хэлбэл, хүний хийж байгаа үйлдэл бүрийг хэлэх ба нийгмийн харилцаанд оролцож байгаа хүний чадавхын үнэлэмж юм.

Үүрэг, хариуцлага:

⁶¹ Б.Даш-Ёндон “Платон өгүүллэгүүд”, УБ., 1995. 28 дахь тал.

⁶² Мөн тэнд. 9 дэх тал.

Хүний нинжин сэтгэлээс үүсэж, зан үйлээр дамжин илэрч байдаг ёс зүйн гол ойлголт юм. Үүрэг нь хүний үйлдлийн ёс суртахууны зайлшгүй чанар, дотоод хэрэгцээ, нийгмээс хүмүүст тавьж байгаа шаардлагыг хэрэгжүүлэх зан үйл юм. Өөрөөр хэлбэл, хүн төрөлхтний нийгмийн харилцаанд томоохон үүрэг, гүйцэтгэдэг зүйл бол үүрэг хариуцлага. Үүрэг, хариуцлага хоёрыг салгаж боломгүй. Үүргийг дагаж хариуцлага бий болдог. Хариуцлага нь үүргийн биелэлтийн хяналт. Үүрэг, хариуцлагатай салшгүй холбоотой зүйл нь эрх, эрх чөлөө юм.

Үүрэг, хариуцлага хоёр нэг юмны хоёр тал. Үүрэг байгаа газар хариуцлага байна. Аливаад хариуцлагатай хандах нь хүний сайн чанарын нэг илэрхийлэл юм. Өөрийгөө хүндэтгэдэг хүн хариуцлагатай байдаг. Тэд хариуцлага алдвал ихээхэн гэмшдэг. Хүнд олон үүрэг хариуцлага бий. Хувь хүний ёс суртахууны хариуцлагыг нэг талаас өөртөө тавих шаардлага, үүргээ ухамсарлан биелүүлэх байдал, бусдад нөлөөлөх, ухаалаг байх чадвар, нөгөө талаас зан төлөв, зан суртахууны байдал нь тухайн цаг үеийн үнэт зүйлстэй тохирч байгаагаар нь тодорхойлдог.


Гүн ухаантан Г.Гегель үүрэг хариуцлагыг дөрвөн үндсэн төрөл болгож хуваасан байдаг. Үүнд:

- Өөрийнхөө өмнө;
- гэр бүлийнхээ өмнө;
- төр улс улсынхаа өмнө;
- бусдын өмнө хүлээх гэж хуваан авч үзжээ.

Шашинд ёс зүйн үзэл баримтлал:

Шашин (Латинаар Religio - "шүтээн", "сүсэг бишрэл", Religare - "уях, нэгтгэх") гэсэн үгнээс гаралтай ёс суртахууны хэм хэмжээний цогцыг багтаасан ер бусын зүйлд итгэх итгэлээр нөхцөлдсөн тодорхой үзэл бодлын систем юм⁶³. Өнөөдөр дэлхий дээр байдаг шашны тоо тодорхойгүй байна. Зарим тооцоогоор 4200 орчим шашин, сүм хийд, шашны байгууллага, итгэл үнэмшлийн бүлгүүд байгаа гэсэн судалгаа байгаа ба ирээдүйд энэ тоо өсөх хандлагатай байна⁶⁴.

Шашин нь дагалдагчдынхаа шүтдэг бурхдын тооноос хамааран хуваагддаг: олон бурханд итгэх нь политеизм, нэг бурханд бурханд итгэх үзлийг монотеизм гэж нэрлэдэг. Дэлхий дээр олон төрлийн шашин байгаа боловч хүн төрлөхтөнд хүлээн зөвшөөрөгдсөн Христ, Мусальман, Хинди, Агностики, Буддист гэм мэт шашингууд байдаг. (Зураг №1)



Религиозные и безрелигиозные группы численностью более 10 млн. человек,

⁶³ Елена Казарина Религия — статья из энциклопедии «Кругосвет». (хандалт: 2020.01.10) https://www.krugosvet.ru/enc/kultura_i_obrazovanie/religiya/RELIGIYA.html

⁶⁴ "World Religions Religion Statistics Geography Church Statistics". Retrieved 5 March 2015.

Шашин бол хүн төрөлхтнийг ер бусын, трансценденталь (чандаас халих) болон оюун санааны элементүүдтэй холбодог зан үйл, ертөнцийг үзэх үзэл, ёс суртахуун, дадал зуршил, бичиг соёл, зөгнөл, ёс зүй, сүнслэг биетэй холбодог ариун газар, нийгэм-соёлын цогц тогтолцоо юм⁶⁵. Гэсэн хэдий ч “Шашин” гэж чухам юу болох талаар эрдэмтдийн санал одоо болтол нэгдсэн дүгнэлтэд хүрээгүй байна.

Нийгэм-соёлын антропологийн ерөнхий салбаруудын нэг болох шашны антропологи гэдэг нь аливаа шашин, шүтлэг бишрэлийн хэлбэр, шашны байгууллагууд, түүний харилцаа холбоог тухайн болон бусад нийгмийн байгуулал, бүтэцтэй харьцуулан соёл дамнасан судалгаа хийдэг гэж болно. Энгийн үгээр бол хүний нийгэм соёл гэдэг нь бие биеэс нь салгаж тастаж аваад судлаад байдаг бүрэлдэхүүн хэсгүүдтэй бус харин ч бие биетэй нь нягт уялдаа холбоотой авч судлах ёстой бүтцүүдтэй байдаг. Ийм тул шашны антропологи нь аль нэг нийгмийн шашныг судлахдаа уг нийгмийнх нь бусад хэсгүүдтэй ч харьцуулан судалдаг гэсэн үг. Тэгвэл эл салбар ухаан шашин судлал хэмээх ухаанаас ямар ялгаа зааг болон ижил талтай юм гэсэн асуулт хэн бүхэнд төрнө.

Шашин бүр ёс зүйн талаар нарийвчлан авч үзсэн байдаг.

Ёс зүйтэй хүн буюу зөв хүн байх талаар олон арван сургаал байх ажээ. Тухайлбал, бурхан багшийн сургаалд " Өглөгч зан, ёс суртахуун, тэвчээр хатуужил, зориг, бясалгах чадвар, оюун ухаан зэрэг хүнийг төрөх, үхэхийн ертөнцөөс гэгээрэхийн ертөнцөд авчирдаг 6 парамит буюу барамид буй гэж үздэг. Японы хавар, намрын “Хиган” хэмээх долоо хоногууд бурхны шашны энэхүү ухагдахуунаас үүдэн гарчээ⁶⁶”.

Христийн шашны (Загалмайн шашин) ёс суртахууны буюу ёс зүйн сургаал нь хүний зан үйлийн ёс суртахууны удирдамжийг тодорхойлдог. Хүний зан байдал нь хүний мөн чанар, зорилго, бурхантай харьцах харьцааны талаарх Христэд итгэгчдийн үзэл баримтлал дээр суурилдаг. Христийн шашны ёс зүйг христийн үйл ажиллагааны онол гэж нэрлэж болно⁶⁷.

Христийн шашны ёс зүй нь Христийн шашны ёс суртахуун, амьдралын тодорхой хэв маягаар илэрхийлэгддэг, түүний илрэл нь олон янз байдаг бөгөөд хувь хүмүүс, христэд итгэгчдийн нийгмийн томоохон бүлгүүдэд байдаг.

Загалмайн шашин буюу Христийн шашин нь 1-р зуунд үүссэн бөгөөд Ромын Эзэнт Гүрний Иуда мужад иудей буюу жүүд (израйль) хүмүүсийн дунд бий болсон. XVI зуунд Ромын католик шашнаас эх авч, шинэчлэгдсэн үзэл санааг түгээх Протестант урсгал бий болсон бөгөөд Протестант урсгал нь дотроо маш олон сектерүүдэд хуваагдах болжээ.

Ислам (الإسلام) гэдэг үг нь Араб хэлний "дуулгавартай байх" гэсэн утгатай. Сүсэгтэн лалын шашинтнуудын Бурханд хандах хандлага бол хувь тавилангаа сохроор биелүүлж байгаа үнэнч, шүүлтгүй үйлчлэгчийн хандлага юм. Энэхүү шашин нь итгэгчдийн тоогоороо Христийн шашны дараа орох дэлхийн томоохон монотеист Абрахамын шашин билээ⁶⁸. Монголчуудын хэрэглэдэг "Лал" хэмээх үг нь Төвд хэлний "Лало" буюу Буруу номтон гэсэн үгнээс гаралтай буруу ойлголт бөгөөд дэлхийн бүх хэлэнд Исламын шашин, мусульман хэмээн хэлэгддэг. Ислам гэдэг нь шашных нь нэр, мусульман гэдэг нь шүтэн бишрэгчдийг нь хэлнэ.

Коран судар бол Исламын канон ба сургаалын гол эх сурвалж юм. Үүний үндсэн зарчмууд нь ёс суртахууны асуудлыг авч үздэг. Түүнчлэн, Лалын шашинтнуудын амьдралын талыг Сунна (Мухаммедын хэлсэн үг, үйлдлийн тухай домог цуглуулах) болон Шариат (Лалын шашны хууль тогтоомжийн системчилсэн код) -д үнэлэв. Тэнгэрлэг нигүүлсэл нь бүх газарт байдаг бөгөөд бүх зүйлийг хамардаг гэж Кур'ан-и Кэрим тунхагладаг. “Бидний Эзэн бол байгаа бүхнийг бүтээж, дараа нь түүнд шулуун замыг харуулсан хүн юм⁶⁹”

Исламын соёлд "Зорилго-үйлдэл" гэсэн харилцаа нь хамгийн чухал бөгөөд ёс зүйн хүрээтэй холбоотой бүхий л ойлголтод хамаатай. Тиймээс, Исламын "фатализм" -ын талаарх одоо байгаа үзэл

⁶⁵ Morreall, John; Sonn, Tamara (2013). "Myth 1: All Societies Have Religions". 50 Great Myths of Religion. Wiley-Blackwell. p. 12–17.

⁶⁶ Бүккё Дэндо Кёкай. Монгол орчуулга: Токио 2017. 315 дахь тал.

⁶⁷ Закон Божий / Под ред. А. Блинского. — Санкт-Петербург: Сатисъ, 1997. — С. 110.

⁶⁸ Ислам / И. Л. Алексеев, Д. Ю. Арапов, В. О. Бобровников, Т. К. Ибрагим; Т. Х. Стародуб // Излучение плазмы — Исламский фронт спасения. — М. : Большая российская энциклопедия, 2008. — С. 741. — (Большая российская энциклопедия).

⁶⁹ Ариун Коран, 20:50) <https://trksunpark.ru/mn/islamskii-kodeks-medicinskoi-etiki-musulmanskaya-etika-musulmanskaya/>

бодолтой холбогдуулан Найдвар нь тодорхой зорилгод чиглэсэн үйл ажиллагаа хэлбэрээр илэрхийлэгддэг бөгөөд энэ нь тэдний ухамсрын үр дүн юм⁷⁰. Тиймээс Ислам дахь ёс суртахууны үнэлгээний объект нь гадаад (үйл ажиллагааны хувьд) ба дотоод (зорилго тодорхойлох) хоёрын салшгүй холбоос юм. Зөвхөн тэдний эв нэгдэл нь тухайн үйлдлийг ойлгох бүрэн байдал, ерөнхийдөө хүний сонголтыг олж авахад тусалдаг. Бурханд итгэх итгэлд мөн адил хамааралтай бөгөөд үүнийг гадны үйлдэл (мэдэгдэл) -ийг нэгтгэх, итгэлийг илчлэх, түүний дотоод туршлагыг ойлгох явдал юм.

Лалын ёс зүй дэх "гэм буруу" ба "нүгэл" гэсэн ойлголтууд нь юуны түрүүнд хорон муу зүйлд хутгалдах бус харин "зохих журмыг зөрчих", "заавал биелүүлэхгүй байх" -тай холбоотой байдаг. Исламын шашны сургаалд анхны гэм нүглийг дурдаагүй бөгөөд хүн төрөлхийн нүглийг хүлээн зөвшөөрөхгүй байх нь энэхүү ойлголтыг хөнгөвчилдөг. Абу Жафар Мухаммед бин Якубагийн хэлсэн үг: "Зөв үйлдлийг бий болгодог зөв үг бүхэн бол мэргэн ухаан юм"⁷¹

Буддын шашин:

Манай эриний өмнөх YI зуунд Энэтхэгт үүссэн хамгийн эртний шашин юм. Буддын шашныг хан хүү Сиддхартхи Гаутам бий болгосон гэж үздэг. Хан хүү Гаутам бясалгалын ачаар амьдралын утга учраг олж 35 насандаа Будда болсон байна. Энэхүү төв зам мөрийг тэрээр хутагтын 4 үнэн, 8 гишүүнт зам мөр гэсэн сургаалуудаараа тайлбарлажээ. Хутагтын 4 үнэн:

- Зовлон буй
- Зовлон шалтгаантай буй. Тэр нь шунал
- Шунал үгүй бол зовлон үгүй
- Зовлонг устгах арга зам буй.

Зовлонгоос гарах тэрхүү зам мөр нь Хутагтын 8 гишүүнт зам мөр юм. Энэ зам мөр нь 3 хэсэгт хуваагддаг. Шилла буюу зөв явдал, самади буюу сэтгэлийн төвлөрөл, панья буюу сэтгэлийг бүрэн цэвэрлэн ариусгах билгүүн ухааныг үүсгэх байдаг.

Ёс суртахуун судлалын томоохон орон зайг шашин эзэлдэг. Ялангуяа дундад зууны үед ёс суртахууны ихэнх хэм хэмжээ шашны гэгээнтнүүдийн номлосон сургаалуудад үндэслэж байсан. Дундад зууны шашны ёс зүй нь нүгэл буян, зөв буруу үйлдэл, нүгэл үйлдэх, нүглээ наминчлах, сэтгэлийн ариусал, оюуны гэгээрэл гэсэн шинэ ойлголтуудаар ёс суртахуун судлалыг өргөтгөсөн билээ.

Хүн ер нь шашинд шүтлэгтэй эсвэл шүтлэггүй байх нь тийм чухал биш ч хүмүүст эдгээр ёс суртахууны зарчмын боловсролыг хэрхэн олгох вэ гэдэг талаар илүү нухацтай бодох нь чухал билээ. Шашин бүр хүнийг сайн сайхан зүйлд дагуулах, муу муухай бүхнээс хол байж, ёс суртахуун, ёс зүйтэй байх талаар сургадаг байна. Бидэнд ёс суртахууны манлайл, тунгаан бодох, бусдын оронд өөрийгөө бодож үзэх, хүнийг хүн ёсоор бодож үзэж чаддаг байх нь хамгаас чухал билээ. Иймд иргэний (бүх нийтийн) ёс зүйг төлөвшүүлэх хүчин чармайлт гаргахад бидэнд олон өөр хүчин зүйл, практик үйл ажиллагаа шаардлагатай гэж үзэж байна.

Шашны олон урсгал чиглэлүүд энэрэн нигүүлсэхүй, хайрлахуй, хүлцэн тэвчихүйн үзлээр нийгмийн ёс суртахууны хэм хэмжээнд эерэг нөлөөлөл, үнэтэй хувь нэмрийг оруулсан. Гэхдээ шашны ёс зүйд “Бүтээгч хүчинд итгэх, номлолыг шүүн тунгаалгүй дагах, хувь хүний эрх чөлөөг хязгаарлах, сургаал айлдагчийн хуурамч төрх, шинэчлэл өөрчлөлтөөс хоцорсон” зэрэг олон алдаа дутагдал илэрч, эдгээр нь цагийн аяс, нийгмийн шинэчлэл өөрчлөлттэй тохирохгүй байсан тул нийгмийн ёс суртахууны хэм хэмжээнд нөлөөлөх байр суурь нь аажимдаа алдагдсан байна.

Ёс зүйн шинжлэх ухаан түүхэн хөгжлийнхөө явцад дараах үндсэн зорилгуудтай байсан. Үүнд:

- Зөв буруу, сайн муу, сайхан муухайн талаар мэдлэг олгох, ялгах, буруу, муу, муухайгаас ангид байх чадвар эзэмшүүлэх;
- Хүний зөв төлөвшихөд, амьдрах ухаанд сургахад туслах;
- Ёс суртахууны итгэл үнэмшлийг төлөвшүүлдэг;
- Хүнд биеэ авч явах ёсны тухай мэдлэг олгох, нийгэмд биеэ зөв авч явах чадвар эзэмшүүлэх;

⁷⁰ Мөн тэнд

⁷¹ (Holy Quran, 6; 6) <https://quran.com/> (хандалт: 2020.01.10)

- Зан суртахууны бодит үйл явц, зан төлөвийн шинжүүдийг судлах, зан суртахуундаа дүгнэлт хийх, ёс суртахуунлаг болох аргуудыг эзэмшүүлэх;
- Хүний өөртөө, бусдад, байгальд, нийгэмд, ажил хөдөлмөртөө, эд зүйлд хандах хандлага, харилцааг зохицуулах;
- Өөрийн, гэр бүлийн, байгууллага хамт олны, улс орны, нийгмийн, байгаль эхийн өмнө хүлээх үүрэг хариуцлага, эдлэх эрх, тэдгээрийн нэгдлийг ухааруулан ойлгуулах, үүрэг хариуцлагаа хүлээх чадвар эзэмшүүлэх;
- Төрд- ёс зүй нөлөөллийн ач холбогдол. Төрийн удирдлагуудад иргэдээ сайн сайхан амьдруулах үүргээ ёс суртахуунлаг гүйцэтгэх;
- Ёс суртахууны соёл эзэмшүүлэх;
- Хүн төрөлхтний гол оршин тогтнох үндэс болдог⁷².

Монгол ёс зүй, ёс суртахуун:

Ёс зүйн шинжлэх ухаан нь улс үндэстний хувьд ялгаатай байдаг байна. Энэ нь тухай улсын хүмүүсийн зан суртахуун, зан заншил, соёл, түүх, газар орны байдал нөхцөл байдал зэргээс хамаардаг ажээ. Монголчуудын хувьд ёс зүй түүний судлагдахуун болох ёс суртахуун нь хүн нийгэмд хэрхэн биеэ авч явах ? юуг ? яаж хийх ? гэсэн бичигдээгүй дүрмээр уламжлагдаж иржээ.

Түүхэн уламжлалаас үзвэл хувь хүний ёс суртахууныг төлөвшүүлэхдээ гэрийн сургууль, ардын аман зохиол, үлгэр домог, зүйр цэцэн үг, хууль цаазын бичгүүдийг голлон ашиглаж байжээ⁷³.

Хөх сударт ёс суртахууныг Чингис хаан “хүний хүндлэгдэх хөнгөлөгдөх өөрийн биед буй⁷⁴” хэмээсэн байна. Тухайн үеийн монгол үндэстнийг мунхаг бядуу хэмээн гадуурхан басамжилж байсан харийныхны доромжлолыг эсэргүүцэж, үндэснийхээ цог сүлдийг мандуулах, монголын ноёд тайж нараас, үндэс язгуураа бодолгүй эд ашгийн боол болж, монгол тоотны дийлэнх үндэстнийхээ түүх, зан заншил, ёс суртахуун, соёл, уламжлалыг мэдэхгүй, үндэстнээ голж, жигших үзэл буй болж байсныг шүүмжлэн сэнхрүүлж, үндэстнээ хайрлах сэтгэлийг буй болгох, харь үндэстний бичиг зохиолд монголын түүх заншлыг гуйвуулан тэмдэглэсээр ирснийг няцааж залруулах, бүх монгол тоотондоо уг түүхийг нь мэдүүлж, улмаар хойч үеийнхэнд уламжлан үлдээхийг зорьсон хэмээжээ. Энэхүү зохиол нь нийгэмд ёс суртахуунгүй ихсэж, өөрийн түүх, зан заншил, соёл уламжлалаа үгүйсгэвэл улс орон мөхөлд хүрч болох талаар тодорхой тусгасан зохиол билээ.

Академич С.Нарангэрэл “Ёс суртахуун бол аливаа хүний зан суртахууны эрхэм нандин чанарын цогц юм. Эсрэгээр ёс суртахуунгүй гэж зан суртахууны эрхэм нандин чанарыг хөсөрдүүлэхийг хэлнэ. Ёс суртахууны өгөгдөл оюун ухаан нь эрүүл аливаа хүний уураг тархинд мөнхөд оршдог ажээ. Хүн гэгч бодгаль сэтгэлийн сайн ба муугийн буюу ёс суртахууны инстинкттэй төрнө⁷⁵” гэж үзсэн байна.

Ёс суртахуун нь нийгмийн харилцааны нэг хэлбэр болохынхоо хувьд зан суртахууны мэдрэмж болон ёс суртахууны ухамсарт тусгалаа олдог. Бие хүний сайн үйл, хэм хэмжээ, хууль дүрэм гэх мэтийн шаардлагууд нь ёс суртахууны харилцааны өвөрмөц хэлбэрүүдийг өөртөө агуулж байдгаараа үнэн хэрэгтээ бодит байдлын шууд илэрхийлэл нь болж байдаг. Ёс суртахууны ухамсрын хэлбэрүүдийн цаана хувь хүн, нийгмийн бодит харилцааны хэв маяг оршиж байдаг. Өөрөөр хэлбэл, ёс суртахууны ухамсрын гол хэмжүүр болох сайн муугийн тухай ойлголт нь хүн бүрийн амьдрал үйл ажиллагаа болон нийгмийн харилцааг бүхэлд нь илэрхийлдэг.

Монголчууд бусад ард түмний адилаар арвин баярлаг домгийн /миф/ сэтгэлгээтэй байсан бөгөөд түүгээрээ дамжуулан зан заншил, түүх, ёс суртахууны үзэл санаагаа өвлүүлэн иржээ. Аман хэлбэрээр үеэс үед уламжлал болон ирсэн домог, үлгэр, туульдаа байгалийн болон хүний мөн чанар, хувь хүний шинж байдал, амьдралын утга учир, нүгэл, буян, зовлон бэрхшээл, түүнийг даван туулах арга замын талаар өгүүлж байв.

⁷² Б.Оюунчимэг “Бизнесийн ёс зүй”, УБ., 2012 он.102-103 дахь тал.

⁷³ Д.Тунгалаг. Ёс зүйн зангилаа асуудлууд. 23 дахь тал.

⁷⁴ В.Инжаннаши Хөх судар. Монгол бичгээс хөрвүүлсэн оршил бичиж, тайлбар зүүлт хийсэн Ш.Чоймаа, М.Баярсайхан., УБ., 2009.

⁷⁵ С.Нарангэрэл. Чингис хааны ёс суртахуун-эрх зүйн шастир бурхан халдун-монгол туургатны голомт. УБ., 2021 он. 24 дэх тал.

Монголын эзэнт гүрний үе: Энэ цаг үед хүн төрөлхтний ёс суртахууны сэтгэлгээний хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан зохиол бүтээлүүдийг туурвисан байна. Тухайлбал, Монголын нууц товчоо, Эрдэнийн сан субашид, Оюунтүлхүүр нэрт шастир, Чингэсийн билиг, Чингисийн тамганы бичиг, Чингисийн есөн өрлөгтэй өнчин хүүгийн цэцэлсэн шастир, Их засаг хууль, Арван буянт номын цагаан түүх зэрэг зохиол бүтээлээс гадна бөө мөргөлийн яруу найраг, ардын аман зохиолд энэ цагийн монголчуудын ёс зүйн сэтгэлгээ тусгалаа олж байжээ. Энэхүү бүтээлүүдэд ёс суртахууныг ихэвчлэн сургамжилсан байдлаар шүлэглэн бичсэн байна.

Тухайн үеийн монголчуудын ёс нь өтгөс дээдсээ хүндлэх ёсыг цэрэг эрс хийгээд иргэдийн сахилгын чухал үндэс гэж үзэж байв. Үр хүүхэд нь эцэг, эхийн сургаалыг үл авах, дүү нар нь ах нарын ятгалгыг үл сонсох, гэргий нь хань ижлээ үл хүндэтгэх нь гэр бүл болоод улс орон доройтох, өстөн дайсан ялагдахын шинж хэмээн үзсэн байдаг.

Чингис хааны ёс суртахууны талаар судлаачид ийн үзжээ. Монголын уламжлалт ёс суртахуун нь “шударга ёс, эр зориг, ичих ба эмээх сэтгэл, үүрэг хариуцлага, жудаг, нинжин ба өрөвч сэтгэл, нэр төр, үнэн, итгэл, тэсвэр тэвчээр, эе эв, өгөөмөр сэтгэл, үл хомхойрох, атаа, хонзон эс өвөрлөх, урвашгүй сэтгэл, найрсаг, зочломтгой зан, эцэг эхийн энэрэл, үрийн элбэрэл, эр хүний холч ухаан, бүсгүй хүний эрхэмсэг оршихуй, ах захаа хүндлэх, багшийн эрдэм оюун, мэргэдийг түших ухаан, сархдыг тэвчих ухаан”⁷⁶ зэргийг авч үзсэн байна.

Үүнээс харахад монголчуудын уламжлалт ёс зүй, ёс суртахуун нь нарийн дэг жаягтай ба үр хүүхдээ хүмүүжүүлэх, тэдний зан байдлыг төлөвшүүлэхэд сургамжит өгүүллэг, үлгэр, домог, туульс зэргээр дамжуулан сургадаг байжээ.

Хандлага

Одоо үед чадвартай мэргэжилтэн олон боловч ёс суртахууны доголдлын улмаас ажилдаа алдаа гаргаж тэр нь ажлын үр дүнд сөргөөр нөлөөлж, хамт олон цаашлаад ард иргэд, нийгмийг хохироох явдал ихээр үзэгдэх боллоо.

Өнөөдөр монгол улсын боловсролын салбарын шинэчлэл ихээр яригдаж байна. Тэгвэл боловсролын салбарын шинэчлэлд хувь хүний хөгжил, ёс суртахууны асуудал гол байр суурийг эзлэх болжээ. Хувь хүний төлөвшил хүмүүжил нь нийгмийн дэвшил хөгжлийг тодорхойлогч нөхцөл, үндсэн зорилтын нэг юм.

Ихэнх шинжлэх ухаан оюунд суурилдаг. Тэгвэл ёс зүйн шинжлэх ухааны бусад шинжлэх ухаанаас ялгарах нэг онцлог бол сэтгэлзүйд суурилдаг явдал юм. Мөн хүний амьдралын зөв хандлагыг хэлж өгдөг. “Attitude”⁷⁷ буюу “Хандлага” гэдэг нь нөхцөл байдал болон ямар нэг зүйлийн тухай мөн бусад хүмүүсийн талаар тааламжтай болон тааламжгүй аль нэг байдлаар үнэлэх сэтгэлгээний үнэлэлт юм.

АНУ-ын сэтгэл зүйч Gordon Allport "Хандлага нь орчин үеийн нийгмийн сэтгэлзүйн хамгийн өвөрмөц бөгөөд зайлшгүй чухал ойлголт" мөн “Хандлага нь тухайн хүний өнгөрсөн ба одоо үеэс бүрэлдэн тогтдог”⁷⁸. гэж тодорхойлсон байдаг.

Доктор С.Наранчимэг “Хандлага гэдэг нь аливаа юманд болон хүнд хандах үйл бөгөөд, энэхүү хандлага нь дотоод сэтгэлээс хамааран эерэг ба сөргөөр илэрхийлэгддэг. Хандлагаа өөрчилнө гэдэг нь бодлоо өөрчилнө гэсэн үг. Амьдралынхаа туршид хуримтлуулж буй мэдлэг ухааны сан хөмрөг нь бодлоо өөрчлөхөд тусалдаг”⁷⁹ гэсэн байна.

Хүн бүр өөр өөр хандлагатай байдаг. Тухай хүний ямарваа юмыг хэрхэн бодож байгаа нь хандлагатай шууд холбоотой. Хүн олон төрлийн хандлагатай байдаг. Тухайлбал, өөртөө хандах, бусдад, ажил хөдөлмөрт, үйл ажиллагаанд, нийгэмд, байгаль дэлхийдээ г.м. Эдгээр хандлагуудаас суурь

⁷⁶ Мөн тэнд. 3 дахь тал.

⁷⁷ <https://dictionary.cambridge.org/dictionary/english/attitude>

⁷⁸ Allport, Gordon. (1935). "Attitudes," in A Handbook of Social Psychology, ed. C. Murchison. Worcester, MA: Clark University Press, P.789-844.

⁷⁹ С.Наранчимэг Хандлагын ид шид. Уб., 2008. 5 дахь тал.

хандлага нь өөрөө өөртөө хандах хандлага юм. Өөртөө зөв (шударга) хандаж байж бусдад хүнлэг хандах явдал юм.

Тухайн нөхцөл байдалд хүн болсон үйл явдлыг яаж хүлээн авч, өөрийгөө яаж илэрхийлж байгаа үг хэл болон үйлдлийн илрэл юм.

Хүний сэтгэлгээний хандлага нь тухайн хүнийхээ хувь заяанд шууд нөлөөлдөг бөгөөд эерэг, сөрөг 2 хандлагаар илэрхийлэгддэг.

Эерэг сэтгэлгээ гэдэг нь аливаа зүйлийн сайн, сайхан, өөдрөг талаас нь харж, аливаа бэрхшээлийг даван туулах арга замыг харж чадах тэр чадварыг бол ойлгож болно.

Сөрөг сэтгэлгээ гэдэг нь байнга болж бүтэхгүй, дутагдалтай талыг харж даг учраас хүнийг урагш бус хойш чангааж байдаг. Одоо танд эерэг зөв хандлага л хэрэгтэй. Ихэнх ололт амжилтууд ч зөв хандлагаас улбаатай байдаг.

Мэдлэг, чадварыг хөдөлгөгч гол хүч бол хандлага юм.

Бодол: Хандлагаа өөрчлөхийн тулд бодлын нууцад нэвтрэх ёстой “Бодол гэдэг нь хүний уураг тархинд урсаж буй эмх замбараагүй үйлүүд. Харин жинхэнэ сайн хүн болохын тулд “бодлоо” хянаж аливаа юмыг олон талаас нь эргэцүүлэн, шүүн тунгааж, зөвхөн эерэг бодлыг бий болгох дадалд суралцах процесс юм”⁸⁰.

Тунгаан бодох чадвар гэдэг нь тодорхой дарааллын дагуу асуудал дэвшүүлж сайтар эргэцүүлэн бодохыг хэлнэ. Мөн дүгнэлт, итгэл үнэмшилд хүрэхийн тулд үндэслэл болон логикийг бүтээлчээр ашиглахыг хэлж болно. Тунгаан бодох чадварт аливаа мэдээлэл болон итгэл үнэмшилд дүн шинжилгээ хийх, сонсож буй зүйлээ үнэн эсэхийг тогтоох чадвар багтана. Түүнчлэн ертөнцийн олон янзын хэв маяг, өнгө төрх дундаас санаа бодлоо ургуулж түүнийгээ сургамж, туршлагатай холбон үзэх боломж олгодог. Үндэслэл сайтай шинэ онол боловсруулах, мөн бодитой, сайтар томъёологдсон нотолгоо гаргаж ирэхэд тунгаан бодох чадвар зайлшгүй шаардагдана.

Харилцаа хандлага хоёр нягт холбоотой бөгөөд харилцааны явцад хандалга мэдрэгддэг. Мэргэжлийн ёс зүйтэй болохын тулд харилцааны ур чадварт суралцах хэрэгтэй болдог.

Харилцаа: Бидний амьдрал бүхэлдээ харилцаан дээр тогтдог. Харилцааны хэв маягийг бид гэр бүлийн орчноосоо олж авсан хүмүүжлээс гадна, сургууль, боловсролын байгууллага, ажил, бизнесийн орчин, интернэт орчин, хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэх мэт зүйлсийн нөлөөгөөр олж авсан мэдлэг, мэдрэмжээрээ бий болгон бэхжүүлж, хөгжүүлж, шаардлагатай бол таслан зогсоож, шинэ харилцааг эхэлж байдаг. XXI зуун бол оюун санааны хүмүүс хоорондын харилцааны зуун өөрөөр хэлбэл таны хандлага ямар байна вэ гэдгээс хамаарч таны хэн байх нь тодорхойлогдож байдаг.

Харилцаа гэдэг нь хүн хоорондын ойлголцол юм. Зөвхөн мэдээлэл дамжуулах төдий биш харин бүлэг хамт олны амьдралын гүнд хүмүүс бие биетэйгээ харилцан үйлчлэх, үзэл бодол, итгэл үнэмшил, хандлагаа солилцох, өөрөөр хэлбэл, тогтсон хандлагыг төлөвшүүлэх, нийгэм-түүхийн туршлагыг эзэмших үйл явцыг харилцаа гэдэг.

Сүүлийн жилүүдэд хүний оюуны чадварыг ойролцоогоор хэмжих төрөл бүрийн тест аргачлалууд нэвтэрч байна. Хүний баруун тархины чадварыг (EQ-Emotional Quotient) гэдэг итгэлцүүрээр, зүүн тархины чадварыг (IQ-Intelligent Quotient) гэдэг итгэлцүүрээр хэмжиж байна. Зүүн ба баруун тархи нь хоорондоо байнга мэдээлэл солилцож байдаг. Энэ солилцох хурд хурдан үр дүнтэй байх тусам оюуны чадвар өндөрсөнө гэж үздэг. Зүүн баруун тархины хөгжлийн балансыг бариулахад бясалгал гэх мэтийн маш олон арга хэрэглэх болжээ.

Алдарт менежер Lee Iacocca “Менежерийн Замнал” номондоо “Амжилтын үндэс бол маш их мэдээлэл боловсруулахад биш. Би чухал шийдвэр гаргахдаа зөн билэгтээ итгэх тохиолдол маш олон байдаг⁸¹” гэжээ. Мөн АНУ-ын ерөнхийлөгч асан Доналд Трамп “Баялагт хүрэх зам” номондоо “Би

⁸⁰ Мөн тэнд 7 дахь тал.

⁸¹ Lee Iacocca career manager An Autobiography : [пер. с англ.] / Ли Якокка, Уильям Новак. — 2 изд. — Мн. : Попурри, 2002. — С.448.

хүнтэй ярьж эхлээд тэр хүний амнаас гарсан эхний 10 үгийг нь сонсоод л дараах 40 үг нь ямар болохыг зөнгөөрөө хэлж чаддаг гэжээ”. Эдгээр жишээ нь дээрх хүмүүс баруун зүүн тархиндаа ижил ач холбогдол өгч байгааг харуулж байна. Дайны дараахан АНУ-д хүний оюун ухааныг IQ буюу зүүн тархины хөгжлөөр хэмжиж ажилд авахдаа хүртэл гол шалгуур болгож байсан. Гэтэл практик дээр IQ багатай боловч оюуны EQ –тэй хүнээс илүү амжилт гаргасан хүмүүс гарч ирсэн. Ер нь хүмүүсийн харилцаанд сэтгэлийн хөдөлгөөн маш чухал үүрэгтэй. Амьдрал дээр өөрийн сэтгэл хөдлөлөө амжилттай удирдах бусдын сэтгэл хөдлөлийг ойлгох нь дан ганц мэргэжлийн ажил үүргээ амжилттай гүйцэтгэхээс дутуугүй үүрэгтэй гэдгийг харуулсан.

Аристотель “Сэтгэлийг төлөвшүүлэхгүйгээр оюуныг хөгжүүлэх нь огтхон ч боловсрол биш” гэж хэлсэн байдаг. Харин XIV дүгээр Далай лам “Хэрвээ бид эерэг оюуны хандлагатай байх юм бол бид ямар ч дайсагнал, өшөө хорсол дунд байлаа ч гэсэн сэтгэл дотор маань амар амгалан байдал оршсоор л байх болно. Хэрвээ айдас сэжиг, амиа бодох, өөрийгөө үзэн ядах гэх мэт сөрөг оюуны хандлагатай байвал, сайн найз нөхдөөрөө хүрээлүүлж, тансаг тохилог орчинд байлаа ч гэсэн бид аз жаргалыг мэдэрч чадахгүй л байх болов уу. Ийм учраас эерэг оюуны хандлага юунаас ч илүү чухал бөгөөд энэ нь биднийг амьдралдаа аз жаргалыг олж хардаг болоход туслах юм⁸²” гэж айлдсан байх юм.

Хандлагын ач холбогдол:

- Хүмүүсийн хооронд ялгааг бий болгодог;
- Хүмүүсийн амжилтад хүргэдэг;
- Гэр бүлийн амьдралын аз жаргалд хүргэдэг;
- Хүмүүсийг манлайлж, хошуучлагч болоход тусалдаг.

Эерэг хандлага хүнд сууснаар:

1. Аливаа зүйлийг хүлээн авах чадвар сайжирч;
2. Стрессээс үүсэх өвчлөл тусахгүй ;
3. Тэсвэр, тэвчээртэй болдог.

Орчин цагт хүний амжилтад хүрэх нь дан ганц авьяас чадвар, оюун ухаанаас хамаарахгүй сэтгэлийн хандлага, хүсэл, эрмэлзлээс хамаардаг болохыг эрдэмтэд үзэх болсон.

Эерэг хандлагыг төлөвшүүлэх нь:

Хүний хандлагыг хоёр үндсэн аргаар өөрчилж болно.

1. *Хүнийг дотоод сэтгэл, оюун бодлоор нь өөрчлөх* буюу ямар нэгэн ухуулах яриа хийх эсвэл тухайн хүн өөрөө бясалгаж бодож ойлгох замаар. Ийм төрлийн нэг жишээ бол бясалгал юм. Бясалгал нь сэтгэлийн сайн төлөвүүдийг төлөвшүүлэх нэг арга юм. Үүнийг тухайн сэтгэлийн төлөвүүдийг зуршил болтол дахин дахин төрүүлэх замаар хийдэг. Бие организмын хувьд бясалгал шинэ мэдрэхүйн замуудыг бий болгодог.

2. *Үйл хөдлөлөөр дамжуулж хандлагыг өөрчлөх.* Учир шалтгааныг нь хэлж тайлбарлах гэхээс илүү тухайн үйл хөдлөлийг хэвшүүлэх замаар хандлагыг өөрчилнө гэсэн үг юм. Жишээ нь, хүнтэй мэндлэх, өглөө эрт босох, цаг барьж сурах, эсвэл баярлалаа гэж тогтмол хэлдэг болох зэргээр. Зөв үйлдэл хийсний үр дүнгүүд нь тухай хүний хандлагад нөлөөлдөг байна.

Дүгнэлт. Бид дээрх бүгдийг нэгтгэн дараах дүгнэлтэд хүрч байна.

1. Нийгмийн хөгжлийг тодорхойлогч нэг чухал хүчин зүйл бол нийгмийн ёс суртахууны төлөвшил байдаг ба ёс суртахууны төлөвшил ямар байна вэ гэдгээс хамаар ч тухай улс үндэстний соёл, хөгжлийн түвшин тодорхойлогддог юм байна.

2. Нийгэм боловсронгуй болж, хөгжил дэвшил нэмэгдэх хэрээр ёс зүйн үүрэг, хариуцлага улам бүр нэмэгдэж байна. Ёс зүй нь шинжлэх ухаан, философи, шашин гэсэн 3 түвшинд судалдаг юм байна.

⁸² Dalai Lama. The Art of Happiness. New York. 2009. P.200.

3. Ёс зүйн шинжлэх ухааны ойлголт, ач холбогдол, үүргийг судалж бүх нийтийн боловсролоор ёс зүйн шинжлэх ухааныг түгээн дэлгэрүүлж, ирээдүй хойч үеэ хүмүүжүүлэх зүй ёсны шаардлага тавигдаж байна.

4. Ёс суртахуун нь боловсролын хэмжээ төдийгүй нийгмийн харилцаа, орчин ахуй бусад зүйлээс зэрэг хамаардаг юм байна. Иймээс нийгмийн харилцааг өөрчлөхгүйгээр зөвхөн боловсрол гэгээрлийг дэлгэрүүлэх замаар хүний ёс суртахууныг өөрчилж болохгүй гэсэн дүгнэлтийг хийж байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Б.Даш-Ёндон “Платон өгүүллэгүүд”, Уб., 1995.
2. С.Наранчимэг Хандлагын ид шид. Уб., 2008.
3. В.Инжаннаши Хөх судар. Монгол бичгээс хөрвүүлсэн оршил бичиж, тайлбар зүүлт хийсэн Ш.Чоймаа, М.Баярсайхан., Уб., 2009.
4. С.Нарангэрэл Монголчуудын зан суртахууны гарваль. Уб., 2010.
5. Монгол хэлний их тайлбар толь. Уб., 2012.
6. Б.Оюунчимэг “Бизнесийн ёс зүй”, Уб., 2012.
7. М.Азжаргал. Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, түүнийг төлөвшүүлэх зарим асуудал. Уб., 2014.
8. Бүккё Дэндо Кёкай. Монгол орчуулга: Токио 2017
9. Д.Тунгалаг. Ёс зүйн зангилаа асуудлууд. Уб.2017
10. Б.Сандаг. Төрийн албан хаагчийн ёс зүй. Уб., 2018.
11. Б.Оюунчимэг Ёс зүй ёс суртахууны тухай ном. Уб., 2019.
12. Төрийн албан хаагчийн ёс зүй. /Авлигатай тэмцэх газар/ Уб., 2019.
13. С.Нарангэрэл. Чингис хааны ёс суртахуун-эрх зүйн шастир бурхан халдун-монгол туургатны голомт. Уб., 2021.
14. А.А.Гусейнов. “Введение в этику”. М., 1985.
15. Коллинз Р. Социология философий: глобальная теория интеллектуального изменения. (Пер. с англ. Н. С. Розова и Ю. Б. Вертгейм). Новосибирск: Сибирский хронограф, 2002.
16. Гусейнов А.А., Ирритц Г. Краткая история этики. М., 1987.
17. Кант И. Метафизика нравов в двух частях // Кант И. Соч.: в 6 т. Т. 4 (2). М., 1965.
18. Закон Божий / Под ред. А. Блинского. — Санкт-Петербург: Сатись, 1997.
19. Ислам / И. Л. Алексеев, Д. Ю. Арапов, В. О. Бобровников, Т. К. Ибрагим; Т. Х. Стародуб // Излучение плазмы — Исламский фронт спасения. — М. : Большая российская энциклопедия, 2008. (Большая российская энциклопедия).
20. Long, A. A.; Sedley, D. N. (1987). The Hellenistic Philosophers: Translations of the Principal Sources with Philosophical Commentary. 1. Cambridge: Cambridge University Press.
21. J.Svara “The Ethics primer for Public administrators in government and nonprofit organizations” jones and Bartlett Learning LLC. 2015. .
22. Alon Lawton. Julie Rayner. Karen Lasthuizen 2013, “Ethics and management in the public sector”, Routledge,
23. Julia Driver. Stanford Encyclopedia of Philosophy. 2014. .
24. Dean Geuras, Charles Garofalo “Practical ethics in Public administration” 2011.
25. Тоорой бандийн домог. <https://mn.wikipedia.org/wiki/>
26. David Misselbrook. Duty, Kant, and Deontology. British Journal of General Practice ·2013
27. Ryan C. Urbano. Public Administration Ethics: James Svara’s Model. Journal of Human Values. 2014.
28. Muel Kaptein, Johan Wempe. Three General Theories of Ethics and the Integrative Role of Integrity Theory. SSRN Electronic Journal · July 2002.

29. Christopher T. Wonnell Published online by Cambridge University Press: 25 November 2011.
30. "Applied Ethics" Oxford Bibliographies. Retrieved June 25, 2017.
31. III. Монтескье. О духе законов. Г.Г. Аркадий (франц-перевод). М., 2019. С.201.
32. Dale Carnegie. The Quick and Easy Way to Effective Speaking. "The Library of Congress Record". Archived from the original on 2012. Retrieved September 16, 2011.
33. Morreall, John; Sonn, Tamara (2013). "Myth 1: All Societies Have Religions". 50 Great Myths of Religion. Wiley-Blackwell.
34. Dalai Lama. The Art of Happiness. New York. 2009.
35. Allport, Gordon. (1935). "Attitudes," in A Handbook of Social Psychology, ed. C. Murchison. Worcester, MA: Clark University Press,
36. Ариун Коран, 20:50)
37. <https://news.harvard.edu/>
38. <https://www.scc-csc.ca/home-accueil/index-eng.aspx>
39. https://www.un.org/ru/documents/decl_conv/declarations/bioethics_and_hr.shtml
40. <https://plato.stanford.edu/entries/bentham/>
41. https://wikipedia.org/wiki/Normative_ethics
42. https://www.krugosvet.ru/enc/kultura_i_obrazovanie/religiya/RELIGIYA.html
43. <https://trksunpark.ru/mn/islamskii-kodeks-medicinskoi-etiki-musulmanskaya-etika-musulmanskaya/>
44. <https://quran.com>
45. <https://dictionary.cambridge.org/dictionary/english/attitude>

**ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ҮНДСЭН ЭРХ,
ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЗАРИМ АСУУДАЛ**

**THE RIGHTS OF POLICE OFFICERS,
SOME ISSUES ON THEIR FREEDOM**

Хууль зүйн докторант Э.Чимидлхам

ДХИС-ийн Эрх зүйн нийгмийн ухааны сургуулийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, цагдаагийн ахлах дэслэгч

E.Chimidlkhham, Doctoral candidate of Law

School of Law and Social Sciences, University of Internal Affairs
Lecturer of the Public Law Department, police senior lieutenant

Хураангуй:

Энэхүү өгүүллээр хүний эрхийн талаар үндсэн ойлголт болоод төрийн байгууллагад тэр дундаа цагдаагийн байгууллагад гардаг хүний эрхийн зарим зөрчил, эрх зүйн зохицуулалт, гадаадын зарим улс орны туршлагыг харьцуулан авч үзэж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зарим саналыг дэвшүүлсэн болно.

Abstract:

In this article, we have focused on comparing the basic concepts of human rights and in particular, some human rights violations in the police as in the governmental organizations, legal regulations, and the experience of some foreign countries and also we have made some suggestions for further action.

Түлхүүр үгс: Хүний эрх, төрийн алба, төрийн алба хаагч, төрийн байгууллага, цагдаагийн алба хаагч.

Keywords: Human rights, public service, public officials, governmental organizations, police officers

Төрийн алба дахь хүний эрх

Хүний эрх гэдэг нь хүний эрхэм чанар, үндсэн эрх, эрх чөлөөнд харшлах үйлдлээс хувь хүн болон аливаа бүлгийг үндэсний, олон улсын хуульчилсан хэм хэмжээгээр хамгаалах явдал юм. Товчхондоо хүний зэрэгтэй, нэр төртэй амьдрахад шаардагдах наад захын баталгаа, хүн нийгэмдээ хэвийн амьдрах нөхцөл боломж юм. Хүнд байдаг төрөлх шинж, мөн чанар буюу субъектив эрх, хууль журмаар хүнд олгосон боломж буюу хэм хэмжээний цогц эрх зүй буюу объектив эрх, эрх чөлөөг нийтэд нь хүний эрхийн хүрээнд хамруулан ойлгодог.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн улсуудад уриалсан бөгөөд нийт 30 зүйлтэй. Уг тунхаглалын гол зарчим нь хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ гагцхүү бусдын эрх, эрх чөлөөг зохих ёсоор хүлээн зөвшөөрч хүндлэх, хүн бүр, нийгмийн нэгж байгууллага бүр гэгээрч боловсрох замаар хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн сахих, үндэсний болон олон улсын хэмжээний дэвшилтэт арга хэмжээ авах тухай юм.

Мөн тунхаглалд хүн бүрд хамаатай нийтлэг эрхийг дараах байдлаар тусгасан. Үүнд: хувь хүн нэр төр, үнэ цэнэтэй, эрэгтэй эмэгтэйчүүд тэгш эрхтэй, бүхий л эрх чөлөөг ямар ч гадуурхалгүйгээр эдлэх эрхтэй, хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчиалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй, хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй, хүн бүр улсаа

удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрхтэй. Эдгээр нийтлэг эрх нь түгээмэл бөгөөд салшгүй шинжтэй.

Тунхаглалд төрийн албатай холбоотой агуулга бий. Тухайлбал, хүн бүр улсдаа төрийн алба хаших эрхтэй⁸³, хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн шударга, аятай нөхцлөөр хангуулах, ажилгүйдлээс хамгаалуулах эрхтэй⁸⁴, хүн бүр ямар ч алагчилалгүйгээр адил хэмжээний хөдөлмөрт адил хэмжээний шан хөлс авах эрхтэй⁸⁵, хүн бүр эрх ашгаа хамгаалах зорилгоор үйлдвэрчний эвлэл байгуулах буюу үйлдвэрчний эвлэлд нэгдэх эрхтэй⁸⁶, хүн бүр ажлын цагаа зохистойгоор хязгаарлуулах, цалинтай ээлжийн амралт эдлэх эрхийг оролцуулан амрах, зав чөлөөтэй байх эрхтэй⁸⁷.

Тунхаглалын үндсэн үзэл санааг бүрнээ ойлгох нь хүний эрхийн мэдрэмжтэй, соёлтой, зөв хандлагатай байхын суурь болно. Гол үзэл санааг тоймловол, бүх хүн төрөхөөсөө эрх чөлөөтэй, хэн ч тэдний жам ёсны эрхийг хязгаарлах, салгах эрхгүй, хүний эрх, эрх чөлөө нь бусад хүний тийм эрх, эрх чөлөөгөөр хязгаарлагддаг, хүний эрх, эрх чөлөөний хязгаарлах үндэслэл, журмыг зөвхөн төрийн хуулиар хязгаарлана.

Хүний эрхийг хязгаарлах нь бүх нийтийн сайн сайхан амьдралыг хангахад чиглэсэн байх ёстой. Хүний эрхийг хуульчлан бэхжүүлэх нь хүн өөрийн боломжийг ямар ч эрх нь эрх чөлөөний агуулгыг зөрчих ёсгүй гэдгийг ухамсарлахад нь туслах зорилготой бөгөөд хүний үндсэн эрх, эрх чөлөө нь түүний үүрэг, хариуцлагатай салшгүй холбоотой юм.

Төрийн байгууллага дахь хүний эрхийн зөрчил

Төрийн байгууллагад хүний эрхийн 2 төрлийн зөрчил тохиолддог байна⁸⁸. Үүнд:

а. Төрийн албанд ажиллаж буй албан хаагчдад тохиолдох хүний эрхийн зөрчил /ажлын байрны дарамт, албан тушаалын нөлөөлөл, хүний эрхийн бусад зөрчил/,

б. Төрийн байгууллага дахь хүний эрхийн бусад зөрчил /төрийн байгууллагын шийдвэр гаргах явцад тохиолдох хүний эрхийн зөрчил, үүргээ биелүүлээгүйгээс үүсэх хүний эрхийн зөрчил/ зэрэг болно.

Жишээ нь, төрийн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчид ажлын байрандаа “намын харъяаллаар ялгаварлагдан гадуурхагдах”, “хүйсийн тэгш бус байдлаар ялгаварлагдан гадуурхагдах” гэх мэт дарамт үүсдэг бөгөөд энэ нь төрийн албан хаагчдад тохиолдож байгаа хүний эрхийн зөрчил болно. Үүнээс гадна төрийн албан хаагч төрийн үйлчилгээ үзүүлэх явцдаа бусад иргэдэд дарамт үзүүлж хүний эрхийн зөрчил гаргадаг. Энэ сэдвийн хүрээнд бид нэгдэх тохиолдлыг түлхүү анхаарах шаардлагатай юм.

Олон улсын хөдөлмөрийн байгууллага нь 2019 оны 6-р сард хуралдан “Ажлын байран дахь хүчирхийлэл, дарамтыг бууруулах конвенц” батлан гаргасан бөгөөд харилцан хүндэтгэлд суурилсан, хүнлэг ёсыг дээдэлсэн ажиллах орчны соёлыг чухалчилан, хүн бүр ямар нэг дарамт, хүчирхийлэлгүй орчинд ажиллах эрхтэйг бататган уг конвенцыг батлан гаргасан байна. Энэхүү конвенц нь ажлын явцад холбогдсон, түүнтэй холбоотойгоор үүссэн ажлын байран дахь хүчирхийлэл, дарамтад хамаарна. Мөн хувийн, төрийн, олон нийтийн бүх байгууллага, албан болон албан бус салбар, хот болон хөдөөд ялгаагүй үйлчилнэ. Конвенцод хүчирхийлэл, дарамт гэдэг нь ажиллах орчинд илрэх бие махбодийн, сэтгэлзүйн, бэлгийн болон эдийн засгийн хохирол учруулах зорилготой, сөрөг үр дагаварт хүргэх, нэг тохиолдох эсвэл давтагдахаас үл хамааран хүлээн зөвшөөрч болохгүй, зохисгүй зан үйл, үйлдлийг хэлнэ гэж тодорхойлсон.

Ажлын байран дахь дарамт нь бие, сэтгэл зүйн олон хэлбэрээр илэрдэг. Тухайлбал, ажлын байрны тодорхойлолт заагаагүй мэдлэг, чадвар шаардсан ажил хийлгэх, ажлын бус цагийг зөвшилцөлгүй

⁸³ “Хүний эрхийн түгээмэл тунхаглал” 1946 он 21 зүйл

⁸⁴ “Хүний эрхийн түгээмэл тунхаглал” 1946 он 23.1 зүйл

⁸⁵ “Хүний эрхийн түгээмэл тунхаглал” 1946 он 23.2 зүйл

⁸⁶ “Хүний эрхийн түгээмэл тунхаглал” 1946 он 23.4 зүйл

⁸⁷ “Хүний эрхийн түгээмэл тунхаглал” 1946 он 24 зүйл

⁸⁸ ХЗДХЯ, Иргэдийн оролцоо II төсөл, “Төрийн алба ба ажлын байрны бэлгийн дарамт”, 2019 он, 10 тал

ашиглах, ажлыг үндэслэлгүйгээр шүүмжлэх, тэгш үл хамруулах, ялгаварлан гадуурхах (урамшуулал, олон нийтийг хамарсан арга хэмжээ г.м.), ганцаардуулах, бүлгэрхэх, гомдлыг түүнд холбогдож байгаа албан тушаалтанд өөрт нь шилжүүлэх, шууд болон шууд бус байдлаар цалин хөлс нэмэхийг санал болгох, ажлын бүтээмжийг эергээр үнэлэхийг амлах, цаашид үргэлжлүүлэн ажиллуулах талаар амлалт өгөх, тухайн ажлыг хийхэд шаардлагатай мэдээлэл өгөхгүй байх, хэл амаар доромжлох, нүд үзүүлэх, удаа дараа дайрсан гомдоосон үг хэлэх, хов жив ярих, ямар нэг байдлаар ялгаварлан харьцах зэрэг нь ажлын байрны дарамтад багтана.

Мөн дээрхээс гадна хөдөлмөрлөх эрхийн хүрээнд ажиллах орчны тулгамдсан асуудлууд байдаг бөгөөд энд ч хүний эрхийн асуудал яригдана. Жишээлбэл, Мэргэжлийн хяналтын байгууллагад нийт 2072 албан хаагч, үүнээс 371 /17.9%/ нь 21 боомтын 12 алба, хэлтэст ажилладаг. Хилийн мэргэжлийн хяналтын албаны хэлтэс албадуудад 1 өрөөнд дунджаар 4-10 ажилтан ажиллаж, 1 албан хаагчид 0.6-3 м.кв талбай оногдож байна. ЗГ-ын 2002 оны 120-р тогтоолын 1-р хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг”-т 1 хүнд дунджаар 8-36 м.кв ногдох ёстой⁸⁹. Судалгаанд оролцсон ажилтнуудын 73,2 хувь нь өдөрт 8-аас дээш цагаар болон уртасгасан цагаар ажилладаг, 87 хувь нь нэмэгдүүлсэн цалин хөлс авдаггүй. Дүрэмт хувцасны чанар, хүртээмж хангалтгүй гэж хариулсан 97.7 хувь байна. Мэргэжлийн хяналтын байцаагчид бага талбайтай орон сууцанд ээлжлэн амьдардаг байна.

Дэлхийн зарим улс оронд ч ажлын байранд дахь хүний эрхийн зөрчил газар авсан байна. Жишээлбэл: БНСУ-д дээд албан тушаалтан доод албан тушаалтныг дарамталж дээрэлхэх үзэгдэл газар авсан: хэл амаар доромжлох, биеийн онцлогоор ялгаварлах, цохих, юм шидэх, хүүхдийнхээ даалгаврыг хийлгэх, бүжиглүүлэх, цагаан үсээ түүлгэх, хов ярих, хувийн мэдээллийг тараах, архи тамхи хэрэглэхийг шаардах, хоолонд орохыг шахах, бусдын өмнө хэл амаар доромжлох г.м. үзэгдэл түгээмэл, гэсэн атлаа далд үйлдэгддэг байна. Судалгаагаар гурван хүн тутмын 2 нь ямар нэг байдлаар дарамтлуулсан, 80 хувь нь ажлын байрны дарамтын гэрч болж байсан. БНСУ-ын ХЭҮК-ийн мэдээнд нийт ажиллагчдын 70 хувь ямар нэг дарамтад өртсөн, тэдний 12 хувь нь өдөр бүр дарамтад өртдөг, гэвч дарамтын 60 хувьд ямар нэг арга хэмжээ аваагүй байна. Ажлын байрны дарамтын суурь шалтгаан нь ажлын байрны төлөөх өрсөлдөөн, захирах захирагдах хатуу ёс жаягтай холбоотой байдаг байна. 2018 онд нийт ажиллагчид дэлхийн дунджаас 278 цагаар илүү ажилласан байна. Ажиллах цагийн дээд хэмжээг 68 цагаас 52 болгон буулгаж, зарим компани ажлын цаг дуусмагц компьютер автоматаар унтрах тохиргоо хийсэн нь гэр бүл, хувь хүний хөгжилд чухал хувь нэмэр оруулж байгаа. 2019 оны 7-р сараас Ажлын байрны дарамтын эсрэг хууль хэрэгжиж эхэлсэн. Уг хуулийн дагуу шударга бусаар ажилтнаа халсан ажил олгогч 3 хүртэл жил хоригдох эсвэл 30 сая вон (25400 USD)-ы торгууль төлнө. Мөн БНСУ-ын ЗГ-аас ямар зан үйлийг дарамт гэж үзэх тухай гарын авлага гаргасан нь үр дүнтэй ажил болжээ.

Мөн Япон Улс нь ажлын байрны дарамт, эрх мэдлээ урвуулан ашигласан төрийн албан хаагчдад хатуу шийтгэл ногдуулахаар төлөвлөж буй талаар эх сурвалжууд мэдээллэв⁹⁰. Сэтгэл санааны хохиролд хүргэсэн ноцтой тохиолдолд буруутай төрийн албан хаагчийг ажлаас нь халах хүртэл арга хэмжээ авахаар Үндэсний хүний нөөцийн агентлаг төлөвлөж бөгөөд уг хуулийн зохицуулалт нь энэ оны 6 дугаар сараас хэрэгжиж эхлэхээр төлөвлөсөн байна. Үндэсний хүний нөөцийн агентлагаас дарамт шахалтаас хамгаалах зорилгоор зөвлөгөө өгөх системээ боловсронгуй болгох, албан хаагчдаа сургахыг бусад төрийн байгууллагуудад уриалж байгаа юм байна.

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн⁹¹ 48-р зүйлд уг хуулийн 37, 39-р зүйлд заасныг зөрчсөн, албан үүргээ биелүүлээгүй болон энэ хуульд заасан бусад тохиолдолд тухайн зөрчлийн шинж байдал, түүнийг анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан төрийн жинхэнэ албан хаагчид дараах

⁸⁹ “Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг” 2002 он.

⁹⁰ **Japan times (2020.03.08)**

⁹¹ “Төрийн албаны тухай хууль”, Төрийн мэдээлэл эмхэтгэл 2018 он, №01

сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна гэж заасан. Үүнд: Сануулах; Албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах; Төрийн албанаас халах; Төрийн албанд 3 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах; Хуульд заасан бусад. Төрийн албаны тухай хуулийн 39-р зүйлд заасныг зөрчсөн төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах нь түүнийг төрийн албанаас чөлөөлөх, төрийн албанд дахин авахаас татгалзах үндэслэл болох бөгөөд харин түүнийг эрүүгийн болон бусад хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй гэж заасан байдаг.

Цагдаагийн албан хаагч ба хүний эрх

Дэлхий дахинд кроновирусын цар тахал тархсантай холбоотойгоор МУ-н хэмжээнд 2020 оны нэгдүгээр сарын 27-ний өдрөөс эхлэн өндөржүүлсэн бэлэн байдал, бүх нийтийн бэлэн байдал зэрэгт шилжүүлэх дэглэмээр өнөөдрийг хүртэл цагдаа, дотоодын цэргийн алба хаагчид бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж байгаа.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор⁹² цагдаагийн байгууллага, алба хаагчдаас иргэдэд чанартай жигд хүртээмжтэй, шуурхай үйлчлэх, цагдаагийн байгууллагын бүтэц, орон тооны жишиг норматив болох 100000 хүртэл хүн ам тутамд дүүргийн цагдаагийн хэлтэс нэг, алба хаагчийн нийт орон тоонд 75-аас доошгүй хувийг гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах шууд үүрэг бүхий ажилтан эзлэх, 4000 хүн ам тутамд хэсгийн байцаагч, нийслэлийн хороо бүрт эрүүгийн төлөөлөгч, цагдаа, 15000 хүн ам тутамд хоёроос доошгүй хэв журмын эргүүл ажиллуулахаар шийдвэрлэсэн.

Гэвч нийслэл хотод гэхэд хүн амын өсөлт сүүлийн 11 жилийн дотор ердийн өсөлтөөр 124.0 мянган хүнээр, механик өсөлтөөр 288.0 мянган хүнээр тус тус огцом өсөж, иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хэрэгжиж эхэлснээр хот руу шилжин ирэгсдийн тоо нэмэгдэж, нийслэлийн нийт хүн амын 94.6 хувь нь төвийн 6 дүүрэгт оршин сууж хэт төвлөрөлт бий болж байна⁹³. Нийслэлд 50 гаруй хотхон сүүлийн 5 орчим жилийн дотор шинээр баригдан ашиглалтад орж, үүний зэрэгцээ гэр хороололд Нийслэлийн хүн амын 62.0 хувь нь оршин сууж, тэлэлт жил ирэх бүр нэмэгдэж байгаагаас цагдаагийн тасаг, хэсэг, эргүүлийн чиглэл байршуулахад хүн, хүч дутагдалтай, бүтэц, зохион байгуулалт оновчтой бус, иргэддээ хүрч ажиллаж чадахгүй байгаа нь цагдаагийн алба хаагчийн ажлын ачаалалыг нэмэгдүүлж амралтгүй олон цагаар ажиллах нэг шалтгаан болж байна.

Тухайлбал Цар тахалтай холбоотойгоор Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол гарсантай холбогдуулан цагдаагийн байгууллагаас 4200 алба хаагч үүрэг гүйцэтгэж, нийт 49 хоног гэртээ хариагүй алба хаагч байгаа тухай УОК-ын шуурхай штабыг гишүүн, ЦЕГ-ын Нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны дарга тухайн үед өгүүлсэн байдаг⁹⁴. Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчид олон хоногоор 24/24 цагаар ажиллах, нийтээр амрах баярын өдрүүд, илүү цагаар болон долоо хоногийн амралтын өдрүүдэд ажиллаж байгаа ч Хөдөлмөрийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1⁹⁵ дэх хэсэг, 53 дугаар зүйлийн 53.1⁹⁶ дэх хэсэгт заасан нэмэгдэл хөлсийг тооцон олгодоггүй байна. Мөн 2021 оны хоёрдугаар сарын 11 ний өдрөөс хоёрдугаар сарын 23-ны өдрийг хүртэл хатуу хөл хорионы үед ажиллаж байгаа алба хаагчдыг халуун хоол ундаар хангахгүй /хоолны мөнгө өгөөгүй/ бие засах газаргүйгээр бүтэн найман цаг хүйтэн нөхцөлд үүрэг гүйцэтгэн зогсоож байсан⁹⁷ нь хүний эрхийн зөрчил юм.

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэлийн 4-р бүлгийн 4.3-д Цагдаагийн алба хаагчдын хөдөлмөрлөх эрхийн асуудлаар тодорхой дурдсан байдаг. Үүнд:

⁹² <https://www.legalinfo.mn>

⁹³ Хууль сахиулахын их сургуулийн эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн судалгааны тайлан. 2017 он

⁹⁴ www.Zaluucom.mn

⁹⁵ Нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол дундаж цалин хөлсийг нь 2.0 дахин нэмэгдүүлж олгоно.

⁹⁶ Илүү цагаар болон долоо хоногийн амралтын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүнд 1.5 дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлсэн цалин хөлс олгоно.

⁹⁷ MASS.mn - төрийн албан хаагч: би чичирсэн байдалтай л байна, 8 цаг бие засах, цай уух боломжгүй

1. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 429 дүгээр тушаалаар “Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтэс, дэд хэсгийн байранд тавигдах ерөнхий шаардлага” CS11-0244:2014 стандартыг хэрэгжүүлж, илүү цаг, амралтын болон бүх нийтийн баярын өдөр ажилласан алба хаагчдад хуульд заасан нэмэгдэл цалинг заавал олгож хэвших, шаардагдах төсвийг баталж өгөх;

2. Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолын дагуу цагдаагийн газар, хэлтсийг бүтэц, орон тоогоор нь ажиллуулах асуудлыг яаралтай шийдвэрлэж, цагдаагийн алба хаагчдын хөдөлмөрлөх эрхийг хамгаалж, албаны үйл ажиллагааг хэвийн явуулах боломжийг хангах;

3. Цагдаагийн алба хаагчийг жил бүр эрүүл мэндийн дэлгэрэнгүй үзлэг оношлогоонд оруулах зардлыг төсөвт тусган баталж, нэгдсэн журмаар зохион байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

4. Хөдөлгөөний аюулгүй байдал хангах чиг үүрэг бүхий алба хаагч албан үүргээ гүйцэтгэж байгаад зам тээврийн осолд өртсөн тохиолдолд тухайн асуудлыг гэмт хэрэг, зөрчил эсэхээс үл хамааран үйлдвэрлэлийн осолд тооцож, хуульд заасан нөхөн төлбөр олгож байх.

Дээр дурдсан саналууд нь өнөөдрийг хүртэл шийдвэрлэгдээгүй байгаа нь алба хаагчдын хөдөлмөрлөх эрх нь өнөөдрийг хүртэл ноцтойгоор зөрчигдөж байна гэх бүрэн үндэслэлтэй юм

Дүгнэлт. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ” 16 дугаар зүйлийн 16.4 “Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй” гэж заасан байдаг.

Гэвч Төрийн алба тэр дундаа цагдаагийн алба хаагчийн хөдөлмөрлөх эрхийн хүрээнд ажлын ачаалал, амралт, цалин хөлс, ажиллах орчны талаар тулгамдсан асуудлууд, зөрчил байсаар байна.

Санал. Цагдаагийн алба хаагчдын хөдөлмөрлөх эрхийн талаар дараах асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай юм. Үүнд:

- Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолын дагуу цагдаагийн газар, хэлтсийг бүтэц, орон тоогоор нь ажиллуулах асуудлыг яаралтай шийдвэрлэх
- Илүү цаг, амралтын болон бүх нийтийн баярын өдөр ажилласан алба хаагчдад хуульд заасан нэмэгдэл цалинг заавал олгож хэвших, шаардагдах төсвийг баталж өгөх

Ашигласан материал

1. Монгол Улсын Үндсэн хууль Төрийн мэдээлэл эмхэтгэл 1992 он, №01
2. “Хөдөлмөрийн тухай” хууль”, Төрийн мэдээлэл эмхэтгэл 1999 он, №25
3. “Төрийн албаны тухай хууль”, Төрийн мэдээлэл эмхэтгэл 2018 он, №01
4. “Хүний эрхийн түгээмэл тунхаглал” 1946 он
5. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 14 дэх илтгэл” 2015 он
6. “Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг” 2002 он
7. Хууль сахиулахын их сургуулийн эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн судалгааны тайлан. 2017 он
8. ХЗДХЯ, Иргэдийн оролцоо II төсөл, “Төрийн алба ба ажлын байрны бэлгийн дарамт”, 2019 он
9. Удирдлагын академи, Төрийн байгууллага дахь хүний эрх ба ажлын байрны дарамтаас сэргийлэх” хичээлийн эмхэтгэл” 2020 он
10. Japan times (2020.03.08)
11. <https://www.legalinfo.mn>
12. www.Zaluucom.mn
13. www.mass.mn

МӨРДӨН БАЙЦААЛТ ба ХЭЛ ШИНЖЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Н.Манлайбаатар

*Дотоод хэргийн их сургуулийн
Цагдаагийн сургуулийн Эрүүгийн
процессын эрх зүйн тэнхимийн
эрхлэгч, цагдаагийн хошууч*

Товч агуулга: Мөрдөн байцаалт гэсэн агуулгаас мөрдөн мөшгөхүйн тогтолцоонд сэтгэлгээ, хэл шинжлэлийн агуулгаар хандах нь зүйтэй. Тийм ч учраас сэдвийн хүрээнд уг агуулгыг энэхүү өгүүлэлд авч үзлээ.

Түлхүүр үгс: Эрүүгийн процесс, мөрдөн байцаалт, мөрдөн мөшгөх, байцаалт

Үндсэн хэсэг. Хэл шинжлэл нь олон салбарт хуваагддаг түвшний зохион байгуулалттай нарийн төвөгтэй шинжлэх ухаан бөгөөд хэлний авиа зүйг судалдаг авиа зүй, тухайн хэлийг бүрдүүлж байдаг үсгийн хэлбэр, түүх, илэрхийлэх утгын талыг судалдаг үгийн сан, утга зүй, үг өгүүлбэр бүтээх арга хэрэгслийг судалдаг хэл зүй, бүтээвэр зүй, үндэсний нэгдмэл хэлний хүрээн дотор тодорхой нутаг дэвсгэрт оршин суугчдын хэлний онцлогтой холбоотой нутгийн аялгуу зэрэг салбартайн дээр хэлийг тодорхой орон цагт тухайн нийгэмд үйлчилж буй байдлаар нь судлдаг хам цагийн, түүхэн хөгжил хувьсалд нь судалдаг цуваа цагийн хэл шинжлэл бий⁹⁸г хууль зүйн эрдэмтэн судлаачдын анхаарлын төвд оруулах шаардлагатайг эргэж харах цаг болсон. Өөрөөр хэлбэл хууль тогтоомжийг боловсронгуй болгох, шинэчлэх, өөрчлөх зүй тогтол нийгмийн хөгжлийн аль ч үе шатанд гарцаагүй нь тодорхой юм бол бидний анхаарах асуудал хууль зүйн техникийн тэр дундаа эрх зүйн актийн хэлэнд тогтсон шаардлагыг анхаарах хэрэгтэй байгааг тэмдэглэж байна.

Бидний авч үзэж байгаа хууль зүйн шинжлэх ухааны нэр томьёо нь эрх зүйн хэллэгээр дамжин, эрх зүйн мэргэжлийн ойлголт, нэршил, категориор тэмдэглэгдэн илэрхийлэгдэж тусгагдсан байдаг⁹⁹ нь хэл шинжлэлийн болон хууль зүйн ухааны салбар дундын шинжтэй судлагдахууныг бүтээнэ. Эрх зүй хэллэг гэдэг нь олон улсын болон тухай улсын хэл зүйн онцлогыг тусгасан, хууль зүйн мэргэжлийн зориулалтаар хэрэглэгдэж буй нэр томьёо, томъёолол, утгын гаргалгаа бүхий өгүүлэгдэхүүн мөн гэснийг дэмжиж байна.

Нэгэнт хэрэгцээ шаардлага үүссэн нь судлаачдын хувьд хууль зүйн техникийн тэр дундаа эрх зүйн актын хэлэнд тавигдах шаардлагыг хууль зүйн доктор (Ph.D), профессор Ч.Нямсүрэн тэмдэглэжээ. Үүнд:

- Эрх зүйн хэм хэмжээний томъёолол нь хатуу тогтсон, нэгдсэн стандарт, хэл зүйн дүрэмтэй байх,
- Эрх зүйн хэм хэмжээний актийн нэр томьёо нэгдсэн нэг байх: актын нэг нэр томьёо, нэг үг нь нэг л утгыг илэрхийлсэн байх; нэг ойлголт нь нэг л нэр томьёог илэрхийлсэн байх; нэр томьёо тодорхой ойлгомжтой байх. Тэдгээр нэр томьёог нэг хэв загвараар ойлгоход нэр томьёоны утгыг тодорхойлсон хуульчилсан тодорхойлолт буюу дифинитив хэм хэмжээг ашиглаж болно,
- Эрх зүйн хэм хэмжээний актад шинжлэх ухаан, практикт нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нэр томьёон хэрэглэх,

⁹⁸ Д.Батчулуун. Хэлшинжлэлийн удиртгал. УБ., 2016 он. 1 дэх тал.

⁹⁹ Д.Баярсайхан. Эрх зүйн онол. УБ., 2018 он. 109 дэх тал.

- Гадаад үг, шинэ үн хэллэг, хуучирсан үг, цэцэн үг, зүйр үг, болон оновчтой бус хоёр буюу олон салаа утгатай үг хэрэглэхээс аль болох зайлхийх зэрэг шаардлага тавигддаг¹⁰⁰ гэж тэмдэглэжээ. Дээрхээс үзвэл эрх зүйн хэм хэмжээний актын гадаад илрэх хэлбэр болох хууль, хуульчилсан актын үг, нэр томьёо, илэрхийлэх дэг нь онолын хувьд үндсэндээ шийдвэрлэх шалгуураа тавьсан байна.

Сүүлийн 10 орчим жилийн хугацаанд эрх зүйн шинэчлэл өрнөж, өнөөдрийг хүртэл үргэлжилж байгааг анхаарч үзвэл Эрүүгийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг өөрчлөх талаар нэлээд олон үе шаттай ажиллаж, эрдэмтэн, судлаачдын анхаарлын төвд байсаар ирлээ. Харин судлаач миний хувьд “мөрдөн байцаалт”, “мөрдөн мөшгөх” гэсэн үгийн утгыг хэл шинжлэлийн ухааны үүднээс авч үзэх шаардлагатайг хууль зүйн салбарын эрдэмтдийн үзэл санаа хийгээд бусад баримтад тулгуурлан тайлбар хийх оролдлого хийлээ.

Хэрэв хуульчид анзаарвал “мөрдөн байцаалт нь хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн бол сэргээн эдлүүлэх, хамгаалахад чиглэсэн шүүхийн өмнөх үе шат” гэж өргөн утгаар нь, харин “нотлох баримтын эх сурвалжийг цуглуулах, бэхжүүлэх, шалгах, үнэлэхэд чиглэсэн үе шат” гэсэн явцуу утга бүхий хууль зүйн агуулгыг тодорхой хэмжээнд мэднэ. Нөгөөтэйгүүр, “эцсийн эцэст хүрэх бодит байдал, физик үзэгдэл (байгалийн философи), ёс зүй (ёс суртахууны философи), юмс үзэгдлийн үлэмж ерөнхий шалтгаан, зарчим болоод тэдгээрээс гарч ирсэн хүний хүртэхүй, бодол санаа зэрэгтэй холбоо бүхий мэдлэг, оюун ухааныг эрэн хайж улмаар түүнээс чангуух зүйлийг эрмэлзэх явдлыг философи гэнэ¹⁰¹” гэсэн тодорхойлолтоос бид мөрдөн байцаалтын агуулга, мөн чанарт “мөрдөн мөшгөх” гэсэн хандлагаар хандах ёстой хэмээн үзэж, хөгжүүлэхийг зорих шаардлагатай. Энэ талаар хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан нарын тэмдэглэснээр “Мөрдөн мөшгөх” гэсэн субстанцын учрыг ойлгож мэдэх, онол, арга зүйн үндсийг баттай тогтоох нь процессын шинжлэх ухааны бие даасан цоо шинэ чиглэлд зүй ёсоор тооцогдох болов¹⁰²” гэсэнтэй санал нэг байгаа билээ.

Эрх зүйн шинэчлэлийн үр нөлөөгөөр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны мөрдөн байцаалтын ажиллагаа нь мөрдөн шалгах нууц ажиллагаатай хослон хэрэгжих нөхцөл бололцоо “мөрдөн мөшгөх” утга агуулгаар яв цав илрэн гарсан гэдгийг бид анхаарах шаардлагатай. Өөрөөр хэлбэл мөрдөгч нуугдмал болон зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх дээ мөрдөн шалгах ердийн болон бусад /тусгай ажиллагаа гэж болно/ ажиллагааны комбинацийг нэгтгэн хэрэглэх, тактикийн үр нөлөөтэй байдлаар хэрэгжүүлэх нь эрх зүйн соёл хандлага зөв төлөвших, хууль хэрэгжүүлэхэд хүний эрхийг хангах, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх явдлаас сэргийлэх, улмаар мөрдөх албаны мөрдөгчид багаар ажиллах, хэргийн илрүүлэлтэд ахиц гарах гэх мэтийн эерэг талууд бүрэлдэх боломжтой гэж үзэж байна.

Мөрдөн байцаалтын агуулгыг бид эрдэмтдийн үзэл санаагаар баяжуулан судлахын зэрэгцээ хэл шинжлэлийн хийгээд гарал үүслийн судалгаагаар дотоод агуулгад нь нарийн шинжилгээ, тайлбар хийх боломжтойг ч анхаарах хэрэгтэй. “Мөрдөн байцаалт” гэж уг гарвалаараа Монгол хэлэнд аливаа зөрчил, хэргийг мөрдөн шалгах үйл явц¹⁰³-ийг илэрхийлсэн ерөнхий түгээмэл утгатай. Гэвч бид мөрний тухай сургаалийг энд авч үзэхгүйгээр утгын гүнд нэвтрэхгүй. “Мөрдөх” гэдэг үгийн язгуур “мөр” хэмээх үг нь “ором, ул, зам, аливаа хэргийн гэрч баримт, шугам, зураас¹⁰⁴” гэсэн утга илэрхийлнэ. Үүнээс улбаалан “мөрдөх” гэсэн үйл үгийн утга нь “юмны зам мөрөөр орон явах, мөрийн мөшгөн хянаж шалгах, гэмт

¹⁰⁰ Ч.Нямсүрэн. Эрх зүйн ерөнхий онол. УБ., 2017 он. 205 дахь тал.

¹⁰¹ Мэл Томпсон. Философи. Өөрөө сурах бичиг. Хоёр дахь удаагийн хэвлэл. УБ., 2003 он. 15 дахь тал. Оксфордын тольд тодорхойлсон тодорхойлолтыг уг бүтээлээс ишлэн авлаа.

¹⁰² Ж.Бямбаа нар. Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал. УБ., 2018 он. 206 дахь тал.

¹⁰³ <https://mongoltoli.mn/dictionary/detail/10845> цахим их тайлбар толь үзнэ үү.

¹⁰⁴ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966 он. 345 дахь тал., <https://mongoltoli.mn/dictionary/detail/58164> цахим их тайлбар тольд уг холбоосоор илүү өргөн агуулгаар тайлбарласныг, шилжсэн утгыг үзнэ үү.

хэрэг эдүүлсэн явдлыг илрүүлэн гаргах¹⁰⁵” гэсэн утга илэрхийлнэ. Харин “байцаалт” гэсэн үгтэй “мөрдөх” хэмээх үг хоршиход криминалистик¹⁰⁶-ийн агуулгаас хууль зүйн агуулгад шилжинэ. Ийнхүү утга шилжилхээ хэл зүйн талаасаа түүний үүрэг өөрчлөгдөж байгааг анхаарах хэрэгтэй. Хэрэв үүрэг өөрчлөгдөж хууль зүйн агуулга илэрхийлж буй бол бид “мөрдөн мөшгөх” гэсэн хоршоо үгийн зорилго хууль зүйн агуулгаараа ч криминалистикийн сонгодог зорилгоо алдахгүй байгааг анхаар болно. Өөрөөр хэлбэр хэлний философийн гол утга нь түүний үүрэгт байдаг бол, бид түүний үүргийн агуулгыг нийгэмд хэрхэн ойлгогддогыг олон жилийн туршлагаар таних мэдэх бололцоотой байгааг энд тэмдэглэж байна.

Мөрдөн байцаалтын агуулга нь хэлний түгээмэл талаас тайлбарлагдаж болох бөгөөд цуваа цагийн агуулгаар авч үзэж болохоор байгааг анхаарах хэрэгтэй болжээ. Монгол хэлний зүйд харь үг сүрхий нутагшин эвдрээгүй ч сүүлийн жилүүдэд хэл шинжлэлийн мэргэжилтэнүүд тэмдэглэж буйгаар хэврэгших болоод байгааг анхаарах хэрэгтэй болжээ. Үүнийг тэмдэглэсний учир нь бидний судлан байгаа мөрдөн байцаалт ба мөрдөн мөшгөх агуулга ч олон утгаар тайлбарлагдаж буйгаар анзаарч болно.

Мөрдөн байцаалт /*англи*: preliminary investigation, pretrial investigation, *орос*: предварительное следствие, *герман*: vorläufige Untersuchung¹⁰⁷/ нь эрүүгийн процессын эрх зүйн шүүхийн өмнөх үе шат болохын хувьд түүний агуулга, мөн чанар, зорилт нь өөрийн гэсэн онцлогтой. Тэрхүү онцлог нь дараах агуулгаар тайлбарлагдаж ирснийг хууль зүйн эрдэмтэд тэмдэглэснийг авч үзье.

Академич С.Нарангэрэлийн тэмдэглэснээр “...гэмт хэрэг үйлдсэн үйл явдал, түүнийг үйлдсэн гэм буруутай этгээд байгаа эсэх, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлын шинж чанар ба хэмжээ, хэрэгт ач холбогдол бүхий бусад нөхцөл байдлыг тогтоохын тулд нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ба шинжлэх талаарх хэрэг бүртгэх ба мөрдөн байцаах байгууллагын үйл ажиллагаанаас бүрддэг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үе шат¹⁰⁸...”, Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор Ж.Авхиа агсны тэмдэглэснээр “...Урьдчилсан мөрдөн байцаалтын зорилт нь эрүүгийн хэрэгт шаардлагатай бүх нотлох баримтуудыг бүрэн гүйцэд цуглуулж шалгах, хэрэгт ач холбогдол бүхий яллах, цагаатгах, хариуцлагыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх, бүх нөхцөл байдлуудыг тогтоох, түүнчлэн уг гэмт хэрэг гарахад нөлөөлсөн нөхцөл, шалтгаануудыг илрүүлэхэд оршино¹⁰⁹...”, Хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор Ж.Бямбаа нарын үзэж байгаагаар “...мөрдөн байцаалт... хэрэг бүртгэлтийн нэгэн адил гэмт хэргийг тал бүрээс нь бүрэн дүүрэн шалган нотлож, гэмт этгээдийн гэм буруу, учирсан хохирлын шинж байдал, хэр хэмжээ болон гэмт хэрэгт ач холбогдолтой бусад байдлын талаархи баримт, сэлт мэдээллийг цуглуулж үнэлэлт дүгнэлт өгөх, шийдвэр гаргах ажиллагааг хэрэгжүүлдэг¹¹⁰...”, мөн “...мөрдөн байцаалтын шатанд мөрдөн шалгах хэлбэрийн бүхий л ажиллагаа явагдах ба уг процессыг мөрдөгч бүрэн хариуцаж хэрэгжүүлнэ...¹¹¹”, Хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор Б.Бат-Эрдэнэ агсны үзсэнээр “...мөрдөн байцаалт нь урьдчилсан мөрдөн байцаалтын ажиллагааны үндсэн хэлбэр¹¹²...”, Хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор Т.Оюунчимэгийн үзэж байгаагаар “...мөрдөн байцаалт бол эрүүгийн процессын эрх зүйн үе шат болохын хувьд нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, шалгах, үнэлэх өөрийн зорилт, агуулга, мөн чанар, хууль зүйн учир холбогдлыг үүсгэдэг, хуульч ажиллагаа

¹⁰⁵ Я.Цэвэл. Дурьдсан бүтээл. УБ., 1966 он. 345 дахь тал., <https://mongoltoli.mn/dictionary/detail/58315> цахим их тайлбар тольд холбоосоор хандаж, үндсэн ба шилжсэн утгын хамт үзнэ үү.

¹⁰⁶ Мөн хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор Б.Лхагвасүрэнгийн “Мөр” хэмээх сонсогч, оюутан, суралцагчид болон мөрдөгчид зориулсан 2015 оны гарын авлагад Мөрний тухай криминалистикийн сургаал хэсэгт багтаан мөр судлалын талаар авч үзсэн. Энд мөрдөн байцаалтын хууль зүйн агуулгыг үл хөндөж, мөрний сургаал, үндсэн ангилал, шинж, мөртэй ажиллах арга зүй, мөр үүсэх зүй тогтол, хэргийн газрын үзлэг, мөр судлалын шинжилгээний талаар авч үзсэн нь өнөөдөр ч эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын гол хэрэглэгдэхүүн байсаар байна.

¹⁰⁷ Ж.Амарсанаа. Англи-Орос-Герман-Монгол Олон улсын эрх зүйн толь. УБ., 2004 он. 400-401 дэх тал.

¹⁰⁸ С.Нарангэрэл. Монголын эрх зүйн англи, орос, латин эх толь бичиг. Нэмэж засварласан дөрөв дэх хэвлэлт. УБ., 2015 он. 457 дахь тал.

¹⁰⁹ Ж.Авхиа нар. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. Их, дээд сургуулийн сурах бичиг. УБ., 1987 он. 89-91 дэх талд үзнэ үү.

¹¹⁰ Ж.Бямбаа. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн үндсэн асуудлууд. УБ., 2008 он. 65 дахь тал.

¹¹¹ Ж.Бямбаа нар. Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал. УБ., 2018 он. 215 дахь тал.

¹¹² Б.Бат-Эрдэнэ. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. /2.Тусгай анги/ УБ., 1999 он. 25 дахь тал.

бөгөөд хүний эрх хэмээх үнэт зүйлийг ямагт анхаарч байх ёстой¹¹³...”, Хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор Д.Зүмбэрэлхамын тэмдэглэснээр “...эрүүгийн процессын аль ч үе шатанд анхаарах зүйл бол гэм буруугүйн презумпцийн зарчмыг анхаарч, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтанд яллах, цагаатгах талыг тэнцүү баримтлах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч хэргийг илрүүлэхэд анхаарлаа хандуулж, сэжиглэж байгаа бол ямар ч үнээр хамаагүй түүнийгээ батлах өрөөсгөл хандах явдал байж таарахгүй¹¹⁴...” гэх зэргээр тэмдэглэсэн байна. Нийтлэг, ерөнхий агуулгын хувьд өөр хоорондоо харилцан давхцах дээрх тайлбар, үзэл санаа нь үг үсгийн хувьд тохирохгүй, бага боловч ондоошиж байгаагийн шалтгаан нь хууль тогтоомжийн шинэчлэл, өөрчлөлт, тус тусын концепци, туршлагаас хамаарах үндэслэл бүхий байж болно. Мөн эрүүгийн процессын эрх зүй судаалч, эрдэмтэд мөрдөн байцаалтын талаар тэмдэглэсэн байдгийг дурьдах нь зүйтэй.

Эрдэмтдийн үзэл санааг сүүлийн 40 орчим жилийн судалгааны ажлуудыг өртөөчлөн судлах замаар илэрхийллээ. Өөрөөр хэлбэл, бидний өнөөдрийг хүртэл ашиглаж байгаа мөрдөн байцаалтын агуулга нь хууль зүйн агуулгаараа тайлбар ойролцоо утга зааж байгаа хэдий ч агуулгад нь субстанцийн гүнзгий утга, үзэл санаа, философи буйг энд тэмдэглэе.

Дүгнэлт:

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэгэн үе шатны нэршил түүний агуулгад байгаа фиолософи утга, хэл шинжлэлийн цуваа утга, ажлын болон онолын нарийн агуулга өөр хоорондоо харилцан тохирохгүй байгаа нь тодорхой байна.
2. Бид хууль зүйн техникийн үүднээс шалгуур тодорхой байгаа ч түүний мөн чанарыг гүйцэт ойлгож хэрэглэхгүй байгаа нь нэгэнт илт. Ийм ч учраас мөрдөн байцаалтын агуулга үзэл баримтлал Үндсэн хуулийн эрх зүйн нэлээд чухал асуудал болохыг тэмдэглэж байна.

¹¹³ Хууль зүйн ухааны доктор (Ph.D), профессор Т.Оюунчимэг багштай харилцан ярилцаж, тэмдэглэж авсан гар бичмэл.

¹¹⁴ Д.Зүмбэрэлхам. Гэм буруугүйн презумпцийн зарчмыг Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэрэгжүүлэх онол, практикийн зарим асуудал. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. УБ., 2001 он. 120-125 дахь талд үзнэ үү.

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

Г.Бямбадорж

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн

ЦЭЗТ-ийн ахлах багш,

магистр, цагдаагийн хошууч

Товч агуулга. Энэхүү өгүүлэлдээ зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл заалт процессийн ажиллагаа явуулах үндэслэл, журам, түүнийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг үндэслэлтэйгээр тайлбарлан, түүнийг боловсронгуй болгох талаар өөрийн санал, дүгнэлтээ боловсруулж та бүхэнд хүргэж байна.

Түлхүү үгс: Хууль, процесс, ажиллагаа, үндэслэл, зөрчил, журам,

Үндсэн хэсэг. Монгол Улсад 1990-ээд оноос өрнөсөн эрх зүйн шинэчлэл, Үндсэн хуулиар тунхагласан хүний эрх, эрх чөлөөг хангах хууль зүйн баталгааг бүрдүүлэх зорилтын хүрээнд зөрчил, түүнийг шалган тогтоох, буруутай этгээдэд хүлээлгэх хариуцлагыг нэгтгэн зохицуулах зорилгоор Захиргааны хариуцлагын тухай хуулийг 1992 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр мөн төрийн хяналт шалгалт болон салбарын хяналтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрөлжсөн хуулиудыг батлан хэрэгжүүлж ирсэн.

Гэвч эдгээр төрөлжсөн хуулиудад салбарын хүрээнд үйлдэгддэг зөрчлийг тодорхойлж, улмаар шалган тогтоох, хянан шийдвэрлэх журмыг тухайн салбарын асуудлыг зохицуулсан хуулиар буюу өөр өөр байдлаар хуульчилсан байна.

Өөрөөр хэлбэл Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг төрийн хяналт шалгалтын ажиллагаатай адилтган зохицуулсан нь салбарын онцлог нэрийн доор салбар бүрт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд өөр өөр стандарт тогтоон хэрэгжүүлж байна. Тухайлбал, Захиргааны хариуцлагын тухай хуульд зааснаар зөрчлийг 14 хоногт багтаан хянан шалгахаар¹¹⁵ заасан бол Өрсөлдөөний тухай хуульд 60 хоногт багтаан шалгахаар¹¹⁶ заасан гэх мэт.

Энэ нь эрх зүйн хэм хэмжээний давхардал, хийдэл, зөрчлийг бий болгож, улмаар салбарын хүрээний дүрэм, журмаар хүний эрхийг хязгаарлаж байгаа нь зөрчил шалган тогтоох болон шийтгэл оногдуулах ажиллагааг харилцан адилгүй, тэнцвэргүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байсан тул түүнийг боловсронгуй болгох зорилгоор Монгол Улсын Их Хурлаас Захиргааны хариуцлагын тухай хууль болон нийгмийн тодорхой төрлийн харилцааг зохицуулж буй 220 гаруй хуулиар тогтоосон зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон хэм хэмжээг төрөлжүүлэн нэгтгэсэн Зөрчлийн тухай хууль¹¹⁷ мөн процессийн ажиллагааны үндэслэл журмыг тогтоосон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг анх удаа хуульчилсан.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар хуулийн үйлчилэх хүрээ, хугацаа тоолох, хэргийн харъяалал, зөрчлийн хэрэг нээх үндэслэл, эрх хязгаарлах арга хэмжээ авах, хураан авах, үзлэх хийх зэрэг тодорхой ажиллагааг явуулах, эрх бүхий байгууллага албан тушаалтны шийдвэрт гомдол гаргах, субъектын эрх зүйн байдал зэрэг зөрчил шалган шийдвэрлэх процессийн ажиллагааг тусгаж өгсөн ч түүнийг хэрэгжүүлэхэд дараах тулгамдсан асуудлууд байна гэж бид үзэж байна. Үүнд:

Нэг. Зөрчлийг шалгах эрх бүхий албан тушаалтан, хэрэг бүртгэгч зөрчлийн хэрэг бүртгэгч нар зөрчлийн хэрэг нээх тохиолдолд бүрт прокурорт хэргийн материалыг хянуулж прокуророос дугаар авах. Практикт зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий нэг субъект /хэсгийн байцаагч/ дунджаар 30 зөрчлийн материал шалгаж байгаа бөгөөд Цагдаагийн албаны тухай хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх эргүүл хийх, хамгаалалтанд үүрэг гүйцэтгэх, гэмт хургээс урьдчилан сэргийлэх зэрэг үйл ажиллагааг үр дүнтэй явуулахад хүндрэл учирч байгаа байгаа зөрчлийг шалгах эрх бүхий албан тушаалтан өөрийн эрх мэдлийн хүрээнд зөрчлийн хэрэг нээж, зөрчлийн хэргийн дугаарыг Цагдаагийн байгууллагын зөрчлийн тоо бүртгэл хариуцсан ажилтан олгодог болгох.

¹¹⁵Захиргааны хариуцлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт

¹¹⁶Өрсөлдөөний тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалт

¹¹⁷Зөрчлийн тухай хуулийн төслийн танилцуулга. 2015 он. www.parliament.mn

Мөн орон нутагт суманд ажиллаж байгаа хэсгийн төлөөлөгч зөрчлийн хэргийн материалд дугаар авах төдийд олон км зам туулах, үргүй зардал гаргах, цагдаагийн төрөл мэргэжлийн албадын бусад чиг үүргийг гүйцэтгэхэд цаг хугацаа алдах зэрэг хүндрэл бэрхшээл учирч байна.

Хоёр. Хуулийн 4.3-р зүйлийн 2 дахь хэсэгт Орон байранд үзлэг хийх тохиолдолд прокуророос зөвшөөрөл авна гэсэн заалтыг эргэж харах. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.3-р зүйлийн 1-д “Эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг тогтоох зорилгоор үзлэг хийнэ”

Цагдаагийн албаны тухай хуулийн 10-р зүйлийн 10.1.3 дахь хэсэгт “Гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэргийн газрыг хамгаалах, үзлэг хийх, нотлох баримт илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах” ажиллагааг явуулж чиг үүргээ хэрэгжүүлэхээр заасан байна.

Дээрх хоёр заалт нь гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, нотлох баримтыг эрж олох, нотолох баримтыг устгаж үгүй болохоос нь өмнө бэхжүүлэх, хураан авах зорилго агуулж байгаа учир орон байранд үзлэг хийхдээ прокуророос заавал зөвшөөрөл авна гэж хатуу тогтоосон заалтыг өөрчлөх.

Зөрчлийн тухай хуульд заасан хулгайлах зөрчил үйлдэгдсэн тохиолдолд эрх бүхий албан тушаалтан дуудлага, мэдээлэл хүлээн авмагц хэргийн газрыг үзлэг явуулах бөгөөд үзлэгийг бусдын орон байранд явуулах тохиолдол элбэг тохиолдоно. Дуудлага мэдээлэл хүлээн авсан алга хаагч дээрх хуулийн заалтын хүрээнд прокуророос зөвшөөрөл авсны дараа үзлэгийг эхлүүлэх ёстой болж таарна.

Харин практикт дуудлага мэдээлэл хүлээн авсан эрх бүхий албан тушаалтан үзлэг явуулахдаа зөвшөөрөл авахгүйгээр энэхүү ажиллагааг хэрэгжүүлж байгаа нь зөрүүтэй байна.

Иймд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд хойшлуулашгүй тохиолдолд орон байранд үзлэг хийх үндэслэлийг “тухайн орон байранд зөрчлийн ул мөр, эд мөрийн баримт байгаа гэх хангалттай үндэслэл байгаа бол зөвшөөрөл авахгүйгээр үзлэг хийж болно” гэж нэмэлт оруулах.

Гурав. ЗШШТХ-ийн 4.5 дугаар зүйл 2.Эд зүйл, баримт бичиг хураан авах бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 24.4 дүгээр зүйлд заасан журмыг баримтална. хэмээн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас иш татсан заалтыг өөрчлөн найруулж хураан авах ажиллагаа явуулах үндэслэл журмыг ойлгомжтой хуульчлан тогтоох.

Учир нь зөрчлийг шалгах эрх бүхий албан тушаалтан өөрийнхөө эрх хэмжээнийхээ хүрээнд дээрх зөрчлийн хэрэгт ач холбогдол бүхий баримт эд зүйлийг хураан авах ажиллагааг үзлэг хийх ажиллагааны үед эсхүл, зөрчлийн талаар дуудлага мэдээлэл хүлээн авч шалгах ажиллагааны үед буюу хойшлуулашгүй үед хэрэгжүүлэх тухай эд зүйлийг хураан авах шаардлага гардаг учир энэхүү заалт нь зөрчлийн процессийн ажиллагааг удаашируулах, зохиомол ачаалал бий болгох, прокурорын эрх хэмжээг хэт дөвийлгөх зэрэг сөрөг талтай учир хуулийн заалтыг өөрчлөн “хүн хуулийн этгээдэд зөрчлийн хэрэгт ач холбогдол бүхий баримт сэлт, эд зүйл байгаа гэх хангалттай үндэслэл байгаа тохиолдолд хураан авах ажиллагааг зөвшөөрөл авахгүйгээр явуулж болно” гэж оруулах.

Дөрөв. ЗШТТХ-ийн 4.8-р зүйлийн 7 дэхь хэсэгт “эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар, эсхүл хүний нэр төрийг гутаан доромжлон харьцаж мэдүүлэг авахыг хориглоно” гэж мэдүүлэг авахад хориглох зүйлийг тусгаж өгсөн ба уг зүйлд хуурч мэхлэх аргаар хөтлөж болон тулгаж мэдүүлэг авахыг хориглоно гэж” нэмэлт өөрчлөлт оруулах.

Учир нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.14-р зүйлийн 4-д “нотлох баримтыг хууль бус арга, хэрэгслээр цуглуулж, бэхжүүлэхийг хориглоно” гэж заасан бөгөөд дээрх хуурч мэхлэх, хөтлөж мэдүүлэг авах болон тулгаж мэдүүлэг авах нь хууль зөрчсөн үйлдэл болох бөгөөд шүүхэд зөрчлийн хэргийг шийдвэрлэхэд нотлох чадвараа алдана.

Тав. ЗШТТХ-ийн 4.11-р зүйлд Зөрчлийг шалгах эрх бүхий албан тушаалтан Шинжилгээ хийлгэх, шинжээч томилохдоо прокуророос зөвшөөрөл авах гэсэн заалт нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг шуурхай явуулахад хүндрэл учруулж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд зохиомол шат дамжлага хүнд суртал бий болгож байгаа учир энэхүү заалтыг хүчингүй болгох.

Эрх бүхий албан тушаалтан зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааны гэрч, хохирогч, холбогдогч зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий байдлыг бодитой тусгаж, зөв мэдүүлэг өгөх чадвартай эсэхийг тогтоох, холбогдогчийн насны байдлыг тогтоох зэрэг ажиллагааг зөрчил үйлдсэн этгээдийг ирүүлж мэдүүлэг авах ажиллагаатай зэрэгцүүлэн хойшлуулашгүй явуулах шаардлагатай.

Гэтэл зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан ажлын цагаар заавал прокуророос зөвшөөрөл авах нь энэхүү ажиллагааг удаашируулах, шинжилгээний объектын шинж чанар

өөрчлөгдөх, зөрчлийн хэргийн оролцогчдод буруу хандлага төрүүлэх зэрэг сөрөг нөхцөл байдал үүсгэж байна.

Мөн хуулийн дээрх зүйлийн 6 дахь хэсэгт “оролцогчийн хүсэлтээр дахин шинжилгээг нэг удаа хийж болно” гэсэн заалт нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.12-р зүйлд заасан оролцогчдоос хүсэлт, гомдол гаргах эрхийг хязгаарлаж, уг заалттай зөрчилдөж байна.

Мөн шинжээчийн дүгнэлт нэг хэрэгт нийт хоёр удаа гаргах бөгөөд эхний дүгнэлт нь сүүлийн дүгнэлтээс өөр гарсан тохиолдолд аль дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргах вэ? зөрчлийг хэрхэн зүйлчлэх вэ? шийтгэлийг хэрхэн ялгамжтай оногдуулах вэ? гэсэн олон асуулт хариултаа хүлээнэ.

Мөн Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 5.1-д “шүүхийн шинжилгээ хийх үндэслэл нь шинжилгээ хийлгэх тухай мөрдөгч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, төрийн эрх бүхий байгууллагын хүсэлт” байна. Мөн хуулийн 20-р зүйлийн 20.1-д “шинжээчийн дүгнэлт, эсхүл түүний зарим хэсэг үндэслэлгүй буюу үнэн зөв болох нь эргэлзээтэй байвал шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн тогтоол, захирамж, хүсэлтээр дахин шинжилгээ хийнэ” гэж заасан нь эрх бүхий албан тушаалтан тогтоол үйлдэж ирүүлснээр шинжилгээ хийх үндэслэл болж байна. Харин энхүү хуульд прокурорын зөвшөөрлөөр шинжилгээ хийнэ гэсэн заалт байхгүй учир шинжилгээ хийлгэхдээ прокуророос зөвшөөрөл авна гэсэн заалтыг хүчингүй болгох шаардлагатай.

Зургаа. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.1-р заасан эрх хязгаарлах арга хэмжээний төрлийг:

- 1.хүнийг саатуулах;
- 2.үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох;
- 3.холбогдогчийн баримт бичгийг хураан авах;

4.Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх гэсэн дөрвөн арга хэмжээг тогтоон хуульчилсан бөгөөд эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хэвийн явагдах нөхцөлийг хангахад дээр дурьдсан эрх хязгаарлах арга хэмжээний төрлийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж бид үзэж байна.

Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий алба хаагчдаас авсан судалгаагаар хүнийг саатуулах эрх хязгаарлах арга хэмжээ нь түр хугацаагаар буюу 6 цаг байдаг тул зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны туршид хэргжүүлэх боломжгүй учир үр дүн бага байдаг.

Мөн үйл ажиллагаа, ашиглалтыг зогсоох эрх хязгаарлах арга хэмжээ нь хуулийн этгээдэд эсхүл тээврийн хэрэгсэл эзэмшигч гэх мэт тусгай субъектэд илүү үр нөлөөтэй. Харин нийтийн хэв журам зөрчигч болон бусад нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон хууль тогтоомж зөрчсөн этгээдэд төлийлөн үр дүн муутай гэж үзжээ.

Мөн холбогдогчийн баримт бичгийг хураан авах ажиллагаа нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны туршид хэрэгжих боловч баримт бичгийг орхин оргон зугтаах, дахин баримт бичиг гаргуулан авах зэрэгээр эрх хязгаарлах арга хэмжээний нөлөөллийг багасгаж байгаа учир төдийлөн үр дүнд хүрэхгүй байна гэжээ.

Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх эрх хязгаарлах арга хэмжээ нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үед бүрэн хэрэгжих үр дүнтэй хэдий ч энэхүү арга хэмжээ нь эрх хязгаарлах арга хэмжээний эцсийн арга хэмжээ бөгөөд Улсын хилээр гарахгүйгээр зарчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас зориуд зайлс хийх, орон нутагт шилжин суурьших, очсон газартаа бүртгүүлэхгүй байх зэрэг нь эрх хязгаарлах арга хэмжээний зорилгыг хангаж чадахгүй байгаа бөгөөд үүнийг эрх хязгаарлах эцсийн арга хэмжээ болгон авч байх шаардлагатай.

Бидний үзэж байгаагаар эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хэвийн явагдах нөхцөлийг хангах зорилгоор дээр дурьдсан арга хэмжээнээс гадна дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр хууль нэмж тусгах.Үүнд:

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.1-р заасан эрх хязгаарлах арга хэмжээний төрөлд батлан даалт өгөх, барьцаа авах гэсэн эрх хязгаарлах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгаж өгөх. Учир нь хүнийг саатуулах, холбогдогчийн баримт бичгийг хураан авах эрх хязгаарлах арга хэмжээ нь анхан шатны Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх эрх хязгаарлах арга хэмжээ нь эцсийн шатны арга хэмжээ гэж үзэх үндэслэлтэй дунд дунд шатны арга хэмжээ болгож батлан даалт өгөх, барьцаа авах эрх хязгаарлах арга хэмжээг шинээр хуулчилах.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.2-р зүйлийн 1.1-д “зөрчлийн холбогдогчийг хэн болохыг тогтоох зорилгоор 6 цаг хүртэл хугацаагаар түр саатуулна” гэсэн заалтыг өөрчлөн найруулж

“зөрчлийн холбогдогчийг нэр, хаягыг тогтоох зорилгоор 6 цаг хүртэл хугацаагаар түр саатуулна” гэж өөрчлөн найруулах.

Учир нь зөрчил үйлдсэн этгээдийг түр саатуулж оршин суугаа газрын хаягыг тогтоосноор тухайн этгээд уг зөрчилд холбоотой эсэхийг тогтоох, тухайн этгээдийн талаарх мэдээллийг холбогдох засаг захиргааны болон иргэний бүртгэлийн байгууллагаас авах, үзлэг хийх, хураан авах ажиллагаа явуулах эсэхийг шийдвэрлэх, зөрчилд холбогдсон насанд хүрээгүй этгээдийн асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг дуудан иүүлэх, гэр бүлийн гишүүнд нь ямар зөрчилд холбогдуулан шалгаж байгаагаа мэдэгдэх зэрэг хууль заасан ажиллагааг явуулах нөхцлийг бүрдүүлэх ач холбогдолтой юм.

Долоо. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлд заасан зөрчлийг хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх дараах үндэслэлийг хуульчилсан. Үүнд:

1.Зөрчил үйлдэгдсэн нь ил тодорхой, зөрчил, учирсан хохирлыг нотлох талаар зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах шаардлагагүй бол;

2.Зөрчил үйлдэгдсэн, учруулсан хохирол нь нотлох баримтаар тогтоогдож холбогдогч зөрчил үйлдсэнээ сайн дураараа хүлээн зөвшөөрсөн бол;

3.Зөрчил үйлдсэн болох нь стандартаар баталгаажсан хэмжилт-хяналтын төхөөрөмжөөр нотлогдсон бол зөрчлийг эрх бүхий албан тушаалтан хялбаршуулсан журмаар шийдвэрлэнэ. Хэмээн заасан бөгөөд хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны гол онцлог нь зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулахгүйгээр тухайн зөрчлийг газар дээр шийдвэрлэх явдал юм.

Гэтэл энэхүү хуулийн 6.6-р зүйлийн 5 дахь хэсэгт заасан “эрх бүхий албан тушаалтан хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн даруй прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ” гэсэн заалтыг гуйвуулж зөрчлийн зарим процессийн ажиллагаа явуулсан байхыг прокурорын байгууллага шаардаж, явуулаагүй тохиолдолд мэдэгдэл шаардлага бичих зэргээр зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих чиг үүргээ урьтал болгож байгаа нь хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зорилго, агуулгыг гажуудуулж байна.

Мөн хуульд зөрчлийн хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх, зөрчлийн улмаас учирсан хохиролын нөхөн төлүүлэлтийг дээшлүүлэх, иргэний зөрчигдсөн эрхийг хангах зорилгоор хялбаршуулсан журмаар хэргийг шийдвэрлэх эрх зүйн үндсийг тусгах өгөх шаардлагатай байна. Үүнд: Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6-р зүйлд “зөрчлийг ердийн журмаар шалган шийдвэрлэх ажиллагааны үед зөрчлийн холбогдогч, хохирогч хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэнэ” гэж нэмэлт заалт оруулж зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хуулийн хугацаанд түргэн шуурхай шийдвэрлэх боломж бүрдэх юм.

Найм. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.11-р зүйлд зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэлд уг зүйлийн 1.4-д “зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацаа дууссан” үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгохоор заасан нь учир дутагдалтай байгаа учир уг заалтыг өөрчилж “зөрчлийн тухай хуульд заасан зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан” гэж өөрчлөн найруулах.

Учир нь Зөрчлийн тухай хуулийн 5.1-р зүйлийн 1-д заасан “олон нийтийн газар, авто зам, орон сууцны орчны газар, гудамж, талбайд бие зассан, эсхүл нус, цэр, тамхины иш, хог хаях зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа нь уг хуулийн 1.5-р зүйлд зааснаар хөөн хэлэлцэх хугацаа нь зургаан сар буюу 180 хоног байна.

Харин уг зөрчлийг шалгах хугацааг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.8 дугаар зүйлд “зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацааг эрх бүхий албан тушаалтан 14 хүртэл хоногийн дотор зөрчлийн хэрэг бүртгэлт явуулна”, “зөрчил шалгах нэмэлт ажиллагаа явуулж нотлох баримт цуглуулах шаардлагатай бол зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацааг зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан 14 хүртэл, прокурор 30 хүртэл хоногоор сунгаж болно” хэмээн заасан бөгөөд уг зөрчлийг шалгах хэрэг бүртгэлтийн хугацаа нийт 58 хоног болж байна.

Тэгэхээр бид өнөөдөр зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байхад буюу процессийн ажиллагаа явуулах боломжтой 122 хоног үлдсэн байхад хэргийг хэрэг бүртгэлийн хугацаа дууссан гэсэн үндэслэлээр зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгож байгаа нь хохирогчийн эрхийг давхар зөрчиж байна.

Хөөн хэлэлцэх хугацаа гэдэг нь: Энэ нь зөрчил үйлдэгдсэнээс хойш, хуулиар тухайн зөрчилд оногдуулах шийтгэлийн төрөл, хэмжээнээс хамааран тодорхой хугацаа өнгөрсөн тохиолдолд зөрчлийг шалгаж шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй байхаар хууль тогтоогчоос тогтоож өгсөн зохицуулалт юм.¹¹⁸

¹¹⁸ <http://www.prokuror.mn/p/88>

Өөрөөр хэлбэл зөрчил үйлдсэн этгээдэд зөрчлийн тухай хуульд заасан хөөн хэлэлцэх хугацааны дотор шийтгэл оногдуулах боломжит хугацаа гэж ойлгож болно.

Гэтэл бид зөрчил үйлдсэн этгээдийг олж тогоон хөөн хэлэлцэх хугацааны дотор шийтгэл ногдуулах ёстой атал хохирогчийн эрхийг зөрчиж хэргийг хэрэгсэхгүй болгож байгаа энэхүү заалтыг даруй өөрчлөн найруулж 6.11-р зүйлд “зөрчлийн тухай хуульд заасан зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан” гэж зааж өгөх шаардлага тулгарч байна.

Дүгнэлт

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар хуулийн үйлчилэх хүрээ, хугацаа тоолох, хэргийн харъяалал, зөрчлийн хэрэг нээх үндэслэл, эрх хязгаарлах арга хэмжээ авах, хураан авах, үзлэх хийх зэрэг тодорхой ажиллагааг явуулах, эрх бүхий байгууллага албан тушаалтны шийдвэрт гомдол гаргах, субъектын эрх зүйн байдал зэрэг зөрчил шалган шийдвэрлэх процессийн бүхий л ажиллагааг тусгаж өгсөн ч түүнийг хэрэгжүүлэхэд дээр дурьдсан тулгамдсан асуудал байгааг анхаарч хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагатай гэж бид үзэж байна.

Санал

-Хууль тогтоомж, хуулийн төслийг боловсруулахдаа хууль зүйн техникийг шаардлагыг баримтлах. Тухайлбал: Ерөнхий сэдэв, нэр нь текстийн зүйл анги, агуулгатайгаа бүрэн тохирсон байх, эрх зүйн хэллэг, нэр томъёо, заалтын үндэслэл, өгүүлэмж нь бүрэн ойлгомжтойгоор илэрхийлэгдсэн байх, тухайн хуулийн төслийн текст нь бусад адил төстэй хуулийн заалтуудтай давхардаагүй буюу зөрчилдөхгүйгээр нарийн нягт зохицсон байх, эрх зүйн шийдлийг хангах замаар нийгмийн харилцааны тодорхой тохиолдлыг бүрэн шийдвэрлэж, зохицуулсан байх, текстийн байгууламж зөв хувиарлагдаж тухайн хуулийн зорилго, агуулга, зарчим болон бүтэц, систем нь зөв оновтой байршиж, томъёологдсон байх гэсэн шалгуурыг баримтлан хуульчлан тогтоох;

-Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд Зөрчлийн хэргийн дугаарыг Цагдаагийн байгууллагын зөрчлийн тоо бүртгэл хариуцсан ажилтан олгоно гэж нэмэлт оруулах;

- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.3-р зүйлийн 2 дахь хэсэгт Орон байранд үзлэг хийх тохиолдолд прокуророос зөвшөөрөл авна гэсэн заалтыг хүчингүй болгож “тухайн орон байранд зөрчлийн ул мөр, эд мөрийн баримт байгаа гэх хангалттай үндэслэл байгаа бол зөвшөөрөл авахгүйгээр үзлэг хийж болно” гэж нэмэлт оруулах;

- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.14-р зүйлийн 4-д “нотлох баримтыг хууль бус арга, хэрэгслээр цуглуулж, бэхжүүлэхийг хориглоно” гэсэн заалтад нийцүүлж “мэдүүлэгийг хуурч мэхлэх, хөтлөж мэдүүлэг авах болон тулгаж мэдүүлэг авахыг хориглоно” гэж нэмэлт оруулах;

- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.11-р зүйлд Зөрчлийг шалгах эрх бүхий албан тушаалтан Шинжилгээ хийлгэх, шинжээч томилохдоо прокуророос зөвшөөрөл авах гэсэн заалт нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг шуурхай явуулахад хүндрэл учруулж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд зохиомол шат дамжлага хүнд суртал бий болгож байгаа учир энэхүү заалтыг хүчингүй болгох;

- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.1-р заасан эрх хязгаарлах арга хэмжээний төрөлд батлан даалт өгөх, барьцаа авах гэсэн эрх хязгаарлах арга хэмжээг нэмж тусгах;

- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6-р зүйлд “зөрчлийг ердийн журмаар шалган шийдвэрлэх ажиллагааны үед зөрчлийн холбогдогч, хохирогч хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэнэ” гэж нэмэлт заалт оруулах;

- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.11-р зүйлд зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэлд уг зүйлийн 1.4-д “зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацаа дууссан” үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгохоор заасан нь учир дутагдалтай байгаа учир уг заалтыг өөрчилж “зөрчлийн тухай хуульд заасан зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан” гэж өөрчлөн найруулах зэрэг саналуудыг дэвшүүлж байна.

ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХЭД ИННОВАЦИЙГ НЭВТРҮҮЛЭХ НЬ

ЦЭЗТ-ийн багш, цагдаагийн
дэд хурандаа Б.Наргулан

Товчлол: Инновацийг хэмжих үндсэн шинжүүд (шалгуурууд) бол шинжлэх ухаан-техникийн хувьд шинэлэг байх, (аж үйлдвэр, хөдөө аж ахуй, эрүүл мэндийг хамгаалах, хууль сахиулах, боловсрол зэрэг үйл ажиллагааны салбаруудад) хэрэгжихүйц, зах зээлд арилжаалагдах шинжтэй, энэ чанараараа хэрэглэгчдийн тодорхой эрэлт хэрэгцээг хангаж чадахуйц байх явдал юм.

Түлхүүр үг: Инноваци” (innovation) гэсэн ойлголт ерөнхий утгаараа “шинэчлэх” гэсэн утга санааг илэрхийлж байна.

Үндсэн хэсэг. XX зууны сүүл хагасаас эхлэн дэлхий дахинд оюуны бүтээлийн үнэ цэнэ үлэмж нэмэгдэн мэдлэг, түүний үр дүн капитал, хөдөлмөрийн нэгэн адил эдийн засгийн нөөц, үйлдвэрлэлийн хүчин чадал, эрх зүйн зохицуулалт нь чухал үүрэг гүйцэтгэдэг болсон байна. Дэлхийн альч өнцөгт буланд байрлаж байгаа, эсвэл баян, ядуу эсэхээс үл хамааран улс орон бүр мэдлэг бий болгох, дэлгэрүүлэх, ашиглахад суурилсан эрх зүйн зохицуулалттай нийгэм буюу өөрөөр хэлбэл инноваци т нийгэм байгуулахад зорих болсон нь олон улсын хөгжлийн орчин үеийн шатны нийтлэг чиг хандлага боллоо.¹¹⁹

Инновацийн соёл, хөгжил эхлэлийн төдий байгаа Монгол орны тухайд инновацийн үйл явц нийгмийн цоо шинэ үзэгдэл болж байна. Зах зээлийн харилцаанд шилжих шилжилтийн жилүүдэд үндэсний инновацийн тогтолцооны зарим нэг элемент бий болсон хэдий боловч хөгжлийн явц нь урсгал шинжтэй, өөр хоорондоо уялдаа холбоо муутай байв.

Энэ үед инновацийн тогтолцоог цогцоор бүрдүүлэх асуудал бие даасан бодлогын тавигдаж байсангүй. Шинэ XXI зууны босгон дээр Монгол улс дотоод нөөц боломжоо тооцон алс хэтийг харсан хөгжлийн чиг шугамаа тодорхойлохдоо чухамхүү инновацийн замыг сонгож авав.

Монгол улс төвлөрсөн эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн жилүүдэд гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг илрүүлэхэд гол ач холбогдол өгч байсан бол дараачийн шатанд гэмт хэрэгтэй тэмцэх асуудлыг гол зорилгоо болгож байна. Энэ зорилгод хүрэхийн тулд улс орныг инновацийн хөгжлийн замаар замнуулах нь улам бүр өсөн нэмэгдсээр буй нь гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх гол арга мөн гэсэн үзэл ойлголт манайд төлөвшөөд байна.

2007 онд төрөөс үндэсний инновацийн тогтолцоог жинхэнэ утгаар нь бүрдүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн өргөн хүрээтэй үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулж баталснаар Монгол улсын инновацийн хөгжилд цоо шинэ үе эхэлсэн гэж үзэж болно.

Бүтээгдэхүүн бий болгох шатан дээр аливаа мэдлэгийг бүрэн эзэмших хэрэглэх нь үлэмж хэмжээний нэмэгдсэн өртөг бүтээж, тэр нь асар их ашиг орлого оруулж байна. Инновацийн онолын эцэг хэмээн нэрлэгддэг Й.Шумпетер үүнийг инновациас өгч буй шан харамж хэмээн нэрлэсэн байдаг.¹²⁰

Орчин үед “Инноваци” (innovation) гэсэн ойлголт ерөнхий утгаараа “шинэчлэх” гэсэн утга санааг илэрхийлж байна. Инновацийн онолын үндэслэгч Й.Шумпетер инноваци бол “бизнесийн зорилгоор үйлдвэрлэлийн хүчин зүйлсийг шинжлэх ухаан-зохион байгуулалтын хувьд шинээр нэгтгэх явдал” гэжээ.¹²¹

Инновациар мэргэшсэн дэлхийн олон эрдэмтэн энэ ойлголтыг олон талаас нь шинжин янз бүрээр тодорхойлж байгаа ч эцсийн дүндээ үндсэн санаа нь адил төстэй байгааг ажиглаж болно.

¹¹⁹ Х.Маам “Инноваци” УБ. 2009 он 6 дахь тал.

¹²⁰ <http://www.maxwell.syr.edu/collaboration/msu/Distance/Innovation/01-01.htm>

¹²¹ Н.Хүүхэнжимээ. “Инновацийн таатай орчинг бүрдүүлэх асуудал УБ 2006. 67-70

Я.Кук, П.Майерс нар “Энэ бол шинэ санаанаас зах зээл дээр борлуулж буй бэлэн бүтээгдэхүүн хүртэлх бүхэл бүтэн үйл явц” гэж. Б.Твисс “шинэ санаа, бүтээл эдийн засгийн агуулгатай болох процесс” гэж, М.Додгсон “инноваци бол шинэ (сайжруулсан) бүтээгдэхүүнийг, эсвэл шинэ (сайжруулсан) үйлдвэрлэлийн үйл явц, юмуу тоног төхөөрөмжийг худалдааны эргэлтэд оруулахад чиглэсэн эрдэм шинжилгээ, технологи, зохион байгуулалт, санхүүгийн үйл ажиллагаа юм.”¹²²

Унгарын эрдэмтэн Б.Санго “инноваци нь шинэ санаа, бүтээлийг практикт хэрэгжүүлэх замаар шинж чанарын хувьд нь илүү сайн бүтээгдэхүүн, технологи бий болгох нийгэм-эдийн засгийн процесс бөгөөд үүний тулд нэмэгдсэн өртөг бий болно” гэж үзсэн байна¹²³.

1993 оны Фраскатын удирдамж (1993 онд Италийн Фраскати хотод) Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага (ОЭСР)-аас баталсан баримт бичигт инновацийг “шинэ ба шинэчилсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх, технологийн процессыг боловсронгуй болгох, нийгмийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр явуулж буй үйл ажиллагааны эцсийн үр дүн” гэж тодорхойлсон бол 1996 оны Ослогийн удирдамжид “технологийн хувьд цоо шинэ, эсвэл сайжруулсан бүтээгдэхүүн, үйл ажиллагааг зах зээлд нэвтрүүлэхийг инноваци” хэмээн тодорхойлсон байдаг.

Монгол улсын Шинжлэх Ухаан Технологийн тухай хуульд “инноваци” гэж эрдэм шинжилгээний ажлын үр дүнг эцсийн бүтээгдэхүүн болгон зах зээл, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх цогц үйл ажиллагаа¹²⁴ гэж тодорхойлсон байдаг.

Тэгэхээр инновацийг хэмжих үндсэн шинжүүд (шалгуурууд) бол шинжлэх ухаан-техникийн хувьд шинэлэг байх, (аж үйлдвэр, хөдөө аж ахуй, эрүүл мэндийг хамгаалах, хууль сахиулах, боловсрол зэрэг үйл ажиллагааны салбаруудад) хэрэгжихүйц, зах зээлд арилжаалагдах шинжтэй, энэ чанараараа хэрэглэгчдийн тодорхой эрэлт хэрэгцээг хангаж чадахуйц байх явдал юм. Зөвхөн шинэ бүтээгдэхүүн эсвэл шинэ процесст шингэж бүтээгдсэн шинэлэг санаа л сая инноваци болж байна.

Шинэ зүйл ба инноваци гэсэн хоёр ойлголтыг зааглаж үзэх хэрэгтэй байна¹²⁵. Шинэ зүйл гэдэг бол үр ашгийг нь дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны аль нэг хүрээнд явуулсан суурь, хавсарга судалгаа, шинжилгээ, боловсруулалт болон туршилтын ажлын үр дүнгийн тодорхойлолт юм.

Шинэ зүйлийг өөрийнхөө хэрэгцээ (өөрийнхөө үйлдвэрт нэвтрүүлэхээр, эсвэл дараа нэвтрүүлэхээр хуримтлуулах)-г хангах үүднээс, худалдах зорилгоор өөрсдөө бүтээдэг. Инноваци бий болгох судалгаа шинжилгээнээс эхлээд маркетингийн боловсруулалт хийх хүртэл явуулж буй бүх төрлийн ажиллагааг инновацийн үйл ажиллагаа гэнэ.

Гэмт хэрэг мөрдөхуйн хөгжлийг философи, ёс зүй, уламжлал, эрх зүй, соёл, нийгмийн байгуулал, эдийн засаг, улс төр хийгээд шинжлэх ухааны ололт амжилт, технологи гээд маш олон салбар мэдлэгийн тогтолцооны нэгдэл, диалектик зөрчилд нь авч үзэх шаардлагатай байдаг.

Гэмт хэрэг нийгмийн үзэгдлийнхээ хувьд түүний хөгжлийн хүрсэн түвшин хийгээд өөрийн гарал үүслээрээ үүсэн бий болох, өөрчлөгдөх (үгүй болох эсхүл үгүйсгэгдэх) зүй тогтолтой байдаг гэж үзвэл гэмт хэргийг мөрдөх нь мөн л тэрхүү зүй тогтолтой харилцан хамааралтай байна. Энэхүү хамаарлыг социодинамикийн үүднээс авч үзвэл хөгжлийнхөө дээд эрэмбэ руу өөрөөр хэлбэл энгийнээс илүү нарийн руу чиглэсэн тасралтгүй хөгжих үйл явц гэж үзэж болно. Нөгөөтэйгүүр боловсронгуй гэж үзэж байгаа үйл явц аажмаар өөрчлөгдөн хувьсаж байдаг зүй тогтол байдаг.

Нийгмийн хөгжил хөдөлгөөний үйл явцад тасралтгүй хөгжиж ирсэн бүхий л үзэгдэл юмсыг дагалдаж ямагт түүний сүүдэр болох гэмт хэрэг, зан үйл энэхүү цаг үеийг хүртэл тасралтгүй орон зайгаа үлдээсээр ирлээ. Альваа нийгэмд төр нь хүчтэй байж төр иргэдийнхээ эрхийг хамгаалж улс үндэстнийхээ аюулгүй байдлыг хангадаг нь зүй билээ.

¹²² <http://www.maxwell.syr.edu/collaboration/msu/Distance/Innovation/01-01.htm>

¹²³ О.Л.Молчанов “Понятие инновации и ее основные свойства” 2001. 35-42 дэхь тал

¹²⁴ ШУТ-ийн тухай хуулийн 3.1.9-р зүйл

¹²⁵ Бурнышева “Управление инновациями и модернизация М. 1999. 7 дахь тал

Хүчтэй төр оршин тогтнохын нэг үндэс бол цагдаа, хууль сахиулах байгууллагуудын мэргэжлийн өндөр түвшинд орчин үеийн техник технологийн шинэчлэлийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаатай холбоотой байдаг. Тийм учраас дэлхийн цагдаа, хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд шинжлэх ухаанд суурилсан инновацийг нэвтрүүлж улсынхаа үндэсний аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам, иргэдийн эрхийг ханган хамгаалах болжээ¹²⁶.

Хууль сахиулах болон цагдаагийн байгууллагад төрийн бусад албаны нэгэн адилаар нийгмийн өөрчлөлтийг даган түүнд нийцүүлэн өөрийн үйл ажиллагааг шинэчлэх, хөгжүүлэн ажиллах шаардлага тавигдаж байна. Иймээс улс орнууд гэмт хэрэгтэй тэмцэх болон цагдаагийн байгууллагынхаа шинэчлэлтийг чухалчлан төрөл бүрийн инновацийг нэвтрүүлэн хэрэглэж байна.

АНУ-д 1980-1990 онуудад боловсруулсан инновацийг өнөөг хүртэл хөгжүүлэн хэрэглэж байна. XIX зуун болон XX зууны эхэн үед Америкийн хууль сахиулах байгууллагын ажилтан үндсэндээ улс төрийн үйлчилгээний ажилтнууд байсан ба эрүүгийн хуулийн болон иргэний эрхийн мэдлэг хязгаарлагдмал байсан байна

Цагдаагийн инновацийг АНУ-ын эрдэмтэд (Мооре, Спелман нарын) хөтөлбөрийн, захиргааны, технологийн болон стратегийн гэж ерөнхийд 4 ангилж байна. Хөтөлбөрийн инноваци нь цагдаагийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр хийгдэж байгаа төрөл бүрийн хөтөлбөрүүд тухайлбал, “хагархай цонх” /broken windows/ хөтөлбөр, “хөршийгөө харах” /neighborhood watch/ хөтөлбөр, сургуулийн насныханд хар тамхи хор хөнөөлийн талаар сургалт явуулах төрөл бүрийн хөтөлбөр, насанд хүрээгүйчүүдэд хорих ангийн бодит байдлыг мэдүүлэх ажиллагаа зэрэг хөтөлбөрүүд юм.

Захиргааны инноваци нь цагдаагийн байгууллага үйл ажиллагаандаа өөрсдийгөө хэрхэн бэлтгэх, ололт амжилтаа тооцоолох зэргийн өөрчлөлт шинэчлэл байдаг. Цагдаа бүрийн, цагдаагийн хэлтэс, нэгжүүдийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулах, түүнийг үнэлэх, түүнчлэн шинэ технологи, сургалт зэргээр дадлагажуулах зэрэг нь багтдаг байна.

Технологийн инноваци гэдэгт цагдаагийн хөнөөлт бус зэр зэвсэг, эдлэл хэрэглэл, ДНК-ийн шинжилгээ болон гэмт хэргийн цахим зураглал хийх зэргийг шинэчлэх асуудал хамаардаг. Технологийн инноваци мэдээлэлд суурилсан технологи (soft) болон материалд суурилсан технологи (hard) гэсэн 2 хэлбэртэй байдаг.

АНУ-д технологийн инноваци асар хурдтай хийгдэж байгаа бөгөөд софт хэлбэрийн инновациудын хувьд компьютерийн шинэ программ хангамж, ангилалын систем, гэмт хэргийн анализ хийх техник, (Компстат), баримт мэдээ болон системийн холбооны техник, түүнчлэн материалд суурилсан технологийн хувьд хурууны хээний бүртгэл, гар утасны мэдээлэл хадгалах тусгай төв, цагдааг хамгаалах хэрэгсэл зэрэг (хүрэм, сум нэвтэрдэггүй хантааз, цагдаагийн машин гэх мэт)байдаг байна.¹²⁷

Стратегийн инноваци нь байгууллагын хэтийн чиг хандлага, түүний ерөнхий философийн үндсэн өөрчлөлт дээр суурилж хийгддэг. Эдгээр өөрчлөлтүүд нь цагдаагийн байгууллагын үндсэн зорилго, үйлчилгээний цар хүрээ, цагдаагийн байгууллагаар хангагдах үйл ажиллагаа, цагдаагийн ажилтны зорилгоо биелүүлэх арга хэрэгсэл, дотоод, гадаад харилцаа холбооны түлхүүр ойлголт зэргүүдийг дахин тодорхойлох явдал байдаг. Энэхүү инноваци нь “хууль сахиулах”-аас “асуудал шийдвэрлэх” руу шилжих ингэхдээ төрөл бүрийн тактикаар нийгмийн бусад хэсгүүдтэй хамтран ажиллах зэргийг чухалчилдаг. АНУ-ын цагдаагийн албанд хамгийн үр дүнтэй хэрэгжиж байгаа дараах инновациуд байна. Үүнд:

1. Нийгэмд суурилсан цагдаа.
2. Мэдээлэлд суурилсан цагдаа

¹²⁶ Б.Одонгэрэл “ АНУ дахь цагдаагийн инноваци, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал, түүнээс суралцах нь” Хууль сахиулахуйн инноваци ОУЭШХ 2014 он 173 дахь тал.

¹²⁷ Жеймс Бирне. Гарри Маркс “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон цагдаагийн үйл ажиллагаан дэхь технологийн инновацийн хэрэгжилт, үр нөлөөний судалгаа”. 2011 он.

Үүнээс үзэхэд Монгол улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд инноваци нэвтрүүлэхэд дээрхи хоёр асуудлын хүрээнд инноваци нэвтрүүлэхийн тулд шинжилгээ судалгаа хийж дүгнэлт хийх шаардлагатай. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам нь алба хаагчдын үүргээ гүйцэтгэх явцад ямар алдаа дутагдал гаргахгүй байхаас гадна, тухайн журмыг дагаж мөрдсөнөөс ямар нэгэн эрсдэл тохиолдохгүй байх талаар анхаарч зохицуулалт хийх нь бидэнд хэрэгтэй инноваци байж болох юм.

Монгол Улсад мөн цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллага гэдгийг хуулиар тодорхойлсон. Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх үүргээ хүлээсэн төрийн томоохон институт юм.

Цагдаагийн байгууллагад олон жилийн турш уламжлалаа хадгалсан шинэчлэл хийгдсээр байгаа ч шинжлэх ухаан, судалгаанд суурилсан томоохон инновациудыг нэвтрүүлэх шаардлагатай. Монгол Улсын цагдаагийн байгууллагын ойрын болон дунд хугацааны тогтвортой хөгжлийг хангаж, үйл ажиллагааг боловсронгуй болгох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох ажилд орчин үеийн менежментийн хэлбэр, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, үр дүнг дээшлүүлэх, иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, алба хаагчийн мэдлэг, ур чадварыг сайжруулах, иргэдийн аюулгүй, амар амгалан амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд оршиж байгаа юм.

Дүгнэлт. Техник технологийн санаачлагыг хууль сахиулах үйл ажиллагаанд богино хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэх гол үндсэн хүч бол цагдаагийн алба хаагчид байдаг. Ийнхүү шинэ санаа, технологийг хэрэгжүүлэх мэдлэг чадвар бүхий алба хаагчийг бий болгоход бодлого, сургалт, мэдээллийн сүлжээ, хүрээг зөв тодорхойлох хэрэгтэй. Энэ чиглэлээр бодлого боловсруулж, сургалт явуулж, мэдлэгийг бүтээснээр чадвар бүхий алба хаагч бэлтгэгдэх нь дамжиггүй юм.

Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажиллагаандаа амжилт олсон гадаад улс орнуудын тэргүүний туршлага, дэвшилтэт техник технологи, инновацийг Монгол Улсад нэвтрүүлэх замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох мөн мөрдөн шалгах ажлын үр дүнг дээшлүүлэх шаардлага бий болжээ.

Цагдаагийн байгууллагын 2020-2025 оны хөгжлийн хөтөлбөрийг үндсэн 5 дахь чиглэлд инноваци болон гэмт хэрэг илрүүлэх урьдчилан сэргийлэхэд дэвшилтэд технологи нэвтрүүлэх тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавих ажлыг эрчимжүүлэх нь ажлын бүтээмжид эерэгээр нөлөөлнө.

Санал.

1. Цахим хяналтын төхөөрөмжийг ашиглах стандарт, аргачлалыг боловсронгуй болгох
2. Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд холбогдох хууль эрх зүйн таатай орчин бий болгох.
3. Шинэ техник, технологийг сургалт, эрдэм шинжилгээний нэгдсэн төв лаборатори байгуулж түүндээ иж бүрэн туршилт, судалгаа хийх замаар практикт нэвтрүүлэх

ЗӨРЧЛИЙГ ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Б.Бямбазаяа

*Цагдаа судлалын магистрант,
цагдаагийн ахмад*

Товчлол. Монгол Улсын Үндсэн хуулийн арван дөрөвдүгээрийн зүйлийн 1 дэх хэсэгт “.. хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, 16.14 дэх хэсэгт “...эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ... нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах эрхтэй”¹²⁸ гэж заасан.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхэлснээр захиргааны хэргийн шүүх зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий зарчим, түүнчлэн цагдаагийн алба хаагчийн хийвэл зохих зан үйлүүд буюу нарийвчилсан зан үйлүүд процесс нь энэхүү хуульд бүрэн тусгагдаж өгөөгүй зэргээс үүдэлтэйгээр хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл үүсгэж байна.

Энэхүү өгүүлэлд зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх зарим арга замын талаар товч авч үзсэн болно.

Түлхүүр үг. Зөрчил, зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэх ажиллагаа, шийтгэл,

Үндсэн хэсэг. Цагдаагийн байгууллага 2020 онд улсын хэмжээнд 2276868 зөрчил бүртгэжээ. Энэ нь өмнөх оныхоос 101043 зөрчлөөр өссөн үзүүлэлт байгаа нь статистик тоо баримтаас харагдаж байгаа бөгөөд 2065296 зөрчлийн хэрэг нээж, 48539550.5 төгрөгийн торгууль ногдуулсан нь байна. Энэхүү өгүүллэгээр Цагдаагийн байгууллага зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар авч үзлээ.


Цагдаагийн байгууллага зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар анкетийн болон асуулгын хоёр хэсэгт авч судаллаа. Цагдаагийн байгууллага зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар төв, орон нутгийн 54 цагдаагийн албан хаагчдыг хамруулан авч судалж үзлээ.

Судалгаанд оролцогчид 18-25 насны 7,4%, 26-30 насны 20,4% болон 31-35 насны 38,9%, 36-40 насны 25,9%-г эзэлж хүйсийн хувьд 92,5% нь эрэгтэй, 7,5% нь эмэгтэй цагдаагийн байгууллагад ажилласан ажлын туршлагыг харахад 1-3 жил 14,8%, 4-6 жил 11,1%, 7-9 жил 9,2%, 10-12 жил 24,1%, 13-15 жил 25,9% нь байна.

Та өдөр бүр зөрчил шалган шийдвэрлэдэг үү гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 94.4% нь “тийм”, 5.6% нь “үгүй” гэсэн хариултыг өгчээ.


¹²⁸ Төрийн мэдээлэл. 1992. №1. Монгол Улсын Үндсэн хууль

График №1




Судалгаанд оролцогчдоос “Та зөрчил шалган шийдвэрлэхдээ хялбаршуулсан журмаар шийдвэрлэж байсан уу” гэсэн асуултад 98.1% нь “тийм”, 1.9% нь “үгүй” гэсэн хариултыг өгсөн байна.

График №2



Харин “Таны шалган шийдвэрлэж буй зөрчлийн хэдэн хувийг нь хялбаршуулсан журмаар шийдвэрлэж байна вэ?” гэсэн асуултад 16.7% нь “0-20 хувь”, 65.2% нь “21-40 хувь”, 31.5% нь “41-60 хувь”, 11.1% нь “61-80 хувь”, 5.5% нь “81 хувиас дээш” гэсэн хариултыг өгчээ.


График №3



Эндээс үзвэл судалгаанд оролцогчдын 48.1 хувь нь зөрчлийг хялбаршуулсан журмаар зөрчлийг ихэвчлэн шалгадаг гэсэн нь зөрчлийг шалгах ажиллагаа хэт олон цаас баримт бүрдүүлдэг, шат дамжлаг ихтэй, прокуророор тэр бүр хянуулаад байх боломж нөхцөл бага байдгаас үүдэлтэй гэж үзэж болохоор байна.

Судалгаанд оролцогчдоос “Зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэх нь оновчтой эсэх” гэсэн асуултыг тавихад 75.9% нь “тийм” гэсэн хариултыг өгсөн нь зөрчлийг түргэн шуурхай, үнэн бодитой шийдвэрлэх эрмэлзлэлтэй байгаагаас харж болохоос байна.

График №4



Цагдаагийн алба хаагчдаас “Зөрчлийн тухай хуулийн ямар зүйл, заалтуудыг түлхүү ашиглаж байна вэ?” гэсэн асуултад өгсөн хариултыг хүснэгтэд оруулан авч үзвэл:


Хүснэгт №1

1.	5.1.1. Олон нийтийн газар, авто зам, орон сууцны орчны газар, гудамж, талбайд бие зассан, эсхүл нус, цэр, тамхины иш, хог хаясан бол хүнийг арван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	7
2.	5.1.2. Согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосон газарт архидаг согтуурсан, эсхүл ажил, үйлдвэрлэлийн зайлшгүй шаардлагатай нөхцөл, эсхүл заншлын дагуу хэрэглэж байгаагаас бусад тохиолдолд хот, суурин газарт биедээ хутга, эсхүл хүний биед гэмтэл учруулж болох тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл авч явсан бол зэвсэг, хэрэгслийг хурааж хүнийг хорин таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	7
3.	5.3.1. Хүний биед хохирол учруулахгүйгээр халдаж зодсон бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	8
4.	5.5.1. Нийтийн зориулалттай орон сууцанд шөнийн цагаар бусад оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	22
5.	6.5.13. Зохих зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлд зааснаас бусад газарт, эсхүл гар дээрээс согтууруулах ундаа худалдсан, эсхүл түүгээр үйлчилсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6
6.	6.20.7. Хүүхдийн бие махбодод халдсан, эсхүл үл хайхарсан, эсхүл хүүхдийн дэргэд архидаг согтуурсан, мансуурсан, хүчирхийлэл үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	8
7.	6.3.1. Утаат тамхи татахыг хориглосон газарт тамхи татсан, эсхүл татах боломж олгосон бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	6
8.	8.8.1. Бусдын эд хөрөнгийг хууль бусаар устгасан, гэмтээсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	11
9.	10.4.1. Хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагад бүртгүүлэх худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээг бүртгүүлээгүй, эсхүл зөвшөөрөлтэй эрхлэх худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээг зөвшөөрөлгүйгээр явуулсан бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	8
10.	14.7.1. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй /жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд/, эсхүл тээврийн хэрэгсэл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн тээврийн хэрэгсэл жолоодсон бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	15

11.	14.7.3.1. согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон;	15
12.	14.7.51. Жолооч замын хөдөлгөөний дүрэм зөрчиж бусдын эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	15
13.	15.9.1. Гэмт хэрэг, зөрчил, түргэн тусламж, гамшиг, аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, гал түймрийн талаар эрх бүхий байгууллагад хуурамч дуудлага, мэдээлэл өгсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	15


“Зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх нь таны ажлын ачаалалд нөлөөлдөг үү?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 68.5% нь “тийм”, 31.5% нь “үгүй” гэсэн хариултыг өгсөн байна.

График №5




“Зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудлуудыг нэрлэнэ үү?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 11.1% нь “нотлох баримтгүй”, 27.8% нь “маргаантай асуудал ихтэй”, 9.3% “нотлох баримтгүй шийдвэрлэгддэг”, 31.5% нь “ачаалал ихтэй”, 20.4% нь “иргэдийн эрх чөлөө ихээр хөндөгддөг” гэсэн хариултыг өгчээ.

График №6



“Хохирол нөхөн төлүүлэх ажиллагаа хийгддэг үү?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 66% нь “тийм”, 34% нь “үгүй” гэсэн хариултыг өгсөн байна.

График №7



Судалгаанд оролцогчдоос “Зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхэд иргэдээс ирүүлдэг санал, хүсэлт, гомдол”-ын талаар асуухад 27.8% нь “торгуулийн нэгжийн хэмжээг

График №8

Хүснэгт №2

	18
--	----

Та зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй

- Зөрчилөө хүлээн зөвшөөрч байхад шууд шийтгэлийн хүүдас таслах, Бэлэн бусаар

- Жишээлбэл: Хүний бичиг баримтыг хуулбарлаж зөрчлийн материалд хавсаргасан тохиолдолд

Үүний улмаас хэсгийн байцаагчийн шалгасан зөрчлийн дийлэнх хувь нь татгалзсан ажил муу хийсэн болж таарна, бэлэн мөнгөөр торгуулахдаа ард иргэд маш ихээр дургуйцдаг пос машинаараа торгогдоггүй юмуу гэх зэргээр эсэргүүцэх байдал үзүүлж байна.

Түүнчлэн иргэдийг бэлэн бусаар торгодог, торгуулаа төлөөгүй бол төрийн үйлчилгээ авхад төрийн үйлчилгээг үзүүлдэггүй байвал эргээд хөшүүрэгтэй юм болов уу гэж бодож байна. Зарим зөрчлийг материалжуулах шаардлагагүйгээр торгуулийн арга хэмжээ авахуулдаг болговол ачаалал багасна. Мөн Зөрчлийн тухай хуулийн 5.5.1 дэх заалтыг хасах саналтай байна.

Иргэд гэртээ байж торгуулах маш их зөрчилдөөн гардаг. Гэр бүл хүчирхийллийн талаар дуудлага мэдээлэл өгсөн, хохирогчид өөрсдийн, эрх зүйн мэдлэг дутмагаас шалтгаалж, тухайн үеийн гэр бүл хүчирхийлэл үйлдэгдсэн гэдгийг цагдаагийн 102 тусгай дугаарт мэдээлсэн хэрнээ маргааш нь тухайн зөрчлийг шалгах үед цагдаагийн байгууллагаас хохирогч холбогдогчдыг дуудан шалгахад үнэхээр холбогдогч хохирогчийг зодсон эсхүл хүсэл зоригийн эсрэг ямар нэг зүйлийг хийхийг албадсан байхад зодсон гэдгийг үгүйсгэдэг, нуудаг, ар гэрээ авч явах хүн холбогдогчоос өөр байхгүй учраас, ямар нэгэн байдлаар баривчилгаанд явуулахгүй, шүүхээр шийдүүлэхгүйгээр торгуулах саналтай байна. Үүнээс болж гэр бүл, хүчирхийлэл далд хэлбэрт орж байна гэж бодож байна.

Мөн хотын захын дүүргүүд, амьжиргааны түвшин доогуур иргэд торгуулийн мөнгө төлөх чадваргүй байдаг. Заавал материалжуулах шаардлагагүй холбогдогч зөрчлөө хүдээн зөвшөөрсөн тохиолдолд шууд л шийтгэврийн руудсыг газар дээр нь бичиж өгөх, бэлэн бусаар замын торгууийн төхөөрөмжөөр торгодог болвол илүү дөхөм болно гэж бодож байна.

Дүгнэлт. Дээрхи судалгааг нэгтгэн авч үзвэл цаашдаа зөрчил шалган шийдвэрлэхэд аль болох алба хаагч нарын ажлын ачааллыг багасгах бодлого хэрэгтэй байна. Зөрчил шалган шийдвэрлэдэг байцаагч нар ялангуяа хэсгийн байцаагч нар бол маш их ачаалалтай ажилладаг. Тийм учраас нотлох баримт бүрдүүлэх шаардлагагүй, холбогдогч нь өөрөө хүлээн зөвшөөрсөн зөрчлийг торгоод шийдчихдэг байх, материалжуулахгүйгээр, олон бичиг цаас шаардахгүй ганц бланканд багтааж шийтгэлийн хуудас дагалдуулах эсхүл шууд шийтгэлийн хуудсаар арга хэмжээ авах зэргээр аль болох хөнгөвчлөх хэрэгтэй байна гэсэн дүгнэлтийг өгч байна..

Санал. Цагдаагийн байгууллага, алба хаагчаас зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэхэд ач холбогдолтой гэж үзсэний үндсэн дээр дараах саналуудыг дэвшүүлж байна. Тухайлбал:

1. Зөрчлийг шалган шийдвэрлэхэд хялбаршуулсан журмаар шийдвэрлэх ажлын хүрээнд торгуулийн мөнгийг бэлэн бусаар авах системийг бүрэн нэвтрүүлэх.
2. Зөрчлийг шалган шийдвэрлэхэд олон бичиг цаас шаардахгүй ганц бланканд багтааж шийтгэлийн хуудас дагалдуулах эсхүл шууд шийтгэлийн хуудсаар арга хэмжээ авдаг тогтолцоо руу шилжих.
3. Зөрчлийн байцаагчийн тоог нэмэгдүүлэх зэрэг саналуудыг дэвшүүлж байна.

ХЯНАЛТТАЙ ХҮРГЭЛТИЙН ҮНДЭСНИЙ БОЛОН ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Мөрдөх арга зүйн тэнхимийн дэд профессор,
цагдаагийн хошууч А.Лхамсүрэн

Товч агуулга: Даяарчлал, гадаад худалдаа, зам тээврийн хөгжил, шуудан илгээмж зэрэг нь хүн төрөлхтөнд олон дэвшлийг авчирсан боловч гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд тодорхой саад учруулж эхэлсэн билээ. Үүний нэг нь үндсэн дамнасан гэмт хэрэг бөгөөд энэ төрлийн гэмт хэрэгтэй хийх тэмцэлд олон улсын хамтын ажиллагаа чухал үүрэгтэй байдаг. НҮБ-ийн 1988 оны “Хар тамхи сэтгэцэд нөлөөлөх бодистой тэмцэх тухай” конвенциор “Хяналттай хүргэлт”-ийн аргын олон улсын эрх зүйн үндэсийг тогтоосон.

Түлхүүр үг: Хяналттай хүргэлт, бараа, олон улсын хамтын ажиллагаа, хяналт, төрийн болон албаны нууц

Үндсэн хэсэг. Нийгмийн хөгжил, технологийн дэвшил зэрэг нь хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаанд эерэгээр болон сөргөөр нөлөөлж байгаа бөгөөд гэмт этгээдүүдийн гэмт үйлдлийг нотлох, бэхжүүлэх зэрэгт шинэ төрлийн арга ажиллагаа шаардлагатай байгаа нь өнгөрсөн зууны 2-р хагасаас тодорхой болсон гэж судлаачид үздэг. Хүнд, зохион байгуулалттай болон үндэстэн дамнасан гэмт хэрэг үйлдэж байгаа этгээдүүдийн үйл хөдлөлд хяналт тавих, гэмт үйлдлийг бэхжүүлэхэд “Хяналттай хүргэлт”-ийн ажиллагааг ашиглаж байна.

Хяналттай хүргэлт нь монгол хэл зүйн үүднээс хяналттай-ажил хэргийн явц, байдлыг нарийвчлан ажиглах, хүргэлт-очих газарт дагуулж аваачиж өгөх¹²⁹ зэргээр тайлбарласан байна.

ОХУ-ын эрдэмтэн А.Ю.Шумилов “Гүйцэтгэх ажлын хяналттай хүргэлт нь гүйцэтгэх ажлын цогц арга хэмжээний нэг бөгөөд хяналттай хүргэлтийн явцад чөлөөт худалдаанд хориглосон, хязгаарлагдсан эд зүй, бараа, мөнгө, үнэт зүйл, гэмт хэрэг үйлдэх замаар олсон эд хөрөнгө, гэмт хэргийн ул мөрийг агуулсан эд зүйл зэргийг гүйцэтгэх ажлын нууц хяналтан доор хүргэж гүйцэтгэх ажлын зорилтыг хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, баримтжуулах, илрүүлэх үйл ажиллагааг хэлнэ¹³⁰ ” гэж тодорхойлжээ.

ОХУ-ын эрдэмтэн А.А.Чувилев “Гүйцэтгэх ажлын хяналттай хүргэлт нь гүйцэтгэа ажилтны хяналтан доор эд зүйл, мөнгө, валют, үнэт зүйл зэргийг сэжигтэй этгээдэд хүргэх, баримтжуулах ажиллагааг хэлнэ¹³¹”.

ОХУ-ын эрдэмтэн А.В.Шахматов “Гүйцэтгэх ажлын хяналттай хүргэлт гэдэг нь гүйцэтгэх байгууллага, ажилтны хяналтан дор бараа эд зүйлийг тодорхой этгээдэд хүргэхийг хэлнэ¹³²”.

“Хяналттай хүргэлт”-ийн мөрдөн шалгах ажиллагаа нь нэг улсын тодорхой нутаг дэвсгэрт болон хоёр буюу түүнээс дээш улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэх аргаар хэрэгжүүлж болох ба хоёр буюу түүнээс дээш улсын нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлж байгаа тохиолдолд олон улсын эрх зүйн баримт бичгээр зохицуулан хэрэгжүүлдэг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 26.5-р зүйл

¹²⁹ Монгол хэлний их тайлбар толь <https://mongoltoli.mn/search.php?opt=1&word=>

¹³⁰ Шумилов.А.Ю Комментарии к федеральному закону “Об оперативно-розыскной деятельности” Москва 2004 стр 84

¹³¹ А.А.Чувилев Оперативно-розыскное право 1999 г стр 80

¹³² А.В Шахматов докторская диссертация “Агентурная работа в ОРД теоритико-правовое исследование России” 2005 г. СПб

1. Мөрдөгч гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн, эсхүл үйлдэхэд оролцсон хүнийг олж тогтоох зорилгоор хууль бус, сэжигтэй барааг өөрийн улсын хилээр нэвтрүүлэх, эсхүл тодорхой нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэхэд хяналт тавих ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулна.

2. Мөрдөгч хяналттай хүргэлтийг хэд хэдэн улсын хилээр нэвтрүүлэх, нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэх бол Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний заалтыг үндэслэн хамтран ажиллах хүрээнд прокурорын зөвшөөрлөөр явуулна¹³³ гэж заасан нь анх удаагаа хяналттай хүргэлтийг үндэсний хуульд хуульчилсан тохиолдол юм.

Өөрөөр хэлбэл тодорхой этгээд, түүний гэмт бурууг тогтоох, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан байж болзошгүй багаж хэрэгсэл, гэмт хэргийн ул мөрийг агуулсан эд зүйл, **бараа**, материал зэрэг материаллаг эд зүйлийг нэг улсын тодорхой нутаг дэвсгэр эсхүл хоёр буюу түүнээс дээш улсын нутаг дэвсгэр дамжуулан хяналтад байлгаж зөөвөрлөхийг ойлгоно. **Бараа** гэдэг нь “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-ийн тухай 1983 оны олон улсын конвенц¹³⁴, Монгол улсын “Барааг тодорхойлох, кодлох, уялдуулах систем”-д заасан бүх эд зүйлийг хэлнэ.

Дээрх төрлийн мөрдөн шалгах ажиллагааны олон улсын эрх зүйн үндэс нь 1988 оны “Хар тамхи сэтгэцэд нөлөөлөх бодистой тэмцэх тухай” конвенци юм. Уг конвенцийн 11-р зүйлээр хэлэлцэн тохирогч улсууд өөр хоорондоо энэ төрлийн мөрдөн шалгах аргыг хэрэгжүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх, харилцан эрх зүйн баримт бичиг боловсруулах үүрэг хүлээсэн байдаг. Мөн Нэгдсэн үндэстний байгууллагын Ерөнхий ассамблейн 55/25 тоот тогтоолоор батлагдсан “Үндэстэн дамнасан гэмт явдалтай тэмцэх тухай” Палермогийн конвенцийн 20-р зүйлд энэ төрлийн мөрдөн шалгах арга хэмжээг үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх тусгай аргад хамааруулж үзсэн байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шинээр нэмэгдсэн гэмт хэргийг илрүүлэх, бүрэн илрүүлэх талаар нэгэн шинэ арга нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 26-р бүлэгт заасан “Бусад мөрдөн шалгах ажиллагаа” буюу “Нууц мөрдөн шалгах ажиллагаа” юм.

“Мөрдөгч гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн эсхүл үйлдэхэд оролцсон хүнийг олж тогтоох зорилгоор хууль бус, сэжигтэй барааг өөрийн улсын хил нэвтрүүлэх, эсхүл тодорхой нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэхэд хяналт тавих ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр хийнэ”¹³⁵ гэж Монгол улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 26.5-р зүйлд заасан байдаг.

Өөрөөр хэлбэл тодорхой этгээд, түүний гэмт бурууг тогтоох, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан байж болзошгүй багаж хэрэгсэл, гэмт хэргийн ул мөрийг агуулсан эд зүйл, **бараа**, материал зэрэг материаллаг эд зүйлийг нэг улсын тодорхой нутаг дэвсгэр эсхүл хоёр буюу түүнээс дээш улсын нутаг дэвсгэр дамжуулан хяналтад байлгаж зөөвөрлөхийг ойлгоно. **Бараа** гэдэг нь “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-ийн тухай 1983 оны олон улсын конвенц¹³⁶, Монгол улсын “Барааг тодорхойлох, кодлох, уялдуулах систем”-д заасан бүх эд зүйлийг хэлнэ.

Хяналттай хүргэлтийн мөрдөн шалгах ажиллагааны зүйл нь Иргэний хууль тогтоомжийн дагуу хийгдсэн хэлцэлийн зүйл, гэмт хэрэг үйлдсэн багаж, зэвсэг, бусад зүйл болон чөлөөт эргэлтэд хориглогдсон болон хязгаарлагдсан бараа эд зүйл байж болно. Хууль сахиулах байгууллагын практикт хяналттай хүргэлтийн мөрдөн шалгах ажиллагааг хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл болон үнэт металл, галт зэвсэг, сум галт хэрэгсэл гэх мэтэд хэрэгжүүлэх нь элбэг байдаг.

Хяналттай хүргэлтийн мөрдөн шалгах ажиллагаа нь тодорхой цаг хугацаанд үргэлжилсэн үйлдэлтэй байдаг тул гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг бүрэн агуулсан цаг үед нь илрүүлж таслан зогсоох арга хувилбарыг баримталсан нь илүү үр дүнтэй байдаг билээ. Өөрөөр хэлбэл гэмт санаа зорилго үүссэн цаг үеэс эхлэн уг мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлж эхлэн улсын хилээр гарах чиглэлд нэвтрэх эсхүл гаалийн нутаг дэвсгэрт нэвтэрч эцсийн хүлээн авагчид очих цаг хугацаа хүртэл

¹³³ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он

¹³⁴ Олон улсын барааг тодорхойлох, кодчилох, уялдуулах тухай Брюсселийн конвенци 1983 он

¹³⁵ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 26.5-р зүйл 2017 он Улаанбаатар

¹³⁶ Олон улсын барааг тодорхойлох, кодчилох, уялдуулах тухай Брюсселийн конвенци 1983 он

гэмт хэргийг таслан зогсоохгүй тасралтгүй хяналтад байлгадагаараа бусад мөрдөн шалгах тодорхой ажиллагаа болон мөрдөн шалгах нууц ажиллагаанаас ялгагддаг юм. Мөн бусад гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, ул мөрийг бэхжүүлэх зорилгоор хяналттай хүргэлтийг хэрэгжүүлж болно.

Хяналттай хүргэлтийн мөрдөн шалгах ажиллагааны зүйл нь Иргэний хууль тогтоомжийн дагуу хийгдсэн хэлцэлийн зүйл, гэмт хэрэг үйлдсэн багаж, зэвсэг, бусад зүйл болон чөлөөт эргэлтэд хориглогдсон болон хязгаарлагдсан бараа эд зүйл байж болно. Хууль сахиулах байгууллагын практикт хяналттай хүргэлтийн мөрдөн шалгах ажиллагааг хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл болон үнэт металл, галт зэвсэг, сум галт хэрэгсэл гэх мэтэд хэрэгжүүлэх нь элбэг байдаг. Хяналттай хүргэлтийн мөрдөн шалгах ажиллагаа нь тодорхой цаг хугацаанд үргэлжилсэн үйлдэлтэй байдаг тул гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг бүрэн агуулсан цаг үед нь илрүүлж таслан зогсоох арга хувилбарыг баримталсан нь илүү үр дүнтэй байдаг билээ. Өөрөөр хэлбэл гэмт санаа зорилго үүссэн цаг үеэс эхлэн уг мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлж эхлэн улсын хилээр гарах чиглэлд нэвтрэх эсхүл гаалийн нутаг дэвсгэрт нэвтэрч эцсийн хүлээн авагчид очих цаг хугацаа хүртэл гэмт хэргийг таслан зогсоохгүй тасралтгүй хяналтад байлгадагаараа бусад мөрдөн шалгах тодорхой ажиллагаа болон мөрдөн шалгах нууц ажиллагаанаас ялгагддаг юм. Мөн бусад гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, ул мөрийг бэхжүүлэх зорилгоор энэ мөрдөн шалгах ажиллагааг явуулж болно.

Эрүүгийн хэрэг хянан шийлвэрлэх тухай хуульд заасан тодорхой ажиллагаа болох хяналттай хүргэлт нь гүйцэтгэх ажлын хууль, тогтоомжид заасан арга хэмжээнээс ялгаатай ойлголт юм.

Монгол улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.3-р зүйлд “...хяналттай хүргэлт... таньж олуулах ажиллагааг нууцаар хийхийг прокурорын зөвшөөрлөөр явуулна” гэж журамласан бөгөөд илээр буюу ердийн арга хэрэгсэл ашиглан явуулах боломж бага байдаг тул практикт ихэнх тохиолдолд прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулдаг. Мөн хуулийн 26.5-р зүйлд хяналттай хүргэлтийн ажиллагааг хэд хэдэн улсын хилээр нэвтрүүлэх, нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэх бол Монгол улсын нэгдсэн орсон олон улсын гэрээний заалтыг үндэслэн хамтран ажиллах хүрээнд прокурорын зөвшөөрлөөр явуулна гэж заасан. Гэмт хэрэгтэй тэмцэх гүйцэтгэх ажлын ажлын олон улсын хамтын ажиллагаа нь хамгийн нарийн түвэгтэй эрх зүйн зохицуулалтын нэг юм.

Хяналттай хүргэлтийн аргыг 2 буюу түүнээс дээш улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тохиолдолд гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагааны эрх зүйн зохицуулалт чухал байна. Мөн мөрдөн шалгах ажиллагааны үйл явцад авагдаж байгаа мэдээлэл, баримт сэлт, хүч, хэрэгслийн талаар мэдээлэл үндэсний болон гадаад улсуудын хууль тогтоомжоор нууцын янз бүрийн зэрэглэлд багтдаг. Иймд гүйцэтгэх ажлын холбогдолтой мэдээлэл, баримт, сэлтийг солилцохдоо Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийг удирдлага болгон ажиллах ёстой.

Гэмт хэрэгтэй тэмцэх хамтын ажиллагааг бөгөөд дараах түвшинд ангилж болно.

1. Олон улсын олон талт гэрээ конвенцийг соёрхон баталсан улс-оролцогчтой хамтран ажиллах
2. Засгийн газар хооронд байгуулсан 2 талт гэрээ хэлцэлийн хүрээнд
3. Олон улсын эрүүгийн тагнуулын байгууллага Интерполын мэдээлэл боловсруулах дүрэмийн хүрээнд хамтран ажиллах
4. 2 улсын яам, агентлагийн түвшинд хамтран ажиллах
5. Бүс нутгийн шинжтэй гэрээ хэлэлцээрийн хүрээнд хамтран ажиллах

Одоогийн байдлаар гадаад улсуудтай байгуулсан 19 эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ¹³⁷ эрүүгийн хэргийн хүрээнд харилцан туслалцаа үзүүлэх талаар заасан гэрээг иргэд эдийн засаг худалдааны харилцаа сайн хөгжсөн, хоёр улсын иргэд харилцан их зорчдог Оросын холбооны улс, Бүгд найрамдах Хятад ард улс, Бүгд найрамдах Солонгос улс, Бүгд найрамдах Казахстан зэрэг 17 улстай байгуулсан нь хүчин төгөлдөр үйлчилж байна.

¹³⁷ https://mojha.gov.mn/newmojha/?page_id=1609

Дүгнэлт. Дээр дурдсан мөрдөн шалгах ажиллагааг олон улсын гэрээ конвенци, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний үндсэн дээр болон цагдаа, хууль сахиулах байгууллагуудын түвшинд зохион явуулж мэдээллийг харилцан шуурхай солилцох, гэмт этгээдүүдийн үйлдлийг бүрэн гүйцэд баримтжуулах, таслан зогсоох нь хөрш улсууд болон бүс нутгийн цагдаагийн байгууллагуудын хэмжээнд тулгамдаж буй асуудал юм.

Сүүлийн жилүүдэд манай улсад хориглосон, хязгаарласан эд зүйл улсын хилээр гадаад улсад гаргах, олон улсын шуудан илгээмж ашиглан зөөвөрлөх тохиолдлууд олноор бүртгэгдэх болсон нь “Хяналттай хүргэлт”-ийг бусад улсын цагдаагийн болон хууль сахиулах байгууллагуудтай хамтран зохион байгуулах, түүний эрх зүйн үндсийг сайтар тогтоох, хамтын ажиллааг хөгжүүлэх шаардлагыг улам нэмэгдүүлж байгааг харуулж байна.

Ашигласан материалын жагсаалт

1. Монгол хэлний их тайлбар толь <https://mongoltoli.mn/search.php?opt=1&word=>
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он
3. теоритико-правовое исследование России” 2005 г. СПб
4. Олон улсын барааг тодорхойлох, кодчилох, уялдуулах тухай Брюсселийн конвенци 1983 он
5. Олон улсын барааг тодорхойлох, кодчилох, уялдуулах тухай Брюсселийн конвенци 1983 он
6. Шумилов.А.Ю Комментарии к федеральному закону “Об оперативно-розыскной деятельности” Москва 2004
7. А.А.Чувилев “Оперативно-розыскное право” 1999 г
8. А.В Шахматов докторская диссертация “Агентурная работа в ОРД” 2004 г
9. https://mojha.gov.mn/newmojha/?page_id=1609

МОНГОЛ УЛС ДАХЬ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ХОЛБОГДОХ ГЭМТ ХЭРГИЙГ МӨРДӨХ, НОТЛОХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙНЗОХИЦУУЛАЛТ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Я.Цэлмэн

*Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын
эрх зүйн тэнхимийн дэд профессор,
цагдаагийн хошууч, докторант*

Хураангуй: Хуулийн этгээдээс гэмт хэрэг үйлдэх, түүний үйлдэл, эс үйлдэхгүйг эрүүгийн хуулийн тусгай ангийн зүйл заалтаар зүйлчлэн, мөрдөн шалгах, нотлох ажиллагаа явуулах ойлголт Монгол Улсын орчин цагийн эрх зүйн орчинд 2017 оноос бий болсон шинэ ойлголт юм. Бидний судалгааны ажлын хүрээнд хуулийн этгээдийн ойлголт, тэдний зүгээс улс орон, ард иргэдэд учруулж байсан сайн ба муу нөлөө, түүний үр дагавар, хэрхэн асуудлыг шийдвэрлэж байсныг түүхэн эх сурвалжуудын хүрээнд авч үзсэнээр энэ ойлголт нь Монголчуудын хувьд шинэ ойлголт биш бөгөөд, түүхэн үйл явдал, түүхийн нугачаанд түр мартагдсан шинэ ойлголт байж болох талаар бид олж мэдсэн билээ. Хэдий тийм ч бидний судалгааны ажлын цаг үеийн шаардлагаар хуулийн этгээдэд холбогдох гэмт хэргийг нотлох, мөрдөн шалгах ажиллагааны талаар хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, эрх зүйн орчинд судалгааны ажлаа чиглүүлж, зарим асуудлаар дүгнэлт хийж, санал дэвшүүлэхийг зорилоо.

Түлхүүр үг: эрх зүйн онол, уламжлал, эрх зүйн шинэчлэл, компани, корпораци, групп, хамтын хариуцлага.

I.Оршил. Хуулийн этгээдэд холбогдох гэмт хэргийг нотлох, мөрдөн шалгах, түүнээс урдчилан сэргийлэх, таслан зогсоох ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг улс орнууд өөрсдийн уламжлал, онцлог, бусад орны эрх зүйн туршлагаас дүгнэлт хийж өөрийн орны эрх зүйн орчины онцлогт тохируулан хөгжүүлж ирсэн байна.

Хуулийн этгээдэд холбогдох гэмт хэргийг мөрдөн шалгах, эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад хуульзүйн үндэслэлийг тодорхойлсон нэг дэвшил болсон.

Бид эрх зүйн эх сурвалжийн ач холбогдлоор нь Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, конвенц, бусад хууль, эрх зүйн акт гэсэн дарааллаар судалгааны ажлаа системчлэн судлах нь зүйтэй.

II. Монгол Улсын Үндсэн хуулинд Хуулийн этгээдийн талаар хэрхэн зохицуулсаныг товч авч үзье.

Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 5: Төрөөс гадаадын иргэн, **хуулийн этгээд**, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно гэж заасан. Үүнээс өөрөөр хуулийн этгээд гэсэн нэр томъёо тусгагдаагүй хэдий ч бид хуулийн этгээдийн шинжээр нь холбон авч үзлээ. Үндсэндээ хуулийн этгээдийг зорилгоор нь

а/ ашгийн төлөө

б/ ашгийн төлөө бус гэсэн үндсэн хоёр бүлэгт ангилж үзэж болхоор байгааг судалгааны үр дүн илтгэж байна.

Хуулийн этгээд нь ашгийн төлөө байх шинжид өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй, түүндээ зориулсан тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа тодорхой орлого олох зорилготой хүмүүс зохион байгуулалттайгаар нэгдэн хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг гэсэн гол шинжүүд багтаж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлийн 2 дах хэсэгт “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.” гэж заасан нь хуулийн этгээдийн өмчлөх эрх, ашгийн төлөөх үйл ажиллагааг баталгаажуулсан байна. Мөн 5 дугаар зүйлийн 3 дах хэсэгт “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно” гэсэн нь хуулийн этгээдийн эрхийг хязгаарлах үндсэн эх сурвалж болсон.

III. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай болон бусад хуулинд хуулийн этгээдийн талаар хэрхэн зохицуулсаныг товч авч үзье.

Хуулийн этгээдэд холбогдох гэмт хэргийг мөрдөх, нотлох ажиллагааг эрүүгийн процессын эрх зүйн зохицуулалтаар зохицуулсан тохиолдол нь 2017 оноос өмнө Монгол Улсад шинэ ойлголт юм. Эрүүгийн процессын хуулинд тусдаа нэг бүлэг болгосон нь 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн.

Олон улсын эрх зүйн практикт хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулдаг жишиг нэгэнт бий болсныг бид өмнөх бүлгүүдийн судалгааны үр дүнд мэддэг болсон билээ. Зөвхөн хувь хүнд эрүүгийн хариуцлага оногдуулдаг байсан онол, үзэл баримтлал өөрчлөгдөн нэгэн зууныг үдэж байгаа бол манай улсад гурав орчим жил болж байна. Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд 50 орчим мянга байгаа бөгөөд тэдгээрийн эдийн засагт үзүүлэх нөлөө асар өргөн төдийгүй мөн нийгэмд учруулж болох хохирол, хор уршиг нэмэгдсээр байна.

Саяхныг хүртэл Монгол улсын эрүүгийн эрх зүйн системд хуулийн этгээд өөрийн ажилтны гэм буруутай үйлдлийн улмаас ашиг хүртэж, давуу байдлыг олж авсан хэдийн ч зөвхөн хувь хүн эрүүгийн хариуцлага хүлээж, хуулийн этгээд хариуцлагын гадна үлддэг байсны халж хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт Монгол Улсын Эрүүгийн хуульд 2014 оноос бий болсон хэдий ч эрүүгийн хариуцлага оногдуулах үндэслэлийг тодорхойлж хуульчлаагүй, цөөн тооны гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэхээр заасан байна. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлийг нарийвчлан тодорхойлж, хариуцлагад татах гэмт хэргийг нэмэгдүүлсэн¹³⁸.

Монгол Улсын засгийн газар компанийн засаглалыг хөгжүүлэх, сайжруулах, хариуцлагажуулах чиглэлээр олон бодлого боловсруулж хэрэгжүүлж байна.

Хуулийн этгээдийн тухай 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдсөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль¹³⁹-ийн зорилтоосоо эхлэн тусгасан юм. Тухайлбал:

1.1 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино.

Энэ мэтчилэн “хуулийн этгээд” гэсэн нэр томъёо орсон зохицуулалт 101 байх бөгөөд бид дараах байдлаар бүлэглэн судалсан болно.

ЭХХШ тухай хуулийн **Хорьдугаар бүлэгт: “Хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”** гэсэн зургаан зүйлтэй зохицуулалт анх удаа хуульчлагдсан. Судлагдахууны хувьд шинэлэг, хэрэглээний хувьд шинэ уг бүлэгт хуулийн этгээдийн үйлдсэн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах тусгай журмыг тогтоосон байна. “Хуулийн этгээдийн үйлдсэн эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд ЭХХШ тухай хуульд заасан ердийн журмаас гадна 20

¹³⁸ Цэцэгмаа.Г. Хуулийн этгээдийн гэм бурууг нотлох ажиллагаа. Эрүүгийн эрх зүйн шинэтгэл: хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал, олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл. УБ., 2017 он. 47-48 дах тал

¹³⁹ Төрийн мэдээлэл. №23 УБ., 2017

дугаар бүлэгт заасан тусгай журмыг баримтална” гэж ЭХХШ тухай хуулийн 20.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан.

Үүнийг дэлхийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай загвар хуулийн албан ёсны орчуулгатай харьцуулж авч үзье.

Д/д	Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль ¹⁴⁰	Дэлхийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай загвар хууль ¹⁴¹	
	ХОРЬДУГААР БҮЛЭГ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ХОЛБОГДОХ ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА	БҮЛЭГ 6. Хуулийн этгээдийн эсрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	
	20.1 дүгээр зүйл.Хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах 1.Хуулийн этгээдийн үйлдсэн эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд энэ хуульд заасан ердийн журмаас гадна энэ бүлэгт заасан тусгай журмыг баримтална. 2.Хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тухайн хуулийн этгээдийг төлөөлөх албан тушаалтны, эсхүл хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдэл хийсэн хүний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаатай хамт явагдана. 3.Хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг тухайн гэмт хэрэгт хүнийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж байгаагаас үл хамааран явуулж болно.	80 дугаар зүйл. Хуулийн этгээдийн эсрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа 1. Эрүүгийн гэмт хэрэг болон зөрчилд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь тухайн хэрэгт хувь хүнд нь хариуцлага хүлээлгэсэн байсан ч хийгдэж болно. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь гэмт хэргийг үйлдсэн хувь хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгээгүй тохиолдолд ч байж болно. 2. Хуулийн этгээд болон хувь хүн нь нэг гэмт хэрэгт эсвэл нэг ажил хэргийн төлөөх өөр өөр гэмт хэргийг үйлдсэний төлөө яллагдаж байгаа тохиолдолд 193 дугаар зүйлд зааснаар нэг яллах дүгнэлт үйлдэгдэж болно.	193 дугаар зүйл. Яллагдагчид хамааралтай байх Адил үйлдэлийн улмаас ижил эсвэл өөр өөр гэмт хэрэгт буруутгагдан яллагдаж байгаа хүмүүсийг нэг ялын төлөвлөгөөгөөр яллаж болно.
	20.2 дугаар зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийг төлөөлөх 1.Хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд тухайн хуулийн этгээдийг дараахь хүнээр төлөөлүүлж болохгүй: 1.1.хуулийн этгээдийн эсрэг шүүх хуралдаанд гэрчээр оролцож байгаа бол; 1.2.хуулийн этгээдийг төлөөлөх хүн нь тухайн хэргийн яллагдагч бол. 2.Яллагдагчаас өөр тухайн хуулийн этгээдийг төлөөлөх	81 дүгээр зүйл. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийг төлөөлөх 1. Хуулийн этгээд эрүүгийн гэмт хэрэг, зөрчилд яллагдаж байгаа бол хуулийн этгээдийн нэг төлөөлөгч бүхий л хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоно. 2. Хуулийн этгээдийн төлөөлөгч нь хэрэглэгдэж буй хуулийн дагуу хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд байна. 3. Хуулийн этгээдийг дараах этгээд төлөөлж болохгүй: а) Хуулийн этгээдийн шүүх хуралд гэрчээр асуугдаж буй этгээд, б) Хуулийн этгээдийн цорын ганц таөлөөлөгч байхаас бусад тохиолдолд	

¹⁴⁰

¹⁴¹ Model Code for post conflict criminal responsibility, Model code for Criminal Procedure

	хүн байхгүй тохиолдолд энэ зүйлийн 1.2 дахь заалт хамаарахгүй. 3.Хуулийн этгээдийг төлөөлөх хүн байхгүй бол тогтоосон хугацааны дотор өөр этгээдийг хууль ёсны төлөөлөгчөөр томилохыг шүүх, прокурор, мөрдөгч хуулийн этгээдэд бичгээр мэдэгдэнэ. 4.Тогтоосон хугацаанд хуулийн этгээд хууль ёсны төлөөлөгчөө томилоогүй бол шүүх, прокурор хууль ёсны төлөөлөгчийг томилж болно. 5.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн хуулийн этгээдийн улсын бүртгэл, зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, тэдгээртэй адилтгах мэдээллийг өөрчлөхгүй байх, улсын бүртгэлээс хасахгүй байхыг шүүх, прокуророос холбогдох байгууллагад мэдэгдэнэ.	тухайн эрүүгийн хэрэгт яллагдаж буй этгээд. 4. 3 дугаар хэсэгт зааснаар тухайн этгээд хуулийн этгээдийн төлөөлөгч байх боломжгүй бол эрх бүхий шүүх хуулийн этгээдийн эрх бүхий этгээдийг тогтоосон хугацааны дотор өөр этгээдийг төлөөлөгчөөр томилохыг шаардах ба томилгооны талаар бичгээр шүүхэд мэдэгдэнэ. Хэрвээ тогтоосон хугацааны дотор энэ нь хийгдэхгүй бол шүүх хуулийн этгээдийн төлөөлөгчийг томилж болно. 5. Эрх бүхий шүүхийн бүртгэлийн газар (тухайн улсад хуулийн этгээдийн бүртгэлийг хариуцдаг этгээдийн нэрийг оруулах)-д тухайн хуулийн этгээд хуулийн ажиллагааны субъект болсныг мөн түүнийг эсрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны туршид татан буулгах боломжгүйг мэдэгдэнэ.	
	20.3 дугаар зүйл.Хуулийн этгээдийн эрх, үүрэг 1.Хуулийн этгээдийн хууль ёсны төлөөлөгч энэ хуульд заасан яллагдагчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.		
	20.4 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн өмгөөлөгч 1.Хуулийн этгээд өмгөөлөгчтэй байж болно. Хуулийн этгээдийн өмгөөлөгч энэ хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.	82 дугаар зүйл. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийг өмгөөлөх өмгөөлөгч 1. Хуулийн этгээд нь өөрийн төлөөлөгчөөс гадна өмгөөлөгчтэй байж болно. 2. Хуулийн этгээд болон хувь хүн нэг гэмт хэрэгт эсвэл нэг ажил хэргийн төлөөх өөр өөр гэмт хэргийг үйлдсэний төлөө яллагдаж байгаа тохиолдолд тэдгээр нь нэг ижил өмгөөлөгчтэй байж болохгүй.	
	20.5 дугаар зүйл.Хуулийн этгээдэд баримт бичиг хүргэх 1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой шүүх, прокурор, мөрдөгчийн шийдвэр, бусад баримт бичгийг хуулийн этгээдийн хаягаар хүргүүлж, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгчид гардуулна. 2.Шүүх, прокурор, мөрдөгчийн шийдвэр, бусад баримт бичгийг хүргүүлэх, гардуулахдаа энэ хуулийн 11.9 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.	83 дугаар зүйл. Хуулийн этгээдэд хамаарах бичиг баримттай холбоотой үйлчилгээ болон шүүхийн бусад материалууд 1. Баримт бичиг болон шүүхийн бусад материалууд тухайлбал, шүүхийн зарлан дуудах, тогтоол, шийдвэр, яллах дүгнэлт, шүүхийн шийтгэх тогтоол эсвэл МССР /Model code for Criminal Procedure/-ийн заалтын дагуу шаардагдсан хүргэлтийн эд зүйлс зэрэг нь хуулийн этгээдийн хаягаар хүргэгдэнэ. 2. Баримт бичиг, бусад шүүхийн материалууд нь 1 дэх хэсэгт зааснаар хүргэгдэхдээ 27 дугаар зүйлд зааснаар хуулийн этгээдийн төлөөлөгчид хүргэгдэнэ.	
	20.6 дугаар зүйл.Яллах дүгнэлт, шүүхийн шийдвэр	84 дүгээр зүйл. Хуулийн этгээдийн ялын дүгнэлтийн агуулга	

	1.Хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэргийн яллах дүгнэлт, шүүхийн шийдвэрт дараахь зүйлийг нэмж тусгана: 1.1.хуулийн этгээдийн нэр; 1.2.хуулийн этгээдийн албан ёсны хаяг.	1. Хуулийн этгээдийн эсрэг ялын дүгнэлт нь 195 (3)-д засан дээр нэмээд дараах мэдээлэл байна: а) Хэрэглэгдэж буй хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн нэр, б) Хуулийн этгээдийн оршин суух газар, с) MCC /Model code for Criminal/-ийн дагуу хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх үндэс.	
		85 дугаар зүйл. Шүүх хуралд мэдэгдэл хийх 1. Хуулийн этгээдийн төлөөлөгч 223 дугаар зүйлд зааснаар шүүх хуралдаан дээр мэдэгдэл хийнэ. 2. Хуулийн этгээдийн төлөөлөгчийг албан ёсны тунхаг хийхийг шаардаж мөн прокурор болон шүүх хурал түүний мэдэгдлийн агуулгын талаар шалгаж болохгүй. 3. Анхан шатны шүүх хурал хэрвээ шаардлагатай бол төлөөлөгчийн мэдэгдлийг нотолгооны үнэ цэнэтэй эсэхийг шийднэ.	
		86 дугаар зүйл. Хуулийн этгээдийн эсрэг шүүхийн шийтгэх тогтоолыг бичгээр гаргах нь 1. 269 дүгээр зүйлийн шаардлага дээр нэмж хуулийн этгээдийн эсрэг бичгэн шийтгэх тогтоол нь дараах зүйлүүдийг агуулсан байна: а) Хэрэглэгдэж буй хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн нэр, б) Хуулийн этгээдийн оршин суух газар, с) MCC-ийн дагуу хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх үндэс.	

Загвар хуулиас хуулийн этгээдэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах заалтууд Монгол Улсын ЭХХШТХ-ийн зохицуулалтад тодорхой агуулгын өөрчлөлтгүйгээр орсон байна. Энэ нь давуу болон сул талтай.

Давуу тал: Хуулийн этгээдийн эсрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар туршлага бүхий улс орнуудын нэгэн адил эрх зүйн нэг ойлголтоор зохицуулагдах боломж бүрдсэн.

Сул тал: Бид үндэсний эрх зүйн зохицуулалтын онцлогийг орхигдуулсан байх магадлалтай. Өнөөдрийг хүртэл хуулийн этгээдтэй холбоотой шүүхээр шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо, чанар үүнийг харуулж байна. Өөрөөр хэлбэл бид хуулийн этгээдийн эсрэг нотлох ажиллагаа явуулахдаа тодорхой заалтуудыг өөрийн орны бүхий л нөхцөл байдалтай уялдуулан томъёолж чадаагүй байх магадлалтай.

Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр, хуулийн этгээд бүр хөрөнгө,

орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын хэлбэрээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна¹⁴² гэж тодорхойлжээ.

Хуулийн дээрх заалт нь хуулийн этгээдийн эсрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа хуулийн этгээдийн үйл ажиллагааны чиглэл үл хамааран, түүний хөрөнгө, орлого, зохион байгуулалтын хэлбэрээр ялгаварлахгүйгээр нотлох ажиллагааг хэрэгжүүлэх тухай юм.

Хуулийн этгээдийн эсрэг нотлох ажиллагааг хэрэгжүүлэхдээ хууль шүүхийн өмнө эрх тэгш байх, шүүхэд хандах, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, гэм буруугүйд тооцох зарчмуудыг удирдлага болгохоор хуульчилсан. Тухайлбал:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүн, хуулийн этгээд хуулиар хамгаалагдсан эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, хөндөгдсөн гэж үзвэл уг эрхээ сэргээлгэхээр шүүхэд хандах эрхтэй¹⁴³ хэмээн хүнтэй нэгэн адил эрхийг нь баталгаажуулж өгсөн.

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан аливаа гэмт хэргийг нотлохын тулд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан “Нотолбол зохих байдал¹⁴⁴”-ыг заавал нотолсон байхаар хуульчилсан.

1.Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны явцад дараахь байдлыг нотолно:

1.1.гэмт хэрэг гарсан байдал /гэмт хэргийг хэзээ, хаана, яаж үйлдсэн болон Эрүүгийн хуульд заасан бусад байдал/;

1.2.гэмт хэргийг хэн үйлдсэн;

1.3.гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэр;

1.4.Эрүүгийн хуульд заасан яллагдагчид оногдуулах ялыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдал;

1.5.гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ;

1.6.гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл.

Дээрх нотолбол зохих нөхцөл байдал тус бүрээр хуулийн этгээдэд холбогдох гэмт хэрэгт хэрхэн нотлох талаарх зохицуулалтуудыг авч үзье.

1.1 Гэмт хэрэг гарсан байдал. /гэмт хэргийг хэзээ, хаана, яаж үйлдсэн болон Эрүүгийн хуульд заасан бусад байдал/;

Гэмт хэргийг хэзээ үйлдсэн.

Үүнийг нотлохын тулд гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацааг тодорхой тогтоох шаардлагатай. Эрүүгийн хуульд “Гэмт хэргийн хор уршиг хэзээ илэрснээс үл хамааран энэ хуульд заасан гэмт үйлдэл, эс үйлдэхүй төгссөн үеийг гэмт хэрэг үйлдсэн хугацаагаар тооцно.” гэж заасан. Тэгэхээр гэмт үйлдэл, эс үйлдэл төгссөн үеийг тодорхойлох хэрэгтэй. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг төгс агуулсан үйлдэл, эс үйлдэхүйг төгссөн гэмт хэрэг гэж ойлгож болно. Энэ шинжээр гэмт хэргийг хэзээ үйлдсэн гэдгийг үйл баримтаар хөдөлбөргүй нотлох нь зүйтэй.

Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдэж энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан бол тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай адил байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно.¹⁴⁵

Гэмт хэргийг хаана үйлдсэн

Эрүүгийн хуульд:

А) Эрүүгийн хууль Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчлэх¹⁴⁶

¹⁴² Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.12 дугаар зүйл. 2017 он.

¹⁴³ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.13 дугаар зүйл. 2017 он.

¹⁴⁴ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйл. 2017 он.

¹⁴⁵ Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ 1.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэг. 2015 он.

¹⁴⁶ Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ 1.5 дугаар зүйл. 2015 он.

Б) Эрүүгийн хууль Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна үйлчлэх¹⁴⁷ гэсэн хоёр зохицуулалт байна. Дээрх хоёр зохицуулалтын Эрүүгийн хууль Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчлэх гэсэн зохицуулалтад “Энэ хуульд заасан тохиолдолд Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.”¹⁴⁸ гэсэн заалт нь хуулийн этгээдэд холбогдож байна. Өөрөөр хэлбэл Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд эрүүгийн хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан. Энэ нь мөн Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, усан, агаарын орон зайд байгаа Монгол Улсын усан онгоц, агаарын хөлөгт нэгэн адил үйлчлэнэ гэж ойлгоно. Тэгхээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны явцад хуулийн этгээд нь гэмт хэргийг хаана үйлдсэнийг тогтоох газрыг дээрх утгаар ойлгож нотлох нь зүйтэй юм. Харин эрүүгийн хууль Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна үйлчлэх гэсэн зохицуулалтын хүрээнд хуулийн этгээдийн талаар заалт байхгүй байгаа нь анхаарах судлагдахуун юм.

Эрүүгийн хэргийг яаж үйлдсэн болон Эрүүгийн хуульд заасан бусад байдал:

Эрүүгийн хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд ял оногдуулахаар заасан гэмт хэргийн шинжийг хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан дангаараа, эсхүл хамтран шийдвэр гаргаж, эсхүл хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хийсэн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан нь хуулийн этгээдэд ял оногдуулах үндэслэл болно¹⁴⁹.

ЭХХШ тухай хуулийн 20.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: **“Хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тухайн хуулийн этгээдийг төлөөлөх албан тушаалтны, эсхүл хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдэл хийсэн хүний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаатай хамт явагдана”** гэжээ. Тухайн хуулийн этгээдийг төлөөлөх албан тушаалтан, эсхүл хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдэл хийсэн этгээд хуулийн этгээдийн хамт шийтгэгдэхээр зохицуулжээ. 2016 онд батлагдсан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад Хуулийн этгээдийг төлөөж байгаа эрх бүхий албан тушаалтан, үйлдэл хийсэн хүнийг шийтгэхгүй, зөвхөн хуулийн этгээдийг шийтгэх зохицуулалттай байсан. 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжих Эрүүгийн хуульд үүнийг засаж оруулсан юм. Хуулийн этгээдийг төлөөлөх албан тушаалтан, үйлдэл хийсэн хүн нь энэ хуульд заасан яллагдагчийн эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ.

Хуулийн этгээдийн төлөөлөгч нь ЭХХШ тухай хуульд заасан яллагдагчийн нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй¹⁵⁰.

1.2 Гэмт хэргийг хэн үйлдсэн:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино¹⁵¹ гэж тодорхойлсон. Хуулийн этгээдийн талаар тодорхойлолт эрүүгийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудын алинд ч байхгүй бөгөөд үүнийг иргэний хуульд¹⁵² заасны нэгэн адил ойлгохоор зохицуулсан байна. Иргэний

¹⁴⁷ Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ 1.6 дугаар зүйл. 2015 он.

¹⁴⁸ Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ 1.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг. 2015 он

¹⁴⁹ Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ 9.1 дүгээр зүйл. 2015 он.

¹⁵⁰ Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ 1.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг. 2015 он.

¹⁵¹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.1 дүгээр зүйл. 2017 он.

¹⁵² Иргэний хууль. Төрийн мэдээлэл., 2002 он. № 7

хуулинд “Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаварыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ” гэж тодорхойлон хуульчилжээ.

Дэлхийн олон улсууд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, эрүүгийн эрх зүйн харилцааны субъект болгон хуульчилж байна. Манай улс олон улсын хэд хэдэн гэрээ конвенцид /Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх Палермогийн протокол, Терроризмтэй тэмцэх, Авилгатай тэмцэх... г.м./ нэгдсэн нь ч нөлөөлж энэхүү өөрчлөлтийг хуульчлан баталгаажууллаа. Хуулийн этгээд гэмт хэрэг үйлдэх нь олширч, ялангуяа байгаль орчны эсрэг гэмт хэргүүд, эдийн засгийн гэмт хэргүүд, түүх дурсгалын хууль бус худалдаа, мөнгө угаах, терроризмыг үйлдэх, бэлтгэх, санхүүжүүлэх зэрэг гэмт хэрэг манай улсад үйлдэгдэж, зарим төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх нөхцөл бүрдсэн.

1.3 Гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэр;

Гэмт хэргийн субъектив тал гэдэг бол гэмт хэрэг үйлдэж буй этгээдээс гэмт хэрэг, түүний үр дагаварт хандаж буй сэтгэхүйн (дотоод) хандлага мөн. Энэхүү сэтгэхүйн хандлагыг тайлбарлахдаа хоорондоо харилцан холбоотой сэтгэхүйн үйл ажиллагааны хэлбэр болох сэдэлт, зорилго, гэм буруу зэрэг ойлголтыг авч үзнэ. Гэмт хэргийн субъектив талын шинжийг үндсэн шинж (гэмт буруу), нэмэгдэл шинж (гэмт зорилго, сэдэлт, гэмт хэрэг үйлдэх үеийн сэтгэл санааны байдал) гэж хоёр хэсэгт хуваана¹⁵³.

Сэдэлт, зорилго, гэм буруу нь сэтгэхүйн хувьд бие даасан даасан үзэгдэл болох бөгөөд гэмт хэргийг зүйлчлэхэд ач холбогдолтой. Үүнд:

Нэгдүгээрт: эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлийн нэг хэсгийн хувьд гэмт хэргийг эрх зүйн бусад зөрчлөөс ялгаж өгнө.

Хоёрдугаарт: объектив шинжээрээ адил төстэй зарим гэмт хэргийг ялгаж зүйлчлэхэд тус дөхөм үзүүлнэ.

Гуравдугаарт: субъектив талын агуулга нь гэмт ажиллагаа, түүнийг хэрэгжүүлж буй этгээдийн нийгэмд аюултай байдлын хэмжээг тодорхойлон, хариуцлагын шинж байдал, ялын хэмжээг нөхцөлдүүлнэ.

Гэм буруу гэдэг бол Эрүүгийн хуульд заасан нийгэмд аюултай ажиллагаа, түүний үр дагаварт (хохирол, хор уршиг) санаатай буюу болгоомжгүй, холимог хэлбэрээр хандаж буй хандлага юм. Оюун санааны болон хүсэл зоригийн шинжийн янз бүрийн хослол нь гэм буруугийн тодорхой хэлбэрийг бүрдүүлнэ.

Эрүүгийн хуулийн 2.3 дугаар зүйлд гэм буруугийн хоёр хэлбэр болох санаатай болон болгоомжгүй хэлбэрийг хуульчилсан. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэм буруутайд тооцох гэдэг нь гэмт хэргийг санаатайгаар эсвэл болгоомжгүйгээр үйлдсэнийг тогтооно гэсэн үг. Өөрөөр хэлбэл гэмт хэргийг санаатай буюу болгоомжгүй үйлдсэнийг нотлох нь хүний ухамсараас ангид орших бодит үйл явдлыг танин мэдэх нэг арга ажээ.

Энэхүү танин мэдэхүйн үйл явц нь хэрэгт цугларсан нотлох баримтыг үнэлж, дүгнэх замаар явагдана. Тиймээс гэм буруу нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож болохгүй.

1.4 Эрүүгийн хуульд заасан яллагдагчид оногдуулах ялыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдал;

Гэмт хэргийн үйлдсэн зорилго нь эрүүгийн хариуцлагын хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлуудыг тогтооход чухал ач холбогдолтой.

1.5 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршигийн шинж чанар, хэр хэмжээ;

¹⁵³ Х.Нямбаатар, Д.Мөрөн, С.Гантулга нар. Эрүүгийн эрх зүй (ерөнхий ба тусгай анги). Уб., 2017 он. 31 дэх тал

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдэж хохирол учруулсны улмаас үүссэн үр дагаврыг гэмт хэргийн хор уршигт тооцно. Эрүүгийн хуульд заасан “ноцтой хохирол, хор уршиг” гэж хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эд хөрөнгийн эрхэд, эсхүл улс орон, хүн амын аюулгүй байдалд ач холбогдол бүхий эрхэд хохирол, хор уршиг учирсныг ойлгоно¹⁵⁴.

Шүүх гэмт хэргийн хохирол, хор уршигийг тодорхойлж, бодит хохирлыг нөхөн төлүүлэх, хор уршигийг арилгахад гарах зардлын мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх хэмжээг тогтооно.

Эрүүгийн хуульд заасан нэг нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байхаар жишин хуульчилсан байна¹⁵⁵.

1.6.гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл.

Монгол Улсын Иргэний хуулийн¹⁵⁶ 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт “Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг **хуулийн этгээд гэнэ**” хэмээн тодорхойлжээ. .

Монгол Улсын хууль тогтоох эрх бүхий байгууллага болох УИХ-аас 2015 онд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэн баталж, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт шинээр хуульчлагдсанааас хойш 6 жил өнгөрөөд байна. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан 33 төрлийн гэмт хэрэг нь нэг талаасаа нотлоход хүндрэлтэй, мөрдөн шалгах ажиллагааны тактик, арга барил өвөрмөц байх болно.

Эрүүгийн хуулийн 9 дүгээр бүлэгт “Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх” талаар тусгайлан зохицуулсан. Эрүүгийн хуулийн 9 дүгээр бүлгийн 9.1 дүгээр зүйлд “Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл”-ийг хуульчилсан байна. Тухайлбал: 9.1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд ял оногдуулахаар заасан гэмт хэргийн шинжийг хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан дангаараа, эсхүл хамтран шийдвэр гаргаж, эсхүл хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хийсэн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан нь хуулийн этгээдэд ял оногдуулах үндэслэл болно.” гэж заасан байна.

Мөн Эрүүгийн хуулийн Нэгдүгээр бүлгийн 1.3 дугаар зүйлд заасан шударга ёсны зарчимд “Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна.”, “Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй”, Эрүүгийн хуулийн нэгдүгээр бүлгийн 1.5 дугаар зүйлд “Энэ хуульд заасан тохиолдолд Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гээд хууль үйлчлэх цаг хугацааны тухай тус хуулийн заалтад “үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, гэм буруутай хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг тухайн гэмт хэргийг үйлдэх үед дагаж мөрдөж байсан хуулиар тодорхойлно” гэж тус тус заажээ. Эдгээр заалтууд нь хуулийн этгээдэд хувь хүнд үйлчилдэг шиг нэг ижил зарчмаар үйлчлэхээр зохицуулжээ.

Эрүүгийн хуулийн тусгай ангид нийт 7 бүлгийн 33 төрлийн гэмт хэрэгт хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заажээ.

¹⁵⁴ Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/ 2.5 дугаар зүйл. 2015 он.

¹⁵⁵ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дүгээр зүйлийн 3 дах хэсэг. 2017 он.

¹⁵⁶ Төрийн мэдээлэл. УБ., 2002 он, №7

Бид хуулийн этгээдэд холбогдох гэмт хэрэг нэг бүрийн криминалистик шинжийг тодорхойлох зорилт тавиагүй бөгөөд ерөнхий агуулгаар нь зарим шинжийг авч үзэхийг оролдсон болно. Гэмт хэргийн криминалистик шинж нь тухайн гэмт хэрэгт хамаарах тусгай шинжийг нээн илрүүлэх, улмаар тухайн шинжийг онол, арга зүйн хувьд зөв тодорхойлсноор мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зөвлөмж боловсруулдаг болохыг дурьдах нь зүйтэй.

Хуулийн этгээдэд холбогдох гэмт хэргүүд нь криминалистик шинжээрээ өөр хоорондоо ялгагдах тусгай шинжүүдтэй байх бөгөөд цаашид бид тухайн гэмт хэрэг нэг бүрийн шинжийг нарийвчлан авч үзэхийг зорьж байгаа болно. Дараах хүснэгтэнд гэмт хэрэг хамаарах бүлгээр бүлэглэн авч үзлээ.

Д/д	Эрүүгийн хуулийн бүлэг, нэр	Зүйл	Хэсэг
1.	АРВАННАЙМДУГААР БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ГЭМТ ХЭРЭГ	1. Зах зээл дэх монополь, давамгайлал, байдлаа хууль бусаар ашиглах; 18.1	3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
		2. Валют, үндэсний мөнгөн тэмдэгтийг ханшид нөлөөлөх; 18.2	3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
		3. Татвар төлөхөөс зайлсхийх; 18.3	1.Татвар төлөгч хувь хүн, хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан татвар төлөхөөс зайлсхийх зорилгоор их хэмжээний татвар ногдох орлого, эд хөрөнгө, бараа үйлчилгээг зориуд худал тодорхойлсон, нуусан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.
		4. Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх; 18.5	5.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хоёр зуун мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
		5. Мөнгө угаах; 18.6	4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
		6. Мөнгөн тэмдэгт, үнэ цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах; 18.7	4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
		7. Үнэт цаасны зах зээлийн дотоод мэдээллийг хууль бусаар ашиглаж, арилжаанд оролцох; 18.8	4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял

2.	Т Г У Й Б А Й Д		шийтгэнэ.
		8. Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах; 18.9	4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
		9. Зориуд, зохиомлоор дампуурах; 18.10	1.Зориуд дампуурах зорилгоор эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, үүрэг, эд хөрөнгийн мэдээлэл, шилжилт хөдөлгөөнийг нуусан; хуулийн этгээд, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн эдийн засгийн үйл ажиллагааг илэрхийлсэн нягтлан бодох бүртгэл, бусад тооцооны баримт бичгийг нуусан, устгасан, өөрчилсөн бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан, үүсгэн байгуулагч зээлийн өр төлөхийг хойшлуулах, түүнийг төлөх нөхцөлийг хөнгөрүүлэх, зээлийн өрийн хүүг багасгах, төлөхгүй байхын тулд төлбөрийн чадваргүй болсон гэж харилцагч талд мэдэгдэж, дампуурлын хэрэг үүсгэх хүсэлт гаргаж зохиомлоор дампуурсны улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
		10. Банк хууд бусаар байгуулах, банкны төлбөрийн чадвар алдагдуулах; 18.13	4.Энэ зүйлд заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
		11. Нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх 18.14	1.Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх зорилгоор нийгмийн даатгалын шимтгэл ногдох их хэмжээний орлогыг нуусан, худал мэдүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.
		12. Үндэсний төлбөрийн системийг зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааг хууль бусаар эрхлэх; 18.18	5.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
		13. Мансууруулах эм, сэтгэгдэл нөлөө	5.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө

		бодисыг хууль бусаар ашиглах; 20.7	үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
		14. Мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг хууль бусаар тариалах; 20.10	3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
		15. Аюултай хог хаягдал, химийн хорт, аюултай бодисыг хаях; 20.11	3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ. 4.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хоёр зуун мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
		16. Эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдах, түгээх; 20.12	3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ. 4.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
		17. Чанар муутай барилга байгууламж ашиглалтад оруулах; 20.13	2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
		18. Хууль бусаар эм, био бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх; 20.14	4.Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ. 5.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хоёр зуун мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

	ХОРИН ХОЁРДУГА АР БҮЛЭГ АВЛИГЫН ГЭМТ ХЭРЭГ	19. Хахууль өгөх 22.5	3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
4.	ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХҮРЭЭЛЭН БАЙГАА ОРЧНЫЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ	20. Байгаль орчныг бохирдуулах; 24.1	3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ. 4.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
		21. Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох; 24.2	3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ. 4.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
		22. Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах; 24.3	3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ. 4.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
		23. Цөмийн бодис, цацраг идэвхт хаягдал, цөмийн материал, цацрагийн үүсгүүрийг хууль бус эргэлтэд оруулах; 24.4	2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
		24. Хууль бусаар мод бэлтгэх; 24.6	3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

		25. Байгалийн тэнцэл алдагдуулах; 24.9	2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
5	ХОРИН ТАВДУГААР БҮЛЭГ СОЁЛЫН ӨВИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ	26. Түүх, соёлын үнэ хөдлөх дурсгалыг эвдэх гэмтээх, устгах; 25.2	3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
		27. Хууль бусаар археологи, палентологийн хайгуул малтлага хийх; 25.4	3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
6	ХӨДӨЛГӨӨН ИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТ БҮЛЭГ	28. Замын байгууламжийн ашиглалт засварын аюулгүй байдлын журам зөрчих 27.9	2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
7	ХОРИН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ХҮН ТӨРӨЛХТНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭНХ ТАЙВНЫ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ	29. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх; 29.3	2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
		30. Террорист үйлдэл хийх; 29.8	2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг албадан татан буулгана.
		31. Террорист үйлдэлд бэлтгэх; 29.9	2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг албадан татан буулгана.
		32. Терроризмыг санхүүжүүлэх. 29.10	3.Энэ гэмт хэргийг хориг арга хэмжээг зөрчиж хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг албадан татан буулгана. 4.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Тайлбар: - Энэ зүйлд заасан “хориг арга хэмжээ” гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн тогтоолоор баталсан үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхтэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээ, түүнчлэн Засгийн газраас терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын саналыг үндэслэн баталсан жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн эсрэг санхүүгийн хориг арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг ойлгоно.
		33. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх; 29.11	2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хуулийн этгээдийг албадан татан буулгана.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийгдсэн хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэмт хэргүүдээс Эдийн засгийн гэмт хэрэг, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг түгээмэл үйлдэгдэж байна. Эдийн засгийн гэмт хэрэг нь нууц далд аргаар үйлдэгдэх бөгөөд хуулийн этгээдийн хувьд гэмт үйлдлээ нуун далдлах, мөрдөгчийн эсрэг үйлдэл гаргах, гэмт хэрэг үйлдэгдэхэд бололцоо олгосон нөхцөл байдлыг ашиглах нийтлэг хэв шинжтэй байна. Энэ төрлийн гэмт хэргийн талаарх мэдээлэл нууцлаг, мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнд илрэх нийт зүй тогтолтой байдаг. Иймээс мөрдөн шалгах ажиллагаанд хамтын ажиллагаа зайлшгүй чухалд тооцогдоно.

Монгол Улсад үйлчилж байгаа хуулиудаас хуулийн этгээдийн эрх, үүрэг, хариуцлагын талаар заасан хэм хэмжээг харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 1. Хуулийн этгээдтэй холбоотой зохицуулалт

Д/д	Хууль	Нэр томъёо орсон зохицуулалт
1	Үндсэн хууль	1
2	Иргэний хууль	125
3	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай	43
4	Эрүүгийн хууль	221
5	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль	101
6	Зөрчлийн тухай хууль	1058
7	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль	50
8	Цагдаагийн албаны тухай	38

Үүнээс үзэхэд хуулийн этгээдтэй холбоотой зохицуулалт цөөнгүй байгаа ч цаашид жижиг аж ахуйн нэгж, компанийг үндэсний хэмжээний болон үндэстэн дамнасан групп компани, корпорациудтай адилтган, нэг хэм хэмжээгээр зохицуулах боломжгүй гэдгийг анхаарах шаардлагатай болжээ. 2011 оны Компанийн тухай хуульд¹⁵⁷ заасны дагуу групп, компани нь охин компанитайгаа нэгдсэн тайлан гаргах ёстой байна. Улс орнуудад санхүүгийн ийм зохицуулалтыг дэмжиж, нийтлэг хэрэгжүүлдэг байна.

Хуулийн этгээдийн холбогдсон гэмт хэргийн талаар 2017 оноос хойших дүн мэдээг судлав. Цагдаагийн байгууллагад нийт 5 төрлийн 29 гэмт хэрэг бүртгэгдсэнийг Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн статистик мэдээнээс хувиар харахад дараах байдалтай байна. Үүнээс үзэхэд Монгол Улсад ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт хэрэгт хуулийн этгээдүүд ихээр холбогдож байгааг харж болно. 2017 оноос өмнөх дүн мэдээтэй харьцуулбал буурсан үзүүлэлттэй байгаа нь хуулийн этгээдийн хариуцлагын зохицуулалт хэрэгжиж эхэлсэнтэй шууд холбоотой гэж дүгнэж болохоор байна.

IV. Монгол Улсад Хуулийн этгээдэд холбогдох гэмт хэргийн шийдвэрлэлт

Монгол Улсын Шүүхийн дүн мэдээ-2018¹⁵⁸:

Анхан шатны шүүх 2018 онд 4 хуулийн этгээдэд холбогдох хэрэг хүлээн авснаас 2 хуулийн этгээдийг торгох ялаар шийтгэж, 2 хуулийн этгээдээс 9 сая 182 мянга 019 төгрөгийг гаргуулан улсын орлого болгосон байна.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад хуульчилснаар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан бөгөөд энэ хуулийн хэрэгжилтийн хүрээнд тайлант онд 1 хуулийн этгээдийг гэм буруутайд тооцож, ял оногдуулж шийдвэрлэсэн.

Монгол Улсын Шүүхийн дүн мэдээ-2019¹⁵⁹:

Анхан шатны шүүхүүд 2019 онд нийт 10 хуулийн этгээдэд холбогдох хэрэг хүлээн авснаас 1 хуулийн этгээдэд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, 4 хуулийн этгээдийг торгох ялаар шийтгэсэн байна. Эрүүгийн хуульд заасан торгох ялаар 7529 хүн, 4 хуулийн этгээдэд 7 тэрбум 732 сая 037 мянга

¹⁵⁷ “Төрийн мэдээлэл”, УБ, 2011 он. №42

¹⁵⁸ Монгол улсын шүүхийн тайлан 2018., http://admincourt2.gov.mn/site/full_story/1435

¹⁵⁹ Монгол улсын шүүхийн тайлан 2019., <https://www.court.za.gov.mn/812--2019-.html>

400 төгрөгийн ял, хөрөнгө хураах албадлагын арга хэмжээг хэрэглэж 3 хуулийн этгээдээс 480 мянган төгрөгийг гаргуулан улсын орлого болгосон байна.

Монгол Улсын Шүүхийн дүн мэдээ-2020¹⁶⁰:

Анхан шатны шүүхүүд 2020 онд нийт 10 хуулийн этгээдэд холбогдох хэрэг хүлээн авснаас 3 хуулийн этгээдэд холбогдох хэргийг прокурорт буцааж, 1 хуулийн этгээдэд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, 1 хуулийн этгээдэд холбогдох хэргийг цагаатгаж, 5 хуулийн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, торгох ялаар шийтгэж шийдвэрлэсэн байна.

Эрүүгийн хуульд заасан торгох ялаар 7650 хүн, 5 хуулийн этгээдэд 9 тэрбум 181 сая 140 мянган төгрөгийн торгох ял, хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээ хэрэглэж, 3 хуулийн этгээдээс 549 сая 123 мянга 590 төгрөгийг тус тус гаргуулан улсын орлого болгосон байна.

Энэ нь хуулийн этгээдийн үйлдэж буй хэрэг бага гэж шууд ойлгож болохгүй бөгөөд хэдийгээр холбогдох хуулиуд батлагдан, хэрэгжиж эхэлсэн ч хэрэглэж буй хууль сахиулагч, хуульчдын мэдлэг, туршлага дутмаг, нотлох ажиллагааг явуулахад эрх зүйн зохицуулалт боловсронгуй бус байгаатай холбож үзэх үндэслэлтэй юм. Ялангуяа үндэсний хэмжээний болон үндэстэн дамнасан компани, корпораци, группийн үйлдсэн гэмт хэргийг илрүүлэх, нотлох хэмжээнд боловсруулагдаагүй байна.

Эрүүгийн хэргээс гадна зөрчлийн хэргийн шийдвэрлэлтийн дүн мэдээнд дүгнэлт хийхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Зөрчлийн хэргийн шийдвэрлэлтийн статистик мэдээ 2017-2019 он

д/д	Зөрчлийн хэргийн шийдвэрлэлт 2017-2019 он	2017	2018	2019	Нийт
1	Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч	867	448	726	2041
2	Мэргэжлийн хяналтын байцаагч	87	293	1215	1595
3	Улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч	298	144	817	1259

Зөрчлийн хэрэг шийдвэрлэсэн статистик мэдээ нь эрүүгийн хэргийн статистик мэдээнээс харьцангуй өндөр байна. Ялангуяа зөрчил үйлдэгч хуулийн этгээдийн тоо их байгаа нь урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө бага байгаатай холбоотой гэж үзэж болохоор байна. Мөн зөрчил үйлдэгчдэд зөвхөн торгох шийтгэл нийтлэг байдлаар оноож байгаа тул сануулах шийтгэл оногдуулах зохицуулалт бий болгох шаардлагатай. Энэ зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болно. Хуулийн этгээдийн түгээмэл үйлддэг зөрчил нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай тухай, Эрүүл ахуйн тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Ашигт малтмалын тухай, Газрын тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Татварын ерөнхий хууль, Гаалийн тухай, Барилгын тухай зэрэг хуулиуд болон Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ үйл ажиллагааны журмыг зөрчиж байна.

V. Дүгнэлт

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлагыг хэрхэн хүлээлгэх, тодорхой төрлийн гэмт хэрэг ялангуяа эдийн засгийн гэмт хэрэг, гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдсэн хэрэгт хуулийн этгээдийн гэм бурууг хэрхэн тодорхойлох асуудлууд нь өнөөг хүртэл маргаантай асуудлын нэг байсаар байна.

Улс орнууд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулж байгаа эрх зүйн зохицуулалт нь хуулийн этгээдийн соёл төлөвшихөд хэрхэн үр дүнтэй нөлөөлж байгаа, практикт гарч байгаа хууль бус үйлдлийг бүрэн хамарч, түүнийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд чиглэж байгаа эсэхэд дүгнэлт хийж өөрийн орны эрх зүйн зохицуулалтын онцлогт тулгуурлан хөгжүүлсээр байна.

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай эрх зүйн зохицуулалт Монгол улсын эрүүгийн хуульд 2014 оноос тусгалаа олсон хэдий ч эрүүгийн хариуцлага оногдуулах үндэслэлийг тодорхойлж хуульчлаагүй, цөөн тооны гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэхээр заасан байсан.

¹⁶⁰ Монгол улсын шүүхийн тайлан 2020., https://www.judcouncil.mn/site/news_full/11129

Шинэчилсэн найруулсан эрүүгийн хуульд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлийг эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжийг хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан дангаараа, эсхүл хамтран шийдвэр гаргаж, эсхүл хуулийн этгээдийн ашиг сонирхолын төлөө хийсэн үйлдэл эс үйлдэхүйгээр хангасан нь хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болно гэж тодорхойлсноос гадна хариуцлага хүлээлгэх гэмт хэргийг өргөн хүрээнд олон төрлийн гэмт хэрэгт хүлээлгэхээр тодорхойлсон.

Монгол Улсад хуулийн этгээдийн эрхийг Үндсэн хууль болон бусад хуулиар баталгаажуулж ирсэн бөгөөд шинэ Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар эрхийн хязгаарлалт хийсэн нь дэвшилтэй боловч хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэж, тэдний холбогдсон зөрчлийн болон эрүүгийн хэргийг шалгаж шийдвэрлэсэн тоо хэмжээ цөөн байгааг тэдний зүгээс үйлдэж буй, хэрэг зөрчил бага гэж шууд ойлгож болохгүй. Хэдийгээр холбогдох хуулиуд батлагдан, хэрэгжиж эхэлсэн ч хэрэглэж буй хууль сахиулагч, хуульчдын мэдлэг, туршлага дутмаг, нотлох ажиллагааг явуулахад эрх зүйн зохицуулалт боловсронгуй бус байгаатай холбож үзэх үндэслэлтэй юм. Ялангуяа үндэсний хэмжээний болон үндэстэн дамнасан компани, корпораци, группийн үйлдсэн гэмт хэргийг илрүүлэх, нотлох хэмжээнд боловсруулагдаагүй байна.

VI. Санал.

1. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийгдсэн хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэмт хэргүүдээс Эдийн засгийн гэмт хэрэг, Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг түгээмэл үйлдэгдэж байна. Эдийн засгийн гэмт хэрэг нь нууц далд аргаар үйлдэгдэх бөгөөд хуулийн этгээдийн хувьд гэмт үйлдлээ нуун далдлах, мөрдөгчийн эсрэг үйлдэл гаргах, гэмт хэрэг үйлдэгдэхэд бололцоо олгосон нөхцөл байдлыг ашиглах нийтлэг хэв шинжтэй байна. Энэ төрлийн гэмт хэргийн талаарх мэдээлэл нууцлаг, мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнд илрэх нийт зүй тогтолтой байдаг. Иймээс мөрдөн шалгах ажиллагаанд хамтын ажиллагаа тодорхой хугацаанд явуулах зайлшгүй чухал.

2. Монгол Улс Хуулийн этгээдэд зөвхөн торгох ял оногдуулахаар хуульчилсан ба дэлхийн улс орнуудад мөн түгээмэл ашиглагдаж байна. Гэхдээ шүүх торгох ял оногдуулахдаа ялын үр нөлөөтэй байх явдлыг нэгдүгээрт анхаарч торгуулийн хэмжээг гэмт хэрэг үйлдэж олсон ашгаас хэд дахин их хэмжээгээр оногдуулж байна. Тухайн гэмт хэргийн нийгмийн хор аюул, гэмт хэргийн хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэр, давтан үйлдсэн эсэх, тухайн гэмт хэрэгтэн хуулийн этгээдийн хөрөнгийн байдал, түүний бизнес цаашид үргэлжлэхэд үзүүлэх үр нөлөө зэргийг харгалзан үзсэн хариуцлагын тогтолцоо, эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлага байсаар байна.

3. Хуулийн этгээдийн эрх зүйн зохицуулалтын талаар онолын болон практик, үндэсний болон олон улсын, хууль хэрэглээний болон хуулийн хэрэгжилтийн судалгааг өргөн хүрээтэй хийж дараагийн шинэчлэлийг хийх зэрэг болно.

Ашигласан материал

1. Монгол эх сурвалж

- Б.Батсүрэн, П.Дэлгэржаргал, У.Эрдэнэбат, Их Монгол Улс. Монголын эзэнт гүрний түүх. Тэргүүн боть. УБ, 2019 он.
- Д.Баярсайхан, Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага. УБ, 2013 он.
- Д.Баярсайхан, Эрх зүйн онол. УБ, 2016 он.
- Г.Баярхүү, Н.Цэдэнбалжир, Бизнесийн эрх зүй. УБ, 2014 он.
- Ч.Далай, Их Монгол Улс. УБ, 2006 он.
- Ч.Нямсүрэн, Эрх зүйн онол. УБ, 2010 он.
- Б.Одонгэрэл, Хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлага. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. УБ, 2020 он.
- Б.Урнаа, Компанийн хууль зүйн зохицуулалтын онолын асуудал” илтгэл. Хууль дээдлэх ёс сэтгүүл, УБ, 2019 он.
- Эрүүгийн эрх зүйн шинэтгэл: “Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал.” Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ, 2017 он.

2. Гадаад эх сурвалж

- Celia Wells, Corporations and Criminal Responsibility, Oxford University press. 2 дахь хэвлэл, АНУ, (2005)
- Models of corporate criminal liability in comparative law. Washington university global studies law review, 4 дэх хэвлэл. АНУ, (2008)
- [Sarbanes-Oxley Act of 2002](#) (PDF). 107th Congress. Retrieved. АНУ, (2016)
- The Laws That Govern the Securities Industry. 5 дахь хэвлэл. АНУ. (2016)
- V.S.Khanna, Corporate Criminal Liability: What Purpose does it Serve, Har.L.Rev. 109 (1996)

3. Эрх зүйн эх сурвалж

- Иргэний хууль, 1956 он.
- Үндсэн хууль, 1992 он.
- Иргэний хууль, 2002 он.
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он.
- Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга), 2015 он.
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017 он.
- Зөрчлийн тухай хууль. (Шинэчилсэн найруулга) 2017 он.
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2017 он.
- Компанийн тухай хууль (Шинэчилсэн найруулга), 2011 он.
- Цагдаагийн албаны тухай хууль. (Шинэчилсэн найруулга) 2017 он.

4. Бусад:

- <https://www.britannica.com/topic/corporate-crime#ref336083>
- https://en.wikipedia.org/wiki/Corporate_crime
- <https://advocate.mn/news/119/single/774>
- <https://www.britannica.com/topic/corporate-crime#ref336083>
- <http://www.judoinstitute.mn/main/244--2019-3-.html>
- https://en.wikipedia.org/wiki/Corporate_crime

**ЦАГДАА-ОЛОН НИЙТИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ**

**МОНГОЛ УЛС ДАХЬ ХӨРШИЙН ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ**

*Д.Булган. Хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор
цагдаагийн дэд хурандаа
Н. Амартүвшин. Цагдаа судлалын магистрант,
цагдаагийн ахмад*

Товчлол: Гэмт хэргийн статистик судалгаанаас харахад нийт гэмт хэргийн тоо сүүлийн жилүүдэд буурсан боловч зарим төрлийн гэмт хэрэг буурахгүй байгаа нь харагдаж байна. Монгол Улсад “хөршийн хяналтын хөтөлбөр” 2015 онд Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 126 дугаар тогтоолоор батлагдсан бөгөөд энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийг одоогийн байдлаар дүгнэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар төлөвлөсөн зүйл одоогоор байхгүй байгаа нь судалгааны явцад ажиглагдлаа. Тиймээс энэхүү өгүүллэгээр иргэдээс судалгаа авч, хөршийн хяналтын үйл ажиллагааны өнөөгийн байдал, түүний хэрэгжилтийг тодорхойлох, цаашид боловсронгуй арга замыг тодорхойлоход чиглэсэн.

Түлхүүр үг. Хөршийн холбоо, хөршийн хяналт, иргэн, хуулийн этгээд


Удиртгал. Монгол Улсын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-т “энэ хуулийн зорилт нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зарчим, үндсэн чиглэл, зохион байгуулалт, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог тодорхойлох замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын эрх зүйн үндсийг тогтооход оршино” гэж заасан. Мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6-т “олон нийтийн оролцоонд түшиглэсэн, хэрэгцээ, шаардлагад нь нийцсэн байх”¹⁶¹ гэж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зарчмыг тусгасан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахдаа иргэд, олон нийтийн туслалцаа, дэмжлэгийг түшиглэх шаардлагатай бөгөөд ингэснээр гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах боломж бүрдэх юм. “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа”-ны хөтөлбөрт “гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, шинэ хандлагыг төлөвшүүлэх зорилгоор 2009 онд Хууль зүй, дотоод хэргийн яам Америкийн Нэгдсэн Улсын Азийн сантай хамтран Улаанбаатар хотын эрүү, хэв журмын нөхцөл байдал хүнд, алслагдсан, хүн ам ихтэй Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн дөрвөн хороонд “Цагдаа-олон нийтийн хамтын ажиллагаа” туршилтын төслийг хэрэгжүүлснээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тогтмол үйл ажиллагаатай “Иргэний зөвлөл” бий болж, тухайн газруудад гэмт хэргийн гаралт 6-28 хувиар буурсан үр дүн гарсан¹⁶² гэж тэмдэглэжээ.

Монгол Улсад сүүлийн 5 жилийн гэмт хэргийн үзүүлэлтийг дараах хүснэгтээр үзүүлээ.

¹⁶¹ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль. 2019 он, Төрийн мэдээлэл №42

¹⁶² “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөр. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 58 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт.



Энэхүү графикаас харахад гэмт хэргийн үзүүлэлт 2018 онд хамгийн өндөр буюу 36220 гэмт хэрэг гарсан боловч 2020 онд 23064 буюу өмнөх оноос 26.8 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд хөнгөн гэмт хэрэг нь нийт гэмт хэргийн 83 хувийг эзэлж байна.

Зарим төрлийн гэмт хэрэг, тухайлбал, ахуйн хүрээнд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн үзүүлэлтийг харьцуулан авч үзье. Цагдаагийн ерөнхий газар, Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар улсын хэмжээнд 2020 оны эхний 3 сард 8003 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1902 (19.2%)-оор, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 279 гэмт хэрэг бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 104 (27.2%)-өөр тус тус буурчээ. Тус гэмт хэргийн нийт дүнд эзлэх хувь 3.5 байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр буурсан байна¹⁶⁴.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 279 гэмт хэргийн

- 91.0% (254) нь хөнгөн, 9% (25) нь хүнд ангилалтай,
- 48.1% нь Улаанбаатар, 51.9% нь орон нутагт,
- 41.9% (117) нь согтуугаар,
- 8.2% (23) нь эмэгтэй хүнээр,
- 86.4% (241) нь гэр, орон сууцанд үйлдэгжээ.

Цагдаагийн байгууллагад 2020 оны эхний 3 сард 545.9 мянган зөрчил бүртгэгдсэнээс гэр бүлийн хүчирхийллийн улмаас 3131 зөрчил шалган, 2244 зөрчлийг шийдвэрлэжээ. Өмнөх оны мөн үеэс нийт зөрчил 15.0 (71.1 мянга) хувиар, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үүдсэн зөрчил 61.6 (1193) хувиар, үүнээс шийдвэрлэсэн нь 99.3(1118) хувиар тус тус өсжээ. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчилд 1813 иргэн өртөж, хохирсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 72.8 (764) хувиар өссөн байна. Тэдний 92.7 (1681) хувь нь эмэгтэйчүүд байна.

Бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн улмаас үүдсэн 3131 зөрчлийн:

- 72.6% нь нийслэлд, 27.4% нь орон нутагт,
- Зөрчлийн хуулийн “5.4.4.1 зодсон,” зүйлийг зөрчсөн нь 76.6%, “5.4.4.2 хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албасан” зүйлийнх 18.1%, бусад холбогдох зүйлийнх 5.3%,
- 94.2% нь гэр, орон сууцанд, 5.8% нь бусад газарт,
- 10 зөрчлийн ойролцоогоор 7 нь шөнө оройн 19-24 цагийн хооронд гарчээ.

¹⁶³ ЦЕГ-ийн статистик мэдээ.

¹⁶⁴ Статистикийн тойм: “Гэр бүлийн хүчирхийлэл” ЦЕГ, ҮСХ. –УБ., 2020.

Дээрх үзүүлэлтээс харахад гэмт хэрэг буурсан боловч зөрчлийн үзүүлэлт өссөн харагдаж байгаа нь шинээр батлагдсан Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан “гэр бүлийн хүчирхийлэл”-ийг ялгамжтай авч үзэх, хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой боловч ерөнхий үзүүлэлтээр нь дүгнэн авч үзвэл ахуйн хүрээнд үйлдэгддэг гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад олон нийтийн оролцоо, түүний дотор хөршийн хяналтын үйл ажиллагааг сайжруулж, хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага байгаа нь харагдаж байна.

Монгол Улсад “хөршийн хяналтын хөтөлбөр” 2015 онд Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 126 дугаар тогтоолоор батлагдсан бөгөөд 2 үе шаттайгаар хэрэгжүүлж, 2020 онд уг хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэхээр тусгажээ. Гэсэн хэдий ч энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийг одоогийн байдлаар дүгнэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар төлөвлөсөн зүйл одоогоор байхгүй байгаа нь судалгааны явцад цагдаагийн алба хаагчидтай ярилцсан ярилцлагаас харагдана.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хөршийн хяналтын чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулсаар ирсэн ч ахуйн хүрээнд үйлдэгдэж буй зарим төрлийн гэмт хэрэг буурахгүй байгаа нь статистик судалгаанаас харагдаж байна. Мөн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас улбаалан хөршийн хяналтын үйл ажиллагааны хэрэгжилт хангалтгүй, цаашид боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага байгаа нь дээрх үндэслэлээс харагдаж байна. Тиймээс энэхүү өгүүлэлгээр Монгол Улсад хөршийн хяналтын үйл ажиллагааны өнөөгийн байдлыг тодорхойлохоор иргэд, цагдаагийн алба хаагчдаас судалгаа авч, түүнд дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулахад чиглэнэ.

Үндсэн хэсэг. Хөршийн хяналт нь оршин суугаа газрынхаа хөрш айл, оршин суугчдадаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн энгийн иргэдийн зохион байгуулалттай бүлэг¹⁶⁵ юм. Хөршийн хяналтын зорилго нь тухайн бүс нутаг, байр, хотхоны оршин суугчид өөрсдөө аюулгүй байдлаа бий болгож, аюулгүй орчинд амьдрахад чиглэгдсэн байна. Гэхдээ гэмт хэрэг, зөрчил илэрсэн үед хөршийн хяналтын гишүүд хөндлөнгөөс оролцохгүй бөгөөд цагдаагийн байгууллагад мэдэгдэхийг уриалдаг.

Хөршийн хяналтын бүлгүүд нь хөрш айлуудын дунд үүсдэг гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой тулгамдсан асуудлуудыг хэлэлцэх, олон нийтийн болон оршин суугчдын харилцаа, эв нэгдлийг нэмэгдүүлэх, асуудлыг шийдэхэд чиглэгдсэн иргэдийн оролцоог дэмжих үүрэгтэй юм зохион байгуулалтын нэгдэл юм. Ингэснээр асуудал үүсэхээс өмнө эсвэл асуудал дөнгөж үүсэж буй үед гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх боломж бүрддэг. Үүний тулд иргэд ба хууль сахиулах байгууллага хамтран ажиллах, иргэдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг таниулах, гэмт хэргээс сэргийлэх олон төрлийн үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх шаардлагатай байдаг¹⁶⁶.

Хөршийн хяналт нь хамгийн үр дүнтэй, албан бус нийгмийн хяналтыг хэрэгжүүлэх хэлбэр нь юм. Bursik and Grasmick нарын “Хөрш ба гэмт хэрэг: Олон нийтийн үр дүнтэй хяналт”¹⁶⁷ гэсэн бүтээлдээ айлуудыг ямар нэгэн зохион байгуулалтад оруулахгүй бол тэдэнд хяналт тавихад хэцүү байдаг гэж бүтээлдээ дурджээ. Тэрээр хөршийн холбоог бий болгохын тулд найз нөхөд, гэр бүл, нутаг дэвсгэрийн бизнес, сүм, сургуулийн үйл ажиллагаа, сүлжээ зэрэг нийгмийн сувгуудыг ашиглах хэрэгтэй гэжээ.

Хөршийн хяналтаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх гол арга нь оршин суугчид ажиглалт, тандалт хийх явдал юм. Ажиглалт хийхдээ гол нь оршин суугчдыг сайн таних нь чухал байдаг бол тандалт хийхдээ тухайн нутаг дэвсгэрийн оршин суугчдын хууль бус үйл ажиллагааг ажиглаж, цагдаагийн байгууллагад мэдээлэх үүрэгтэй байдаг. Өөрөөр хэлбэл, цагдаагийн байгууллага нь

¹⁶⁵ https://en.wikipedia.org/wiki/Neighborhood_watch

¹⁶⁶ Lab Steven P. Crime Prevention: Approaches, Practices, and Evaluations, Routledge. 2016.

¹⁶⁷ Neighborhoods and Crime: The Dimensions of Effective Community Control, by Robert Bursik, Jr. and Harold G. Grasmick. New York: Lexington Books, 1993

нэгэн зэрэг өөр өөр газарт гэмт хэрэг, зөрчилд хяналт тавих боломжгүй тул энгийн иргэдийг хариуцлагажуулан, тэдгээрээр дамжуулан хяналт тавих боломжийг бүрдүүлдэг юм.

Олон улсад хөршийн хяналтын хөтөлбөр нь АНУ, Их Британи, Канад, Австрали, Шинэ Зеланд болон Азийн орнуудад илүү түгээмэл хэрэгжиж байна. Хөршийн хяналтын хөтөлбөрт оролцогчдын тоог ойролцоогоор гаргах боломжтой ч оролцоог нь тодорхойлоход хэцүү байдаг. Дээрх улс орнуудад хөршийн хяналт нь олон төрлийн үйл ажиллагаатай хамтруулан хэрэгжүүлж, үр дүнд хүрдэг. Эдгээрээс заримыг нь дурдвал эд хөрөнгийг бүртгэлжүүлэх /эзнийх нь жолооны үнэмлэхний дугаараар бүртгэлжүүлж эд хөрөнгө алдагдаад хэн нэгэн олдвол эргүүлж эзэнд олгох зорилготой/ нийт хөтөлбөрүүдийн 81 хувь нь энэ үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Гэр бүлийн аюулгүй байдлын судалгаа, гэмт хэргийг мэдээлэх, хүүхэд хамгааллын хөтөлбөр, амьдрах орчин сайжруулах, гэрэлтүүлэг нэмэх, бие хамгаалах үйлчилгээ, хөршүүдийн утасны жагсаалт хийж тараах, зохион байгуулалттайгаар тандалт явуулах зэрэг олон үйл ажиллагааг хөршийн хяналтын хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлдэг.

Хөтөлбөрийн хүрээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн боловсролын дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, хөршүүдийн бүлэг болгон хуваарилах, олон нийтийн арга хэмжээ зохиох, хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх зэрэг олон ажлыг зохион байгуулдаг байна.

Дээрх улс орнуудад хөршийн хяналтын хөтөлбөрийн хүрээд хэрэгжиж буй хөтөлбөрүүдэд хар тамхины хөтөлбөр 1990-ээд оноос шинээр нэмэгдсэн юм. Энэ нь иргэд хар тамхины эсрэг давлагаанд нэгдэж, цагдаагийн байгууллага, бусад агентлагуудтай хамтран хар тамхины хэрэглээ, наймаа, түүнээс үүдсэн асуудлуудыг бууруулах тал дээр анхаарч эхэлсэн юм. Иргэд хар тамхины талаар мэдээлэх, бусад оршин суугчдад хар тамхины хор уршгийн тухай мэдлэг мэдээлэл өгөх, хар тамхины наймаа хийж буй гэмт хэрэгтнүүдийг ажиглах, иргэдийн эргүүл хөтөлбөрт оролцох зэргээр хөршийн хяналтыг хэрэгжүүлсэн¹⁶⁸.

Иргэний эргүүл нь хөршийн хяналтын гол элемент бөгөөд энэ нь тандалт хийх гол арга юм. Эргүүлийн (иргэний) зорилго нь гудамжинд сэжигтэй хүнийг ажиглах, гэмт хэргийг илрүүлэх бөгөөд үүнд оршин суугчдаас гадна сайн дурынхан эсвэл урамшуулалт иргэдийг цалинжуулан хийлгэдэг. Ихэнх эргүүл явган алхаж зарим нь хөдөлгөөнт эргүүл хийдэг. Эргүүлүүд нь гудамжинд сэжигтэй үйлдэл илрүүлбэл цагдаад утас ашиглан дуудлага өгөх бөгөөд өөр нэмэлт үйлдэл хийдэггүй.

Хөршийн хяналтын бас нэг чухал элемент нь хамгаалалт хийх юм. Хамгийн анхан шатны хамгаалагчид бол тухайн нутаг дэвсгэрийн хууль ёсны оршин суугчид бөгөөд гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэх иргэдийн оролцоог нэмэгдүүлдэг.

Хөршийн хяналтын хөтөлбөрийн үндсэн зорилго нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, гэмт хэргийн гаралтын түвшинг бууруулах юм. Энэхүү гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь юуны түрүүнд хулгай, дээрмийн гэмт хэрэг, хүчирхийллийн болон хүн амины гэмт хэргийг ч бууруулахад ч нөлөөлөх ёстой. Тус хөтөлбөрөөр хүчирхийллийн гэмт хэрэгт дорвитой нөлөөлж чадахгүй байгаа шалтгаан нь энэ төрлийн гэмт хэрэг ихэвчлэн гэр бүлийн хүрээнд эсвэл нэг нэгнээ мэддэг хүмүүсийн дунд үйлдэгдэж буйтай холбоотой. Гэмт хэрэгтэн нь тухайн нутаг дэвсгэрийн оршин суугч, хөрш байх үед ажиглалт танталт үр дүнгүй. Харин оршин суугчдыг гадны сэжигтэй этгээдээс сэргийлэхэд хөршийн хяналтын хөтөлбөр илүү үр дүнтэй байдаг гэж судлаачид үздэг.

Монгол Улсад нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 126 дугаар тогтоолоор Хөршийн хяналтын хөтөлбөр батлагдсан бөгөөд 2015 он дуустал бэлтгэл ажил, 2016-2020 онд

¹⁶⁸ R C Davis, A J Lurigio, D P Rosenbaum. Drugs and the community: involving community residents in combatting the sale of illegal drugs.

хэрэгжүүлэх үе шат гэсэн хоёр үе шаттай байхаар хэрэгжүүлсэн байна. Энэхүү хөтөлбөрөөр нийслэлийн иргэд өөрсдийн оршин суугаа нутаг дэвсгэрийн аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор сайн дурын үндсэн дээр нэгдэж, энэ чиглэлээр нутгийн захиргааны байгууллага болон цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах тогтолцоог бүрдүүлэхэд оршино гэж заасан.

Энэхүү өгүүллэгээр хөршийн хяналтын хөтөлбөрийн хэрэгжилт, иргэд, олон нийт энэ талаар мэдээлэлтэй байгаа эсэх, иргэд, олон нийтийн оролцоог тодорхойлох зорилгоор социологийн судалгаа авч нэгтгэлээ.


1. Судалгааны ажлын үр дүн. Монгол Улс дахь хөршийн хяналтын үйл ажиллагааны өнөөгийн байдлыг тодорхойлохын тулд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөршийн хяналтын хөтөлбөрт иргэдийн оролцоо хэр байгааг тодорхойлох, энэ чиглэлээр холбогдох байгууллагуудын зүгээс хийсэн ажлын чиглэл, бодлого, үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч, хөтөлбөрийн ач холбогдол зэргийг үнэлэх зорилготой юм.

Энэхүү судалгааг Улаанбаатар хотын иргэдээс google form ашиглаж, санамсаргүй байдлаар болон фокус бүлгийн ярилцлагын аргыг ашиглан тус судалгааг авсан. Судалгааг хийхдээ судлаачийн үзэл бодлыг тусгахгүйгээр зөвхөн судалгааны үр дүнг гаргаж, нөхцөл байдлыг бодитоор тодорхойлсон.

2. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл. Уг судалгаагаар нийслэлийн 158 иргэнээс “google form” ашиглан судалгаа авсан бөгөөд ерөнхий мэдээллийг дараах хүснэгтээр орууллаа.

<i>Үзүүлэлт</i>	<i>Үзүүлэлт</i>	<i>Давталт</i>	<i>Хувь, %</i>
Нас	18-24	11	7%
	25-30	31	19,6%
	31-36	40	25.3%
	37-42	50	31.6%
	43-50	18	11.4%
	50 дээш	8	5.1%
Хүйс	Эрэгтэй	19	12%
	Эмэгтэй	139	88%
Оршин суугаа газар	Улаанбаатар	143	90.5%
	Орон нутагт	19	9.5%
Дүүрэг	БЗД	60	42%
	БГД	15	10.5%
	СБД	6	4.2%
	СХД	40	28%
	ХУД	17	11.9%
	ЧД	3	2.1%
	Налайх	1	0.7%
	Багануур	1	0.7%
	Багахангай		
Амьдрах газар	Өөрийн орон сууцанд	67	61.4%
	Түрээсийн орон сууцанд	6	3.8 %
	Гэр хороололд	54	34.2%
	Түрээсийн хашаа байшинд		
	Нийтийн байранд	1	0.6%

3. Хөршийн хяналтын талаарх иргэдийн үнэлгээ. Судалгаагаар иргэд оршин суугчид бие биенээ таньдаг эсэх, өөр хоорондоо тусалдаг эсэх, хөршүүдийн хоорондын харилцааны өнөөгийн



байдлыг тодорхойлохоор 7 асуулт бүхий асуулт боловсруулсан. Эхний асуулт буюу та хөршөө таних уу гэсэн асуултад муу, маш муу танина гэж 63, дунд зэрэг гэж 63, сайн, маш сайн гэж 32 хүн хариулсан байна. Эндээс харахад 126 хүн буюу 79.7 хувь нь хөршөө танихгүй, зүс мэдэх буюу дунд зэрэг мэддэг болох нь харагдаж байна. Мөн Та хөрштэйгээ мэндэлдэг үү гэсэн асуултад муу, маш муу гэж 53, дунд зэрэг гэж 49, сайн, маш сайн гэж 56 хүн тус тус хариулжээ. Эндээс харахад 66.4 хувь нь бие биетэйгээ мэндэлдэг болох нь харагдаж байна.

Та хөршдөө тусалдаг уу гэсэн асуултад сайн, маш сайн тусалдаг гэж 36, тусалдаггүй гэж 61, дунд



зэрэг гэж 87 хүн тус тус хариулжээ. Мөн танай хөрш танаас тусламж хүсэж байсан уу гэсэн асуултад үгүй гэж 79, дунд зэрэг гэж 44, тийм гэж 30 хүн хариулжээ. Эдгээр хариултаас харахад хөршүүд харилцан бие бие дээ тусламж хүсдэггүй болох нь харагдаж байна. Оршин суугч, иргэдээс тухайн амьдарч байгаа олон нийт, иргэдийн хамтын ажиллагаа, олон нийтийн арга хэмжээнд оролцдог эсэхийг асуухад муу, маш муу оролцдог

гэж 84, дунд зэрэг гэж 41 хүн хариулжээ. Ийнхүү дээрх асуулгыг дүгнэн үзвэл саахалт айл, хөршүүд бие биенээ төдийлөн сайн мэддэггүй, хүнд хэцүү үед бие биедээ туслах боломж бага, хөршүүд олон нийтийн арга хэмжээнд оролцдоггүй, хөршүүд гэмт хэрэг, зөрчилд холбогдох нь бага, цагдаагийн байгууллагад мэдээлэл төдийлөн өгдөггүй байна.

Та “хөршийн хяналт” гэдэг ойлголтод юуг хамааруулан ойлгож байна вэ? гэсэн асуултад сайн



дурын нийгэмлэгийн үйл ажиллагаа гэж 13 хүн буюу 8 хувь, СӨХ-ийн үйл ажиллагаа гэж 6 хүн буюу 4 хувь нь, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай ойлголт гэж 59 хүн буюу 38 хувь, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа гэж 1 хүн буюу 0.6 хувь, иргэд, цагдаагийн байгууллагын хамтын

үйл ажиллагаа гэж 41 буюу 27 хувь, энэ талаар сонсож байгаагүй гэж 34 хүн буюу 22 хувь нь хариулсан байна. Эндээс харахад судалгаанд оролцогчдын 35 хувь нь хөршийн хяналтын талаар мэдэхгүй бол 65 хувь нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэд, цагдаагийн байгууллагын хамтын үйл ажиллагаа гэж хариулжээ. Өөрөөр хэлбэл, хөршийн хяналтын талаар иргэдийн дийлэнх хувь мэддэг болох нь харагдаж байна.

Таны оршин суугаа газарт “хөршийн хяналт”-ын үйл ажиллагаа хэрхэн явагдаж байна вэ? гэсэн



асуултад манай дүүрэг хороонд хөршийн хяналтын үйл ажиллагаа хэрэгдэг эсэх талаар мэдэхгүй гэж 102 хүн буюу 65 хувь, хөршийн хяналтын үйл ажиллагаа сайн хэрэгждэг гэж 10 хүн буюу 6 хувь, хөршийн хяналтын үйл ажиллагаа дунд зэрэг гэж 13 хүн буюу 8 хувь, хөршийн хяналтын үйл ажиллагаа хэрэгждэггүй гэж 31 хүн буюу

20 хувь нь хариулжээ. Эндээс харахад 85 хувь нь хөршийн хяналтын үйл ажиллагааг хэрэгждэггүй ба энэ талаар мэдэхгүй гэж хариулсан нь хөршийн хяналтын үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэх боломжгүй болох нь харагдаж байна.

Та “хөршийн хяналт”-ын үйл ажиллагаанд оролцож байсан уу? гэсэн асуултад би хөршийн хяналтын




гишүүн гэж 4 хүн буюу 3 хувь, хөршийн хяналтын үйл ажиллагаанд оролцдоггүй гэж 38 хүн буюу 25 хувь, оршин суугаа газарт хөршийн хяналтын үйл ажиллагаа хэрэгждэггүй гэж 110 буюу 72 хувь нь хариулсан байна. Эндээс харахад судалгаанд оролцогчдын 97 хувь хөршийн хяналтын үйл ажиллагаанд оролцож үзээгүй болох нь харагдаж байна.

Таны оршин суугаа газрын Засаг дарга, Цагдаагийн байгууллага, СӨХ-оос “хөршийн хяналтын бүлэг”-ийн үйл ажиллагааны талаарх танилцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байсан уу? гэсэн асуултад тийм гэж 8 хүн буюу 5.1 хувь, үгүй гэж 148 буюу 94.9 хувь нь хариулсан байна. Эндээс харахад хөршийн хяналтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх алба хаагчдаас хэрэгжүүлсэн арга хэмжээ нь иргэдэд хүртээмжгүй байгаа нь харагдаж байна. Хэрэв тийм гэж хариулсан бол ямар арга хэмжээнд та оролцож байсан бэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчид хариулаагүй байна.



Хөршийн хяналтын үйл ажиллагааны талаарх хагас жилийн тайлан, мэдээллийг сонсож, хүлээн авч байсан уу? гэсэн асуултад үгүй гэж 149 буюу 96 хувь нь гэж хариулжээ.



Та оршин суугаа газрын аюулгүй байдлаа та хэрхэн үнэлэх вэ гэсэн асуултад 69 хүн буюу 39 хувь нь аюулгүй, аюултай гэж 35 буюу 25 хувь, шөнө орой явахад айдаг гэж 42 буюу 23 хувь, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах шаардлагатай гэж 32 буюу 18 хувь нь хариулжээ.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд “хөршийн хяналт”-ын үйл ажиллагааг сайжруулах талаар Та саналаа хэлнэ үү? гэсэн асуултад

- Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар сайн мэдэхгүй байна, дахин хэрэгжүүлэх шаардлагатай;
- Иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хөршийн хяналтын үйл ажиллагааг цааш нь үргэлжлүүлэн зохион байгуулах, хөршүүд хоорондоо харилцаатай байж нэгэндээ тусалж байвал сайн;
- Иргэн бүрийн оролцоог нэмэгдүүлэх, сэдэлжүүлэх зохион байгуулалттай, хариуцлагатай, хяналттай арга хэмжээ зохион байгуулах;
- Хөршийн эргүүл, цагдааг байнга ажиллуулах, техник технологийн дэвшлийг ашиглах, харанхуй гудамжийг гэрэлтэй болгох;
- Ухуулга суртчилгаа, ухуулга хуудас болон сургалт зохион байгуулахаас илүүтэйгээр *social* орчинд түгээх, давхар, орц бүрээрээ Фэйсбүүк групп үүсгэж ажиллах, нийгмийн сүлжээнд маш хүчтэй сурталчилгаа хийх хэрэгтэй;
- Хөдөө орон нутагт СӨХ байгуулах, хөдөө орон нутгийн иргэдээ ч бас ийм сургалтад сайн хамруулж мэдээлэлтэй болгох хэрэгтэй;
- Иргэн болон хорооны ажилтанууд хоорондын харилцаа холбоог сайжруулах, хамтарч ажиллах, иргэд оршин суучдад хөршийн хяналтын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын

талаар ЗД, ЦБ, СӨХ-өөс тайлбарлан, танилцуулах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах хөршийн холбоог үүсгэх, дахин сэргээх;

- Дүүрэг хорооноос ямар нэгэн энэ талаар ямар ч мэдээлэл өгдөггүй зөвхөн сошиал орчиноос мэдээлэл авдаг дүүрэг хороог сайн ажиллуулах хэрэгтэй Иргэдтэйгээ аль болохоор ойр байж хийж бгаа ажлаа тогтмол танилцуулах нь зүйтэй гэсэн саналуудыг ирүүлжээ.

Дүгнэлт. Монгол Улсад 2015 оноос нийслэлийн иргэд өөрсдийн оршин суугаа нутаг дэвсгэртээ аюулгүй амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор сайн дураар хамтран ажиллах санаачлагыг бий болгохоор “Хөршийн хяналтын хөтөлбөр”-ийг боловсруулж, хэрэгжүүлсэн нь сайшаалтай байна. Мөн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын онолын хүрээнд хөршийн хяналтын үйл ажиллагааны талаарх ойлголт, үзэл баримтлалыг харьцуулан судалж, энэ чиглэлийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хийх, практикт нэвтрүүлэх, хөгжүүлэх шаардлагатай байна.

Иргэдээс хөршийн хяналтын үйл ажиллагааны өнөөгийн байдлыг тодорхойлохоор судалгаа авахад хөршүүд дийлэнх нь бие биеэ сайн таньдаггүй, хөршийн хяналтын үйл ажиллагааны тухай ерөнхий ойлголттой боловч энэхүү хөтөлбөрийг хэн хэрэгжүүлж, ямар арга хэмжээ явуулж байгаа нь иргэдэд мэдээлэл байхгүй байна. Мөн судалгаанд оролцогчдын 97 хувь нь хөршийн хяналтын үйл ажиллагаанд оролцож байгаагүй, ямар арга хэмжээ зохион байгуулагдсныг мэдэхгүй болох нь харагдаж байна.

Санал: Хөршийн хяналтын үйл ажиллагааг үр нөлөөг дээшлүүлэхийн тулд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хөршийн хяналтын хөтөлбөрийг дахин хэрэгжүүлэх. Ингэхдээ бусад хамтран хэрэгжүүлж болох хавсралт хөтөлбөрүүдийг судалж, хэрэгжүүлэх;
2. Хөршийн хяналтын үйл ажиллагааны талаарх ухуулга, сурталчилгааг нийгмийн сүлжээнд түгээх, иргэд, оршин суугчдын фэйсбүүк группыг үүсгэж хамтран ажиллах;
3. Оршин суугчдыг танилцуулах, хамтын ажиллагааг өргөжүүлэхийн тулд хороо, СӨХ-өөс олон нийтийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах, хотхон, орон сууцнуудын гадаах тохижолтыг сайжруулах,
4. 2015-2020 онд хэрэгжсэн хөршийн хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтийн сайн болон дутагдалтай талыг тодорхойлж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой зохион байгуулах;
5. Хөршийн хяналтын хөтөлбөрийн хүрээнд урамшуулалт эргүүл ажиллуулах санхүүгийн асуудлыг шийдвэрлэж, тогтмол эргүүл хийх, тандалт хийх боломжуудыг нэмэгдүүлэх нь зүйтэй байна.

ДОТООДЫН ЦЭРГИЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛТ,
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН
УЛАМЖЛАЛ

ДХИС-ийн магистрант,
ахмад П.Оюунболд

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд Дотоодын цэргийн үүсэл хөгжилт, мэргэжлийн цэрэг үүсэх хэрэгцээ шаардлага болон үйл ажиллагааг зохицуулж ирсэн эрх зүйн зохицуулалтын уламжлалын талаар товч авч үзсэн.

Түлхүүр үг: Дотоодын цэрэг,

Үндсэн хэсэг. Дотоодын цэрэг нь тайван цагт бие даасан үйл ажиллагаа явуулдаг, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй, төрөл мэргэжлийн цэрэг юм.

Эзэн Чингис хааны хэвтүүл цэргээс эхтэй Дотоодын цэрэг нь 1922 онд дотоодын харуул хамгаалалтын үүргийг дагнан гүйцэтгэх зорилгоор Ардын хувьсгалын партизаны тулгын чулууг нь тавьсанаас хойш өнөөдрийг хүртэл төр, засаг, командлалаас даалгасан үүргийг нэр төртэй биелүүлж иржээ.

Дотоодын цэргийн эрх зүйн зохицуулалтын уламжлалыг түүхэн цаг үеийн байдлаар нь:

- 1921-1945 он
- 1945- 1985 он
- 1986-1990 он
- 1991 – 2014 он
- 2017 оноос одоог хүртэл хэмээн ангилж болно.

Харьяалагдах байгууллагаар нь:

- Дотоодыг хамгаалах газрын харьяанд,
- Дотоод явдлын яамны харьяанд,
- Нийгмийг аюулаас хамгаалах яамны Хилийн ба дотоодын цэргийг удирдах газрын бүрэлдэхүүнд,
- Цагдаагийн ерөнхий газрын харьяанд байх үе хэмээн үечилж бас болно.

Дотоодын цэргийг нэрлэгдэж байсан нэр томъёогоор авч үзвэл: 1933 оны Цэргийн ба Хязгаарын хэлтэс, 1936 онд Дотоодын ба Хязгаарын газар байгуулагдсан байна. Цэргийн яам тусдаа байсан учраас “Цэргийн” гэдэг нь Дотоодын цэргийг хэлдэг байсан байжээ. 1967 оноос эхлэн Хязгаарын ба Дотоодын цэргийн Хэрэг эрхлэх Газар байгуулагдсан үеэс албан ёсоор “Дотоодын цэрэг” гэж нэрлэх болсон байна.

1921 онд Монгол оронд Ардын хувьсгал ялсан хэдий ч тухайн үед гадаад, дотоодын үймээн самуун дарагдаж намжаагүй, улс орны байдал маш ээдрээ түвэгтэй байдлыг харгалзан жанжин Дамдины Сүхбаатарын санаачлага, Ардын түр засгийн газар, Бүх цэргийн Зөвлөлийн шийдвэрээр Дотоодыг хамгаалах газрыг Бүх цэргийн зөвлөлийн дэргэд анх байгуулсан түүхтэй. 1922 оны 07 дугаар сарын 16-ны өдөр Дотоодыг хамгаалах газар анх байгуулагдахад уг газрын бүрэлдэхүүнд дотоодын харуул хамгаалалтын үүргийг дагнан гүйцэтгүүлэх зорилгоор цөөн хүний бүрэлдэхүүнтэй нэгэн тусгай тасаг байгуулагдсан ба уг Тусгай тасаг нь монгол цэргийн нэгэн өвөрмөц төрөл болох дотоодын цэргийн

үүсвэр, суурь, үндэс нь бөгөөд дотоодын цэрэг үүсгэн байгуулагдсан өдрийг 1922 оны 07 дугаар сарын 16-ны өдөр хэмээн тогтоон тодорхойлжээ¹⁶⁹.

Уг тусгай тасгийг байгуулахдаа Ардын журамт цэргийн нэгдүгээр морин хорооноос хувьсгалын үйл хэрэгт үнэнч, шударгаар оролцож байсан шилдэг 13 цэрэг, дайчдыг шилэн авч, Оросын улаан армийн 103 дугаар хорооны тусгай батальоны дарга цэргүүдийг дагалдуулан сургаж улмаар 1922 оны эцсээр 20 хүнтэй Тусгай салаа, 1924 онд морин цэргийн болон 55 алба хаагчидтай Тусгай суман болгон өргөжүүлсэн байна.

1926 онд тус тусгай сумангийн харуул хамгаалалтын хүчин чадлыг нэмэгдүүлж 170 хүний орон тоотой болгон өргөжүүлсэн байна. Хувьсгалын эсрэг хүчинд цохилт өгөх, бослого хөдөлгөөнийг дарж намжаахад оролцох, Нийслэл хүрээний чухал албан газрууд, шорон гянданг манаж хамгаалах төвөөс алсдагдсан зарим аймаг, хошуудад чухал бичиг, харилцааг биечлэн хүргэх, төвд ирүүлэх хүмүүсийг дуудан ирүүлэх зэрэг үүрийг тусгайлан гүйцэтгэж байжээ.

1929 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Бүх цэргийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн Дотоодыг хамгаалах газрын даргын тушаалаар 250 хүний бүрэлдэхүүнтэй Тусгай дивизион болгон өөрчилж, бүтцийн хувьд биеэ даасан зохион байгуулалтад шилжүүлж, удирдлагын штабыг анх бий болгосон байна¹⁷⁰.

1929 оны Дотоодыг хамгаалах газрын шинэчилэн батлагдсан дүрмэнд “Тус улсын хууль, дүрмийн ёсоор тогтоосон амар тайван байдлыг сахиулах сэргийлэн хамгаалах цэргийн ангиуд нь тус улсын дотор үүрэг гүйцэтгэх аваас Дотоодыг хамгаалахын Дотоодын цэрэг” хэмээн нэрийднэ хэмээн заасан аж¹⁷¹.

Мөн дүрмэнд хил хязгаарыг хамгаалахаар хязгаарт суулгасан ангиудыг “Дотоодыг хамгаалахын хил хязгаарыг батлан хамгаалах харуул” хэмээн нэрлэхээр болсон байна.

1930 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн Бүх цэргийн зөвлөлийн хуралдааны 133 дугаар тоот тушаалд Дотоодыг хамгаалах Тусгай дивизионыг Тусгай хороо болгон өөрчлөн зохион байгуулсан байна.

Уг өөрчлөлтөөр тусгай дивизион нь бүрэлдэхүүндээ морин суман 2, пулемонт суман 1, бага даргын салаа 1, ажил ангийн салаа 1, нийт 400 гаруй албан хаагч, дайчидтай Тусгай морин хороо болгон өргөжсөн байна¹⁷².

Дотоодыг хамгаалах цэрэгт үүрэг гүйцэтгүүлэхээр Бүх цэргийн зөвлөлөөс нийлүүлэн ирүүлэх хүмүүсийг онц нарийвчлан хянаж, улс төрийн талаар гүйцэд итгэмж бүхий цэргийн албанд тэнцэх бие эрүүл шинэ цэргийг татах тухайд дотоодыг хамгаалах газар нь өөрийн бие төлөөлөгчийг явуулж, дайчилгааны комисст оруулдаг байжээ. Хувьсгалын эсэргүү хөдөлгөөн, зэвсэгт бослогын бүлэглэл энд тэндгүй бий болж, шинэ засаг төвхнөж бүрэн хүч зохион байгуулалтад орж бэхжээгүй, ард нийтээр шашны нөлөөнд хэт гүнзгий автагдсан байдлыг ашиглан зарим нутагт бослого хөдөлгөөн гаргах, хил хязгаарт ойр нутгийн ард иргэдийг хууран мэхэлж, хил давуулан нүүлгэх, орон нутгийн засаг захиргааны хариуцлагатай ажилтан, сонгуультаан идэвхтнүүдийг алах төрийн байгууллага, ардын хоршоо, сургуулиудыг галдан шатаах зэрэг дайсагнасан ажиллагааг таслан зогсоох, хатуу ширүүн, амь өрсөн тэмцэл тулаанд өгөгдсөн үүрэг даалгаварыг нэр төртэй биелүүлж ирсэн байна.

1931 оны оноос Дотоодын хамгаалах газрын Цэргийн ба Хязгаарын тусгай хэлтэс болгон өргөтгөж, удирдлагын штаб, улс төр, байлдааны бэлтгэл, гүйцэтгэх албаны гэсэн 4 тасагтай болон өргөжсөн байна.

1936 оны 02 дугаар сарын 24-нд Улсын бага хурлын тэргүүлэгчид, Ардын сайды нарын зөвлөлийн шийдвэрээр Дотоодыг хамгаалах газрыг Дотоод явдлын яам болгон, Дотоодыг хамгаалах

¹⁶⁹ З.Батсүх, “Дотоодын цэргийн түүхэн замнал”, УБ, 2002 он, 2-4 дэх тал

¹⁷⁰ З.Батсүх, “Дотоодын цэргийн түүхэн замнал”, УБ, 2002 он, 2-4 дэх тал

¹⁷¹ БНМАУ-ын НАХБ-ын түүхэнд холбогдох тогтоол, зарлиг, баримт бичгүүдийн эмхтгэл (1921-1960), УБ, 1971 он

¹⁷² Ардын цэргийн төв архив, 1, х/н, 183, 152 дах тал

газрын гүйцэтгэж байсан үүргийн чиглэл, зорилгыг өөрчлөн хуулийн байгууллагын шинжтэй болгон, Дотоодын аюулгүй байдлыг хангах цэргийн байгууллагын шинж чиг үүргийг цэргийн ба хязгаарын хэлтэст хамааруулан үлдээсэн ба үүний илрэл нь Ардын Сайд нарын Зөвлөлийн 1945 оны 24 дүгээр тогтоолын дагуу Дотоод явдлын яамны сайдын 1945 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 429 дүгээр тушаалаар олзлогдогсодыг хамгаалах Дотоодын цэргийн тусгай хороог 4 хүний бүрэлдэхүүнтэй шинээр байгуулсан явдал юм.

1941 оны Ардын хувьсгалын 20 жилийн ой угтсан уралдаанд 1 дүгээр байр эзэлж “Хязгаарын ба Дотоодын цэргийн ангиудад шилжин явах уралдааны улаан туг”-ийг хүлээн авч 5 жил дааралан түрүүлж, үүрд хадгалагдах тугтай болжээ¹⁷³.

Одон тэмдэгт тусгай хорооны хамт олны байлдааны онцгой үүрэг, даалгаварыг цаг ямагт нэр төртэй биелүүлж ирсэн эх оронч үйлсийг нь өндрөөр үнэлж Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1946 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн 50 дугаар тогтоолоор “Жанжин Дамдин Сүхбаатарын нэрэмжит” хороо болгохоор шийдвэрлэсэн байна¹⁷⁴.

Хорооны үүрэг нь дайны уршгаар сүйдсэн улс ардын аж ахуйг сэргээн босгох, бүтээн байгуулалтад олзлогдогсодыг зохион байгуулан ажиллуулах үүргийг нарийн чанд гүйцэтгэж байжээ. Дотоодыг хамгаалах тусгай хороо нь улс орны дотоодод Улсын онц чухал объектын харуул хамгаалалт, байлдааны үүргийг гүйцэтгэж байсны зэрэгцээгээр дотоодыг хамгаалах газар Маршал Хорлоо Чойбалсангийн өвлийн байр, орон нутагт ажиллах үеийн харуул хамгаалалт, Зөвлөлт Холбоот Улсаас тус улсад суух элчин сайдын ба худалдааны төлөөлөгчийн албан газрыг өдөр шөнийн 24 цагийн харуулаар хамгаалалтыг зохион байгуулдаг байжээ.

1947-1952 онуудад Сайд нарын Зөвлөлийн 86 дугаар тогтоолоор Барилгын хэргийг удирдах ерөнхий газрын харьяанд хоригдлуудыг ажиллуулах 6 хорих лагерь, 42 объектыг 121 постоор хуяглан хамгаалалтын үүргийг гүйцэтгэж байгаад 1953 онд Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колонийн хамгаалалтын тусгай хороонд хариуцуулсан байна.

1953 онд цэрэг, армийн анги нэгтгэлүүдийг цомхотголоор хамгаалах хороог татан буулгаж, тусгай хороог батальон болгосон ба Дотоод явдлын яамны сайдын 1954 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 338 дугаар тушаалаар Хилийн ба Дотоодын цэргийн харуул хамгаалалтын тусгай хороог татан буулгаж харуул хамгаалалтын тусгай хорооны гүйцэтгэж байсан үүргийг тусгай батальонд хавсруулан зохион байгуулалтыг өргөтгөж уг батальоныг Одон тэмдэгт тусгай хороо гэж нэрлэх болжээ¹⁷⁵.

Шинэ зохион байгуулалтаар харуул хамгаалалтын албыг дараах 3 чиглэлээр зохион байгуулж явуулж байжээ. Үүнд:

1. Улсын онц чухал объект

- Хорлоогийн Чойбалсангийн бунхан
- Ерөнхий сайдын өвлийн байр
- Ерөнхий сайдын Баянгол дахь зуслан
- Их тэнгэрийн аман дахь зочдын байр
- Бага тэнгэрийн аман дахь хүнсний лабораторийн байрны хамгаалалтыг хорооны 1 суман хамгаалж байна.

2. Гарнизоны объект

- Засгийн газрын болон Дотоод явдлын яамны бензин колонк
- Улсын архив
- Өөрийн хорооны дотоодын хамгаалалт

3. Гарнизоны хуяглан хамгаалах объект

¹⁷³З.Батсүх, “Дотоодын цэргийн түүхэн замнал”, УБ, 2002 он, 21 дахь тал

¹⁷⁴ “Монгол Улсын Дотоодын цэргийн 805 дугаар хорооны түүхэн замнал”, УБ, 1996 он, 4-9 дах тал

¹⁷⁵ З.Батсүх, “Дотоодын цэргийн түүхэн замнал”, УБ, 2002 он, 23 дахь тал

- Төв хорих
- Цагаан хуарангийн хорих лагерь

1955 онд Дотоод явдлыг татан буулгаж Ардын цэргийг эрхлэх газартай нэгтгэж Цэрэг ба Нийгмийг аюулаас хамгаалах хэрэг эрхлэх яам байгуулагдан, 1957 оны 11 дүгээр сараас 1959 оны 7 дугаар сар хүртэл харъяалагдан төрийн ёслол хүндэтгэлийн ажиллагааг эрхэлж шинэчилсэн тоо, бүтэц, зохион байгуулалтаар ажиллах болсон түүхтэй¹⁷⁶.

Монгол Ардын Хувьсгалт намын Тэргүүлэгчдийн хурлын 1959 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор Цэргийн ба Нийгмийг аюулаас хамгаалах хэрэг эрхлэх газрыг татан буулгаж Нийгмийг аюулаас хамгаалах яам (НАХЯ)¹⁷⁷, Ардын цэргийн хэрэг эрхлэх яамыг байгуулж, уг тогтоолоор тусгай батальон болон хилийн цэргийн анги салбаруудыг Нийгмийг аюулаас хамгаалах яамны бүтэц, бүрэлдэхүүнд харъяалуулан, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн 1959 оны 244 тоот тогтоолоор НАХЯ-ын Хязгаарын ба Дотоодын цэргийн хэргийг эрхлэх хэлтсийг байгуулсан байна¹⁷⁸.

Монгол Ардын Хувьсгалт намын Тэргүүлэгчдийн хурлын 1967 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 25 тоот тогтоолоор тусгай хороо болгон өргөтгөж бүрэлдэхүүнд нь Хязгаарын ба Дотоодын анги, салбарын бага дарга нарыг бэлтгэх сургуулийн рот, холбооны алба хаагчдыг бэлтгэх байнгын курсыг байгуулжээ¹⁷⁹.

Нийгмийг аюулаас хамгаалах яамны харьяа байгууллагуудын дэг журмыг сайжруулах зорилгоор Нийгмийг аюулаас хамгаалах яамны цэргийн комендатыг байгуулж уг үүргийг 1978 оноос Дотоодын цэргийн хэлтэс хариуцаж байгаад 1980 оноос 05 дугаар ангид шилжүүлсэн билээ¹⁸⁰.

Хилийн ба Дотоодын цэргийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр Дотоодын цэргийн хэлтсийг 1982 онд Тусгай тасаг болгон өөрчилж, Сайд нарын Зөвлөлийн 1986 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 239 дүгээр тогтоолоор Дотоодын цэргийн гэрээт хамгаалалтад байх албан байгууллагуудыг тодорхойлон заажээ. Үүнд:

1. Улаанбаатар хотын 1,2,3,4 дүгээр цахилгаан станц
2. Чойбалсан, Дархан, Эрдэнэт хотын цахилгаан станц
3. Монгол Зөвлөлтийн хамтарсан уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр
4. Эрдэнэт хотын ус түгээгүүрийн сан
5. Сэлэнгэ аймгийн толгойтын алтны уурхай
6. Ганц худаг дахь Урьдчилсан хорих төв
7. Онцгой болон чанга дэглэмийн засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колониудыг хамгаална гэж заасан байна.

Нийгмийг аюулаас хамгаалах яамны сайдын 1987 оны А-23 тоот тушаалаар “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Нийгмийг Аюулаас хамгаалах яамны Дотоодын цэргийн анги салбаруудын алба, байлдааны ажиллагааны заавар”-ыг баталсан байна¹⁸¹.

1990 онд Нийгмийг аюулаас хамгаалах яамыг татан буулгаж, Цагдаагийн Ерөнхий газарт Дотоодын цэргийн бие бүрэлдэхүүнийг шилжүүлж, бие даасан байгууллага болох үндэс суурийг тавьсан бөгөөд харуул хамгаалалтын үүргээ урьдын адил гүйцэтгэх болсон байна.

Дотоодын цэрэг нь Цагдаагийн Ерөнхий газрын явуулж байгаа ажиллагаанд туслах зорилгоор олон нийтийн хамарсан арга хэмжээ (нийгэм-улс төрийн, соёл олон түмний, биеийн тамир спортын

¹⁷⁶ Г.Очирсум, “Цагдаагийн түүхийн тодотголд”, УБ, 2007 он, 19-25 дах тал

“Монгол Улсын хилийн хамгаалалтын түүх”, УБ, 2008 он, I-III боть

¹⁷⁷ МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчид, Улс төрийн товчооны тогтоолууд, УБ, 1921-1960 он

¹⁷⁸ БНМАУ-ын НАХБ-ын түүхэнд холбогдох тогтоол, зарлиг, баримт бичгийн эмхэтгэл, УБ, 1971 он

¹⁷⁹ А.Думбурай, “Монгол төрийн цагдаагийн уламжлал, түүхэн хөгжилт”, УБ, II боть, 1999 он

¹⁸⁰ Д.Шагдар, “Хилийн цэргийн 50 жил”, УБ, 1983 он, 65 дах тал

¹⁸¹ З.Батсүх, “Дотоодын цэргийн түүхэн замнал”, УБ, 2002 он, 35 дахь тал

болон бусад) явагдах үед, элдэв төрлийн гоц халдварт өвчин гарсан үед хорио цээрийн дэглэм журмыг сахин хамгаалах, төв суурин газруудад гарсан нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчих үйл ажиллагааг таслан зогсоох ба арилгах, гал түймэр, байгалийн гамшгаас улс нийгмийн өмч, нийгмийн хэв журмыг хамгаалах болон бусад ажиллагаануудад тогтоосон журмын дагуу оролцож, хамгаалж байгаа үйлдвэрийн болон, засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колониудын дэглэм журам сахиулах үүрэгтэй болсон байна.

Монгол Улс нийгмийн шинэ харилцаанд шилжиж, шинэ нөхцөл байдалтай уялдан Дотоодын цэрэг нь үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй төрөл мэргэжлийн биеэ даасан гүйцэтгэх үүрэгт чанарын өөрчлөлт орж түүний эрх зүйн хувьд баталгаажин 1995 онд “Дотоодын цэргийн тухай” хуулийг баталж эрх зүйн зохицуулалтын ардчилсан нийгмийн чиг хандлагатай нийцүүлсэн билээ.

Өнөөдөр Дотоодын цэргийн үйл ажиллагаа улам өргөжин тэлж Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 135 дугаар тогтоолоор цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад байх объектын жагсаалтыг шинэчлэн баталсан. Үүнд: Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз, “Дулааны цахилгаан станц-3, 4” ТӨХК-ууд, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, Байгалийн голомтот халдварт өвчин судлалын үндэсний төв, Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр, Улаанбаатар, Чойбалсан, Дархан хотуудын цэвэр усны объектууд, цөмийн энергийн “Изотоп” төв, МОНЦАМЭ агентлаг, Ашигт малтмал ашиглах лиценз бүхий аж ахуйн нэгжүүдийн алт олборлох үйлдвэрийн талбай, Алтанбулагийн Худалдааны чөлөөт бүс, Хонхор дахь Радио телевизийн сүлжээний газар, Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх газар зэрэг улсын онц чухал объектууд хамгаалж, аюулгүй байдлыг нь сахин хангуулж байна.

Дотоодын цэргийн алба хаагчдийг бэлтгэж байсан түүхэн хөгжлийг эрх зүйн зохицуулалтын хүрээнд авч үзэх нь зүйтэй болов уу.

1934 онд Дотоодыг хамгаалах газрын дэргэд хилчний ба гүйцэтгэх ажилтан бэлтгэх жилийн хугацаатай КУРС байгуулсан ба Цэргийн сургуулийн үндэс суурь болсон гэж үздэг¹⁸². Энэ нь Хилийн ба Дотоодын цэргийг зохих мэдлэг, дадлага, чадвартай боловсон хүчнийг бэлтгэх суурь тавигдсан том алхам болсон юм. Уг сургууль 20 гаруй орон тоотой, 80 сурагчийг жилийн хугацаатай элсүүлэн “... нам, ард түмэндээ үнэнч, нам улсын бодлогыг бүрэн ойлгосон командлалын өмнө ажил хариуцах чадвартай, цэргийн дүрмийг биелүүлж хэвшүүлдэг, цэргийг сурган боловсруулах мэдлэг, дадлагатай, онол практикт сурсан мэдлэгээ хилийн цэрэг, дотоодыг хамгаалах байгууллагын ажлын онцлогт дүүрэн ашиглаж сурсан, хатуужилттай боловсон хүчнийг бэлтгэх ядвал мөн ” гэж тодорхойлсон зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байв¹⁸³.

Дотоодыг хамгаалах газрын даргын 1934 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 450 тоот тушаалаар уг сургуулийг “Төв сургууль” гэж нэрлэхээр болсон байна¹⁸⁴. Тус сургууль нь 1935-1942 он хүртэл жагсаалын, гүйцэтгэх ажлын 1-3 жилийн ангийг бэлтгэн сургаж, сургалтад семинарын хичээлийг анх удаа явуулж, цэргийн анги, салбарт сарын хугацаагаар дадлага хичээлийг гүйцэтгүүлж байсан байна. Энэ үед дарга нарын түр давтан, онгоцны нисгэгч, автомашины жолооч нарын сургалтыг сарын хугацаагаар анх удаа нээж, улс төрийн болон байлдааны тактикийн хичээлээр мэдлэг чадварыг нь дээшлүүлж байсан байна.

1935 оны үеэс Хязгаарын цэрэг өөрийн нисэх онгоцны ангитай болж, алба хаагчдаа сургаж бэлтгэх болсон байна.

1937 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн Дотоод явдлын яамны сайдын 47 тоот тушаалаар “Радио түр сургууль”-ийг 36 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна. Дотоод явдлын яамны

¹⁸² З.Батсүх, “Дотоодын цэргийн түүхэн замнал”, УБ, 2002 он, 15 дахь тал

¹⁸³ Д.Дашдэмбэрэл, “Манай сургуулийнхан”, УБ, 2000 он

¹⁸⁴ БНМАУ-ын Хилийн цэргийн түүхэн замнал, УБ, 1972 он

сайдын 1938 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 172 тоот тушаалаар Төв сургуулийг Дотоод явдлын яамны харъяа “Дотоодын ба Хязгаарын цэргийн сургууль” гэж нэрлэхээр болсон аж.

Хилийн ба Дотоодын цэргийг багш, дунд мэргэжилтнээр хангах явдал чухал байсан бөгөөд Дотоод явдлын яамны орлогч сайдын 1938 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 25 тоот тушаалаар “Бага дарга нарыг бэлтгэх сургууль”, Дотоод явдлын яамны сайдын 1939 оны 270 тоот тушаалаар “Мал эмнэлэгийн сургууль”-ийг морин цэргийн заводын дэргэд, мөн онд “Хүний эмнэлэгийн дунд дунд сургууль”, 1940 онд Зөвлөлтийн хилчдийн туршлагад түшиглэн “Нохой сургууль”-ийг тус тус байгуулсан түүхтэй билээ.

Сайд нарын Зөвлөлийн 1951 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 158 тоот тогтоолыг үндэслэн Дотоод явдлын яамны сайдын 1951 оны 705 тоот тушаалаар Хязгаарын ба Дотоодын цэргийн хэрэгцээт албан хаагчдыг Батлан хамгаалах яамнаас хангаж байх болсон ба 1951 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс Хязгаарын ба Дотоодын цэргийн сургуулийг татан буулгаж, хөгжмийн салааг нь батлагдсан орон тоо, төсвийн хамт тусгай хороонд шилжүүлсэн байна.

Хязгаарын ба Дотоодын цэргийн сургууль нь 1934-1951 он хүртэл хязгаарын ба дотоодын цэрэгт улс төр, захиран командлах болон гүйцэтгэх ажлын мэргэжил эзэмшсэн 1011 офицер бэлтгэсэн өнөр түүхтэй байгууллага юм.

Монгол Улсын Их Хурлаас 1995 онд батлагдсан Дотоодын цэргийн тухай хуулийг 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар хүчингүй болгож дотоодын цэргийн чиг үүргийг цагдаагийн байгууллагад шилжүүлсэн байна.

Зэвсэгт хүчнийг дотоодын үймээн самуун, зэвсэгт бослогыг дарахад ашиглах нь зэвсэгт хүчнийг ард түмний эсрэг ашиглахын нэг хэлбэр бөгөөд энэ нь зэвсэгт хүчний эх орноо хамгаалах үндсэн чиг үүргээс гажсан, хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдах өндөр эрсдлийг дагуулдаг төдийгүй зэвсэгт хүчнийг улс төрийн тэмцэлд ашиглах, хутган оролцуулах боломж нээгдэж олон улсын тавцанд улс орны нэр хүндэд сөргөөр нөлөөлөх алхам болдгийг дэлхийн улс орнуудын жишгээс харж болно.

Түүнчлэн улсын онц чухал объектууд, тухайлбал, Улаанбаатар хотын усан хангамжийн эх үүсвэр, гүний худгууд, усан сангийн хамгаалалтад хоног тутам 1 ахлагчаар хамгаалалтыг зохион байгуулж байгаа нь объектын найдвартай хамгаалалт хангагдахгүйгээс гадна, харуулчны аюулгүй байдал алдагдаж, аюул осол үүсэх эрсдлийг дагуулах болсон байна.

Дотоодын цэргийг татан буулгахаас өмнөх хугацаанд хугацаат цэргийн алба хаагч нарыг хамгаалалтын ажиллагаанд татан оролцуулсанаар тэдгээрийг хүчийг объектуудад тараан байрлуулах, хамгаалалтыг сайжруулах боломжтой төдийгүй офицер, ахлагч нараар хамгаалуулахаас бага зардлаар шийдвэрлэж байсан байна

Дотоодын үймээн самуун, эмх замбараагүй байдал болон бусад аюул ослыг шатлан өргөжихөөс сэргийлэх, таслан зогсоох, иргэн, төрийн байгууллага, тэдгээрийн өмч хөрөнгө, объектын аюулгүй байдлыг хангах ажиллагааг уг ажиллагааны арга тактик бүхий тусгай бэлтгэгдсэн, удирдлага зохион байгуулалтын хувьд аливаа нөхцөл байдал, аюул осолд шуурхай хариу өгч чадахуйц, байнгын бэлтгэл сургуультай мэргэшсэн бүрэлдэхүүнээр хохирол багатай гүйцэтгүүлэх нь төрийн болон иргэд, нийгмийн эрх ашиг, сонирхолд нийцэхүйц алхам болох юм.

Дотоодын цэргийг дахин байгуулах, түүний хэрэгцээ шаардлагыг 2016 оноос дахин эхлэн мэдэрч, мэргэжлийн цомхон, мэргэшсэн бүтэц, бүрэлдэхүүнтэйгээр байгуулах, хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх ажил эхэлсэн байдаг.

Дотоодын цэргийн бие даасан байдлыг хангаж улсын онц чухал объектыг хамгаалах, шаардлагатай үед нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, дотоодын бусад үймээн самууны үед иргэн, байгууллагын аюулгүй байдал, өмч хөрөнгийг хамгаалах, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг гүйцэтгүүлэх, гамшиг, аюулт үзэгдэл, техникийн осол, гал түймэр, хүн, малын гоц

халдварт өвчин гарсан үед аврах болон хорио цээрийн дэглэмийг сахиулахад оролцох хэрэгцээ нь Дотоодын цэргийг дахин байгуулах үндэслэл болсон.

УИХ-ын 2017 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар Дотоодын цэргийн тухай хууль батлагдаж, дахин байгуулагдах эрх зүйн үндэс бүрдсэн.

Дотоодын цэргийн тухай хуулийн 2.1-д “Дотоодын цэргийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ”¹⁸⁵ заасан байна.

Засгийн газрын 2017 оны 283 дугаар тогтоолоор “Дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрэм”-ийг батлан гаргасан байдаг. Энэхүү дүрмээр Дотоодын цэргийн алба-ажиллагааны зохион байгуулалт, улсын онц чухал объектыг хамгаалах, бусад объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч, ачаа тээшийг харгалзан хүргэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулж байна.

Түүнчлэн Дотоодын цэргийн нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг таслан зогсооход дэмжлэг үзүүлэх, гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюул тохиолдсон үед болон эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, террорист үйлдлийг таслан зогсоох тусгай ажиллагаанд оролцох үйл ажиллагааг Дотоодын цэргийн командлагчийн баталсан журам, төлөвлөгөө, удирдамжийн дагуу зохион байгуулахаар энэхүү дүрмэнд оржээ.

Дүгнэлт. Монгол Улсад дотоодын цэрэг анх 1922 онд үүсгэн байгуулагдаж улсын чухал объектын харуул хамгаалалт, гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, олзлогсад болон хоригдлыг хуяглан хүргэх, төр засгийн шийдвэрээр улс оронд гарсан үймээн самууныг таслан зогсоох үүргийг голчлон гүйцэтгэж иржээ.

Дотоодын цэрэг нь НАХЯ-ны /хуучин нэрээр/ Хилийн ба Дотоодын цэргийн удирдлагад, 1990 оноос 2014 онд татан буугдах хугацааг хүртэл цагдаагийн төв байгууллагын удирдлагад чиг үүргээ хэрэгжүүлж байжээ.

Эрх зүйн зохицуулалтын хувьд Дотоодын цэргийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын хувьд 1922 оноос 2014 болон 2017 оноос өнөөг хүртэл эрх зүйн зохицуулалт бүрэн хангагдан ажиллаж байна.

¹⁸⁵ Төрийн мэдээлэл. 2017. №12. Дотоодын цэргийн тухай хууль

COVID-19 БУЮУ КОРОНАВИРУС ЦАР ТАХЛЫН ҮЕД ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Э.Батболд.
ДХИС-ийн Магистрант,
цагдаагийн хошууч


Товчлол. Дэлхий дээр хүн төрөлхтөн биднээс хамааралгүй байгалийн гамшиг, аюулт үзэгдэл болон хүний хүчин зүйлээс хамааралтай осол, сүйрэл, эмх замбараагүй байдал, террорист халдлага гэх мэт олон нийтийн аюулгүй байдалд заналхийлж байгаа аюулт хор уршиг, үр дагавар жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Сүүлийн 2 жилийн хугацаанд дэлхийн улс орнуудад COVID 19 коронавирус цар тахал эрчимтэй нэмэгдэж, хүн амь насаа алдах, улс орны эдийн засагт нөлөөлхүйцээр хор учруулж байна. Энэ нь зөвхөн Монгол улсын төдийгүй дэлхийн улс орнуудын тулгамдсан асуудлуудын нэг болоод байгаа бөгөөд учруулсан хор хохирол, аюулын хэм хэмжээ, давтамж, хүрээ, далайц нь өссөөр байгаа нь нэн тэргүүний тулгамдсан асуудлуудыг нэг болоод байна.

Иймд Монгол улс 2020 оны 04 сарын 29 өдөр коронавируст халдвар /ковид-19/-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль батлан энэхүү цар тахалтай тэмцэхэд анхааран олон нийтийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн олон арга хэмжээг авч ажиллаж байна.

Түлхүүр үг. Олон нийтийн аюулгүй байдал, цар тахал, хариу арга хэмжээ

Үндсэн хэсэг. Аливаа нийгэмд төрийн үндсэн үүрэг нь иргэдээ гадна, дотнын аюул заналхийллээс хамгаалж, эрх ашиг сонирхлыг нь хангах явдал байдаг. Үүнийгээ биелүүлэхийн тулд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон хууль тогтоомж гаргаж, түүнийг хүн бүрээр сахиулж мөрдүүлэхэд анхааран төр засаг шүүх, цэрэг, цагдаа гэсэн институцүүдийг ажиллуулах замаар хэрэгжүүлдэг. Аюул занал бол яг таг тодорхойлж болдог ойлголт биш бөгөөд үүнийг янз бүрийн утгаар хэрэглэдэг. Аюулгүй байдал гэдгийн анхдагч ухагдахуун нь **“Аюул”** гэсэн үг юм.

Аюул гэсэн ойлголтыг дараах 4 хүрээнд авч үзсэн байна.¹⁸⁶



Иймд аюул гэдэг нь сөнөөх, сүйтгэх шинж чанар бүхий объект, хүчин зүйлсийн зүгээс хүн, амьд байгаль, ямар нэгэн зүйлд хор хохирол учруулах магадлалын тухай ойлголт юм. Аюулыг арилгах, багасгах, сааруулах, учруулах хор хохирлыг бууруулах нь аюулгүй байдлыг хангах арга хэмжээний нэг зорилго юм.

¹⁸⁶ Доктор Б.Эрдэнэчимэгийн “Аюул” гэсэн ойлголтын тодорхойлолт

Аюулгүй байдлын олон төрөл, олон талт байдал, олон хүчин зүйлсээс шалтгаалах зэргээс үндэслэн шинжлэх ухааны бүхий л цогц асуудлыг багтааж үзэх зорилгоор эрдэмтэд аюулгүй байдлын шинжлэх ухаан **“Секьюритологи”** хэмээн нэрлэх нь оновчтой гэж үзсэн.¹⁸⁷ Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар тольд **“Аюулгүй гэдэг нь аюул байхгүй, айж эмээх, сандрах, түгшүүргүй гэсэн утгатай бол аюулгүй байдал гэдэг нь осол, түгшүүргүй байх төлөв”**¹⁸⁸ гэж тодорхойлжээ. Нөгөө талаараа аюулгүй байдал нь зөвхөн эрх, ашиг сонирхол хамгаалагдсан байдал биш, халдлага, дайралт, довтолгооноос хамгаалах, няцаах, сөрөг тэмцэл явуулах зэрэг үйл ажиллагаануудыг хамтад нь багтаасан цогц ойлголт юм.


Аюулгүй байдал нь доорх 2 элементтэй.

1. **Субъект** – Нөхцөл байдалд идэвхтэй нөлөө үзүүлж, аюулгүй байдлын аль нэгэн төрлийн төлөө хариуцлага хүлээж, түүний талаар шийдвэр гаргаж, практикт хэрэгжүүлж байх үүрэгтэй хувь хүн, байгууллагыг ойлгоно.

2. **Объект** – сөрөг хүчний нөлөөлөлд автагдан өөрийн оршин тогтнох, хөгжин дэвших нөхцөлөө алдаж, эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж, хохирч болох бие хүн, нийгэм, түүний бүрэлдэхүүн хэсэг, төр, улс, түүний байгууллага, институцүүд, орон зайн нөхцөл байдал, хамгаалалт шаардлагатай болж байгаа биет зүйл, үйл хөдлөл, ажиллагаа, тогтолцоо, түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг хамааруулан ойлгоно.

Олон нийтийн аюулгүй байдал гэдгийг Монгол Улсын Үнсэн хуулиар хамгаалагдсан иргэн, нийгэм, төрийн эрх ашиг сонирхол дотоод ба гадаад шинж чанартай аюул заналхийллээс хамгаалагдсан байдал гэж тодорхойлж болно.

Олон нийт гэдэг нь ямар нэг ашиг, сонирхол нэгтэйгээр хамтран тодорхой орон зай, цаг хугацааны газар орчны байршлаас үл хамааран хамтдаа аж төрж буй хүмүүсийн бүлэг юм. Олон нийтийн аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлсийг дараах байдлаар ангилна.



Монгол улсын аюулгүй байдлын үндсэн объект нь дараах ашиг сонирхлоор тодорхойлогддог байна. Үүнд:

- Бие хүний аюулгүй байдал
- Нийгмийн аюулгүй байдал
- Төрийн аюулгүй байдал

Олон нийтийн аюулгүй байдлыг

хангах ажиллагааны үндсэн чухал объект нь хүний аюулгүй байдал юм. Хүний аюулгүй байдал нь өөр хоорондоо уялдаа бүхий дараах 7 үндсэн чиглэлээс бүрдэнэ.

1. Хувийн аюулгүй байдал
2. Эрүүл мэндийн аюулгүй байдал
3. Хүнсний аюулгүй байдал
4. Хүрээлэн буй орчны аюулгүй байдал
5. Эдийн засгийн аюулгүй байдал
6. Улс төрийн аюулгүй байдал

Олон нийтийн газарт иргэний амь нас, эрүүл мэнд, аж ахуйн нэгж, байгууллагын эд хөрөнгөнд аюул учирсан эсхүл аюул чирч болохуйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд олон нийтийн аюулгүй байдал алдагдана. *Онцгой нөхцөл байдал гэдэг нь* байгалийн болон хүний хүчин зүйлээс хамааралтай

¹⁸⁷ Ч.Улаанхүү, Аюулгүй байдлын үндэс, УБ, 2016, 18 дахь тал

¹⁸⁸ Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, I боть,(А-Г), Шинжлэх ухааны академи. Хэл зохиолын хүрээлэн. УБ. 2008. 176 дахь тал

нийгмийн тодорхой тогтолцоог алдагдуулсан, олон нийтийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхүйц үзэгдэл, үйл явц юм. Иймд аюулгүй байдлаа хангах хэрэгцээ шаардлага нь нийгэм, хүмүүсийн амьдрал, үйл ажиллагааны анхдагч асуудал бөгөөд урьдчилан зөв мэдэрч, зохион байгуулалттай тасралтгүй явуулах сөрөг арга хэмжээ нь гадаад, дотоод орчинд болж буй аюул заналхийлэлд хариу үйлчлэл үзүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны төрөл, арга, хэлбэр: Аливаа улс орон дотооддоо олон нийтийн аюулгүй байдлыг хангах хүч хэрэгслийн гол бүрэлдэхүүн хэсэг нь цагдаагийн байгууллага байдаг. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь онцгой нөхцөл байдал үүссэн үед төр, нийгэм, иргэний эрх ашиг сонирхлыг хамгаалах, нийгмийн дэг журмын хэвийн байдлыг хангах, сэргээхэд чиглэгдсэн төрөөс явуулж буй нийгэм, эдийн засаг, эрх зүй, зохион байгуулалтын цогц арга хэмжээ юм. Цагдаагийн байгууллагын нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах гэсэн 2 чиглэл бүхий хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэг нь хоорондоо салшгүй холбоотой бөгөөд нийтийн хэв журам сахиулах үйл ажиллагаа алдагдсан тохиолдолд олон нийтийн аюулгүй байдал давхар алдагдана гэсэн үг юм.



Хамгаалалт нь дараах хэлбэртэй байна.

- Алба хаагчдын хүчээр хийх хамгаалалт
- Техник хэрэгслийн хамгаалалт
- Цахим технологийн хамгаалалт
- Хамтын ажиллагааны хамгаалалт
- Олон нийтэд түшиглэсэн хамгаалалт

Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

- Нөхцөл байдлын мэдээ, мэдээллийг хүлээн авч, дүн шинжилгээ хийх
- Дээд шатны дарга, удирдлагад мэдээлэх илтгэх
- Албаны болон өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж, хүч хэрэгслийг төвлөрүүлэх арга хэмжээ авах
- Урьдчилан боловсруулсан төлөвлөгөөний дагуу удирдлагын багийг бүрдүүлэх
- Нөхцөл байдалтай уялдуулан төлөвлөгөөндөө тодотгол хийх
- Шаардлагатай хүч хэрэгслийн тооцоог гаргах
- Удирдлагын багийн гүйцэтгэх үүргийг нарийвчлан хуваарилах
- Хүч хэрэгслийн шаардлагатай хэсэгт байршуулах ажлыг зохион байгуулах
- Удирдлагын баг ажиллагааг удирдах байр луугаа хурдан шилжин байрлах
- Төлөвлөгөөний дагуу эргүүл, хамгаалалтын үйл ажиллагаа зохион байгуулах
- Нөхцөл байдал хүндэрсэн тохиолдолд нөөц хүч хэрэгслийг татан оролцуулах
- Хамгаалалтын явцад гарсан алдаа дутагдал, гаргасан амжилтыг дүгнэн хэлэлцэх
- Ажиллагаа дууссаны дараа дээд шатны удирдлагад илтгэн танилцуулах
- Бэлэн байдлыг цуцалж, хэвийн горимд шилжих заавар өгөх гэх мэт.

Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны харилцан, хамтын ажиллагаа: Цагдаагийн байгууллага нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг хэрэгжүүлэхдээ дан ганц өөрсдийн хүч хэрэгсэлд тулгуурлах бус харин төрийн болон төрийн бус, тусгай чиг үүргийн бусад байгууллагуудтай харилцан, хамтран ажиллах замаар зохион байгуулах нь ажиллагааны хүссэн үр дүнд хүрэх магадлалыг улам нэмэгдүүлнэ.

Хамтын ажиллагаа гэдэг нь тодорхой зорилтыг хамтран шийдвэрлэхийн тулд хоёр буюу түүнээс дээш оролцогчийн харилцан зөвшилцсөн үйл ажиллагааг хэлнэ.

Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажиллагаанд шаардлагатай тохиолдолд харьяалал харгалзахгүй бүх аж ахуйн нэгж, байгууллагууд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана. Тухайлбал:

- Төрийн байгууллага
- Төрийн бус байгууллага
- Нутгийн захиргааны байгууллага
- Тусгай чиг үүргийн байгууллага
- Аж ахуйн нэгж

Цагдаагийн байгууллага **“Олон нийтийн аюулгүй байдлыг хангах”** чиг үүргээ хэрэгжүүлэхдээ тухайн үйл ажиллагааны зорилго, хамрах хүрээ, объектын зэрэглэл, ач холбогдол, хүч хэрэгслийн төвлөрөл зэрэг олон хүчин зүйлсээс хамаарч дор дурдсан олон байгууллагатай харилцан хамтран ажилладаг.

- Төрийн тусгай хамгаалалтын байгууллага
- Онцгой байдлын байгууллага
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага
- Эмнэлгийн байгууллага
- Тагнуулын байгууллага
- Мэргэжлийн хяналтын байгууллага
- Нутгийн захиргааны байгууллага
- Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага
- Бусад байгууллага

Цагдаагийн байгууллага дээрх байгууллагуудтай дараах эрх зүйн хэлбэрээр харилцан хамтран ажиллана.

- Хууль тогтоомжид тусгайлан үүрэг болгосон
- Хамтран ажиллах гэрээ байгуулах
- Санамж бичиг байгуулах

Цагдаагийн байгууллага нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хамтран ажиллах байгууллагуудаас ирүүлсэн тухай санал, хүсэлт, эсхүл харилцан, хамтран ажиллахаар цагдаагийн байгууллагаас тавьсан хүсэлтийг хүлээн авсан бол энэ талаар Цагдаагийн төв байгууллагын даргад танилцуулж, өгсөн үүрэг чиглэлийн дагуу хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

Хүн, малын гоц халдварт өвчний тухай ойлголт: Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүн, мал, амьтны гоц халдварт, халдварт нийт 118 төрлийн өвчнийг тодорхойлсон байдаг. **Хүн, мал, амьтны гоц халдварт өвчин** гэж олон улсын хил хязгаараас үл хамааран богино хугацаанд дамжин тархаж хүн ба мал амьтны эрүүл мэндэд болон улс орны эдийн засагт ихээхэн хохирол уяруулж, үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх халдварт өвчнийг хэлнэ.¹⁸⁹

Өвчин гэж гарал буюу эх үүсвэрээсээ хамаарахгүйгээр хүмүүст ихээхэн гэм хор учруулах эсхүл учруулж болох өвчин эмгэг буюу эрүүл мэндийн төлөв байдлыг хэлнэ.

Халдвар гэж хүн амьтны эрүүл мэндэд аюул учруулж болох халдвар үүсгэгч хүн болон амьтны биед нэвтрэн орох өсөх буюу үржихийг хэлнэ.

Хүн, малын гоц халдварт өвчин гарсан үед хорио цээрийн дэглэм сахиулах үйл ажиллагааны арга, хэлбэр: Гоц халдварт өвчин гарсан бүс, нутаг дэвсгэрт хорио цээрийн бүс байгуулж, дэглэм тогтооход оролцох цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааны арга нь:

- Ажиглалт хийх
- Шалгалт хийх

¹⁸⁹ Г.Даваадорж, С.Цогтбаатар. Аюулт үзэгдэл, ослоос сэргийлэхүй. УБ. 2009.54 дэх тал


- Хязгаарлалт, хориг тавих
- Мэдээлэл цуглуулах
- Хүн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих
- Техник хэрэгсэл ашиглан хяналт тавих

Хүн, малын гоц халдварт өвчин гарч, хорио цээрийн дэглэм тогтоосон бүсэд цагдаагийн байгууллагын явуулах үйл ажиллагаа нь:

- Хөдөлгөөнт болон явган эргүүлийг зохион байгуулах
- Хэв журмын харуул ажиллуулах
- Шалган нэвтрүүлэх цэгээр орох, гарах хөдөлгөөнд хяналт шалгалт хийх
- Голомтын төв цэгт хорио цээрийн хамгаалалт зохион байгуулах
- Бичиг баримт шалгах
- Хүний бие, тээврийн хэрэгсэл, эд зүйл, ачаа тээшинд үзлэг хийх
- Сэжиг бүхий эд зүйлийг түр хураан авах
- Хорио цээрийн дэглэм зөрчсөн үйлийг илрүүлж, эрх бүхий албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлэх
- Онцгой байдлын болон мэргэжлийн ангиудын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

Хорио цээрийн дэглэм тогтооно гэдэг нь хүн ба мал, амьтны гоц халдварт өвчин гарсан үед халдварын тархалтын голомтыг хязгаарлан зогсоох, халдвар дамжин тархахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн иж бүрэн арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг хэлнэ. Хүн, мал, амьтны гоц халдварт өвчнөөр хүн өвчилсөн үед Эрүүл мэндийн яамны харьяа ХӨСҮТ, БГХӨСҮТ, УМЭГ, УМЭАЦЭЛ гэх мэт газрууд гоц халдварт өвчний оношийг баталгаажуулж, Улсын мэргэжлийн хяналтын газар дүгнэлт гаргана.

Гоц халдварт өвчин гарсан тохиолдолд хорио цээрийн дэглэм тогтоох бүсийг өвчний тархалтын байдлаас хамаарч 4 бүс болгон хорио цээр тогтоодог. Үүнд:



Хүн ба мал, амьтны гоц халдварт өвчин гарч хорио цээрийн дэглэм тогтоох нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг дараах 3 үе шатанд хуваана. Үүнд:

- ✚ Бэлтгэх
- ✚ Явц
- ✚ Төгсгөл

Бэлтгэл үе:

- Бие бүрэлдэхүүнийг өндөржүүлсэн бэлэн байдлын дохиогоор цуглуулах схем боловсруулах
- Хорио цээрийн дэглэм сахиулахад шаардлагатай хүч хэрэгслийн тооцоог урьдчилсан байдлаар гаргаж, бэлэн байдлыг хангуулах
- Хорио цээрийн дэглэм тогтоосон голомтын бүсэд хүч хэрэгслийг байршуулах зохион байгуулалтын арга хэмжээг авах
- Нөөц хүч хэрэгслийн тооцоог урьдчилан гаргасан байх
- Хүн, малын гоц халдварт өвчин гарсан үед ажиллах бие бүрэлдэхүүний бэлтгэлийг урьдчилан хангах, төлөвлөгдсөн ажлын зохион байгуулалтын арга хэмжээний биелэлтийг шалгах

- Халдварт өвчний голомтын бүсэд ажиллах хүч хэрэгслийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий удирдлагын баг /шуурхай штаб/-ийг байгуулах
- Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын харьяа албадын харилцан, хамтран ажиллах зааварчилгаа боловсруулах

Явцын үе:

- Хүн, малын гоц халдварт өвчин гарсан голомтын бүсэд гүйцэтгэх үүрэг, ажиллах хуваарийг тодорхой болгох
- Нутаг дэвсгэрийн засаг захиргаа, мэргэжлийн хяналтын алба, мал эмнэлгийн албадын үйл ажиллагаатай уялдуулах ажлыг зохион байгуулах
- Халдварт өвчин гарсан голомтын бүсэд эмх замбараагүй байдал үүссэн үед ажиллах төлөвлөгөөний дагуу хүч хэрэгслээ хуваарилан бэлтгэх
- Тээврийн хэрэгсэл, явган зорчигчдын хөдөлгөөнийг хязгаарлаж хяналт тавих
- Хүн, малын гоц халдварт өвчин гарсан бүс, нутаг дэвсгэрт ажиллаж амьдарч байгаа иргэдэд анхааруулга, санамжийг мэдээллийн хэрэгсэл ашиглаж явуулах
- Хорио цээрийн дэглэмийг зөрчиж байгаа иргэдийн үйлдлийг илрүүлэн баримтжуулах, таслан зогсоох, албадан саатуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Халдварын голомтын бүс болон түүний ойр орчинд эргүүл, хэв журмын харуулыг зохион байгуулж, нийтийн хэв журам сахиулах
- Сэжигтэй зүйл илэрсэн тохиолдолд удирдлагад яаралтай мэдэгдэж, холбогдох арга хэмжээг авахуулах

Төгсгөлийн үе:

- Голомтын бүс рүү орж , гарах тээврийн хэрэгсэл, явган зорчигчдын хөдөлгөөний хязгаарлалтыг зогсоох
- Онцгой комисс болон Засаг даргаас өгсөн чиглэлийн дагуу голомтын бүсэд ажилласан бие бүрэлдэхүүнийг буулгах, удирдлагаас тогтоосон газарт төвлөрүүлэх
- Голомтын бүсэд ажилласан алба хаагчдын хувцас, хэрэглэл болон бусад зүйлсийг ариутгах ажлыг зохион байгуулах

Голомтын бүсэд хорио цээрийн дэглэм сахиулах ажиллагаа дууссаны дараа онцгой комисс, шуурхай бүлэг, нутгийн гамшгаас хамгаалах албаны удирдлагаас дэглэмийг цуцлах шийдвэр өгөхөөс өмнө дур мэдэн дэглэм сахиулах ажиллагааг зогсоохыг хориглоно.

Тэгвэл цар тахал гэдэг нь юу гэсэн үг вэ? Цар тахал гэдэг нь тахал үүсгэж буй өвчний шинж, түүний эсрэг авах арга хэмжээ өөрчлөгдөөгүй гэсэн үг бөгөөд харин өвчний хамрах газар зүйн хүрээ тэлснийг хэлж байгаа нэр томьёо юм. ДЭМБ -ын гаргасан мэдэгдэлд дурдсанаар хүн ам дархлаагүй ямар нэгэн шинэ өвчин гарч урьдчилсан таамаглалыг даван олон хүнийг хамарч дэлхий нийтээр тархах үед цар тахал хэмээх тодорхойлолтыг өгдөг аж. Халдварт өвчний тархалт өндөр байгаа гадны ямар нэгэн оронд зорчоод ирсэн хүмүүс болон тухайн хүмүүсээс бусад хүн халдвар авч өвчин өөр өөр улс орнуудад шинээр тархаж байгаа тохиолдолд цар тахал гэж хараахан үздэггүй бөгөөд харин гаднаас зөөвөрлөгдөн орж ирсэн өвчин дэлхийн олон улс орнуудад тэсвэртэй оршиж улс орнууд дотор халдварын “хоёрдогч давлагаа” буюу гаднаас зөөвөрлөгдөх боломжийг хаачаад байхад улс орнуудын хүн амын дунд тухайн өвчин бие даан тархаж байгаа тохиолдолд уг халдварыг **цар тахал буюу пандемийн** хэмжээнд хүрсэн гэж зарладаг байна. Харин **тахал буюу эпидеми** гэдэг нь цөөн бүс нутаг буюу улс орны дунд халдварын тархалт огцом нэмэгдэхийг хэлнэ.

Тодорхой өвчин дэлхий нийтийг хамарсан цар тахал болсныг зөвхөн ДЭМБ зарлах ба дэлхий нийтийг хамарсан хуурамч түгшүүр төрүүлэхгүйн тулд олон хүчин зүйлийг тооцож, маш сайн нягталж үзсэний үндсэн дээр зарладаг.

Томуугийн цар тахал хүн төрөлхтний түүхэнд хэд хэдэн удаа тохиолдож байсан байна. 20 зуунд томуугийн 3 цар тахал бүртгэгдсэн байна. Үүнд:

- Испани томуу (H1N1; 1918-1919) – 50 -100 сая хүн ам дэлхийн хэмжээнд нас барсан
- Азийн томуу (H2N2; 1957-1958) – 2 сая хүн нас барсан
- Хон Конг томуу (H3N2; 1968-1969) – 1 сая хүн нас барсан нь бүртгэгдсэн байна.

COVID-19 буюу коронавирус цар тахлын сүүлийн үеийн мэдээ: / Олон улсад /



Улс орнууд дахь тохиолдлуудыг
графикаар харуулбал:

Coronavirus Cases:

156,365,369


[view by country](#)

Deaths:

3,262,856

Recovered:

133,741,131



Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр: АНУ нь олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч ажиллаж байна.

- *Хууль сахиулах байгууллагуудыг олны сэтгэл зүйд сургах.* Хэрэв хууль сахиулагчид эсэргүүцлийн жагсаалд хандах хандлага нь үймээн самуунтай тэмцэх сургалтад найдаж байгаа бол офицерууд аль хэдийн тогтворгүй эсвэл догдолсон бүлэглэлийг даамжруулах магадлалтай. Офицеруудын ихэнх сургалт тактик дээр төвлөрдөг бол эсэргүүцлийн цагдаа нь олон хүний сэтгэлзүйн талаар ойлголттой байхыг шаарддаг.
- *Орон нутгийн хууль сахиулах байгууллагуудтай уялдуулан жагсагчдын үндсэн хуулиар олгогдсон эрхийг албан тушаалтнуудад ойлгуулах.* Офицеруудын сургалт нь офицеруудад жагсаалд оролцогчдын үндсэн хуулиар олгогдсон эрхийг ойлгуулах ёстой. Олон нийтийн цугларах эрхийг цаг хугацаа, газар, хэв маягийн хязгаарлалтад үндэслэн хязгаарлаж болох боловч Офицеруудыг Нэгдүгээр нэмэлт өөрчлөлтөөр олон нийтийн гишүүдийн эрхийг хамгаалахад ямар үүрэг гүйцэтгэж байгааг ойлгоход сургах хэрэгтэй. Олон нийтийн цугларалтыг хамгаалах үүргээ ойлгосноор офицерууд жагсаал цуглаанд оролцогчидтой илүү үр дүнтэй харилцаж, олон нийтийн хууль сахиулах байгууллагад итгэх итгэлийг дээшлүүлж чадна.
- *Хууль сахиулагчдын сургалтад хурцадмал байдлыг бууруулахын ач холбогдлыг онцлон тэмдэглэ.* Олон хүний сэтгэлзүйн талаарх ойлголттой зэрэгцэн сургалт нь олон нийтийн жагсаалын хүрээнд нөхцөл байдлыг бууруулах, харилцаа холбооны тактикийн ач холбогдлыг онцлох ёстой. Төрийн болон орон нутгийн хууль сахиулах байгууллагуудын ажилтнууд харилцааг тайван, мэргэжлийн түвшинд зохицуулах чадвартай байх нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарлаа төвлөрүүлснээр жагсаал бослого болохоос сэргийлж чадна.

- *Эсэргүүцлийн жагсаал цуглааны үеэр эсвэл ойролцоо шинжилгээнд хамрагдах боломжийг өргөжүүлэх.* Олон нийтийн цугларалтад өртөх магадлалтай эсвэл бодит эрсдэлтэй байсан ч гэсэн хүмүүс цар тахлын үеэр эсэргүүцлийн жагсаалд оролцсон. Засаг даргын тамгын газрууд эсэргүүцлийн жагсаал цуглааны үеэр эсвэл ойролцоох тестийн хүртээмжийг нэмэгдүүлэх, эсэргүүцэгчдийг шинжилгээнд хамруулах замаар орон нутгийг дэмжихэд туслах болно.
- *Эсэргүүцэгчдэд зориулсан туршилтыг эрэмбэлж, тестийг хэн авах ёстой, хэзээ тохиромжтой болох талаар олон нийтэд тууштай мессеж хүргэх.*
- *Хүрээлэнгийн хамт олон, эмийн бус үйл ажиллагаа (NPIs).* Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр чиглэсэн, хурдан хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд нь COVID-19-ийн тархалтаас урьдчилан сэргийлэх, багасгах, эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн тасалдлыг бууруулах боломжтой юм. Төрийн удирдагчид ямар NPI-ийг байрлуулахаа шийдэхдээ хариу арга хэмжээ авахдаа хувийн, олон нийтийн болон хүрээлэн буй орчны цогц арга хэмжээг багтаасан байх ёстой. Бусад анхаарах зүйлс нь нийгмийн болон соёлын хүчин зүйлүүд, тухайлбал NPI-ийг хүлээн зөвшөөрөх, COVID-19-тэй холбоотой мэдлэг, хандлага, дадлыг ойлгох зэрэг орно. Өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх төвүүд NPI-тэй холбоотой COVID-19 зөвлөмж, зааврыг гаргасан бөгөөд практикт хэрэгжүүлснээр COVID-19-ийн тархалтыг бууруулах, бууруулах боломжтой юм. Жишээлбэл, тэд эндээс маск зүүх талаар зөвлөмж, анхааруулга гаргажээ.
- *Гар угаах цэгийн хүртээмж, гар ариутгагч бодис түгээх ажлыг нэмэгдүүлэх;*
- *Газар дээр нь халдварт өвчний тандалт хийх, /эсвэл шинжилгээ хийх/*
- *Бөөнөөр цугларах орон зайг нэмэгдүүлэх нь оролцогчдын хоорондын холбоог хязгаарлах*
- *Оролцогчид болон хууль сахиулагчдад маск, бээлий, бусад ХХХ-ээр хангах* (гал сөнөөгчид, эрүүл мэндийн ажилтнууд гэх мэт төвийг сахисан талуудыг ашиглах, болзошгүй зөрчилдөөнөөс зайлсхийхийн тулд материал тараах)
- *Ард иргэдийг вакцинжуулалтад хамруулах*

Монгол улсын хэмжээнд цар тахал Covid-19 өвчний өнөөгийн байдал, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийгдэж буй арга хэмжээ, түүний үр дүн:



Монгол улсын хувьд COVID 19 коронавирусууд урьдчилан сэргийлэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь үндсэндээ 3 үе шаттай явагдаж байна.

1. COVID 19 коронавирусууд урьдчилан сэргийлэх, гаднаас зөөвөрлөгдөн орж ирэх эрсдэлийг бууруулахад чиглэсэн Улсын Онцгой комиссын шийдвэрт үндэслэсэн арга хэмжээ
2. COVID 19 коронавирусууд урьдчилан сэргийлэх, дотоодод алдагдсан халдварыг хумих, цар хүрээг нэмэгдүүлэхгүй байхад чиглэсэн Улсын Онцгой комиссын шийдвэрт үндэслэсэн арга хэмжээ
3. COVID 19 коронавирусууд эсрэг вакцинжуулалтын ажлыг эрчимтэй зохион байгуулах, иргэдийг идэвхтэй хамрагдахад чиглэсэн Улсын Онцгой комиссын шийдвэрт үндэслэсэн арга хэмжээ

2020.11.10-нд Улсын Онцгой комисс хуралдан дотооддоо алдсан гэх албан ёсны мэдээллийг өгснөөр 2-р үе шат буюу COVID 19 коронавирусууд урьдчилан сэргийлэх, дотоодод алдагдсан халдварыг хумих, цар хүрээг нэмэгдүүлэхгүй байхад чиглэсэн Улсын онцгой комисс, Цагдаагийн Ерөнхий газар болон

хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагууд, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн яамны харьяа Эрүүл мэндийн төв байгууллагууд, Нийслэлийн Онцгой байдлын газар, Хэвлэл мэлээллийн газрууд хамтран олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажлыг өөрсдийн чиг үүргийн дагуу үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж эхэлсэн.

Үүнд:

- Улсын онцгой комисс – 25 гишүүн
- Цагдаагийн Ерөнхий газар болон хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагууд – 5000 алба хаагчид
- Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар – 700
- Эрүүл мэндийн яамны харьяа Эрүүл мэндийн төв байгууллагууд -2500 орчим алба хаагчид тус тус ажиллаж байна.

COVID 19 коронавирус халдварт өвчин гарсан бүс, нутаг дэвсгэрт хорио цээрийн бүс байгуулж, дэглэм тогтооход оролцох цагдаагийн байгууллага, алба хаагчид

- Ажиглалт хийх
- Шалгалт хийх
- Хязгаарлалт, хориг тавих
- Мэдээлэл цуглуулах
- Хүн, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих
- Техник хэрэгсэл ашиглан хяналт тавих зэргээр чиг үүргийнхээ дагуу үйл ажиллагааны төлөвлөгөө гарган мөрдөж ажиллаж байна.

Мөн COVID 19 коронавирус халдварт өвчин гарч, хорио цээрийн дэглэм тогтоосон бүсэд цагдаагийн байгууллага нь:

- Хөдөлгөөнт болон явган эргүүлийг зохион байгуулах
- Хэв журмын харуул ажиллуулах
- Шалган нэвтрүүлэх цэгээр орох, гарах хөдөлгөөнд хяналт шалгалт хийх
- Голомтын төв цэгт хорио цээрийн хамгаалалт зохион байгуулах
- Бичиг баримт шалгах
- Хүний бие, тээврийн хэрэгсэл, эд зүйл, ачаа тээшинд үзлэг хийх
- Сэжиг бүхий эд зүйлийг түр хураан авах
- Хорио цээрийн дэглэм зөрчсөн үйлийг илрүүлж, эрх бүхий албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлэх гэх мэт үйл ажлыг 24 цагийн турш бие бүрэлдэхүүнийг хүртээмжтэй, хариуцлагатай хуваарилан иргэдийн дунд хорио цээрийн дэглэмийг сахиулахад анхааран ажиллаж байна.

Дараах зөвлөмжүүдийг гаргаж аж ахуйн нэгж байгууллага, ард иргэдэд чандлан сахихыг анхааруулж байна.

- Ажилтанд ханиад, томууны шинж тэмдэг илрэх тохиолдолд эмнэлэгт хандах, ажлын байранд ирэхгүй байхыг зөвлөх
- Бүх сайт, кэмп болон оффисын орчинд нэмэлт цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх
- Ажлын уян хатан зохицуулалт хийх, чухал ажил үүргийг ээлжээр гүйцэтгэх, мэдээлэл технологийн хэрэглээг нэмэгдүүлэх зэргээр биечлэн байлцах хурал, уулзалтуудыг багасгах
- Оффисын ажилтнуудыг гэрээсээ ажиллах боломжоор хангах
- Оффис болон сайтад зайлшгүй шалтгаанаас бусад тохиолдолд зочид, харилцагчдыг хүлээж авахгүй байх

- Ажлын өдөр, үдийн цайны цаг эхлэх дуусах цагийг уян хатан болгох
- Ажилчдад үйлчлэх автобусны тоог зайнаас харьцах, зайтай зорчих шаардлагад нийцүүлэн нэмэх
- Үйл ажиллагааны багт хамаарахгүй ажилтнуудын гадаад, дотоод томилолтыг дараагийн мэдэгдэл ирүүлэх хүртэл түр хориглох
- Хоолыг авч явахад зориулсан савлагаатай болгох
- Ард иргэдийг вакцинжуулалтад идэвхтэй хамруулах

Дүгнэлт. Нийгэм бүхэлдээ хувьсан өөрчлөгдөж улс орон эрчимтэй хөгжиж байгаа өнөөгийн нийгэмд хүн төрөлхтний соёл, зан заншил, ёс суртахуун нь даган хөгжиж амар амгалан тайван, эрүүл орчинд ажиллаж амьдрах хүсэл сонирхол илүү болсон боловч тэр бүр энэ нь биелэгдэхэд хэцүү цаг үе болоод байна. Энэ нь сайны хажуугаар саар гэхтэй адил зүйл юм. Улс эх орон хөгжихийн хэрээр баян хоосны ялгаа ихсэж, хувь хүний аливаа зүйлд хандах хандлага хоорондоо харилцан адилгүй болсноор сэтгэл сэрдхийлгэм аюул заналт осол, гэмт хэрэг, олныг айдаст автуулам үйл явдал хэргүүд ихсэх хандлагатай болсон. Мөн хүн төрөлхтний эдэлж хэрэглэж буй эд хогшил, амьдарч буй орчин нөхцөл, идэж хоол хүнснээс шалтгаалан олон нийтийн дундах өвчлөл болон өвчний төрөл зүйл төсөөлөхийн аргагүй ихэссэн.

Дэлхий нийтэд Ковид-19 буюу цар тахлын халдвар, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбоотойгоор нэн түрүүнд амьд явах эрх, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрхийг хөндсөн юм. Үүний зэрэгцээ хүний бусад эрх, эрх чөлөөгөө хамгаалуулах, гадны улс оронд байгаа иргэд тухайн улсын иргэдийн адил эрх үүрэг эдэлнэ гэдэг хүний эрхийн олон төрөл хэлбэрийг хөндөж, хөдөлмөрлөх, сурч боловсрох, шилжин суурьших, аж ахуй эрхлэх зэрэг эрх зөрчигдсөн асуудал гарсаар байна. Аль хэдийн 222 орны 156,365,369 орчим хүнд халдварлаж, нас баралтын тохиолдол 3,262,856 гаруйд хүрээд буй COVID-19 цар тахал нь эдийн засаг, хөдөлмөрийн зах зээлийг цочроогоод зогсохгүй зөвхөн нийлүүлэлт (бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээ) төдийгүй эрэлтэд (хэрэглээ, хөрөнгө оруулалтад) нөлөөлж байна.

**УЛСЫН ОНЦ ЧУХАЛ ОБЪЕКТЫН ХАМГААЛАЛТЫН
ИНЖЕНЕРИЙН БАЙГУУЛАМЖЫН ТӨХӨӨРӨМЖЛӨЛТ, ТҮҮНИЙГ
САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ**

Э.Рэгдэндагва

Цагдаагийн сургуулийн Дотоодын цэргийн албаны
тэнхимийн ахлах багш, цагдаагийн дэд хурандаа

Товч агуулга: Улсын онц чухал объектыг хамгаалах тогтолцооны нэг томоохон бүрэлдэхүүн нь инженер байгууламж, хамгаалалтын техникийн хэрэгсэл бөгөөд бага хүчээр харьцангуй том нутаг дэвсгэр, объектыг хамгаалдаг төрийн тусгай чиг үүргийн байгууллагуудын хувьд цаашид ихээхэн ач холбогдол өгч мэргэжлийн болон бусад байгууллагын хамтын хүчээр шийдвэрлэх, эрх зүйн зохицуулалт бий болгох шаардлагатай асуудал болоод байна.

Түлхүүр үгс: Улсын онц чухал объект, хамгаалалтын инженер байгууламж, хамгаалалтын техникийн хэрэгсэл, хамгаалалт

Үндсэн хэсэг. Манай улсын хэмжээнд улсын онц чухал объектын хориглон хамгаалалтын асуудлыг ихэвчлэн тухайн объектыг хамгаалахаар томилогдсон хүч болон объектын хашаа түүнийг ашиглан хийсэн тор, мөр хянах зурвас, анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ, автомашины хурд сааруулах зориулалттай хийцлэл, хаалга, автомат хаалт, төрөл бүрийн дохиолол, камерын хяналтын төхөөрөмжөөр ихэвчлэн шийдвэрлэж ирсэн.

Аливаа барилга байгууламжийн аюулгүй байдлыг хамгаалах асуудал нь:

1. Хамгаалалтын бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа;
2. Хамгаалалтын ажиллагаа, сөрөг хяналт /зарим улс оронд тагнуулын ажиллагаа ч гэж нэрлэдэг/;
3. Биет хамгаалалт /бие бүрэлдэхүүн, хашаа, хаалт гэх мэт/;
4. Хамгаалалтын тоног төхөөрөмж, систем;
5. Кибер аюулгүй байдал гэх хэсгүүдэд хуваагддаг бөгөөд энэ илтгэлийг зөвхөн улсын онц чухал объектын хамгаалалты инженерийн байгууламжын төхөөрөмжлөлт зарим асуудлыг хөндөн бэлтгэлээ.

Техник технологийн хөгжил өндөр хурдтай явагдаж байгаа өнөө үед энэ байдлаар улсын онц чухал объектын хориглон хамгаалалтын үйл ажиллагааг “...хамгаалалт, аюулгүй байдлыг уян хатан, шуурхай тасралтгүй зохион байгуулах...”¹⁹⁰ боломж цаашид улам бүр хязгаарлагдана гэдгийг бүх шатандаа хүлээн зөвшөөрч, хамтран ажиллах шаардлагатай болоод байна. Тухайлбал: Анх төлөвлөхдөө суурьшлын бүсээс харьцангуй зайтай төлөвлөж барьсан объектууд суурьшлын бүстэй хиллэх болсон, биет байсан мэдээллүүд цахим хэлбэрт шилжсэн, нисгэгчгүй нисэх төхөөрөмжийг дуртай газраасаа олж авах, дуртай хэлбэрээрээ ашиглах боломжтой болсон гэх мэт бидний өмнө сорилт болж байгаа олон асуудал тулгарч байна.

“Улсын онц чухал объектын хамгаалалтад тавих шаардлага” гэх **CS 11-0129 :2010** стандартад “- Хүн хүчийг хэмнэх, объектын хамгаалалтын найдвартай байдлыг хангах, зөрчил гарч болзошгүй чиглэлд нягтралыг нэмэгдүүлэх зорилгоор хамгаалалтын инженер, техникийн хэрэгслийг ашиглана.


Хамгаалалтын инженер-техникийн хэрэгсэл гэдэгт хориотой бүс, мөр хянах зурвас, торон саад, хаалт, хашаа, гэрэлтүүлэг, инженерийн байгууламж, дохиоллын болон хяналтын хэрэгслүүд хамаарна.”¹⁹¹ гэж заажээ.

Хамгаалалтын инженер, техникийн хэрэгслийг идэвхитэй болон идэвхигүй гэж ангилан үздэг бөгөөд идэвхитэй хэрэгсэлд механик болон бусад байдлаар хөдөлгөөн хийх замаар хориглох үүрэгтэй

¹⁹⁰ Дотоодын цэргийн тухай хуулийн 3 дугаар зүйл

¹⁹¹ **CS 11-0129 : 2010** стандарт

хэрэгслийг ойлгодог бол идэвхигүй хэрэгсэлд өөрийн хийц, төлөвлөлтийн байдлаараа хориглолтын бүрэлдэхүүн болдог хашаа, хаалт, шуудуу, бусад байгууламжийг ойлгодог.



Улсын онц чухал объектын хамгаалалтын найдвартай байдлыг дээшлүүлэхэд ашиглаж болох олон арга, төрлүүдээс Америкийн Нэгдсэн Улсын туршлагад тулгуурлан зарим зүйлсэд та бүхний анхаарлыг хандуулж байна.

Дээрх асуудал дэлхий дахинд терроризмийн аюул занал бодитойгоор тулгарсан 2000 оны эхнээс томоохон улс орнуудад анхаарал татсан асуудал болсон бөгөөд улс орны аюулгүй байдалд ач холбогдол бүхий барилга байгууламжид тэсрэх бодис бүхий тээврийн хэрэгслээр халдахаас сэргийлэх зорилгоор судлагдаж эхэлсэн байна.

Америкийн Нэгдсэн Улсын Үндэсний нийслэлийн төлөвлөлтийн комисс /NCPC/ нь хамгаалалтын загвар дизайны асуудлыг анх 2001 оны 3 сараас эхлэн шийдвэрлэж ирсэн. Аюулгүй байдлыг зохицуулах ажлын хэсгээр дамжуулан NCPC нь 2001 оны 10-р сард “*Үндэсний Нийслэлд зориулсан хамгаалалтын загвар дизайн*” гэх тайлан гаргажээ. Уг тайланд Вашингтон хотын өнгө үзэмжийг сайжруулах, олон нийтийн талбайг хүртээмжтэй болгох зэрэг төлөвлөлтийн стратегийг тусгасан байна. Энэ тайлангийн гол зөвлөмжүүдийн нэг бол хамгаалалтын шийдлүүдийг өнгө үзэмж сайтайгаар зохион бүтээх талаар дэлгэрэнгүй төлөвлөгөөг холбооны агентлагуудад санал болгосон байна.

Энэ ажлыг хэрэгжүүлэхдээ 2000 оны 1-р сард холбооны болон орон нутгийн төлөөлөл бүхий 75 гаруй байгууллага, иргэний болон бизнесийн бүлгүүд, мэргэжлийн дизайны нийгэмлэг, олон нийтийн байгууллагуудыг хамруулсан бөгөөд “*Үндэсний нийслэлийн загвар дизайн ба хамгаалалтын төлөвлөгөө*”-г 2002 оны 10 дугаар сард анх гаргасан байна.

Уг төлөвлөгөө нь нийслэлийн хот төлөвлөлтийн орон зайг хадгалж, тэсрэх бөмбөг ачсан тээврийн хэрэгслийн эсрэг арга хэмжээ авах зорилгоор үзэмж сайтай тоноглол болон гаднах орчны үзэмжийг хадгалах өргөн сонголттой шийдлүүдийг санал болгосон байдаг. Зураг төслийн хүрээнд Вашингтон хотын хөшөө дурсгалын цөм болсон газрын өвөрмөц шинж чанарыг хадгалах хамгаалалтын шийдлүүдийг тусгасан байдаг.

Уг төлөвлөгөө нь зөвхөн Вашингтон хотын хамгаалалтын шийдлүүдэд анхаарлаа хандуулсан хэдий ч тухайн орчинд зохицсон дизайны зарчмуудыг Монгол Улсын төрийн тусгай хамгаалалттай болон улсын онц чухал объектод хэрэгжүүлэх боломжтой юм.

Энгийн хүн нь хотын төв хэсэгт байрладаг объектын периметрийн хамгаалалтын идэвхигүй хэлбэрийн арга хэмжээг авахдаа хотын өнгө төрх, орон зай, түүх соёл, хэлбэр дизайныг харгалзан үзэж үр дүнтэй төлөвлөсөн орчин дахь сандал, гэрлийн шон, ундны усан оргилуур зэрэг хамгаалалтын хийцлэлүүдийг аюулгүй байдлын үүднээс хийгдсэн хамгаалалтын саад гэж авч үздэггүй, өөрөөр хэлбэл хамгаалалтын найдвартай байдлыг бууруулахгүйгээр хэт нүсэр, хориотой, айдас төрүүлсэн өргөст тор

бүхий хашаанаас огт өөр сэтгэгдэл төрүүлж, иргэд, объектод ажиллагсадад төрдөг сөрөг ойлголтыг үгүй болгох боломж бий болгодог давуу талтай.¹⁹²

Периметрийн идэвхигүй хамгаалалтын хийцлэлүүдийн байршил, загвар дизайны нийцлийг нарийвчилсан зураг, төлөвлөлтөөр хангахаас гадна хамгаалалтад байгаа объектын эрсдэл, ач холбогдлоос шалтгаалан хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд тухайн объектын эрсдэл, байрлаж байгаа байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаа, дотоод дэг журмын талаар хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ (тандалт, шинжилгээ хийх гэх мэт аргаар)-ний мэдээллийг авч үзэхээс гадна загвар дизайны стратеги (байгууламжийн архитектурын шийдэл, барилгын бүтээц, барилга, байгууламжид хамаарах талбай, түүний дэд бүтэц, эмзэг хэсгүүдтэй уялдуулан цонхны шил, периметрийн биет саадыг хэрхэн байрлуулах, ямар хэлбэр, материалаар хийх гэх мэт) зэргийг бодолцож үзэх хэрэгтэй.

Зохимжтой загвар дизайн, инженерчлэлийн тусламжтайгаар тээврийн хэрэгслийг зогсоох саадыг бий болгохын тулд төрөл бүрийн үзэмж сайтай элементүүд болон газар орны онцлогийг өргөнөөр ашигладаг. Ийм хийцлэлүүд нь явган зорчигч болон унадаг дугуйнд нэвтрэх боломжийг олгож, тэдэнд нээлттэй байдлын мэдрэмжийг төрүүлдэг.

Хамгаалалтын арга хэмжээнүүдийг төлөвлөх үед хүрээлэн буй орчны нөхцөл байдлыг авч үзэх нь зайлшгүй чухал юм. Ландшафтын архитекторууд, архитекторчид, хотын дизайнерууд зураг төсөл боловсруулах явцад тухайн барилга, байгууламж, гудамж талбайн аюулгүй байдал талаас хэрэгцээг хангаж байгаа талаар бодолцож үзэх шаардлагатай бөгөөд идэвхигүй хэлбэрийн инженер, техникийн хэрэгслийн шийдэл нь гудамжны үзэмжийг сайжруулахаас гадна тээврийн хэрэгслийн саад хаалтыг давхар гүйцэтгэдэг.

Барилга болон периметрийн хамгаалалтын загвар дизайныг гаргахдаа барилгын зураг төсөл ба байршлын хүчин зүйлсийг зайлшгүй бодолцох хэрэгтэй. Байшин барих суурь, замын зураг төсөл, ландшафт зэрэг нь периметрийн аюулгүй байдалд маш чухал юм. Эдгээр асуудлууд нь барилгын периметрт багтсан аюулгүй байдлын хамгаалалтын түвшинг тодорхойлж өгөх гол үүргийг гүйцэтгэдэг. Жишээ нь: задгай талбай ба гудамжны байршил, хэлбэр нь периметрийн хамгаалалтын элементүүдийн хэрэгцээ бага бөгөөд шаардагдах түвшин ч доогуур байна. Шаардагдах түвшин доогуур байх үед загвар дизайн уян хатан байх боломж бүрддэг. Загвар зохион бүтээгчид нь периметрийн хамгаалалтын төлөвлөгөөг амжилттай хийхийн тулд байршлын онцлог давуу талыг харгалзаж үзэх хэрэгтэй.

Барилгын зураг төсөлд барилга, байгууламжийн өнцөг болон гудамжны хоорондох зайг харгалзан тээврийн хэрэгсэл нэвтрэх боломжтой зөвшөөрөгдөх хэмжээг тодорхойлдог. Тээврийн хэрэгсэл нэвтрэх боломжтой зөвшөөрөгдөх зай (саад ба хамгаалагдсан барилга хоорондын зай) бол маш чухал үзүүлэлт бөгөөд хангалттай зайтай байх тусам том хэмжээний, үнэтэй тусах хамгаалалтын арга хэмжээнээс татгалзаж, шаардагдах түвшинээс доогуур хамгаалалтын элементүүдийг ашиглах боломж олгодог бөгөөд хамгаалалтын хэд хэдэн бүс төлөвлөх боломжтой бол тээврийн хэрэгсэл нэвтрэх боломжтой зөвшөөрөгдөх зай бага байх тохиолдолд гүйцэтгэлийн өндөр стандарт, бүтээлч оновчтой загвар дизайн шаардах шаардлагатай болдог.

Хамгаалалттай объектыг орчны автозамын аюулгүй байдалд нөлөөлөх эрсдлийн нарийвчилсан үнэлгээг хийхдээ төлөвлөсөн болон одоо байгаа хамгаалалтын саадыг тээврийн хэрэгсэлд ашиглан давах хамгийн их хурдыг тооцоолох хэрэгтэй. Барилга чиглэсэн шулуун замаар зорчих тээврийн хэрэгслийн хурд маш өндөр байдаг тул бат бөхийн хувьд маш өндөр түвшний хамгаалалтын саадыг байрлуулах шаардлагатай. Харин эсрэгээр нь давчуу муруй зам, нарийн гудамж, замын түгжрэл, огцом эргэлт зэрэг нь аюулгүй байдлыг хамгаалахад зайлшгүй шаардагдах хийцлэлд тавигдах шаардлага, бат бөхийн түвшинг бууруулдаг тул барилга байгууламжийн орц, гарцыг төлөвлөхдөө тооцоолох шаардлагатай юм. Өөрөөр хэлбэл хамгаалалттай объектын орц, гарц нь тээврийн хэрэгсэл шулуунаар өндөр хурдтай ирэх боломжийг хязгаарласан байдлаар төлөвлөх нь зүйтэй.

¹⁹² Төрийн тусгай хамгаалалтын тухай... 331 хуудас

Тээврийн хэрэгслийг саатуулах идэвхигүй хаалтыг гоёлын тохижуулалттай хослуулснаар дээрх элементүүдийг хялбархан бэхжүүлж болно. Сонин борлуулах цэг, автобусны зогсоол, гэрлийн шонгийн дэргэд хамгаалалтын шонг давхар суурилуулан хослуулснаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хорьж болно. Түүнчлэн унадаг дугуйны зогсоол, сандал, ундны усан оргилуур нь периметрийн хамгаалалтын найдвартай элементүүдэд тооцогдоно.

Зарим тохиолдолд хамгийн сайн шийдэл бол хотын гудамж талбайтай уялдуулан сайтар тохижуулах явдал юм. Вандан сандал, автобусны буудал, сонин борлуулах цэг гэх мэт цөөн хэдэн элементийг сайтар зохиомжлон байрлуулахад тээврийн хэрэгслийн саад болж чаддаг. Түүнчлэн хамгаалалтын элементэд тооцогдох замын хашлага, хайс, зам дагуух таримал ургамалыг хүрээлэн буй орчны архитектурын дагуу тохируулан өөрчлөж болдог.

Вашингтон хотын хувьд нэгэнт хот тохижилтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн загвар дизайн, бат бөхийн туршилтын ажлууд хийгдэж дууссан хойно зохион бүтээгчид дээрх хэсгүүдээс сонголт хийн хамгаалалтын цогц саадыг багтаасан төлөвлөгөөг зохиодог байна.

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлахад ашигладаг зарим идэвхигүй хамгаалалтын хийцлэлийг дурьдвал:

1. Хана, барилгын гадна талбай, тусгай саванд /хайрцагласан газар/ тарьсан ургамал:
 - Хана нь тээврийн хэрэгслийг барилгад ойртохоос хамгаалж өгдөг бөгөөд объектын хамгаалалтын бүсийн хязгаараар барилгыг тойруулан явган хүний замын хажуугаар байрлуулна.
 - Барилгын гадна талбай нь тэгш болон шаталсан хэлбэртэй, хатуу хучилттай байж болно.
 - Хайрцагласан ургамал нь ихэвчлэн барилгын нэг давхрын өргөтгөл хэсэг болдог бөгөөд барилгын гаднах талбайд байрлана.
2. Намхан хана /өвдгөөр татсан/, хашаа, хайс:
 - Барилга архитектурын нэг хэсэг болж өгдөг намхан ханыг цэцэрлэг болон таримал ургамалтай хослуулж өгдөг.
 - Аюулгүй байдлын шаардлагыг хангахын тулд гоёл чимэглэлийн төмөр хашаа хайсыг нэмж хийдэг.

3. Хамгаалалтын шон:
 - Замын хашлагын дагуух хамгаалалтын шон нь тээврийн хэрэгслийн дайралтаас хамгаалах зорилготой. Гоёмсог загвар хийцтэй, зөв байрлуулсан хамгаалалтын шон нь явган хүний замын эргэлтийг чиглүүлэх, объектод ойртох хязгаарыг зааж өгөх, гудамжны үзэмжийг сайжруулах зэрэг олон ач холбогдолтой. /зургийг хавсаргав/

Периметрийн хамгаалалтын идэвхигүй саадыг хийхэд ашигладаг нийтлэг дөрвөн материал байдаг. Үүнд:

- төмөр, цутгамал төмөр;
- сайжруулсан бетон;
- байгалийн чулуу багтдаг.¹⁹³

Материал бүрийн давуу, сул талыг харгалзан аюулгүй байдлын шийдлийн онцлогт тохируулан загвар гаргах шаардлагатай. Төмөр болон ширэм нь бусад материалыг бодвол суурилуулахад хялбар бөгөөд аливаа хэлбэр дизайн сайтай болж чаддаг. Төмөр болон ширэм нь бетон материалыг бодвол илүү бат бөх шинж чанартай. Төмөр саад, хашаа нь бусад материалыг бодвол тогтмол будах зэргээр арчилгаа тордолгоо их шаарддаг.

Сайжруулсан бетон саадыг суурилуулахад хүний хүч болон цаг хугацаа нэлээд зарцуулагдах боловч арчилгаа бага шаардагдахын дээр төмөр, ширмийг бодвол илүү бага зардалтай байдаг. Учир нь бетонон барилга нь хотод элбэг бөгөөд хүрээлэн буй орчинтойгоо илүү сайн нийцдэг.

¹⁹³ Төрийн тусгай хамгаалалтын тухай... 332 хуудас

Боржин болон бусад чулуугаар хийгдсэн хамгаалалтын элементүүд нь бусад төмөр, бетоноор хийгдсэн элементүүдээс илүү овор ихтэй бөгөөд тэдгээрийг хэлбэрт оруулахгүйгээр газарт суурилуулах эсвэл хэлбэрт оруулан сандал маягаар ашиглаж болно. Боржин чулуу нь барилга байгууламжийн архитектурт маш сайн нийцдэг бөгөөд маш бат бөх, удаан хугацаагаар ашиглах боломжтой, өнгө үзэмжтэй материал юм.

Периметрийн хамгаалалтын идэвхигүй хийцлэлийн нэг төрөл шуудуу болон овоолго бөгөөд тээврийн хэрэгслийг зогсоох бусад элементүүдийн адил маш чухал арга юм. Объектын нөхцөл байдал, газрын гадаргаас хамааран тохирох хамгаалалтын шуудуу, овоолгын хэлбэрийг сонгох нь чухал юм. Тодорхой хурд, жинтэй тээврийн хэрэгслийг зогсоохын тулд хамгаалалтын шуудуу, овоолго нь хангалттай бат бэх хийцлэлтэй байх ёстой.

Газар доор байрлах цахилгааны, утасны кабель, бусад шугам сүлжээ, хөрсний нөхцөл байдал нь ямар төрлийн шуудууг байрлуулах шийдвэрт нөлөө үзүүлнэ. Эдгээр нөхцөл байдлыг тогтоосны дараагаар үндсэн гурван төрлийн шуудууг сонгож болно.

Нью-Йорк хотод нийтийн эзэмшлийн талбайн хамгаалалтын идэвхигүй хэлбэрийн нэгэн шийдлийг иргэдэд хамгаалалтын байгууламж гэж мэдэгдэхгүй байхаар бүтээлчээр хийжээ. Уг шийдлийг *Tiger Trap* /Барын урхи/ систем гэж нэрлэдэг бөгөөд барилга байгууламжийн периметрийн хамгаалалтын хязгаараар газрын түвшинд байхаар тооцож бүтээжээ. Дээрх систем нь ердийн дугуй болон явган хүний зам байдлаар автозамын хажууд хийгдсэн бөгөөд дугуй гэх мэт хөнгөн тээврийн хэрэгслийг хангалттай даах чадвартай юм. Харин түүний гадаргуу дээр тээврийн хэрэгсэл нэвтэрсэн тохиолдолд уг материал нь доош нурж /эсвэл ус нь гадагшилж/, хөдөлгөөнийг нь зогсоодог. Уг шийдэл нь олон нийтийн газар явган хүний хөдөлгөөнийг зохицуулах боловч зөвшөөрөлгүй тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг шууд зогсоох чадвартай. *Tiger Trap* системийг АНУ-ын Инженерийн армийн корпуст туршин үзэхэд 50 км/цагт хурдтай 6.2 тонн жинтэй ачааны машиныг амжилттай зогсоож байсан байна.

Энэ төрлийн дүн шинжилгээ нь объектын эргэн тойронд тээврийн хэрэгслийн аюул учруулж болох боломжит өнцөг болон хурдыг тооцоолох юм. Халдлага гарах нөхцөлд хамгийн муу хувилбар гаргаж болох чанх урд болон перпендикуляр талын хамгаалалтын саадыг тооцоох явдал билээ. Ихэнх тохиолдолд тээврийн хэрэгсэл нь барилгын чанх урдаас бус харин өнцөгдөж чиглэх явдал байдаг. Ийм чиглэлээр ирж буй тээврийн хэрэгсэл нь хэд хэдэн метал, бетон багана, гудамжны хашлага болон бусад саадыг цохисноор хурд удааширч саадыг устгах эрчийг бууруулж өгдөг. Үүнийг харгалзан үзэж, зохион бүтээгчид шаардлагагүй олон элемент болох метал, бетон нүсэр том багана, таримал ургамал гэх зэргийг хэтрүүлэн хийх албагүй. Объектын агуулга, хамгаалалтын шаардагдах түвшинг мэдсэнээр мөнгө хэмнэж, гудамжны гоо зүйн талаас үзэмжтэй хийх хэрэгтэй.

Эцэст нь хамгаалалтын идэвхитэй хэлбэрийн талаар цоон асуудлыг хөндөж байна. Улсын хэмжээнд хувийн болон төрийн байгууллагын аль ч салбарт хамгаалалтын гэх автомат хаалтыг түгээмэл ашиглаж байгаад улсын онц чухал объектын аюулгүй байдлыг хамгаалах ёстой байгууллагууд зүй ёсны анхаарлаа хандуулах нь зүйтэй.

Хамгаалалтын гэх энэ хаалт, хөнгөн гүйдэг хаалгууд олон газар тэр дотроо улсын онц чухал объектын хамгаалалтад ч ашиглагдаг. Энэ бол хамгаалалт биш, замын цагдаагийн автомат дохиур гэдэгтэй санал нийлэх байх.

Периметрийн хамгаалалтын идэвхитэй хэлбэрийн нэг болох автомат хаалт, хаалгыг цохилт, мөргөлтөд тэсвэртэй материал, хийцлэлээр хийх шаардлагатай бөгөөд холбогдох бат бөхийн тушилт тооцоололтойгоор өөрийн эх оронд үйлдвэрлүүлэн хэрэглэх бүрэн боломжтой байгаа юм.

Автомат хаалтын бас нэг төрөл бол газрын түвшинтэй адил түвшинд суулгах зориулалттай хаалт юм. Энэ нь хаалт бүхэлдээ дээш болох замаар хаалт тавьдаг болон автомашины дугуй хагалах замаар хөдөлгөөнийг хязгаарладаг гэсэн хэлбэртэйгээр ашиглагдаж байна. Эдгээртэй уялдуулан автомашины доод хэсэгт үзлэг хийх зориулалттай бодит камерын хяналтыг ч суурилуулан ашиглах боломжтой.

Бид олон жил хамгаалалтын цэгийн ажиглалтаар хяналтыг явуулж ирсэн бөгөөд одоо ч явуулж байна. Сүүлийн жилүүдэд хэт ягаан туяаны, дулааны, ердийн гээд олон төрлийн камераар хяналтын нягтралыг нэмэгдүүлсэн боловч техникийн гэмтэл, улирал, цаг агаар, гэрэлтүүлэг гээд олон шалтгаанаар хяналтыг бүрэн явуулах асуудал тулгамдаж байна. Дэлхий олон орон энэ асуудлаа радарын хяналтыг хяналтын камертай хослуулах замаар шийдвэрлэж байна. Би энд Blighter радарын системийг онцолж байгаа юм. Энэ төхөөрөмж нь хөдөлж буй тээврийн хэрэгсэл болон хүн (мөлхөж буй биет)–ийг 8 км радиуст хайж илрүүлэх чадвартай. Радар өөрийн дэлгэцэнд илрүүлсэн байг автоматаар камеруудад мэдээлж, дулаан мэдрэгч бүхий камер нь байг таньж, тодорхойлон утсан болон утасгүй TCP/IP сүлжээгээр хамгаалалтад харуулдаг. Энэ системийн давуу тал нь зөрчигчийн байршлын үнэн зөв мэдээлэл /байны координат, хүрээ, хөдөлгөөний чиглэл/-ийг тодорхойлон гаргадаг. Үүнийг хамгаалалтад ашиглаж эхлэснээр хамгаалалтын цэгийн тоог багасгах замаар хөдөлгөөнт бүлэг байгуулан хамгаалалтын найдвартай байдлыг дээшлүүлэх боломжтой.

Дүгнэлт

Улсын онц чухал объектын хамгаалалтыг боловсронгуй болгох, миний энэ нийтлэлд дурьдсан дэвшилтэт аргуудыг ашиглах боломж аль нэг байгууллага, салбарын дангаар хийж хэрэгжүүлэх ажил биш гэдэг нь ойлгомжтой.


Энд хамгаалалтын чиг үүрэг хэрэгжүүлж байгаа байгууллагаас баримтлах бодлого, төлөвлөлтөөс гадна нийслэл, орон нутгийн төлөвлөлтийн байгууллага, нэг, барилга, барилгын материалын судлаач, үйлдвэрлэгчид, автоматжуулалтын мэргэжилтнүүд, хамгаалуулагч байгууллагын хамтын ажиллагаа, мэргэжлийн хэмжээнд хийгдсэн тандалт, судалгаа, дүн шинжилгээ шаардлагатай болно. Түүнчлэн эдгээрийг зэвсэгт хүчний объектууд, улсын хилийн хамгаалалт, төрийн тусгай хамгаалалт, улсын онц чухал объектын хамгаалалтад нийтлэг байдлаар хэрэгжүүлэхэд нэгдсэн зохион байгуулалт, бодлого, төлөвлөлт зайлшгүй үгүйлэгдэнэ. Иймээс улсын хэмжээнд цэргийн болон бусад онц чухал объект, улсын хилийн шалган нэвтрүүлэх боомт дахь хамгаалалтын инженер-техникийн хэрэгслийн шийдэл, судалгаа хийх, зөвлөмж гаргах чиг үүргийг хамгаалалтын мэргэжлийн байгууллагад хуулиар олгож, хэрэгжүүлж эхлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Ингэснээр зэвсэгт хүчний объектууд, улсын хилийн хамгаалалт, төрийн тусгай хамгаалалт, улсын онц чухал объектын хамгаалалтын найдвартай байдал дээшлэх, аюулгүй байдлыг хангахтай холбоотой төлөвлөлтийг уялдуулах, үр ашиг муутай үйл ажиллагаанаас татгалзах, зарим объектод хот тохижилтийн хөрөнгийг зарцуулах замаар төсвийг хэмнэх боломж бүрдэх ач холбогдолтой.

Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улсын Дотоодын цэргийн тухай хууль УБ., 2017 он
2. “Улсын онц чухал объектын хамгаалалтад тавих шаардлага” CS 11-0129 :2010 стандарт
3. Төрийн тусгай хамгаалалтын тухай... Ш.Нацагдорж, Я.Тогтохням УБ., 2018 он.
4. **Reference Manual** to Mitigate Potential Terrorist Attacks Against Buildings. FEMA-426/BIPS-06/October 2011

Хамгаалалтын бүсийн хязгаараар шуудуу ашигласан шийдэл



Мөргөлтөд тэсвэртэй автомашины хаалт



ДОТООДЫН ЦЭРГИЙН АНГИ БАЙГУУЛЛАГУУДАД ИНЖЕНЕРИЙН САЛБАР, САЛААГ БАЙГУУЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Г.Мэндбаяр
*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Дотоодын цэргийн албаны
тэнхимийн багш, хошууч*

Товчлол: Дотоодын цэрэг нь үүсгэн байгуулагдсан үеэсээ улсын онц чухал албан газруудыг манаж хамгаалах, хоригдол ялтанг хуяглан хүргэх, цагдан харгалзах, алслагдсан аймаг хошуудад баримт бичиг хүргэх зэрэг үүрэг гүйцэтгэж байжээ. Энэхүү өгүүлэлд Дотоодын цэргийн анги байгууллагуудад инженерийн салбар, салаа байгуулах хэрэгцээ шаардлага, түүний ач холбогдол болон зарим дэвшилтэд техник технологийн талаар дурдсан болно.

Түлхүүл үг: Оросын холбооны улс, Дотоодын цэрэг, улсын онц чухал объект, цэргийн албан хаагч

Оршил хэсэг. Тус тасгийг 1922 оны эцсээр 20 хүнтэй тусгай салаа 1924 онд морин цэргийн болон 55 алба хаагчидтай тусгай суман болгон өргөжүүлсэн байна. 1926 онд тус тусгай сумангийн харуул хамгаалалтын хүчин чадлыг нэмэгдүүлж 170 хүний орон тоотой болгон өргөжүүлсэн байна. 1929 оны 10 дугаар сарын 15-ны өдөр бүх цэргийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн Дотоодыг хамгаалах газрын даргын тушаалаар 250 хүний бүрэлдэхүүнтэй ТУСГАЙ ДИВИЗОН болгон өөрчилж, бүтцийн хувьд цэргийн биеэ даасан зохион байгуулалтад шилжүүлж, удирдлагын штабыг анх бий болгосон байна. 1936 оноос Дотоод явдлын яамны харьяанд орж бүх цэргийн зөвлөлийн хуралдааны 133 дугаар тоот тушаалд Дотоодыг хамгаалах Тусгай дивизоныг тусгай хороо болгон өөрчлөн зохион байгуулсан байна. 1959 оноос Нийгмийг аюулаас хамгаалах газрын хилийн ба дотоодын цэргийг удирдах газрын бүрэлдэхүүнд орж 1950-аад оны үед төр засгийн дээд байгууллагын шугамаар манай оронд албан ёсны ажлын айлчлалаар ирж байсан гадаад орнуудын төр, засгийн төлөөлөгчдийн хамгаалалтыг гүйцэтгэдэг байжээ. 1950-аад оны дунд үеэс улс орны гадаад, дотоод байдал тогтворжиж, харуул хамгаалалтын албыг 3-н чиглэлээр зохион байгуулж явуулдаг байжээ.

Дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно. Тухайлбал:

“Дотоодын цэрэг” гэж дотоодын цэрэгт алба хааж байгаа цэргийн жинхэнэ алба хаагчийг¹⁹⁴

“Цэргийн жинхэнэ алба хаагч” гэж цэргийн байгууллагад цэргийн алба биеэр хааж байгаа монгол улсын иргэнийг;

“Хугацаат цэргийн алба хаагч” гэж цэргийн албанд татагдан цэргийн байгууллагад энэ хуулиар тогтоосон хугацаанд цэргийн жинхэнэ албыг биеэр хааж байгаа иргэнийг;

“Цэргийн гэрээт алба хаагч” гэж цэргийн байгууллагад сайн дураар гэрээгээр цэргийн жинхэнэ алба хааж байгаа иргэнийг;¹⁹⁵

Зэвсэгт хүчин жанжин штабын даргын тушаалаар батлагдсан “Цэргийн ар талын дүрэм”-д

“Цэргийн ар тал” зэвсэглэл, цэргийн техник, бүх төрлийн материал хэрэгслийн хангалт, хүн, мал, амьтны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, барилга, байгууламжийн ашиглалт, үйлчилгээ, засвар, хэмжил зүйн хангалтыг төлөвлөн хэрэгжүүлэх, цэргийн үйл ажиллагааны экологийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий, цэргийн анги, салбарын ар талын алба, нэгж, ар талын анги, салбар.¹⁹⁶

¹⁹⁴ Дотоодын цэргийн тухай хуулийн 4 дугаар зүйл 4.1.1 2017 оны 2 дугаар сарын 09-ний өдөр

¹⁹⁵ Цэргийн албаны тухай хууль 3 дугаар зүйл 3.1.9 2016 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр

¹⁹⁶ Цэргийн ар талын дүрэм 2 дугаар бүлэг 2017 он

“Арчлан хамгаалалт” – зэвсэглэл, цэргийн техник, цэргийн объект, материал хэрэгслийн ашиглалтын болон хэрэглээний үндсэн чанарыг алдагдуулах, тоногдохоос сэргийлэх, хамгаалахын тулд тэдгээрийн ашиглалт, хадгалалтын явцад гүйцэтгэх үзлэг, арчилгаа, техник ажиллагаа, хамгаалалт¹⁹⁷ гэж тус тус тодорхойлсон байна.

“Барилга-инженерийн цэрэг” гэж улсын онц чухал объект, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, салбарын барилга, инженерийн байгууламжийг барих, сэргээн засварлах, дайн байлдааны болон гамшгийн дараах сэргээн босгох,

Үндсэн хэсэг:

ОХУ-ын УОЧО болох дулааны цахилгаан станцын хамгаалалтанд ашиглаж буй инженер техникийн хэрэгсэл

Орчин үед террорист халдлагын тохиолдлууд ихэссэнтэй холбогдуулан улсын онц чухал объектуудын аюулгүй байдлыг хангах нь нэн тэргүүний асуудал болсон. Гадаадын орнуудын цөмийн болон усан цахилгаан станцуудад олон төрлийн халдлага гардаг. Усан цахилгаан станцуудын хувьд террорист халдаг нь усан болон далангийн хэсгээс ирэх магадлал ихтэй байдаг. Жишээ нь 2010 онд ОХУ-ын Баксаны усан цахилгаан станцад террорист халдлага гарсан. Иймээс агаарын, газрын болон усны цогц хамгаалалтын системийг суурилуулах шаардлага гарсан. Усан цахилгаан станц нь дараах хамгаалалтын системүүдтэй байх ёстой:

- Объект илрүүлэх тоног төхөөрөмж
- Мэдээлэл цуглуулах болон боловсруулах систем
- Видео хяналтын систем
- Протокол үүсгэх, видео архив үүсгэх болон мэдээлэл хадгалах систем
- Локал тооцооллын сүлжээ
- Дохиолол, мэдээллэх төхөөрөмж
- Хэрэгтнүүдэд нөлөөлөх төхөөрөмжүүд
- Автоматжуулсан операторын систем

Хэдий олон төрлийн систем байдаг ч объект бүрийг мэргэжилтнүүд сайтар судалж, тухайн объектод тохирох системийг суурилуулах нь аюулгүй байдлыг дээд зэргээр хангана.

ОХУ-ын Сургут хотын ДЦС-2-ын хамгаалалтын инженер техникийн хэрэгсэл

1. Хол зайнаас онгоц, завь илрүүлэх сантиметрийн диапозоны радарын станц (5 км хүртэл – моторт завь, 7 км хүртэл – завь, 20 км хүртэл – 3000 т багтаамжтай усан онгоц). Уг төхөөрөмж нь хийлдэг завь, хүнийг 1-4 км зайд эргээс илрүүлэх хүчин чадалтай.



Зураг 1. МР-2ПВ (БАЛТИКА-М) радарын станц

¹⁹⁷ Цэргийн ар талын дүрэм 2 дугаар бүлэг 2017 он

Зориулалт

Уг миллиметрийн диапазоны радарын станц нь усан гадаргууны аюулгүй байдлыг хангах үүрэгтэй. Завь, усан онгоцуудыг илрүүлэх чадвартай. Бүрэн автоматажсан.

Ажиллах зарчим

Уг станц нь богино радио долгионыг цацаж, буцааж хүлээн авахдаа эх үүсвэр болон объектын хоорондын зайг хэмжих зарчмаар ажилладаг.

2. Zoom-тэй болон видео архивтай видео хяналтын систем



Зураг 2. Видео хяналтын систем

Эдгээр видео хяналтын системүүдийн гол онцлог нь 1000 хүртэлх камерын хяналтыг зэрэг хийх боломжтойд оршино. Бүх хяналтын системүүд нь үндсэн төв процессор, камер, хөрвүүлэгч, хадгалах төхөөрөмж болон хяналтын дэлгэцнүүдээс тогтдог.

3. Хэт улаан туяаны камерын систем.



Зураг 3. Хэт улаан туяаны камер

Эдгээр системүүд нь жирийн камеруудыг бодвол илүү их нягтаршилтай, ялгарал ихтэй, халдагчийг харанхуй үед болон байгалийн хүнд нөхцөл байдалд ч илрүүлэх чадвараараа ялгаатай.

Хэт улаан туяаны камерийн систем нь эргэн тойрны хамгаалалтын видео хяналтыг хийх үүрэгтэй. Энэхүү систем нь байгаль орчны хүнд нөхцөл байдал болон гэрэлтүүлэг хангалтгүй нөхцөлд

халдлагчдыг хол зайнаас илрүүлэх чадвартай. Суурин дээрээ эргэн чадвартай тул цэгэн дүрслэлийг гаргах, ойртуулах, программын дагуу орчныг судлах, радарын станцын хамт ажиллах боломжтой.

Давуу тал ба онцлог:

- Радарын станцтай ажиллах боломжтой
- Төрөл бүрийн видео хяналтын системтэй ажиллах боломжтой
- Хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэн тохируулах боломжтой
- Хэт улаан туяаны болон видео хяналтыг зэрэг хийх боломжтой
- Ухаалаг эргэлтийн төхөөрөмж
- Эргэх төхөөрөмжийн удирдлага
- Суурилуулахад хялбар

4. Гэрэлтүүлэг



Зураг 4. LED гэрэл

Чухал объектуудын хамгаалалтанд ихэвчлэн LED гэрлүүд ашиглагддаг. Энэхүү ухаалаг гэрэл нь халдагчийг илрүүлсэн даруйд анивчиж эхэлдэг ба сэтгэлзүйн нөлөө үзүүлдгээрээ онцлогтой.

Давуу тал ба онцлог:

- 6000-50000 люмен хүртэл гэрлийн урсгалын хүчийг тааруулах боломжтой
- Төв удирдлагын дэлгэцнээс удирдах боломжтой
- (-28) – (+30) Цельсийн хэмд ажиллах чадвартай

5. Чичиргээ мэдрэгч систем



Зураг 5. Чичиргээ мэдрэгч

Объектын хүрээний хамгаалалтыг ихэвчлэн хашаагаар хамгаалсан байдаг ба энэхүү төхөөрөмж нь чичиргээг мэдэрч халдагчийг илрүүлдэг. (-50) – (+60) Цельсийн хэмд ажиллах чадвартай. Уг төхөөрөмжтэй дагалддаг илрүүлэгчүүдийг электрон мэдрэгч блоконд залгаснаар:

- хашлагыг давж, эвдэлж эсвэл ухааж давж буй халдагчийг илрүүлэх
- гадаргуугаар алхаж буй халдагчийг илрүүлэх боломжтой.

Дотоодын цэргийн анги байгууллага нь улс оронд нийгэм эдийн засгийн өндөр ач холбогдол бүхий барилга байгууламж, улс орныхоо дотоод аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудад дэмжлэг үзүүлэх, зорчигч, тусгай ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх, байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, гэнэтийн аюул тохиолдсон үед авран хамгаалах ажилд туслах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журмыг сахиулах, террорист байгууллагын эсрэг тусгай ажиллагаанд оролцох зэрэг нийтлэг үүрэг гүйцэтгэдэг.

Дотоодын цэрэг нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, нууцыг чанд хадгалах, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх, захирах, захирагдах, хамгаалалт, аюулгүй байдлыг уян хатан, шуурхай тасралтгүй зохион байгуулах зарчмыг баримтална гэж заасан байдаг байна.¹⁹⁸

Өнөөдөр Дотоодын цэргийн байгууллага, алба хаагчийн үүрэг оролцоо хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт өдрөөс өдөрт өсөн дэвшиж, өргөжин тэлж байгаа нь харагдаж байна. Мөн аймаг хөдөө орон нутгуудад Монгол улсын засгийн газрын тогтоолоор, Улсын онц чухал объектууд нэмэгдэж байна.

Иймд хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд, алба ажиллагааны болон цэргийн дүрмийн хэрэгжилт, үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулахад бэлтгэгдсэн алба хаагч, болон салбар, салаа, албадын үйл ажиллагаа ихээхэн чухал юм.

Улсын онц чухал объектын хамгаалалтын үйл ажиллагааны стандартын зорилго нь Улсын онц чухал объектын хамгаалалтыг Монгол Улсын хууль, тогтоомж, дүрэм, заавар, стандартаар зохион байгуулж, хамгаалалтын чанарыг сайжруулах, ашиглах инженер-техникийн хэрэгсэл, харуулын байр, цэгийн байр, шалган нэвтрүүлэх байрыг жигдрүүлэх, албаны нохойн байр, тоног хэрэгсэлд тавих шаардлагыг тогтооход чиглэгддэг байна.

Дотоодын цэргийн анги байгууллага нь Хамгаалалтын инженер-техникийн хэрэгсэлийг ашиглахдаа хүн хүчийг хэмнэх, объектын хамгаалалтын найдвартай байдлыг хангах, зөрчил гарч болзошгүй чиглэлд нягтралыг бий болгох зорилгоор хамгаалалтын инженер-техникийн хэрэгсэл ашигладаг.

Хамгаалалтын инженер-техникийн хэрэгсэл гэдэгт хориотой бүс, мөр хянах зурвас, торон саад, хаалт, хашаа, гэрэлтүүлэг, инженерийн байгууламж, дохиоллын болон хяналтын хэрэгслүүд хамаардаг байна.

ОХУ-д УОЧО хамгаалалтыг тус бүрт нь харьяа яамдууд нарийн судалж, объектуудын онцлог шинж чанарт тохируулан тусгайлан инженер техникийн хэрэгслийг ашигладаг бол МУ-д объектуудыг онцлог, ач холбогдлоор нь ангилалгүйгээр “Хамгаалалтанд тавигдах шаардлага байгууллагын стандарт”-д заасан инженер техникийн хэрэгсэл ашиглаж байгаа нь ихээхэн учир дутагдалтай байна.

Манай улсад объектуудын хамгаалалтын буюу биет хамгаалалтын, хууль эрх зүйн арга хэмжээ, инженер-техникийн хамгаалалтын хэрэгслүүдийн хувьд дараах шаардлагуудыг тавих хэрэгтэй байна. Объект нь дараах төрлийн хамгаалалтуудтай байна:

1. Дохиоллын систем. Үүнд:
 - Объектын хил хязгаарын дагуу халдагчийг илрүүлэх хэрэгсэл

¹⁹⁸ Дотоодын цэргийн тухай хуулийн 3 дугаар зүйл 2017 оны 2 дугаар сарын 09-ний өдөр

- Хууль бус нэвтрэх оролдлогыг илрүүлэх автомат болон гар дохиоллын систем /объект уруу нэвтрэхээс хамгаалах/

- Мэдээлэл цуглуулах болон боловсруулах систем /халдлага илрүүлэх төхөөрөмж, төв боловсруулах процессор, дуут болон гэрлэн дохио өгөх төхөөрөмж, объектын тухай нөхцөл байдлыг цааш нь дамжуулах боломж/

- Нэмэлт техник хэрэгсэл

2. Мэдээлэл цуглуулах, боловсруулах систем. Үүнд:

- Дохиоллын системээс ирэх мэдээллийг цуглуулах, анхдагч боловсруулалтыг хийх төхөөрөмж

- Кабель болон радио холболтоор мэдээлэл илгээх дэд систем

- Удирдлагын шийдвэр гаргалтыг хялбар хийх боломжийг олгох үүднээс ойлгомжтой хэлбэрээр мэдээллийг гаргах

- Харилцаа холбооны шугам

3. Нэвтрэх эрхийн хяналт болон удирдлага. Үүнд:

- Нэвтрэх хэсгийг хамгаалах гар, хагас автомат, автомат удирдлагатай турникет, хаалга, хаалт.

- Нэвтрэх эрхийг баталгаажуулах хэрэгсэл

- Программ

4. Үзлэгийн техникийн хэрэгсэл. Үүнд:

- Металл илрүүлэгч

- Рентген тоног төхөөрөмж

- Шугаман бус локатор

- Аюултай химийн болон дэлбэрэх бодисуудыг илрүүлэгч

- Цөмийн идэвхт чанарыг шалгагч хэрэгсэл

5. Видео хяналтын систем. Үүнд:

- IP65 стандартаас дошгүй усны хамгаалалттай видео камерууд

- Төв хяналтын дэлгэц

- Нөөц цахилгаан үүсгүүр

6. Харилцаа холбооны хэрэгсэл. Үүнд:

- Суурин болон хөдөлгөөнт радио төхөөрөмж

- Кабель харилцааны хэрэгсэл

- Дохионы хүч ихэсгэгч төхөөрөмж

- Харилцааны холбооны төв самбар

- Нөөц цахилгаан үүсгүүр

7. Хамгаалалтын гэрэлтүүлэг. Үүнд:

- Гэрэл

- Кабель шугам сүлжээ

- Удирдлагын хэрэгсэл

8. Цахилгаан хангамжийн систем

- Хамгаалалтын инженер-техникийн хэрэгслийн тэжээл нь нөөц цахилгаан үүсгүүрт холбогдсон байх ба ослын горимд удаан хугацаагаар ажиллах чадвартай байна. Нөөц цахилгаан үүсгүүр, түүний шугам нь далдлагдсан бөгөөд объектын цахилгаан хангамжаас хамааралгүй ажиллах чадвартай байна.


Дүгнээд хэлбэл объектуудад 8 төрлийн хамгаалалтын систем байх ёстой ба систем тус бүрийн бүрэлдэхүүнийг нарийн тодорхойлсон байна.

Монгол Улсын онц чухал объект хамгаалалтанд тавигдах шаардлага байгууллагын стандартаас дурдвал:

1. Хяналт, дохиолол, холбооны техник хэрэгслийн төхөөрөмж




2. Хамгаалалтын хашаа




3. Харуулын байр



4. Харуулын цэргийн байр



5. Харуулын цэргийн хориотой бүсийн гортиг



6. Торон саад

7.



Хамгаалалт, аюулгүй байдлыг уян хатан, шуурхай тасралтгүй зохион байгуулж, найдвартай байдлыг хангах тогтолцооны нэг томоохон бүрэлдэхүүн нь алба үйл ажиллагаанд мэргэшсэн алба хаагчийг бэлтгэхээс гадна хамгаалалтын инженер, техникийн хэрэгсэл, байгууламж, нэмэгдэл техник хэрэгслийг ашиглан бага хүчээр харьцангуй том нутаг дэвсгэр хамгаалах юм.

Хамгаалалтын инженер-техникийн хэрэгсэл нь хүн хүчийг хэмнэх, объектын хамгаалалтын найдвартай байдлыг хангах, зөрчил гарч болзошгүй чиглэлд хамгаалалтын нягтралыг бий болгох зорилгоор хамгаалалтын инженер-техникийн хэрэгслийг ашигладаг.

Хамгаалалтын инженер-техникийн хэрэгсэл гэдэгт хориотой бүс, мөр хянах зурвас, торон саад, хаалт, хашаа, гэрэлтүүлэг, инженерийн байгууламж, дохиоллын болон хяналтын хэрэгслүүд хамаардаг байна.

Дүгнэлт. Дотоодын цэргийн анги, байгууллага нь объектын хамгаалалтанд ашиглаж буй инженерийн төхөөрөмжийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн, ажиллагааг бүрэн хангаж, ариг гамтай ашиглахын тулд мэргэжлийн алба хаагч, түүнчлэн салбар нэгж, салаа бий болгох нь чухал хэрэгцээ шаардлагатай байна.

Ингэснээр хэрэгцээнд нийцсэн цэргийн байгууллагуудын цэргийн инженер, мэргэжлээр мэдлэг, ур чадвар эзэмшсэн, магистр, бакалаврын болон мэргэжлийн боловсролтой боловсон хүчин бэлтгэгдэн гарч, инженер, техникийн хэрэгсэл, технологийн ашиглалтыг сайжруулах, инновацийг нэвтрүүлэх чиглэлээр судалгаа, шинжилгээний ажлыг хөгжүүлэх болон инженер техник хэрэгслийн шинэчлэл тогтмол хийгдэж, хамгаалалт, аюулгүй байдлыг уян хатан, шуурхай тасралтгүй зохион байгуулагдана гэж үзэж байна.

Санал:

- Инженерийн хэрэгслийн мэргэжлийн офицерыг байгууллагын захиалгаар, гадаад, дотоодын их дээд сургуулиудад суралцуулах.
- Дотоодын цэргийн ангид ЦАХ-н болон ХЦАХ-н инженерийн рот, салбар, салааг бий болгох.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:**Нэг. Хууль тогтоомж, эрх зүйн актууд**

1. Дотоодын цэргийн тухай хууль 2017 он
2. Цагдаагийн албаны тухай хууль 2017
3. Цэргийн албаны тухай хууль 2016 он
4. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль 2016 он
5. ЦБҮАЖ-Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам
6. ДЦҮАЖ-Дотоодын цэргийн үйл ажиллагааны журам

Хоёр. Ном сурах бичиг гарын авлага

1. МУ ерөнхийлөгчийн 17-р зарлиг Цэргийн дүрэм 2019 он
2. Цэргийн ар талын дүрэм 2017 он

Гурав. Цахим эх сурвалж

1. <https://www.legalinfo.mn/>
2. <https://police.gov.mn/>
3. <https://www.google.mn/>